



УЙЛУУЛАХ УЧИРГҮЙ ҮНСЭЛТ

Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг

ЛИЗА БИВЭР

Хүндэт найз минь,

Нүгэл, ичгүүр хоёр нь биднийг Бурханы хайрыг харах нүдгүй болгож, эрх чөлөөнөөс хорьдог ахан дүүс, ихрүүд юм. Үнэн л биднийг эрх чөлөөтэй болгоно. “Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно” гэж Есүс амласан (Иохан 8:36). Эмэгтэйчүүд өөрсдийнх нь нэр төрийг хуулж хаяад, ял дор булшлахыг санаархагч дайсныхаа саварт тарчилж байна.

“Үйлуулах учиргүй үнсэлт” ном нь хайртай охин чамдаа зориулсан Бурханы зүрхний үгс юм. Бурхан чамд дотносол, хайр, дур хүслийг эдлүүлэхээр чамайг бүтээсэн. Чи хэн нэгний бэлгийн гарц юмуу дур хүслийг тайлагч байхаар бүтээгдээгүй. Бурханы Үгийн хүч нь чиний цагаас нь өмнө сэрээсэн зүйлсийг чинь тайвшруулан, буцааж нойрсуулахаар айлчилж байна. Бурхан миний нэр төр, хүч чадал, эрх хүчийг сэргээсэн шигээ чинийхийг ч сэргээнэ.

Би энэхүү номоо дэлхий даяарх хамтран зүтгэгч нартаа зориулан, бяцхан бэлэг болгон илгээж байна. CloudLibrary.org хаяг дээр байгаа энэ ном тэргүүтэй бүх материалыг өөрсдөө үнэ төлбөргүй бөгөөд чөлөөтэй хэрэглэхээс гадна таньдаг, мэддэг бүх хүндээ түгээн дэлгэрүүлээрэй. Энэхүү номын хуудсан дээрх үнэнд шумбаад эрэг дээр гарахдаа, Бурханы та нарт тогтоож өгсөн бүх гоо үзэсгэлэн, сайн сайхныг өөртөө шингээгээрэй.

Хайрлагдсан охин минь, хайр, нигүүлслийн энэ илчлэл миний амьдралыг мөнхөд өөрчилсөн юм шүү. Чамд хандсан Бурханы зүрхийг ойлгохдоо, хурдан өөрчлөгдөх болтугай хэмээн би чиний төлөө залбирч байна. Энэ үг чиний болоод чамд хамаатай хүмүүсийн амьдралыг хэрхэн өөрчилсөн талаар дуулгаарай.

Хүндэтгэсэн



Лиза Бивэр
LisaBevere@ymail.com





УЙЛУУЛАХ УЧИРГҮЙ ҮНСЭЛТ

Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг

ЛИЗА БИВЭР

Уйлуулах учиргүй үнсэлт Сайшаалын үгс

Лиза Бивэр бол миний мэдэх, хамгийн ил тод, шулуухан Бурханы эмэгтэй бөгөөд яг л байгаа онож хэлдэг. Тиймээс энэ номын үг нь маш их залбирал, эмх цэгцтэй амьдрал, Бурханыг дотно таньж мэдсэн амьдрал, хүмүүст туслахын төлөө цохилох зүрхнээс төрсөн гэдэгт итгэж болно. Эмэгтэйчүүд өөрт нь зориулсан Бурханы юмс руу явах замдаа дайсанд хууртагдаж, дээрэмдүүлдэг. Лиза энэ асуудлыг уншигчдыг салахын аргагүй хэлбэрээр яг үнэнээр нь тодорхой заажээ. Өөрөө энэ номыг барьж аваад, дуусгах хүртлээ тавьж чадаагүй хүнийхээ хувьд хэлж байгаа юм шүү. Энэ ном өнөөгийн хөгшин, залуу бүх эмэгтэйд ус агаар мэт хэрэгтэй үг ажээ. Хүүхэд байхад минь ийм ном байсан ч болоосой.

— Сторми Омартиан

Power of a Praying Wife бестселлер номын зохиолч

Лиза Бурханы Үгээр өнөөгийн завхарсан байдлыг гэхээсээ илүү энэ бүхнийг хэрхэхийг хүсдэг Бурханы хүслийг гэрэлтүүлэн харуулжээ. Энэ ном нь миний ч, таны ч охинд бас эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөн дотор эрх чөлөөг олж авахыг хүссэн бүгдэд амин чухал үг ажээ.

— Стив Артербурн

Every Man's Battle, Avoiding Mr. Wrong and Finding Mr. Right

бестселлер номын зохиолч бөгөөд

Women of Faith байгууллагын үндэслэн байгуулагч

Лиза эмэгтэй хүний бэлгийн мөн чанарын талаар тун нигүүлсэнгүй, хүчтэй, сайхан өгүүлжээ. Бурхан эмэгтэйчүүдийг бэлгийн хувь тавилангаа эргүүлж авахыг уриалан дуудаж байна.

Лиза Бурханы зүрхэнд хүрч, эмэгтэйчүүдэд ариун нандин чанарын хувцсыг нь эргүүлж авчиржээ.

Биднийг сэргээх нь Бурханы бөгөөд энэ номын амин зүрх болой.

Лиза эмэгтэй хүний бэлгийн цэвэр нандин мөн чанарт хандсан Бурханы санааг маш нигүүлсэнгүй, ятгангүй өгүүлсэн байна.

Би энэ номыг Бурханы охин болгонд заавал санал болгоно – хөгшин, залуу хамаагүй. Би энэ номыг удирдагч, зөвлөх, охиддоо хайртай аав, ээжүүдэд заавал санал болгоно.

— Доктор Дуглас Вэйс

Heart to Heart зөвлөх төвийн гүйцэтгэх захирал

Лиза Бивэр энэхүү ухаарал хайрласан номдоо эмэгтэй хүн бүрийн тавьдаг бас дийлэнх удирдагч нарын бултдаг сексийн талаарх асуултад зоригтой хариулжээ.

Тиймээс энэ номыг аав, ээж болгон, залуусын удирдагч бүр унших хэрэгтэй. Тэгээд хамгийн гол нь энэ завхарсан дэлхийд цэвэр амьдрах Бурханы цэц ухааныг хайж байгаа эмэгтэй хүн бүр унших хэрэгтэй.

— Нэнси Алкорн
Mercy Ministries of America байгууллагын
үндэслэн байгуулагч бөгөөд ерөнхийлөгч

Бурхан Лизад насанд нь баймгүй их цэц ухаан, мэдлэг хайрлажээ. Би түүний энэ номд жигтэйхэн баярлаж байна. Энд залуу эмэгтэйчүүдийг ерөөж, энэ нийгмийн дарамтаас чөлөөлсөн сүнсний хүчирхэг зөвлөгөө оршиж байна. Энэ ном ээжүүд, залуусын удирдагч нар, ганц бие хүмүүсийн пасторуудад маш хэрэгтэй гарын авлага ажээ.

— Бетти Робисон
Life Today нэвтрүүлгийн хөтлөгч

Найз маань дахиад л нэг онц ном бичжээ. Энэ шинэ ном эмэгтэйчүүдийн зүрхийг онож, үнэнийг сургана.

— Шерри Роуз Шеперд
Fit for Excellence, Life is Not a Dress Rehearsal
номын зохиогч, илтгэгч

Лиза эмэгтэй хүний хамгийн гүн хүсэл санаашралыг илчлээд, энэ бүхнийг хангаж чадах цорын ганц Бурхан руу чиглүүлжээ. Лиза энэ дэлхийн системийн заль мэх, худлыг илчлээд, эмэгтэй хүний жинхэнэ мөн чанарын үнэ цэнэ, нөр төрийг сэргээжээ.

— Кэйти Лүчэ
Teen Mania хөдөлгөөний үндэслэн байгуулагчдын нэг

Эрэгтэйчүүдийн бэлгийн цэвэр байдлын талаар бичсэн хүнийхээ хувьд би үргэлж “Тэгээд эмэгтэйчүүд бид яах болж байна? Бид ч бас сексийн асуудалтай зөрчилддөг шүү дээ!” гэж асуудаг байлаа. Эмэгтэйчүүд энэ талаар эмэгтэй хүнээсээ л сонсох ёстой бөгөөд үүнийг хийх хүн нь чухам Лиза Бивэр мөн билээ. Бурхан Лиза Бивэрийн номуудаар миний амьдралыг өөрчилсөн. Лиза энэ талаар Бурханы зүрхийг мэдэхийн тулд залбирч, мацаг барьж, эрэл хайгуул хийсэн нь тодорхой тул энэ ном таны амьдралыг ч өөрчилнө гэдэгт би итгэлтэй байна.

— Фред Стойкер
Every Man's Battle, Every Woman's Desire номын зохиолч

УЙЛУУЛАХ
УЧИРГҮЙ
ҮНСЭЛТ

Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг

ЛИЗА БИВЭР

Kissed the Girls (Mongolian) by Lisa Bevere
© 2019 Messenger International

Originally published in English as Kissed the Girls
© 2002 Thomas Nelson Inc.

Additional resources in Mongolian by John and Lisa Bevere are available
for free download at: CloudLibrary.org

To contact the author: LisaBevere@ymail.com
This book is a gift from Messenger International and is
NOT FOR SALE

Printed in Mongolia

Уйлуулах учиргүй үнсэлт
Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг
© 2019 Мессенжер Интернэйшнэл

Англи хэлээр анх Kissed the Girls нэрээр
© 2002 Тома Нелсон ХХК хэвлэсэн.

Жон, Лиза Бивэрийн Монгол болоод бусад хэл дээрх материалыг дараах цахим
хуудаснаас үнэ төлбөргүй татаж авах боломжтой: CloudLibrary.org

Зохиолчтой холбогдох имэйл: LisaBevere@ymail.com
Монгол хэл дээрх энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас Монголчуудад
бэлэглэж байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв



Энэ номоо мөрөөдөх хүсэлтэй ч,
яаж мөрөөдөхийг мартсан үе үеийн эмэгтэйчүүдэд зориулав.
Үнсэлт нь биднийг уйлуулах учиргүй – баярын нулимс л биш бол.
Энэ номын үг чиний зүрхний мөрөөдлийг дахин сэрээж бэхжүүлэх
болтугай. Чи энэ үнэнийг өөрийн болгож, үүгээр баяр хөөр,
та хоёрын дундуур хөндөлсөж байгаа сүүдэртэй дурсамж,
хар дарсан зүүдийг үлдэн хөөх болтугай.
Ханхүүгийнхээ тэвэр рүү гүйж,
мөрөөдөл рүүгээ нэвтрээрэй.

— *Лиза Бивэр*



АГУУЛГА

	Зориулалт	9
Бүлэг 1	Бурханы үлгэрийн цаг	13
Бүлэг 2	Бид хаана байна?	23
Бүлэг 3	Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд	33
Бүлэг 4	Хайр сэрсэн нь	43
Бүлэг 5	Нойрсож буй гоо бүсгүй	59
Бүлэг 6	Жинхэнэ Үнсгэлжин	69
Бүлэг 7	Бэлгийн хайр сэрсчихсэн бол, яах вэ?	79
Бүлэг 8	Аавыгаа хүндэтгэх	91
Бүлэг 9	Амьд өргөл	101
Бүлэг 10	Хараалыг таслах	113

Бүлэг 11	Халуун зүрхтэй, ариун Бурханаар сонгогдсон	129
Бүлэг 12	Цэвэр байдлын хүч	139
Бүлэг 13	Аминд халгай хувцаслалт	153
Бүлэг 14	Харуусалгүй амьдрах юмсан	165
Бүлэг 15	Бид буулт хийхдээ ялагддагийн учир	179
	Дүгнэлт: Хайрын хүч	187
	Тэмдэглэл	191
	Зохиолчийн тухайд	192
	Талархал	193



1 Бурханы үлгэрийн цаг

Зуны амралт нь дөнгөж эхлээд буй, дөрвөн жижигхэн залуутай айлын хөл толгой нь олдохгүй амьдралыг утасны дуудлага гацаав.

–“Байна уу?”

Манай пастор ажээ.

–“Лиза, чи өнөөдөр орой ахлах сургуулийн охидод сексийн талаар ярих боломжтой юу?”

Үүнийг сонсоод хэдэн өдрийн өмнө угаалгаас гаргасан овоолон хувцсаа эвхэж байх зуураа зурагтаар сонссон ток шоу санаанд орсон тул би тэрхэн зуур зог тусав. Тэр ток шоу үнэн л юм ярьж байлаа. Учир нь өнөөдөр юмс миний ахлах сургуулийн үеэс тэс өөр болжээ. Нэвтрүүлгээр ярьснаар хүүхдүүд бүр дунд сургуулиасаа л бэлгийн харилцаанд орох болжээ. Гэтэл би дунд сургуульд байхдаа “тийм юм” байдгийг ч мэддэггүй, ангайсан амьтан явсан.

Би ч бантсандаа: “Өнөөдөр үү?” хэмээн бувтналаа.

Пастор маань ч: “Тийм ээ. Тэгэхээр ингэе. Бид охид, хөвгүүдийг хуваана. Би хөвгүүдийг нь хариуцаж авна, харин чи охидыг аваад, залуусын танхимд заана шүү” гэлээ.

Би ч цаг хожих гэсэндээ: “Жон өнөөдөр ирнэ. Би эхлээд Жонтой ярьж болох уу?” хэмээн ээрлээ.

–“Өө, тэгэлгүй яахав. Шийдээд дараа нь надад юмуу залуусын пасторт хэлээрэй.”

~ Хүүхдүүд бүр дунд сургуулиасаа л бэлгийн харилцаанд орох болжээ. Гэтэл би дунд сургуульд байхдаа “тийм юм” байдгийг ч мэддэггүй, ангайсан амьтан явсан.

Утсаа тавихдаа, гар маань салгалж байхыг анзаарлаа. Юу болж байна аа? Би чинь Америк даяар аялж, нас насны, хүйс хүйсийн, том том цуглаанд номлодог хүн байж, хотынхоо сургуулийн ахлах ангийн охидод яриа өрнүүл гэхээр юундаа ингэж тэвдэнэ вэ? Би чинь экс залуусын цуглааны пастор хүний гэргий шүү дээ. Би тэр хоёр жилийг дажгүй л давсан. Тэгтэл намайг охидын нас нь биш, харин ярианы сэдэв нь сандаргасныг ухаарав.

Би Жоны гар утас руу залгалаа. Жон гэр рүүгээ нисэхээр нисэх буудлын транзит хэсэг дээр онгоцоо хүлээж байж таарав.

– “Жон, пастор намайг өнөө орой ахлах сургуулийн охидод сексийн талаар заагаач гэнэ ээ. Би яахаа мэдэхгүй байна. ... Чи өнөөдөр орой ирнэ. Цаг нь ч дэндүү тулгамдуу, дээрээс нь би тэдэнд юу хэлэхээ ч мэдэхгүй байна. Өнөөдөр дунд сургуулийн олон охид аман секс хийдэг талаар чи дуулсан уу?”

Би уг нь төгсгөлийнхөө үгээр Жоныг цочирдуулах гэсэн чинь, Жон цочирдсон янзгүй байв: “Би зүгээр ш дээ. Чи заах хэрэгтэй байх.”

Тэгэхээр нь би: “Гэхдээ би ахлах сургуулийн охидод юугаа заах юм бэ? Би өөрөө ч охингүй хүн бас бэлтгэх цаг ч алга” гэж ирээд л маргав.

Гэтэл Жон: “Лиза, чамд гурван цаг байна. Чи заах хэрэгтэй байх” гэв.

Хмм, энэ хүн намайг дэмжих шинж алга. Гэтэл дээд давхарт хөвгүүдийн маань марган түчигнэх чимээ дуулав.

– “Манай дөрөв гэрээ буулгаад, надад юу ч бэлтгэх боломж олгохгүй нь. Тэгээд ч би ер нь сексийн талаар юугаа заах юм бэ?”

– “Бурхан чамд зааж өгнө. За, найз нь одоо онгоцондоо суулаа. Пастор руу залгаад, тэгье гэж хэл.”

– “Харин ээ, сайн мэдэхгүй байна аа. За сайн яваад ирээрэй. Буугаад залгаарай” хэмээн би бувтналаа.

Мэдээж Жон өөрөө заахгүй юм чинь, тэг тэг гэх нь тодорхой. Тэр намайг ийм юмнаас “чөлөөлдөггүй” нь ёстой хэцүү. Би хэрэг болчихмоор ном байгаа эсэхийг шалгахгаар түүний албан өрөөг гүйлгэж харангаа, пасторгаа яг юу гэж хэлэхээ ч мэдэхгүй байж, түүн рүү залгалаа.

Тэгснээ өөрөө ч мэдэлгүй: “Байна уу, аа пастор аа, Жон тэг тэг гэнэ ээ” гээд хэлчихэв.

– “За ашгүй дээ! Тэгэхээр хэтэрхий их юм битгий бэлдээрэй. Нэг иймэрхүү форматаар явна шүү: Хамтдаа магтан хүндэтгэнэ. Дараа нь охид чамтай хамт явна. Тэдэнд гурвыг харьцах тавын хэмжээтэй хуудас дээр хүссэн асуултаа бичих боломж олгоно. Чи эхний гучин минут асуултад хариулна. Дараагийн гучин минутад нь хичээлээ заана. Тэгээд тарна.”

– Асуултыг нь урьдчилан харж болох уу?”

– “Боломжгүй.”

Би бүр ч балмагдав.

– “Ингэхэд пастор аа, би итгэхээсээ өмнө нилээд хүнд гар байсан ш дээ. Юу л даа, надад ариун амьдралын талаар гайхуулаад байх гэрчлэл мэрчлэл байгаагүй л дээ. Тэгэхээр, энэ лекцийг өөр хүнээр хийлгэбэл дээргүй юу?”

– “Өө, чи гэрчлэх хэрэггүй. (Угаасаа надад гэрчлэх зүйл байхгүй нь тодорхой болсон болохоор) Чи зүгээр л цэвэр байдлын талаар заагаад л, шулуухан хариулт өгөхөд л болно. Чи чадна аа.”

Тэгээд утсаа тавьчихав. Би ч утсаа тавихдаа, яаж яваад ийм түргэний байдалд орчихсноо гайхав. Надад хийх ажил мундахгүй байна. Өнөө орой заана гэдэг чинь дахиад л үдшийн цагаар хүүхдүүдээ орхиж явна гэсэн үг. Тэгээд хамгийн гол нь би энэ ажилд хамгийн тохиромжгүй хүн. Би Жоны ажлын өрөөнөөс гүйхээрээ гараад, дөрвөн хүүхдээ цуглуулож байгаад, хэргээ учирлан, хүсэлт тавьлаа:

“Хөвгүүд ээ, ээжид нь та дөрвийн тусламж үнэхээр хэрэгтэй байна. Ээж нь гурван цагийн дараа ахлах сургуулийн охидод хичээл заах болчихлоо. Тэгээд бэлтгэх хэрэгтэй байна. Ээж нь одоо аавынх нь ажлын өрөөнд орлоо. Та нар ээждээ саад болж ёстой болохгүй шүү. Цус чинь гоожоогүй л бол, битгий орж ирээрэй. Хоорондоо эвтэй байгаарай. Гадаа юмуу эсвэл дээшээ гараад тогло. Эсвэл доошоо ороод тогло. Харин энэ давхарт байж болохгүй шүү. Ээж нь та нарын хэрүүлийг сонсож болохгүй, ойлгоо?”

Тэд над руу, дараа нь бие бие рүүгээ хараад, толгойгоо бөнжигнүүлээ. Хөөрхий ээж нь үнэхээр арга ядаад байгааг тэд ойлгожээ.

Би Жоны ажлын өрөөнд ороод, энэ талаарх материал, конкордансыг сугалан овооллоо. Гэтэл нүдний маань буланд есөн настай Алек Жоны ажлын өрөөний шилэн хаалганд наалдаатай зогсож байхыг мэдээд, очиж хаалгаа нээв.

Тэгээд бухимдангуй: “Яасан, Алек?” гэж асуутал, тэрбээр:

“Яагаа ч үгүй. Зүгээр л таныг харсан юм” гэлээ.

“Харж болохгүй ээ. Энэ давхарт байж болохгүйг санаж байна уу? Одоо яв!”

Алек: “За ээж ээ” хэмээн мөрөө хавчсаар, тоодогносоор одов.

Энэ хөвгүүдийг уу! Би дахиад л түгжигдэж аваад, *Мэтью Хенри’с Тайлбарыг* нээсэн боловч, юунаас эхлэхээ ч мэдсэнгүй. *Амплифайд Библиэ* гаргаж ирээд, цэвэр амьдрал, садарлал, завхайрлын талаарх танил эшлэлээ эргүүлж байтал дахиад л утас жингэнэлээ. Би ч энэ удаа нилээд ширүүн шүүрч аваад:

“За байна!” гэлээ.

Тэгтэл дахиад л пастор байв. “Өө Лиза, өнөөдөр оройны цуглаан цуцлагдсан. Арай л тулгамдуу байна. Гэхдээ өнөө орой зарлаад, дараа долоо хоногт хийх байх. Чи дараа долоо хоногт хотод байх уу?”

“Азны Коля!” Азаар дараа долоо хоногт эзгүй байж таарах ч юм билүү.

Би тэмдэглэлээ аваад, дараа долоо хоногийн хуваариа шалгалаа.

– “Дараа долоо хоногт биии... хотод байх юм байна.”

– “Маш сайн. Тэгвэл дараа долоо хоногт хийе.” Пастор ингэж хэлээд, дахиад л алга болчихов.

Бэлтгэх гуравхан цагийн биш, долоо хоногийн зайтай болсондоо дотор жаахан уужрав. (Би шүршүүрт ч орж амжаагүй, оройн хоолоо ч хийж амжаагүй байсан болохоор үүнээс ч бага цаг гэж бодож болно) Амьсгаа аваад, хөвгүүддээ үргэлжлүүлэн буулгаж болно гэсэн тушаал өгчихөөд, жаахан дотор онгойлоо.

Тэгээд бүтэн долоо хоногийн турш зүрхэндээ бэлтгэлээ. Асуулт хариултад бэлтгэн, Бурханыг чин сэтгэлээсээ хайж, Бичээсийг ч, зүрхээ ч самналаа. Өнөөдөр сексийн амьдрал тухайлбал дугуйн уралдаан шиг л хэвийн зүйлд тооцогддог болсон учраас, ямар ч байсан “аль хүртэл явж болох” гэсэн утгатай асуулт ирнэ гэдгийг харин ч нэг мэдэж байлаа. Би хөвгүүддээ зааж байсан хариулт маань хангалтгүй гэдгийг ойлгоод, Бичээсээс тодорхой, баттай хариулт хайв. Тэгээд ч би алдарт Мэжик Жонсон зөндөө олон охин үнссэнээсээ болоод ДОХ тусчихсан гээд заачихсан чинь манай залуус хамаатнууддаа ч баяртай гэж үнсүүлэхээс цааргалдаг болчихож билээ. “Дэндүү нялх” хөвгүүддээ цаад учрыг нь би яаж хэлэх ёстой байсан юм бэ?

Би ууган хүүгээ 12 настай байхад нь үерхлийн семинарт явуулж бас гэрлэх хүнийг нь өөрөө олж өгнө гэж амлаж байсан, тийм л ээж. Тэр бүү хэл аялж явахдаа, хүүдээ таарч тохирчихмоор нэр дэвшигч охиноор анкет бөглүүлэх санаа гаргаж явсан, тийм л ээж. Энэ ч гайгүй. Би чинь тэр байтугай хүүдээ болзоонд явж, мөнгө үрж байхаар, тэр мөнгөө хадгалбал, төдий хэмжээний мөнгө хэмнэж, үүгээрээ хөөрхөн машин аваад уначихаж болно гэсэн тооцоо хүртэл гаргаж танилцуулж явсан, тийм л ээж.

Гэтэл одоо нухацтай хандах хэрэгтэй болоод байв. Тэр газарт миний зуучлан гэрлэх онолд автаад байхгүй хэдэн зуун охин байх нь тодорхой. Тэгээд үнэн голоосоо залбирлаа:

Аав аа, би тэр охидод юу гэж хариулахаа мэдэхгүй байна. Би өөрийнхөө юмуу хүний биш, харин Таны цэц ухааныг дамжуулмаар байна. Цаашаа даврахгүй л байвал, хөтлөлцөх нь зүгээр гэж хэлэх ёстой юу? Эсвэл үнсэлцэх нь зүгээр гэх үү? Би мэдмээр байна.

Би Бурханыг хүлээсэн ч, хариулт сонсоогүй учраас босоод усанд орохоор явлаа. Маргааш би заана. Усанд орж байхдаа, маргаашийн талаар л бодсоор байлаа. Гэтэл Ариун Сүнсний үг намайг чиглүүлэв.

Ариун Сүнс надад: “Чи тэдний авир үйлдлийг ямар дүрэм журмаар хязгаарлахыг л бодоод байна. Тэднийг дүрэм журам тогтоохгүй. Тэдний

хүч хат харилцаанаас төрөх ёстой юм. “Болохгүй” юмсаас “болох” юмс дээр төвлөр. Найз хөвгүүдтэйгээ юу хийж болох, юу хийж болохгүй вэ гэж үү? Төрсөн аавынхаа нүдэн дээр юу хийж чадах уу – хоёулханаа байхдаа ч түүнийгээ л хий гэж хэл. Учир нь аавууд бол охидынхоо нандин чанарын өмгөөлөн хамгаалагч.

Би баярлав! Энэ чинь дүрэм журам биш. Гэтэл би дүрэм журам л гэж бодож явсан. Энэ маань бидний ярилцлагыг хуулийн талаарх лекц болгон хувиргаж, хүүхдүүдийг хүчгүй, намайг сэтгэл дундуур үлдээх байж. Гэтэл үнэндээ энэ бүхний утга нь Тэнгэрийн Аавтайгаа харилцаж, газрын аавуудыгаа хүндэтгэх явдал байжээ. Энэ нь хязгаарлалт, ёс суртахуун, чулуужсан ёс зүйн коод бус, харин зүрхэнд нь сийлээтэй амьд зүйл ажээ. Би шүршүүрээс үсэрч гарч ирээд, өөртөө зориулан зургаан хуудас юм биччихэв.

Маргааш орой нь би магтаал хүндэтгэлийн дараа орж ирмэгцээ л хачин эв хавгүй санагдаад явчихав. Учир нь баахан өсвөр насны цэцэг цэврүү шиг

~ *Найз хөвгүүдтэйгээ юу хийж болох, юу хийж болохгүй вэ гэж үү? Төрсөн аавынхаа нүдэн дээр юу хийж чадах уу – хоёулханаа байхдаа ч түүнийгээ л хий гэж хэл.*

охидын дунд дөч хэвийсэн ганц хүүхэн зогсоно. Анзаарагдахгүй өнгөрөх арга байсангүй. Тэд намайг хэн нэгнийх нь “тагнуулч ээж” л гэж бодоо байх. Хүндэтгэл дуусахад, нөгөө аймшигтай асуултууд бичигдэх, 3х5–ын харьцаатай хуудсыг зааланд байгаа бүх хүүхдэд өргөөшөө, уртаашаа тараалаа. Би ойролцоо суугаа хэд хэдэн охид руу мишээн, тэдэн рүү бөхийгөөд, асуултаа бичихийг нь урамшууллаа. Тэд намайг өөрсдийг нь бичгийнх нь хэвээр таньчих байх гэж айсандаа, зүгээр л боловсон зүйл асуугаад өнгөрөх байх хэмээн би битүүхэн горьдож байлаа.

Тэгтэл нэг нь: “Өө, би зүгээр л хувцасны талаар асуумаар байна” гэлээ. Би ч өөдөөс нь итгэл дүүрэн толгой дохин мишээхдээ дотроо *“Ашгүй минь! Энэ талаар ч хариулчихна шүү. Миний төсөөлсөн шиг хэцүү биш болтой. Тэгтлээ айгаад байх хэрэггүй байжээ”* гэж бодоод амжлаа.

Хуудас бөглөж дууссаны дараа охид том танхимаас гараад, доор байдаг залуусын цуглааны танхим руу явлаа. Тэгээд үүдээр нь цуварч орохдоо, нөгөө хуудсуудаа хураалгав. Гарч явахдаа, охид ямар их дуу чимээтэй, дэггүй байгааг би гайхаж байлаа. Залуусын ахлах бараг дөрвөн зуун охиноос хуудсыг нь хурааж оруулах хооронд би хажуугаас ажиглан зогсов. Охид сандлыг дүүргээд, шалаар асгаран суулаа. Бүх хуудсыг хурааж дууссаны дараа тэдгээрийг микрофоны хамт надад гардуулж, би ч асуулт – хариултад орохоор тайзан дээр гарлаа.

Тийм боловч “бонус” долоо хоног ч надад тийм асуултанд хариулах

хангалттай хугацаа олгоогүй юм. Хамгийн эхний асуулт нь чуулганы нэр бүхий нэгэн ажилтан (хуудсан дээр нэрийг нь бичсэн байв) энэ цагийн хамгийн тачаангуй залуу гэдэгтэй санал нийлж байна уу гэсэн асуулт байлаа. Би санал нийлэхгүй байна гээд, өөрийнхөө нөхрийг энэ цагийн хамгийн секси залуу гэж бодож явдгаа хэллээ.

Дараагийн асуулт нь хувцас руу оров: *Ил задгай хувцаслаж болох уу? Нэг удаадаа биеэ аль зэрэг гаргаж болох уу?*

Би тэнд байгаа охид руу харлаа. Олонх нь суухад яах бол гэхээс санаа зоволгүй, бөгсөө гаргах шахам, оодон өмд өмссөн байлаа. Зарим нь цоолбортой хүйс, гэдсээ зориуд гаргах гэсэндээ өмд, богино өмдөө ташаан дээрээ тохож өмссөн байв.

Тиймээс би асуултыг тодруулахын тулд: “Та нар намайг өдсөн шинжтэй хувцаслах нь зүгээр гэж бодож байгаа эсэхийг мэдмээр байна уу?” гэж асуулаа.

Охидын дийлэх нь намайг асуултыг ойлгосонд талархсан шиг толгой дохив.

– “Тийм ээ, дажгүй санаа. Гаж донтой амьтныг татъя гэж бодож байвал, янхан шиг л хувцасла. Загас барихтай л адил. Ямар өгөөш хэрэглэнэ – тийм л загас барина. Тиймээс бүтэхгүй амьтан олзлоё гэж бодож байвал, бүтэхгүй л хувцас өмс.”

Охидын нүд орой дээрээ гарсан тул би цааш нь тайлбарлалаа: “Би та нарыг гоё сайхан юмуу ганган хувцаслаж болохгүй гээгүй. Гэхдээ өдсөн шинжтэй хувцаслалт нь хаалттай хаалганы цаана эхнэр – нөхрийн хооронд л байх зүйл.”

Жишээ нь би унтлагын өрөөндөө нөхөртэйгээ хоёулханаа байхдаа өмсдөг хувцсаа нохойгоо салхилуулахаар гарахдаа эсвэл хөвгүүддээ өндөг шарж өгөхдөө өмсөхгүй. Бас хөвгүүд маань ээждээ угаасан хувцсаа эвхэж туслахдаа, хачин жигтэй тод

*~ Ямар өгөөш хэрэглэнэ
– тийм л загас барина.*

өнгийн, сонин хэлбэр дүрстэй дотуур хувцас барьчихаад, түүнийхээ эзнийг тодруулахаар хашхирахад нь би “Энэ чинь аав– ээжийн” хувцас гэж хэлэхэд,

тэд маань мөрөө хавчаад: “Май энийгээ өөрөө эвх. Би мэдэхгүйм байна” гээд надад өгдөг талаар ярьлаа.

Өөр нэг охин биеийнхээ аль хэсгийг цоолбол зүгээр болохыг асуусан байлаа. Би үүнд нь цоолборын талаар хэлсэн Библийн эшлэлийг заагаад (Езекиел 16:12): чих, хамар гэж хариуллаа. Тэгээд мөгөөрснөөс бусад газраас холхон байхыг зөвлөв.

Үүнээс гадна Библи ижил хүйсийн талаар юу хэлсэн талаар хэд хэдэн

хүн асуусан байлаа. “Библи энэ талаар юм хэлсэн үү? Энэ чинь буруу юу? Ижил хүйстэй ч байна уу, үгүй ч байна уу – хоёр хүний хайр сэтгэл яагаад буруу гэж?” Би тэдэнд бие дааж судлах ишлэлийг нь хэлж өгөөд, буруу загвартай (нэг ижил хүйсийн хоёр хүний дунд сексийн сэдлээр илэрхийлэгдсэн) зөв зүйл (хайр) нь буруу болно гэж хариулсан юм. Энэ нь Бурханы тогтоож өгсөн сексийн хайрын үнэ цэнийг завхруулсан, үнэ цэнэтэй хэрэгцээг угтах үнэ цэнэгүй арга зам юм.

Бас аман сексийн талаар – тэр бүү хэл дурьдахаас ч ичмээр бүдүүлэг, харгис, хүндэтгэлгүй асуулт ч байв. Тэгтэл тэр дунд нэг том асуулт гарч ирэх нь тэр. Тэгэхээр, намайг бүү ташаа ойлгоорой. Энэ асуулт надад хэд хэдэн удаа ирсэн боловч, би уншилгүй, буцааж хийгээд байсан юм л даа. Энэ нь нөгөө секси хувцаслаж болох уу гэдэг асуултын хувилбар шиг л олон давтагдсан асуулт байв. Тиймээс би цаашид зайлсхийж чадсангүй. Энэ бол тэдний харуулдан хүлээсэн асуулт байв: Зөвшөөрөгдсөн үйлдлийн хэмжээ хязгаар нь юу вэ?

~ Зөвшөөрөгдсөн үйлдлийн хэмжээ хязгаар нь юу вэ?

Ариун Сүнсний хэлсэн зүйлийг хэлсний минь дараа жиг жуг, жуумалзсан инээдүүд зогсож, зүү унагахад ч сонсогдмоор нам гүм тогтов. Охин болгон дотроо бодсон байх: *Аавынхаа өмнө үү? Ямар байх бол? Яана аа, яаж аавынхаа өмнө тэгэх юм бэ?*

Энэ үнэн. Учир нь бидний бэлгийн явдал ихэвчлэн хаалттай хаалганы цаана, харанхуй буланд, шөнийн цагаар юмуу архи, тамхины мансуурал дор л өрнөдөг. Бүр бүдүүн зүрхтэй нь аав, ээжийгээ унтаж байх хойгуур гэрийнхээ аль нэг харанхуй өрөөнд эх захаа алддаг. Гэхдээ хэзээ ч гэрэлд, эрүүл ухаантайгаар юмуу аавынхаа өмнө үйлддэггүй!

Өрөөн дэхь нам гүм үргэлжилсээр, би ч энэ бол эргэлзэж, задгайрсан цагийн охидоос ирсэн буруу асуултад өгсөн зөв хариулт гэдэгт итгэлтэй байлаа. Хамгийн сэрдхиймээр нь би маш эрч хүчтэй, халуун, галтай залуусын пасторын удирдлага дор байдаг чуулганы охидын асуултад хариулж байгаа минь энэ шүү дээ. Энэ залуусын бүлгийн удирдлага нь залуусын дундуур хуй татуулан, сэргэлтийг авчрах Бурханы ариун байдлын галаар өлсөж цангасан хүмүүс болохыг би мэддэг байлаа. Удирдагч нар нь өөрсдөө ариун байдлыг мөшгидгийг би мэднэ. Тэгвэл асуудал нь юундаа байна? Энэ талаар удахгүй ярина аа.

Би номлож дуусаад, цуглаан 21 цагт тарав. Залбирах эсвэл зүгээр л ярилцах юмуу өөр асуулт асуухыг хүссэн хүүхдүүд нь чөлөөтэй үлдээд, надтай юмуу залуусын бүлгийн удирдагчтай уулзахыг урив. Олон охид анх орж ирснээсээ тэс өөр болоод гарч байгаад би гайхав. Дараагийн хоёр

цагийн турш би зүрх үйрмээр гашуун түүхүүд сонсож билээ.

Олон охид хамгийн дотны хүмүүсийнхээ буюу найз, найз хөвгүүд, садангийн ах, төрсөн ах, хойд эцэг, тэр бүү хэл аавынхаа бэлгийн хүчирхийлэл дор дарлагдан амьдардаг ажээ. Жаахан охид толгойд нь ахин дахин тоглогдох сексийн сэдэлтэй дүр зураг, бохир кино, клип, зураг, интернэт хуудсаас харсан дүрсдээ тамлуулна. Жаахан охид өртсөн эсвэл дам сонссон эсвэл дуудуулсан бохир яриа, элэг доогь, нэр хочноосоо болж өөрийгөө жигшинэ.

Зарим нь гар хангалгад орооцолджээ.

Энэ бүх нууц шинэхэн амьдралыг яг л арилдаггүй хар толбо шиг бохирлож, хэгэн залгина. Яг л бохир галаас гарч ирснийг нь илтгэн араас нь суунаглах хар утаа шиг.

Энэ охидод өнгөрсний ямар ч дүр дүрс, төсөөлөл, дуу хоолой, сүүдэртэй тэмцэлдэхгүйгээр, амар тайван хэвтэж амрах аюулгүй газар байхгүй ажээ. Тэд шившиг, айдсаар амар тайвнаас тусгаарлагджээ. Зарим нь дүрэм журмаа мэднэ. Гэвч тэдгээр нь тэдний оюун санааны эсрэг өрнөх тулаанд хамгаалж чадахгүйг ухаарна. Биеийн хүчирхийллээс биеэр зугтаж болох ч, оюун санаагаар зугтах арга байхгүй. Тэд цагаан морьтой дайчин ханхүүгээ хүлээсээр. Сүүдрийн харанхуй цамхагаас зугтмаар байвч, хан хөвгүүд нь хаяад явжээ. Сүүдрийн харанхуй цамхагаас зугтмаар байвч, хан хөвгүүд нь хаяад явжээ. Голдуу тэдний амьдрал

~ Тэд цагаан морьтой дайчин ханхүүгээ хүлээсээр. Сүүдрийн харанхуй цамхагаас зугтмаар байвч, хан хөвгүүд нь хаяад явжээ.

дахь эрчүүд л тэднийг ийнхүү эмзэглүүлж, эрэмдэглэж, гонсойлгож, хүчирхийлж хаясан байдаг.

Би тэр орой хүчирхийллийн олон түүх сонссон – маш зальхай учраас, та үүнийг гэм зэмгүй хэмээн эндүүрэх вий: ээж, аав нь гэрийнхээ дээвэр дор юмуу эсвэл кино театрт хүүхдүүдийнхээ дэргэд сексийн бохир үзэгдэлтэй, сэдэлтэй, шалдан нүцгэн явдалтай кино үзэх. Жаахан охид иймэрхүү юмсыг эцэг, эхийнхээ дэргэд – ялангуяа аавынхаа дэргэд үзэхээс ичдэг. Тэд ичэж зовсоор аав, ээжийгээ ажиглахад, тэдэнд ямар ч ичэж зовсон шинж байдаггүй. Киноны дараа ичгүүр, эвгүй мэдрэмж нь яваандаа арилдаг ч, охид аав, ээжийгээ хуучин шигээ харж чаддаггүй. Дэлгэцэн дээрх хөх дэлэнг шал тоохгүй үзэж суугаа аав нь яг л өөрсдийнх нь хөхийг харж байгаа юм шиг санагдана. Тэд учрыг нь мэдэхгүй ч, энэ явдал тэднийг эмзэглүүлж, хүчирхийлдэг.

Төрсөн эцэг нь бохир зүйлээр зугаацаж байхад, охин хүүхэд яаж аюулгүй байдлыг мэдрэх билээ?

Аавыгаа дэргэд байхад нь аюулгүй байдал, үл зөвшөөрөл, дургүйцлийг нь мэдрээгүй хүүхэд яаж байхгүй байхад нь мэдрэх билээ? Жаахан охин

аюулгүй байдлыг мэдрэхгүй бол, яах уу?

Чи хэзээ ч ийм байдалд ороогүй байж болох ч, манай нийгмийн авчирсан бурхангүй, бохир дүр төрхийн улмаас сексийн харилцаа гэхээр хүлээтэй санагддаг болчихсон байж магадгүй. Дайсан эрүүл хүсэл, хайрын дүр төрхийг эвдэж, үүнийг тачаалын хямд зураг болгон хувиргажээ. Тиймээс бид ямарваа нэгэн хүсэл, сэрлийг аймшигтай зүйл мэт харна. Тиймээс бид хуулийн хоригийг хэзээ, яаж эрх чөлөөтэй дур хүслээр солихоо мэдэхгүй учраас, голдуу ганцаардалд орно.

~ Төрсөн эцэг нь бохир зүйлээр зугаацаж байхад, охин хүүхэд яаж аюулгүй байдлыг мэдрэх билээ?

Тэгээд ч хэн ч сонирхохгүй бас сонсохгүй байхад, би яагаад ариун амьдралын талаар ном бичих гэж? Хэнд зориулж бичих гэж? Энэ ном нь хүлээж байгаа охидод зориулагдсан юм. Бас ээжүүдэд сануулах гэж бичигдсэн юм. Унасан хүн болгоныг босгох гэж бичигдсэн юм. Бас дотроо шаналж яваа эмэгтэйчүүдэд шагнал байгаа учраас, хүчтэй байгаарай гэдгийг мэдүүлж, ухааруулах гэж бичсэн юм.

Энэ ном нь харуусал гэдгийг үзсэн ээжүүд, зөвлөхүүдийн үеийнхэнээс тэдний алдааг давталгүй амьдраад, зовиурыг бус, амлалтыг өвлөөсэй гэсэндээ энэ үеийн охидод илгээсэн захидал юм. Энэ нь өөрөө олон жилийн өмнө зөвшөөрсөн учраас, өнөөдөр охиндоо “үгүй” гэж хэлээрэй гэж хэлж чадахгүй яваа ээжүүдэд зориулсан зэмсэг юм.

Энэ маань болно, болохгүйн ном биш, харин сэргэлтийн ном юм. Бурхан юмсыг яаж хардгийг ухааруулах хараа, Түүний анхны санааны илчлэл. Зарим нь үүнийг амьдралгүй үлгэр гэж болох ч, харин би үүнийг үнэн гэдэгт итгэнэ. Айдас, хяналт хэзээ ч биднийг аюулгүй болгодоггүйтэй адил, дүрэм биднийг хэзээ ч чөлөөлөхгүй. Биднийг хүрээлэх бүх худлаас илүү томоор цацрах үнэн л биднийг чөлөөлнө. Үнэн – аймшигтай гутрал, гонсролоор дүүрэн урт, муухай шөнийг халах үүрийн гэгээ юм.

Хэнд нэгэнд үгээ сонсгохыг хүсбэл, түүхээр өгүүл гэж ярьцгаадаг. Олон жилийн өмнө балчир хөвгүүдээ унтуулахаар үлгэр ярьж өгдөг байхдаа би энэ үнэнийг мэдсэн юм. Энэ маань шинэ адал явдлыг туулахаар баруун зүгээс хөдлөсөн, анхдагч гэр бүлийн хөгжилтэй, хөгтэй түүх байв.

Хөвгүүдээ унтах хүртэл нь зохиож өгнө. Тэр зуур хөвгүүд маань унтаж, сэрээд л зүйрмэглэн сонсоно. Би ч бас хөвгүүдтэйгээ адил унтаж, сэрээд л

~ Бурхан чиний хатуу ширүүнээр хүчлэн сэрээсэн зүйлийг чинь тайвшруулаад, буцааж нойрсуулахын тулд үлгэр ярьж өгөхийг хүсч байгаа гэдэгт би итгэдэг.

зүйрмэглэн ярина. Тэгээд унтаад өгбөл, сэрүүн байгаа нь намайг сэрээгээд, залруулж өгдөг байж билээ. Өнөөдөр хөвгүүд маань тэр түүхийг надаас ч илүү тод санадаг нь гайхмаар.

Яагаад үүнийг ярина вэ гэж үү? Яагаад гэвэл Бурхан чиний хатуу ширүүнээр хүчлэн сэрээсэн зүйлийг чинь тайвшруулаад, буцааж нойрсуулахын тулд үлгэр ярьж өгөхийг хүсч байгаа гэдэгт би итгэдэг. Цагаас нь өмнө хүчлэн сэрээсэн дур хүслийг чинь оронд нь хэвтүүлээд, бүүвэйлэн нойрсуулж амрах түүхийг. Айдас номхорч, найдвар сэргэдэг түүхийг. Шившиг үгүй, бүх юмс хаврын борооны дараах шиг шинэ соргог байдаг Тэнгэрийн түүхийг.

Тэгэхээр, тийшээ хөдлөхөөсөө өмнө бүгдээрээ залбирья:

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,
Та бол тэнгэр, газрын Бүтээгч. Түүнчлэн дотно янаг
байдлын Зохиогч. Миний амьдралд цагаас нь өмнө сэрээчихсэн
зүйлс байна. . . амарч гүйцээгүй, зүүдлэж дуусаагүй байхад нь
цагаас нь өмнө сэрээж, хүчлэн бадраасан сексийн асуудал. Энэ
талууд дээр минь эдгэрлээрээ хүрэлцээч. Энэ номыг уншиж
байхад, Таны үнэний гэрэл тусч, энэ талбар дээрх сүүдрийг
сарниах болтугай.*

*Үүнийг Та л хийнэ. Учир нь Та бүгдийг мэддэг, хүчирхэг
Бурхан. Таныг танин мэдэж, Таны замаар алхахын
тулд зүрхний минь нүдийг нээгээч. Амрах ёстой асуудлыг
амраагаач. Айдсыг сарниаж, жигүүрийнхээ аюулгүй байдал
дор намайг хамгаалаач. Зүрхийг минь нээж, надад түүхээ
ярьж өгөөч. Тэр цагт би Таны зорилгыг мэдэж, ойлгох болно.*

Таны хайрт охиноос.

2 Бид хаана байна?

Өнгөрсөн бүлгээрээ бид Өндөр Бурханы охид, хөвгүүд – бидний амьдралд байдаг, бэлгийн эмгэнэлийн талаар ярьсан билээ. Гэхдээ бид яаж яваад ийм цөхрөл, хүчирхийлэлд өртдөг вэ? Хийсэн ганц алхам маань л энэ хүчирхийллийн замд оруулдаг уу эсвэл олон алхам оруулдаг уу? Эрхэм нандин зүйлийг минь хулгайлаад, хүчгүй бөгөөд чармай нүцгэн үлдээсэн тэдгээр нөхөдтэй бид өөрсдөө далжигнасан уу? Яаж яваад бүсгүй чанарын гоо үзэсгэлэн, бэлгийн нууц маань ийм хямдхан бөгөөд хэвийн зүйл болж хувирав? Бид яаж яваад, хүүхэд насны шидэт үлгэрээс зовиур, шившигтэй хар дарсан зүүдний сүүдэр, цөхрөлд орчихов?

Бид хар шивнээ, худалд анхаарах үед зүүд маань хар дарсан зүүдэнд зам гаргаж өгөөд, чих зүрхийг маань гудамжинд хашхиран дуудах Цэц ухааны дуу хоолойгоос (Сургаалт үгс 1:20) тасладаг. Бид үнэ цэнэтэй зүйлийг үнэ цэнэгүйд тооцон, зохисгүй арга замаар хангах гэж оролдох үед зүүд маань хар дарсан зүүд болж хувирна. Бид найдвар, мөрөөдлөө айдсаар үргээлгүүлж, биднийг зам дээр маань хөшөөхийг зөвшөөрөх үед зүүд маань хар дарсан зүүдэнд бууж өгдөг (Иошуа 1:9).

Би өнөөгийн баримтуудыг гаргаж тавьж, *статистикийн* баримт мэдээг цохон тэмдэглэмээргүй байна (салсан гэр бүл, өрх толгойлсон эмэгтэйчүүд, насанд хүрээгүй атлаа бэлгийн харилцаанд орсон хүүхдүүдийн тоо, хувь зэрэг). Ийм баримтыг чи өөрөө ч олоод үзчихэж болно. Би чиний тархи,

~ Яаж яваад бүсгүй чанарын
гоо үзэсгэлэн, бэлгийн нууц
маань ийм хямдхан бөгөөд
хэвийн зүйл болж хувирав?

оюунтай бус, зүрхтэй чинь ярьмаар байна. Би эмэгтэйчүүд бидний *сүнсний* байр суурийг илчилмээр байна: Бид хар дарсан зүүдэндээ шалдан хэвтэж байна.

Дэлхий даяарх эмэгтэйчүүд бүгдээрээ л: “Би ийм зүйлийг хармааргүй байна. Би хувцсаа өмсмөөр байна! Би нэр хүндээ, хүндэтгэлээ, нууцаа сэргээмээр байна. Би айдсыг жадлаж хаямаар байна. Би хүчтэй бөгөөд чөлөөтэй баймаар байна!” хэмээн хашхирч байна.

Бид дуулгаваргүй хүүхдүүд шиг байгаа учраас, хар дарсан зүүдэнд амьдарч байна. Бид тэрслэл биднийг чөлөөлнө гэдэгт итгэсэндээ худалд итгэжээ. Тийм боловч эцсийн эцэст хайрын хууль зөрчигдөх үед эмэгтэй хүмүүс л хамгийн их зовдог. Энэ бол шинэ зөрчил биш... олон жилийн тэртээ Еден цэцэрлэгт могой эмэгтэйд: “*Бурханы өөдөөс тэрслэ. Тэгвэл чи ухаантай бөгөөд чөлөөтэй болно!*” гэж шивнэх үед энэ явдал болсон юм. Тиймээс бид жимсийг аваад, идээд, нүдээ аниад, хэсэг зуур хоронд нь мансуурав. Тэгээд нүдээ нээхдээ, нэг л биш байгааг мэдэрсэн. Бид нүцгэн бөгөөд ичгүүрээр будагдсан байгаагаа мэдсэн. Бид Адам руу хартал, тэр ч бас нүцгэн бөгөөд өөрийнхөө асуудалтай зөрчилдөөд бидэнд туслаж, биднийг сэргээхтэй манатай л байв. Ичсэн хүн хүн ална гэгчээр, Адам нүүр хийх газаргүй болсондоо эргээд биднийгээ буруутгав!

Тиймээс эр, эм хоёр нүцгэний ичгүүрээ нуухын тулд Бурханыг Еденд бууж ирэхээс өмнө зугтаад, Бурханыг ирэхэд эцэс төгсгөлгүй буруутгал эхлэсэн юм:

- Адам: “Өнөөх эмэгтэй, надтай хамт байлгахаар Таны надад өгсөн тэр л надад нөгөө модны жимснээс өгсөн. Тэгээд л би идсэн”
(Эхлэл 3:12).
- Ева: “Тэр могой, тэр л намайг мэхэлснээс болоод би идсэн”
(Эхлэл 3:13).
- Бурхан: “Би тэр эмэгтэй та хоёрын хооронд, Бас чиний үр, тэр эмэгтэйн үрийн хооронд дайсагнал үүсгэнэ. Тэр үр толгойг чинь бяцалж, түүний өсгийг чи няцална гээд эмэгтэйд Өөрийн чинь жирэмсний бэрхшээл зүдүүрийг Би бүр ихэсгэнэ. Өвдөж зовж чи үр хүүхдээ төрүүлнэ. Эр нөхрөө чи эрмэлзэнэ, Эр чинь чамайг эзэгнэнэ” (Эхлэл 3:15–16).

Адам эмэгтэйг ч, Бурханыг ч *буруутгаж* байгааг хараарай. “Таны

надад өгсөн эмэгтэй.” Энэ чинь одоо юу гэсэн үг вэ? Нөгөө “Махны минь мах, ясны минь яс” (Эхлэл 2:23) гээд байсан баярт мэдэгдэл яав? Адам хандлагаа эрс өөрчилжээ! Энд үнэхээр ямар нэгэн зүйл болжээ... тэд цаашид нүцгэнээсээ ичдэг болсон учраас, хоёр нь нэг байхаа больжээ. Ичгүүр нь хэдийнээ салган бутаргах ажлаа хийж, тэднийг хуваажээ.

~ Эцсийн эцэст хайрын хууль зөрчигдөх үед эмэгтэй хүмүүс л хамгийн их зовдог.

Тэгтэл эмэгтэйгээс байцаалт авахад, тэр үнэнээ л хэлсэн: “Би хууртаад, идчихсэн.” Түүний үгээс буруутгал биш, харин харуусал, гашуудал сонсогдож байна. Тэрбээр ямар алдагдалд орсноо их бага хэмжээгээр ойлгожээ. Тэрбээр үеийн үед могойтой дайсагнах болно. Тэр нөхрийгөө хүсэв ч, нөхөр нь түүнийг захирна. Энд л хамгийн анх хайрын бус, хуулийн (сайн, муугийн мэдлэгийн хуулийн) санаа цухалзжээ. Учир нь хууль нь нэхэж, түрэмгийлдэг бол, хайр нь үлгэрлэж, өгдөг юм.

Адамтай адил эрчүүд мэдрэмж, хүчгүй байдалтайгаа зөрчилдөхдөө, эмэгтэйчүүдэд хянан захиргааддаг объект шиг л хандах нь олонтаа. Тэд энэ хяналтаа зарим газар хууль тогтоох маягаар, зарим газар нь хуульгүй авирлах маягаар хэрэгжүүлдэг. Тэд эмэгтэйчүүдийг байлдан дагуулж, хянан захиргаадаж эсвэл ашиглаж болдог эд юм шиг л дорд үзнэ.

Тэгээд тэмцэл эхлэв. Эрх хүчний энэ тэмцэл дунд эмэгтэйчүүдийн эрэгтэй хүний дүүргэлт, туслах байх анхны хүндэт эх үүсвэр, эр хүний батлан хамгаалагч, тэжээгч байх хүчирхэг дүр төрх алдагджээ. Дахин бүрэн бүтэн болох гэсэндээ шархтай Адам, Ева хоёр бүрэн бүтэн байдлыг бие биеэсээ бус, гаднаас олохоор гадагшаа харжээ. Эвдэрсэн эрчүүд толгойгоо ижил хүйсийн явдалд алдаж, эрэгтэй хүн эрэгтэй хүнтэйгээ нэгдэн, бүтэн бие болж болно гэсэн амлалтад итгэн, эрээгээ алдав. Гэхдээ энэ хэзээ ч бүтэхгүй. Юм бүтэн болохдоо, амийг авчирдаг. Эрэгтэй хүн эрэгтэй хүнтэй хэзээ ч бүтэн болохгүй, эмэгтэй хүн ч эмэгтэй хүнтэй бүтэн болохгүй.

~ Хууль нь нэхэж, түрэмгийлдэг бол, хайр нь үлгэрлэж, өгдөг юм.

Нүглээс өмнө Адам бүх бүтээлийг төгс сүр жавхлангаар нь судлахдаа, энэ дундаас түүнд хань болох амьтан алга гэж хэлсэн бол, Еватай учрахдаа л түүнийг өөрийнхөө хань мөн байна гэж таньсан байдаг. Чөлөөт хүн Адам, үзэсгэлэнт хэсэг болох Еватайгаа ялагдашгүй байсан учраас, Сатан үүнийг нь зүгээр харж тэвчээгүй юм. Тиймээс Сатан төгс бөгөөд цэврийг Бурханы сайн чанар, цэц ухаанд эргэлзүүлэх асуултаар завхруулжээ. Тэрбээр Еваг хориотой жимсийг идтэл мэхлэж, Ева ч хажуудаа чимээгүй

зогсох Адамд өгч идүүлжээ. Тэгээд худлын эцэг, ёрын Сатан тэднийг Бурханы оршихуйгаас урхидан зайлуулаад, явцдаа байр суурь, эрх мэдэл, хүчээс нь салгасан юм.

Дараа нь Сатан тэднийг бие биеийнх нь дайсан хэмээн, шархыг нь хувилуулжээ. Ууртай, том эрчүүд – шархтай, ууртай эмэгтэйчүүдийн хоорондох энэ зөрчил өнөөдөр ч үргэлжилсээр. Гэхдээ эрэгтэйчүүд ч, эмэгтэйчүүд ч энэ шархаа эдгээж чадахгүй. Гагцхүү Бурхан л биднийг дахин сэргээж, зүүдний маань цэцэрлэгт дахин суулгаж чадна.

Эмэгтэй, могойн хоёрын хооронд эш үзүүлсэн зөрчил ч (Эхлэл 3:15)

өнөөдөр үргэлжилсээр байна. Бурханы охид оо, Адамын газрын хөвгүүд чамайг энэ могойноос аврахгүй. Гагцхүү тэнгэрийн Ханхүү л аварна. Могой хэзээд ганц л зорилготой байсан: Евагийн охидын нандин чанар, хүч, хүндэтгэлийг нүцгэлж хаяад, тэднийг ямар ч бүл чадалгүйд

~ Бурханы охид оо, Адамын газрын хөвгүүд чамайг энэ могойноос аврахгүй. Гагцхүү тэнгэрийн Ханхүү л аварна.

тооцуулах. Могой энэ ажлаа зарим газар охидыг хувцсаа тайчиж, гоо үзэсгэлэнгээ бүгдийн нүдэнд ил болгохыг уриалах маягаар хуульгүй задгай явдлаар хийдэг бол, зарим газар нь эмэгтэйчүүдийг үл үзэгдэгч болгох гэсэндээ зулайнаасаа ул хүртлээ сүүдэр мэт хар хувцсаар хучсан хуулиар хүчирхийлдэг. Тийм боловч эмэгтэй хүн баглаатай байна уу, нүцгэн байна уу – байнга ичгүүрийн бай болж, түүний гоо үзэсгэлэнг эрчүүдийн тачаал, асуудлын хамаг л уул уурхай мэт үздэг.

Гэхдээ эмэгтэйчүүд нэр хүндээсээ нүцгэрч, доош орбол, эмэгтэй хүн нь эр хүний алдар учраас (1Коринт 11:7), эрчүүд ч ялгаагүй ичгүүрт унана. Эр хүн түүнийг тайчихдаа, өөрийгөө л үл хүндэтгэж байгаа хэрэг.

Тэрбээр Бурханаас заяасан, эмэгтэй хүнийг хамгаалах хүслээ алдахдаа, давхар жинхэнэ эрх мэдлийн төлөөх зорилгоо ч алддаг. Эмэгтэй хүн хүч, хүндэтгэлийн хувцсаа тайчуулах үед эрчүүд жинхэнэ булчинлаг эрх мэдлээ тайчуулдаг.

~ Эмэгтэйчүүд нэр хүндээсээ нүцгэрч, доош орбол, эмэгтэй хүн нь эр хүний алдар учраас (1Коринт 11:7), эрчүүд ч ялгаагүй ичгүүрт унана.

Бүсгүйн чанар эрхэм нандин хэмээн тооцогдохоо болихын цагт эмэгтэйчүүд

сэрэл өдөөлтөө хангахаар бохир хүч рүү эргэх өдөөлтөд өртдөг бөгөөд мэдрэмжийн хувцсаар гангалж эхлэдэг. Эмэгтэйчүүд бүсгүй хүний гоо үзэсгэлэн, хүндэтгэл, нэр хүндийн зорилготойгоо холбогдохгүй бол, бэлгийн мөлжлөгөд амархан өртөнө.

Харамсалтай нь бид өөрсдөө ч жаахан охиддоо ариун байдал, гоо

үзэсгэлэн, хүчний үлгэр жишээ болж чадсангүй. Энэ нь чухам ямархуу байдгийг бид өөрсдөө ч мэдэхгүй. Эргэн тойрондоо байгаа жаахан охидын байдлыг нэг хар даа. Хөх ч ургаагүй шахам байж, бэлгийн элдэв дүр зурагаар бөмбөгдүүлж байна. Тэд секс гэж юу байдгийг ч мэдэхгүй байж, “тачаангуй” хүүхнүүдтэй адил харагдах гэж оролдож байна. Жаахан охид гэлтгүй, насанд хүрсэн бүсгүйчүүдэд ч үлгэрлэн дагачихмаар, хүчтэй атлаа цэвэр ариун дүр зураг сонин, сэтгүүл дээр бараг л гарахгүй.

Энэ зөрчлийн цаана үнэндээ юу байгааг чи харах болтугай: Могой чамайг хүч, нандин чанар, хувцасгүй болгожээ! Чи үүнийг ойлгоод, жигших ёстой. Учир нь зөвхөн тэр цагт л чи жинхэнэ дайсантайгаа дайтах зоригтой байж, итгэмжтэй бөгөөд жинхэнэ Хаантайгаа бүрэн нэг тал болно. Чи өөрийнхөө нүцгэн байдлыг сүр жавхлантайя далдлах хувцастай байх болно. Чи сэрээд, бид нөхрүүдтэйгээ юмуу эрчүүдтэй дайсангаагүй, харин сэтгэлийнхээ дайсантай дайтаж байгааг ухаарна. Бид хар дарсан зүүднээсээ сэрээд, зүүдээ сэргээхийн төлөө хашхирч эхлэнэ.

~ Энэ зөрчлийн цаана үнэндээ юу байгааг чи харах болтугай: Могой чамайг хүч, нандин чанар, хувцасгүй болгожээ!

Би чиний тэр сэтгэлийн хашхираанд чинь л... секс хангаж чадахгүй, тэр хоосон, нууц газарт чинь л хандаж яриад байна. Чи эр хүний өгч чадахаас илүү гүн хайр, дотносол, харилцааг хүсэн хайж байна. Чи газар дээр байдгаас илүү баталгаатай тэнгэрээр дутаж байна. Чи тэнгэрийн Ханхүүгийн хайрыг хүсч байна. Тэгээд чи итгэнэ үү, байна уу хамаагүй – гэхдээ надад чамд хэлэх нууц байна... Тэр Ханхүү ч бас чамаар дутаж, чамайг хүсдэг. Тэр Ханхүү л чиний зүрхний цөмд энэ хүслийн үрийг суулгасан бөгөөд Тэр л чиний зүрхний мөрөөдлийг хангаж чадна.

Бид энэ бүхнийг буруу газраасаа хайгаад байвал, хана мөргөсөөр л байна. Эрчүүд чиний асуудал ч биш, хариулт ч биш! Бид тэнгэр өөд харах хэрэгтэй. Учир нь бидний тусламж тэнгэр, газрыг бүтээсэн Бүтээгч – Эзэнээс маань ирдэг юм (Дуулал 121:1–2). Тэр цагт л бид эх үүсвэрээ олж, хүч, хүндэтгэлээ сэргээнэ.

~ Эрчүүд чиний асуудал ч биш, хариулт ч биш!

Зарим эмэгтэйчүүд яагаад эмзэг байдаг вэ? Мэдээж бид хуульгүй байдал, зөрчил газар авсан үед (Матай 24:12) аж төрж байна. Хуульгүй байдал захирахад хайр үхэж, хамгаалалт алдардаг. Нүгэл хийх хүсэл хүмүүсийг захирч эхлэх үед гэр бүлийн эмзэг тэнцвэр алдагдаж, эмэгтэйчүүдийн зүрх үйрдэг. Хүсэл нь хувьсан, байраа сольж, худал нь үнэн болж хувирдаг.

Өнөөгийн энэ байдлыг Ром номын дараах эшлэл дүрслэн хэлжээ:

Иймд Бурхан тэднийг зүрхнийнх нь хүсэл тачаалын бузар юмстай зөнд нь орхиж, тэд бие махбодоо өвөр хоорондоо гутаажээ. Учир нь, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүүгээр бүтээлд нь мөргөн, зарагджээ. Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен. (1:24–25)

Бид үнэнийг худлаар солин, амьд Бурханд бус, өөрийнхөө хүсэлд үйлчилж эхлэхдээ, бэлгийн цэвэр бус явдлыг өргөмжилдөг. Зүрх маань бэлгийн хүсэл дээр тогтоход, Бурхан биднийг дураар маань орхидог. Яг л Адам, Ева хоёрыг Цэцэрлэгт хүслээс нь хориогүй шигээ биднийг ч бидний хүслээс хорихгүй. Тэр бидний жинхэнэ хүсэл байхыг хүсдэг ч, бид өөрсдөө Түүнийг хүсэхгүй бол, хүсээд байгаа зүйл маань биднийг хохироох байсан ч хамаагүй – дураар минь явуулдаг.

Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхиж. Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж, эрчүүд эрчүүдтэйгээ ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна. (Ром 1:26–27)

Сэдэл маань амьдрал бус, таашаал болохын цагт яваандаа садар самуун, бэлгийн бохир явдлууд ч бидний дур хүслийг хангахаа болино. Хүсэл биднийг бүр л ичгүүртэй, бүр л завхарсан тачаал руу уруудуулсаар байна.

Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тул тэднийг Бурхан завхарсан сэтгэл болон хийх ёсгүй үйлдэлд нь орхижээ. (Ром 1:28)

Бид Бурханы мэдлэгийг эсэргүүцэх үедээ ёс суртахуун, ариун байдлаас дайжин мунхаг, завхарсан байдлыг л өвлөж авна. Энэ үед сайн зүйл алдагдаж, бид харанхуйд бүдэчсээр, муугаас улам муу руу уруудна. Бурхан л биднийг ийнхүү муутгаад байна уу? Яалаа гэж! Биднийг сэргээх нь Бурханы туйлын хүслэн. Үндсэндээ Бурхан бидний зүрхийг Өөрийн болгохыг хүсдэг. Гэтэл хэрэв бид хөлөө дэвслээд: “Түй ээ! Би өөр зүйлийг хүсч байна!” гэх юм бол, Бурхан гэдрэг ухраад, биднийг хүсээд байгаа мунхаглалаа бүрэн эдлэхийг зөвшөөрнө.

Эрчүүд эршүүд чанараа алдаад ирэхдээ, дахин эр хүн шиг болохын тулд бэлгийн адал явдалд гардаг. Эрчүүд гутаагдахаараа, дахин хүчтэй болохын тулд юу ч хийхэд бэлэн болно. Энэ үедээ тэд ааваараа, жинхэнэ удирдагч хүнээр харангаддаг боловч, тийм хүнийг олдоггүй. Даган дууриах бурханлаг үлгэр жишээ байхгүй учраас, тэд гутарсандаа сэтгэл санаагаараа бас ихэвчлэн биеэрээ үүрэг хариуцлага, гэр бүлээ хаяж явна. Үүнийг харсан эмэгтэйчүүд эрчүүдийн байрыг эзлэх гэж үзэв ч, чадахгүй учраас хоригдол болж хувирна. Дэлхий даяар эр хүний чанараа алдсан, ууртай эрчүүд хүчтэй гэдгээ дахин мэдрэхийн тулд эмэгтэйчүүд, хүүхдүүдийг дээрэлхсээр явна. Тэгэвч санаандаа хүрэхгүй.

Бурхан биднийг шийтгэхийг хэзээ ч хүсдэггүй.

Дуулгаваргүй байдал нь олзлол, илдийг л авчирдаг. Гэтэл Бурхан биднийг шийтгэхийг хэзээ ч хүсдэггүй. Бурхан эрх чөлөөг тунхаглахыг хүснэ! Түүний урилгыг сонсоно уу:

“Хүрээд ир, тэгээд хэлэлцье” гэж ЭЗЭН айлдаж байна. “Хилэнц нүгэл чинь час улаан мэт байвч цасан адил цагаан болно. Хүрэн лугаа улаан боловч ноос лугаа адил болно. Уриалгахнаар та нар дагах аваас Уул газрын сайныг иднэ. (Исаиа 1:18–19)

Бурхан биднийг бодолтой байж, нөхцөл байдлаа зоригтой бөгөөд үнэнээр нь харж, энэ бүхэн тийм ч сайхан биш гэдгийг ухаараасай гэж хүснэ! Бидний нүгэл ягаан биш... харин жаад хийсэн чарлаантай, цусан улаан өнгөтэй бөгөөд өөрийг нь хангах тахилын цусыг шаарддаг. Гэтэл Бурхан бидний улаан тахилыг хүсдэггүй, Ханхүү маань Өөрөө энэ төлөөсийг төлсөн билээ.

Бурхан биднийг цэв цэвэр болтол угаахыг хүсдэг. Биднийг хэзээ ч цагтахгүй, хоосон хоолоор (дотносол байхгүй секс, гэрээ байхгүй гэрлэлт) тэжээхийн оронд хэрэв бид хүсэлтэй бөгөөд дуулгавартай байвал, Бурхан

Энэ тулааны бай нь эмэгтэйчүүдийн зурх байсаар ирсэн бөгөөд Бурхан чиний эвдэрсэн, хөхөрсөн, шархласан зүрхийг чинь гуйж байна.

бидэнд газрын сор шимийг өгөхийг хүсдэг. Гэмших хүсэлтэй, буруу замаар явснаа хүлээх хүсэлтэй байвал. Сайн, итгэмжтэй, үнэн Бурханд үйлчлэх хүсэлтэй байвал. Хайр, амь, эрх чөлөөний хууль болсон Бурханы Үгэнд орох хүсэлтэй байвал. Загалмайгаа аваад, амиа махан бие болж ирсэн Үг – Христийн дотор нууж, Түүний үлгэр жишээг дагах хүсэлтэй байвал. Иоел биднийг юунд дуудсаныг үзнэ үү:

ЭЗЭН тунхаглаж байна. “Одоо гэлтгүй мацаг, уйлаан, гашуудал дор Над уруу зүрхээрээ эргэгтүн! Та нар хувцсаа биш, Харин зүрхээ урж тасчигтүн” Бурхан ЭЗЭНдээ эргэгтүн. Учир нь Тэрээр нигүүлсэнгүй, өршөөнгүй, Уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам, Шийтгэхдээ зөөлөрдөг. (Иоел 2:12–13)

Бурхан энэ үеийнхэнд хандан: *Хамаг найдвар чинь тасарч, өөрийгөө жигшиж, өөрийгөө үзэн ядаж байлаа ч, бүгд чамайг хөсөрдүүлж, яаж ч оролдсон бүтэлгүйтсэн байлаа ч, Би чамайг хөсөрдүүлэхгүй! Бүх зүйл хэдийнээ хожидсон мэт харагдаж байлаа ч, хождоогүй! Над руу бүх зүрхээрээ эргээд ир! Энэ тулааны бай нь эмэгтэйчүүдийн зүрх байсаар ирсэн бөгөөд Бурхан чиний эвдэрсэн, хөхөрсөн, шархласан зүрхийг чинь гуйж байна. Бурхан чамайг өнөөгийн аймигаас гараад, Өөрийнх нь зүүд рүү буцаж ороосой гэж хүсч байна.* Учир нь дэлхийн сууриас ч өмнө Бурхан чам шиг л сүйт бүсгүйг хайсан билээ. Бурхан газар сайгүй байгаа олзны эмэгтэйчүүдийг: “*Хонгор дүүдэй, сүйт бүсгүй чи минь Зүрх юуг минь догдлуулав. Халтихан ганц харцаараа Зүүлт ганцхан сондроороо Зүрх юуг чинь догдлуулав*” (Соломоны дуун 4:9) хэмээн дуудаж байна.

Чи Бурханы зүрхийг олзлосон бөгөөд эдүгээ Түүнд олзлогдож, зүрхээ олзлуул. Энэ номын хуудсан дээрх хайр, үнэнд зүрхээ нээгээд, дотроо амилуул. Бид дэлхийд үнсүүлэхдээ, нулимстай хоцорсон ч, Ханхүү маань одоо ч Өөрт нь хариу өгсөн хүмүүсийг дуудаж, илүү сайн сайхан зүйлсийг амлаж байна.

Хайрт минь надад хандаж өгүүлрүүн: —Сэрж босооч, хайр минь Цэвэрхэн ганц минь гарч ирээч. Өвөл нэгтээ өнгөрчээ, Бороо ч болиод татарчээ. Дэлхийд цэцэгс дэлгэрээд Жиргээн дуулиан жигдрээд Хүүрзгэнийн дуу нутагт маань дуулдаад...
(Соломоны дуун 2:10–12).

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Таны “Хэзээ ч хождоогүй шүү!” гэдэг дуу хоолойг сонслоо. Зүрхийг минь хулгайлаад, аюулгүй байлгаач. Худалд итгэж, Танаас буруулсныг минь уучлаач. Миний нүгэл цусан улаан гэдгийг би хүлээж байна. Тийм боловч Та намайг цасан цагаан болгохын төлөө Хүүгээ өгсөнд баярлалаа. Би Түүний асгарсан цусыг эрдэнэт цусанд тооцно. Миний үнэн байдлыг ухааруулсанд баярлалаа. Би нүцгэн, ичгүүртэй, аймхай байхаас залхаж байна. Би хувцсаа өмсмөөр байна! Би мэдрэмжийн, хуульгүй байдлын дүр зургаас буруулж, бүсгүй хүний агуулга дор Таны нуусан хүндэтгэл, хүч, нууцлал, эрхэм байдлыг дахин тэврэн авч байна. Намайг бүрэн төгс чөлөөтэй бөгөөд Таных байлгахын тулд хүлээстэй, худлаа амьдралын минь тал бүр дээр үнэнээ тогтоогооч.

Таны хайрт охиноос.

3 Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд

Өглөөний бүрийгээр Есүс гэдэг залуу раббигийн үгийг сонсох гэсэн түмэн олон сүмийн үүдэнд багширна. Эмэгтэйчүүд нар дээшлэхээс өмнө амжиж олны дунд сэм уусахгүй бол болохгүй. Есүс хуулийн бусад багш нараас тэс өөр байх бөгөөд айлдаж байхдаа сонсогчдынхоо дунд суугаад л ярина. Түүнийг өгүүлэхэд бас нэгэн үл үзэгдэх дуу сонсогдоно – Түүний ярианаас Бурхан Аавын үг дуулдана.

Тийм боловч Түүнийг хаа ч явсан хэл ам дагасаар. Есүсийг Бурханы хайраар чөлөөтэй ярихад, өвчтэй зовлонтой хүмүүс дээр эдгэрэл асгарна. Шашны удирдагч нар Түүнийг үзэн ядав ч, эгэл ардууд Түүнийг хайрлана. Эмэгтэйчүүд ямар ч асуудалтай зүйлтэй хутгалдаж үл болно. Эмэгтэйчүүдэд Түүнээс хол байхыг анхааруулав ч, эмэгтэйчүүд хол байж чадсангүй. Энэ өглөө чи Түүний оршихуй руу эсэргүүцэхийн аргагүй татагдав. Чи Түүний үгийг сонсохийн хүслэн болно... тэдгээр нь чиний зүрхнээс тэнхээ мэдэн хашхирах цөхрөлийн дууны үгс ажээ. Энэ ер бусын чимээгүй боловч, гэгэлзэн оволзох олны дунд чи Түүнийг тэсэн ядан хүлээнэ... Тэрбээр өглөө ирээд, заахаар амлажээ.

Өглөө эрт Түүнийг сүмд дахин ирэхэд хүмүүс бүгд Түүн уруу ирцгээв.
Тэр суугаад, тэдэнд зааж эхлэв. (Иохан 8:2)

Гэтэл гэгээ орж, тэнгэр зүйл бүрийн өнгөөр сүр жавхлантайяа туяарахтай зэрэгцэн Тэрбээр дагалдагч нартайгаа гарч ирэв. Араас нь нарны туяа гялбаад, дүр төрх нь тодорхой харагдсангүй. Цуглаан доторх хэдэн хүнтэй тэврэлдэн мэндчилснийхээ дараа Тэрбээр заахаар суулаа.

Чи ч гарах үг бүрийг нь олзлон, хамаг л зүрхээрээ сонсоно. Гэтэл алсын бараанаа хэрэг манджээ.

Есүсийн болоод дагалдагч нарын цаанаас өөр нэгэн бүлэг айсуу нь үзэгдэх. Ууртай дуу, бараан дүрсүүд нэгэн үл үзэгдэх юмыг чирч гулдагсаар. Сүмийн хашаанд орж ирмэгц нь чи тэр хүмүүсийг алдарт нөмрөгөөр нь шашны удирдагч нар болохыг нь танив. Тэд явсаар Есүс ба хурсан олны дунд хөндөлсөн зогсоод, нэг хүнийг Есүсийн хөлд навс хийтэл шидэх хүртэл хэрэг заргын “эзэн” харагдсангүй. Тэр нь нүцгэн биеэ орныхоо даавуугаар хагас хугас халхласан, халтар царайлсан эмэгтэй хүн байв. Түүнийг шууд л шившгийн хэвтрээс нь чирч авчирсан нь илт харагдана. Чи эрэгтэй нь хаана байгаа юм бол хэмээн гайхшрав. Удирдагч нар түүнийг газар хэвтүүлэлгүй, олны шившиг болгохоор хөл дээр нь зогсоолоо.

Завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйг Хуулийн багш нар ба фарисайчууд авчраад, голдоо зогсоолоо. Тэд Есүст —Багш аа, энэ эмэгтэйг завхайрч байхад нь үйлдэл дээр нь барьсан юм. “Ийм эмэгтэйчүүд уруу чулуу шидэгтүн” гэж Мосегийн хуульд тушаасан. Харин Та юу гэж хэлэх вэ? гэгцгээв. (Иохан 8:3–5)

Есүс ийм эмэгтэйд юу хэлэх бол? Түүний заяа хэрхэн эргэх бол? Удирдагч нар мэдээж түүнд санаа тавихгүй. Тэд дараах шалтгаанаар Есүсээс хариу шаардав:

Тэд Есүсийг буруутгах шалтаг хайхын тулд Түүнийг сорин ийнхүү асуужээ (Иохан ба).

— Есүс яриангүй буруутай энэ эмэгтэйн талаар юу хэлэх бол? Үхлийг шаардаж байгаа олонд ямар шүүх зааж өгөх бол?

Чи ч бас Түүнээс хариу хүсч байгаа. Чи тэр өдөр олны дунд байсан эмэгтэйчүүд шиг л Есүсээс хариулт харж байгаа. Есүс яриангүй буруутай энэ эмэгтэйн талаар юу хэлэх бол? Үхлийг шаардаж байгаа олонд ямар шүүх зааж өгөх бол? Мэдээж тэр бүсгүй

хавьгүй том хэргийн шалтаг л болжээ. Тэр нь Бурханыг доош хийх гэсэн эртний оролдлого байсан бөгөөд шашны удирдагч нар үнэндээ Есүсийг л унагах гэсэн ганц санаатай байв. Цааш умшгъя:

Гэтэл Есүс бөхийж, хуруугаараа газарт бичив. (Иохан 8:6b)

Анхандаа Есүс тэр эмэгтэй рүү харах ч, тэдэнд хариулах ч хүсэлгүй байв. Тэр зүгээр л доошоо суугаад, шороон дээр бичжээ. Бурханы хуруу бидний мэдлэгт зориулагдаагүй нэгэн зүйлийг шороон дээр буулгажээ. Ингэтэл шившиглэгдэж, айсан хүн Түүний харцыг жигшил гэж хүлээж авна гэдгийг Есүс мэдэж байсан болохоороо эмэгтэй рүү харсангүй. Тэртээ тэргүй түүнийг түмэн харц шүүж байхад, Есүс түүн дээр нь нэмэрлэхгүй. Магадгүй энэ явдал Есүст өнө эрт Цэцэрлэгт нүцгэнээ нуух гэж оролдсон өөр нэгэн эмэгтэйг санагдуулсан байх.

Харин тэд зогсоо зайгүй асуусанд Есүс цэх зогсоод, тэдэнд —Та нарын дундаас нүгэлгүй нь эхлээд энэ эмэгтэй уруу чулуу шид гээд, Тэр дахин бөхийж, газарт бичив. (Иохан 8:7–8)

Алдрын Хааныг газар дээр бичиглэж байх хооронд сайн, муугийн талаарх яллагч дуу хоолой өөрийгөө хангахаар орилж байв. Магадгүй тэдний дуу хоолойноос Есүс могойн яллагч дууг сонсоо байх: *Чи наадахаа нөмөрч болно. Гэхдээ би Чиний нөмөрснийг дахин нүцгэлж, дахин шившиглэнэ! Тэр хэзээ ч сурахгүй. Тэр Чиний гарт үхэх ёстой... хууль ийм!* Есүс энэ удаа могойн ялд хариулсангүй. Есүс удахгүй могойг нэг мөр шийдвэрлэх л болно. Тиймээс энэ удаа Есүс зүгээр л өмнө нь зогсож байгаа яллагч нарт л хариулна. Тэгээд нүгэл үйлдэж яваагүй хүн нь түрүүлж чулуу нүүлгээрэй гэж хэлчихээд, буцаад бичгийнхээ ажилд оржээ. Чи энэ явдлыг амьсгаа түгжин ажиглана.

Үүнийг сонсоод, тэд ахмадуудаасаа эхлэн нэг нэгээрээ гарч явсаар ганц Есүс л үлджээ. Өнөөх эмэгтэй тэндээ зогссоор л байв. (Иохан 8:9)

Нэг нь л түрүүлээд шидэхэд, бусад нь дагаад шидэх байв. Гэтэл тэнд байсан хүмүүсийн хэн нь ч чулуу шидэж чадаагүй... эсвэл тэнд Хэн Нэгэн байв уу? Тийм ээ, тэнд Хэн Нэгэн байсан. Есүс Өөрөө ширхэг ч нүгэлгүй атлаа тэр эмэгтэй рүү чулуу нүүлгэхээс татгалзсан. Тэр цорын ганц зөвт шүүгч боловч, эмэгтэйг яллалгүй, аварчээ.

— Есүс Өөрөө ширхэг ч нүгэлгүй атлаа тэр эмэгтэй рүү чулуу нүүлгэхээс татгалзсан.

Яллагч нарыг бүгдийг нь явж одтол, Есүс чимээгүй л сууна. Нүгэлдээ будагдсан тэд дөнгөж сая түмэн амьтны нүдэн дээр Есүсийг унагах гээд чадаагүйдээ шаралхан, хэлэх ч үггүй – нэг талаараа магадгүй нүүр хийх

газаргүй болоод уван цуван одоцгоожээ.

Есүс тэнд байгаа ялагч дуу хоолойг бүгдийг нь арилсны дараа л эмэгтэйд:

Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд тэр — Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс — Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ.] (Иохан 8:10–11)

Есүсийг босч ирээд ярьтал эмэгтэй үг хэлээгүйг ажигласан уу? Тэр Есүсийн *өөрийнх нь талаарх үгэнд ханаагүй*, харин Түүнийг *өөрт нь хандаж яриасай* гэж хүсчээ. Ялагч нарыг явж дуусмагц эмэгтэй нуугдахаар сүүдэр рүү гүйж болох байсан ч, тэр Есүсийн өмнө шившигтэй, нүцгэн чигээрээ л хүлээсэн. Тэр сүүдрийн амьдралаас залхжээ. Тэр уучлал, чөлөөлөлтийг хүссэндээ үлджээ. Эмэгтэй Есүсийн үгийг сонссон болохоороо... олны өмнө бүхий л ялын асуудлаас чөлөөлөгдөн, уучлагдаж, үхлээс чөлөөлөгдсөн болохоороо, одоо явж болно. Тэрбээр эдгээр бэлэгийг хүлээн авсан болохоороо, эдүгээ нүглийн амьдралаа хаях хүчтэй болжээ.

~ Тэрбээр Есүсийн мэлмийгээс уучлал, өршөөл, хайрыг тэгээд бас нэгэн зүйлийг олж харав — шаналлыг юм болов уу?

Эмэгтэй толгойгоо өргөөд Есүсийн харцгай мөргөлдөв. Тэрбээр Есүсийн мэлмийгээс уучлал, өршөөл, хайрыг тэгээд бас нэгэн зүйлийг олж харав — шаналлыг юм болов уу? Цуглаан дунд зогсож байгаад болсон явдлыг мэдэрсэн нэгэн эмэгтэй гарч ирээд, нүцгэн эмэгтэйг өөрийнхөө дээл хувцаснаас

илүүчлэн нөмрөө байх. Магадгүй тэр эмэгтэй нь чи байх. Уучлагдсан эмэгтэйг хэдхэн минутын өмнө чирэгдэж ирсэн гудмаараа чимээгүйхэн буцахад, эргэн тойрон нам гүм байна. Нар хэдийнээ гэрэлтэж, тэр эмэгтэйн хувьд шинэ найдвар, амлалтыг тээсэн цоо шинэ өдөр эхлэжээ. Түүнийг явахад Есүс чимээгүй байлаа.

Тэгээд Есүс тэдэнд дахин — Ертөнцийн гэрэл бол Би байгаа юм. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав. (Иохан 8:12)

Тэр эмэгтэй одоо үхэл, харанхуйн охин бус, харин амь, гэрлийн охин болжээ. Тэрбээр Израилийн охин байсан учраас л шашны удирдагч нарын шүүх дор оржээ. Тэрбээр гэрээг эвдэж, нүглийн хоригдол болжээ. Гэхдээ энэ итгэмжгүй охин өршөөлт Ханхүүтэй учирч, цоо шинэ хүн болов.

Өршөөлгүй дайсан энэ үеийн эмэгтэйчүүдийг ариун Бурханы өмнө нүцгэн шалднаар нь чирч гулдачсаар авирч байна. Өнөөдөр ч могой Ханхүүг бидний шившгээр элэглэдэг: “Ийм завхай, садар охидоо Та яана? Тэд чинь Тантай гэрээ байгуулаагүй билүү? Тэгээд яахаараа ийм хурдан дэлхийн өвөрт орчихдог билээ? Та тэднийг хэдий болтол уучилж, үхлийн ялаас чөлөөлөх гээв?” Элэг эмтэрсэн Ханхүүд маань үүнээс хүнд асуулт байх уу? Түүний хувьд нэг л хариулт бий: *“Би чамайг яллахгүй. Яв, үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд!”* Тэр бидний нүглийг хараад, ингэж л хариулдаг гэдэгт би итгэдэг. Яагаад гэвэл Еврей 13:8 дээр *“Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ”* гэсэн амлалт бий.

Түүний үг, амлалтын учир эмэгтэйчүүд бид үнэхээр яваад, дахиж нүгэл үйлдэхгүйн тулд босоод, өөрийнхөө ч, бие биеийнхээ ч нүцгэнийг нөмрөх цаг нь иржээ. Энэ амлалт, хүчийг шившгийн олзонд байгаа охидод тунхаглах цаг нь иржээ.

Учир нь бүх хүнд аврал авчрагч Бурханы нигүүлсэл үзэгдэж, сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг үгүйсгэхийг, мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд сургадаг. Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхлант илэрхийллийг хүлээдэг.

Тэр Өөрийгөө бидний төлөө өгсөн нь биднийг алив ёс бус явдлаас золин, сайн үйлсэд зүтгэгч тусгай ард түмнийг Өөртөө цэвэршүүлэхийн тулд юм. (Тит 2:11–14)

Энэ бол гайхамшигтай мэдээ! Нүгэл бидний дээр эрх мэдэлгүй болсон. Бид нүглээс эргээд, үгүй гэж хэлж чадна! Есүс бидэн дээгүүр өршөөлөө сунгаад, Бурханы нигүүлслээр биднийг хүчжүүлжээ. Бид уучлагдаж, үхлээс амь руу шинээр төрсөн. Хайрт охид минь, сэтгэлийн чинь дайсан та нараас үүнийг л тас нуудаг. Тэр та нарыг нүглийн боол хэвээрээ байгаа гэж хэлдэг ч, энэ худлаа юм. Мэдээж бид өөрийнхөө хүчээр зүтгэбэл, гарцаагүй бүтэлгүйтнэ. Гэхдээ бид энэ тулаанд ганцаараа тулалдаагүй. Бид Есүсийн дотор байгаа бөгөөд зэвсэг маань хүчирхэг!

Эдүгээ бид эрх чөлөөтэй бөгөөд ирээдүйн талаарх сүр жавхлантай найдвартай болсон. Бид Эзэн бөгөөд Аврагчийгаа эргэж ирнэ гэхээс айхгүй. Учир нь Тэр биднийг муу бүхнээс аварч, Өөрийн болгосон. Үүнээс өмнө бид муу ёрыг хийхгүй л бол, болдоггүй байсан бол, одоо сайныг

~ Нүгэл бидний дээр
эрх мэдэлгүй болсон.

хийхгүй л бол, болохоо байж! Биднийг жинхэнээсээ дахин төрөхөд, төрөлх хүслүүд маань өөрчлөгджээ. Тэр биднийг уучилж, “Яв, дахин нүгэл бүү үйлд” гэдэг үгээрээ бидний мөн чанарыг өөрчилжээ. Энэ нь уучлалын өмнөх нөхцөл биш юм. Уучлал хэдийнээ ирсэн. Энэ нь итгэлтэй байдлын санал бөгөөд илүү дээр зүйлст итгэх явдал юм. Дахин төрөхөөс минь өмнө надад садар самуун, архи сайхан л байдаг байлаа. Би энэ цагийг хүсэн хүлээдэг байлаа. Би эдгээрт хүсэн тэмүүлдэг байлаа. Гэтэл дахин төрсний минь дараа миний энэ нүглийн жолоо зайлсан билээ.

Над шиг ялтай эмэгтэйчүүдэд Есүс нэг иймэрхүү үг хэлдэг: “Би чамайг яллахгүй... Би чамайг нүглийн ял, шүүхээс уучилж, чөлөөлж байна. Одоо яв... тэгээд дахин нүгэл бүү үйлд. Чи чөлөөтэй!” Бид ийм өршөөл хүртэх ямар ч зохисгүй хүмүүс. Бид бас Бурханы нигүүлсэлгүйгээр хэзээ ч дэлхийг эсэргүүцээд, бурханлаг байдал дотор явж чадахгүй. Нүгэл биднийг эрхшээхээ больсон. Учир нь:

Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун. (Галат 5:1)

Цэх зогс! Чамайг дахин нүглийн амьдрал руу урвуулахыг оролдох ял бүхний эсрэг бат зогс. Бурханлаг бус явдалд үгүй гэж хэлэх эрхийг чинь хөндөж байгаа өнгөрсний шившиг болгоны сүүдрийг эсэргүүц. Магадгүй өмнө нь чи ял, ичгүүрт үгүй гэж хэлж чаддаггүй байсан бол, одоо чи өнгөрснөөсөө суллагдсан бөгөөд *өнгөрсөн чинь чиний ирээдүй биш!* Чамд эрх чөлөөтэй, гэрэлтэй ирээдүй байна!

Бос, гэрэлт. Учир нь гэрэл чинь ирж, ЭЗЭНий алдар чиний дээр мандаж байна. Үзэгтүн, газрыг харанхуй, Хүмүүсийг гүн харанхуй бүрхэнэ. Гэвч ЭЗЭН чиний дээр мандаж, Алдар нь чиний дээр үзэгдэнэ. (Исаиа 60:1–2)

Нүглийн сүүдэр дороос гарч, Түүний гэрэл рүү орох цаг иржээ. Бидний ялагч нар Түүний өмнөөс үг дуугүй гарч явах л болно. Тэр одоо ч босоод: “Би чамайг яллахгүй. Одоо энэ харанхуйгаас гар! Чиний хайгаад байгаа гэрэл чинь Би байна. Тиймээс дахин нүгэл бүү үйлд” гэдэг. Гэхдээ бид энэ боломжгүй хэмээн айдаг. Яагаад гэвэл эргэн тойронд тас харанхуй байна. Үүнд Тэр: “Чи газар дээр бас газрын хүмүүс дээр харанхуй байхыг харж байгаа. Гэхдээ Би чиний нөмрөг – Гэрэл” гэдэг. Бидний Цэцэрлэгт алдсан нөмрөг – алдрыг Есүс сэргээсэн билээ.

~ Шашин бидний
нүцгэнийг халхлахгүй.

Шашин бидний нүцгэнийг халхлахгүй. Эрэгтэй хүн бидний нүцгэнийг халхлахгүй. Гагцхүү Тэр л бидний нүцгэнийг тансаг, цэвэр, цагаан давуугаар хучна.

Чи харж, сүрдэн гэрэлтэх бөгөөд Далайн баялаг чинийх болж,
Үндэстнүүдийн хөрөнгө чамд ирэх учир Зүрх чинь чичрэн баясна.
(Исаиа 60:5)

Бүгдээрээ завхайрч байгаад үйлдэл дээрээ баригдсан нэргүй эмэгтэй рүүгээ эргэе. Тэр хэн ч байсан байж болох учраас, нэрээрээ дурьдаагүй ажээ. Учир нь бидний хэн ч нүгэлгүй биш бөгөөд бид бусдад таалагдахын тулд эрчүүдтэй, шашинтай юмуу дэлхийтэй нэг оронд амархан явж ордог. Гэхдээ тэд биднийг гонсойлгоно. Эцсийн эцэст нүгэл, шашин хоёр чамаас урвана. Есүс олны шившиг болсон тэр эмэгтэйд нэр нүүр, хүч, хүндэтгэл хайрлажээ. Есүс хараажийн зүйлсээс давж хараад, түүнийг өнөөгийнх нь нөхцлөөр мөнхөд дүгнэхээс татгалзжээ. Үндсэндээ Есүс түүнд: “Өнгөрсөн чинь чиний ирээдүй биш! Яв тэгээд дахиж нүгэл бүү үйлд! Нүгэл – чиний өнгөрсөн, бурханлаг байдал – чиний ирээдүй. Ичгүүр – чиний өнгөрсөн, нэр хүнд – чиний ирээдүй. Нүцгэн байдал – чиний өнгөрсөн, сүр жавхлантай дээл – чиний ирээдүй!” гэжээ.

*Эцсийн эцэст нүгэл,
шашин хоёр чамаас урвана.*

Есүс тэр эмэгтэйд зүгээр нэг уучлаад өнгөрөөгүй... харин чөлөөлж явуулсан. Уучлал нь эрх чөлөөний эхлэл боловчиг, нүглийн хүслээсээ чөлөөтэйгээр цаашаа явах хүч үгүй бол, бид удалгүй дахиад л хүлэгдэнэ. Бид эхлээд өршөөлөөр тансаглаж, дараа нь нигүүлслээр бэхэждэг.

Учир нь та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа тул нүгэл та нарыг захирахгүй. (Ром 6:14)

Би нүглийг ялах хүчийн талаар заадаг шигээ нигүүлслийн талаар заагаагүй уджээ хэмээн эмээнэ. Бид Есүсийн хэлсэн дахиж нүгэл үйлдэхгүй байх тушаалыг биелүүлэх боломжтой гэдэгт итгэх зүрхээ гээгээд уджээ. Түүний дотор бас Түүнтэй хамт боломжгүй зүйл үгүй. Гэтэл бид Бурханы нигүүлслийг нүгэл үйлдэхгүй байх сүнсний өсөлт гэхээсээ илүү улам нүгэл үйлдэх лиценз болгосноороо, Түүний өршөөлийг шившиг болгожээ.

Өнөөдөр ч ариун нэртэй, амьд Бурханы Сүнс энэ дэлхийн охидыг:

Сэрэгтүн, сэрэгтүн. Сион оо, хүч чадлаар хувцаслагтун. Ариун хот Иерусалим аа, үзэсгэлэнт хувцсаа өмс. Учир нь, хозлуулагүй, бузар нь Цаашид чам уруу орохгүй. (Исаиа 52:1) хэмээн дуудсаар байна.

Охид оо, цаг хугацаа бодсоноос чинь богино байгаа учраас, сэр. Бурханы нигүүлсэл, баяр баяслыг өмс – учир нь эдгээр нь чиний хүч хат. Энэ хүч хат дээгүүрээ алдрын найдвар, сүр жавхлангийн дээлийг өмс. Тэнгэрийг мөрөөсч, газар дээр язгууртан шиг алх. Чи гэрээн дор байгаа учраас, зүрхлэж чадна. Хозлуулагүй, Гэрээний гадна байгсад нь чамд нэвтэрч чадахгүй! Өнгөрсний бэлгийн нүгэл, ичгүүр нь цаашид чамайг тодорхойлохгүй... чи эрх чөлөөтэй! Нүгэл, ичгүүр цаашид чамайг нууц газар хүчирхийлэхгүй.

Шороогоо гөвөөд бос, Иерусалим аа. Хүзүүн дэх гав гинжээ мултгал, олзлогдсон Сион охин оо. (Исаиа 52:2)

Эзэн: “Өнгөрсний шороогоо гөв. Ичэх зүйлгүй цэх зогсоод, эрх мэдлийн байр сууриа эзлэ. Би нүглийн атгыг эвдсэн. Чамайг цаашид энэ гинж биш, харин Би барина. Тиймээс хүзүүнээсээ тайлаад, өөрийгөө чөлөөл, Миний нандин сүйт бүсгүй!” гэж байна.

Бидэнд Түүний нигүүлсэл бий. Энэ нь биднийг хүчжүүлж, хүзүүг маань ороосон гинжнээс өөрсдийгөө чөлөөлөх хүчтэй болгоно! Хүлээсний хүч эвдэрсэн. Гэтэл бид чөлөөлөгчийн үгэнд бус, харин гинжний хүчинд итгэсээр байдаг. Би чамайг гинжлэгдсэн гинжээ харах бус, харин харагдахгүй байгаа зүйлсийг харахыг уриалж байна. Учир нь Тэр: “Өнгөрснийхөө гинжнээс чөлөөлөгд. Тэр гинжний барьц нь Миний барьцаас сул. Итгэ тэгээд гинжээ аваад хая!” хэмээн ятгаж бас амлаж байна.

Исаиа 52 бол миний Бичээс. Арваад жилийн өмнө би энэ үгийн амлалт, итгэлийн өмнө эмээн чичрээд, итгэлээр хавсрахдаа, айдсаас чөлөөлөгдөх аугаа эрх чөлөөг олсон бөгөөд энэ тухайгаа “*Out of Control and Loving It!*” гэдэг номдоо бичсэн билээ. Харин одоо үүнийгээ Өндөр Бурханы охид та нарт сексийн талбар дээр чинь үнэт амлалт, бэлэг болгон барьж байна.

Бидний хувьд үнэнийг мэдэх цаг ирсэн бөгөөд энэ үнэнээр өөрсдийгөө чөлөөлье! Бид үнэнийг, худлыг мэдэхээсээ дотно мэдэх ёстой. Худлын хүчийг эвдэхийн тулд би эвдэрсэн эмэгтэйчүүдийн

~ Гэтэл бид чөлөөлөгчийн үгэнд бус, харин гинжний хүчинд итгэсээр байдаг.

~ Бид үнэнийг, худлыг мэдэхээсээ дотно мэдэх ёстой.

амьдралд амь бөхтэй байдаг нэгэн бугуйлыг илчилмээр байна.

Энэ худал эмэгтэйчүүдийг дэндүү удаан хорьжээ. Энэ шалтгааны улмаас залуу охид сексийн тал дээр буулт хийсээр яваад, эцэстээ үгүй гэж хэлэх эрхгүй болсон мэт санадаг. Энэ шалтгааны улмаас эмэгтэйчүүд: “Би анхнаасаа түүнийг өөртөө хүргэхийг зөвшөөрчихөөд, одоо яаж үгүй гэх билээ?” гэж хэлэхэд хүрдэг. Мэдээж энэ шалтаг үүгээр дуусахгүй, үргэлжилнэ. Энэ шалтгаан залуу охидыг (ихэвчлэн онгон охидыг) хожим харуусах зүйл хийхэд албаддаг юм. Тэд гэртээ ирээд толинд харахдаа, хэдэн цагийн өмнө байсан цэвэрхэн, хөөрхөн төрхөө биш, халтаргаж, сэгсийсэн царайг олж харна.

Та нар уйлж байна уу? Ийм ичгүүрийг амссан ч, ямар ч хүчгүй санагдаж байсан хүн байна уу? Дэргэд чинь хэн ч байхгүй, чи ганцаараа. Хэн ч: “Гүйцээ! Түүнийг зүгээр орхи!” гэж хашхираагүй. Хэн ч чиний нэр хүндийг хамгаалаагүй.

Христэд итгэдэг хөгшин, залуу олон эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдийг бодохноо урьд өмнийн явдлынхаа ичгүүр, ялыг илүү хүндээр тусгаж авдаг учраас, тэдний хувьд үгүй гэж хэлэх бүр ч хэцүү байдаг. Тэд: Муу охид үгүй гэж хэлж чадахгүй гэдэг худалд итгэдэг. Тэгээд тэд би өөрөө л цэвэр байдал, нэр хүнд, хүндэтгэлээ уландаа гишгэсэн учраас, шившиг болж явахдаа таарна гэсэн дүгнэлтэд хүрдэг. Тэдний хувьд дотносол нь хориотой мөрөөдөл учраас, харанхуйдаа тэмтэцсээр явах нь дээдийн заяа ажээ.

Гэхдээ мэдээж энэ бүхэн худлаа юм. Завхайрч байгаад баригдсан эмэгтэйг харъя. Тэр буруутай юу? Буруутай! Тэр шүүгдэх ёстой юу? Ёстой! Тэр өнгөрснийхөө нүгэлд гацсан Сионы охин байсан уу? Байсан! Гэтэл Есүс түүнийг чөлөөлөхөөр ирсэн. Эмэгтэй “Яв, дахин нүгэл бүү үйлд” гэдэг үгийг сонсохоосоо өмнө өөрийгөө шившиг болж амьдрахдаа таарсан амьтан л гэж бодож явжээ.

Тэр явахдаа тэс өөр хүн болсон... тэр дахиж хэзээ ч урьдынх шигээ байхгүй. Тэрбээр ичгүүрийн гудмаараа буцахдаа нүүрэндээ амар амгалантай, нуруундаа ачаагүй явсан. Хажуугаар нь зөрж өнгөрөх олон түмэн түүнийг гайхсан нүдээр харна. Тэд түүнийг ингээд л дуусаа гэж боджээ... тэд түүнийг овоолгоотой чулуун дор үхсэн хэвтэж байгаа гэж боджээ. Энэ бол хууль! Гэтэл гайхамшигтай зүйл болж... шүүхийн дээр өршөөл ялж, тэрбээр амьдралаа цоо шинээр эхлэхээр уучлагджээ. Үнэндээ тэрбээр Есүсийн оршихуйд амиа алджээ. Есүс эмэгтэйн биеийг чулуугаар нүүлгэхийн оронд чулуун зүрхийг нь авчээ. Энэ нь өөрчлөгдөх бас л нэг бүтэлгүй оролдлого байсангүй. Тэрбээр гэртээ ирээд, усанд орж, хувцсаа өмсөв. Нүгэл, ичгүүр нь цаашид түүнд хамаатахгүй. Учир нь тэр өршөөл, нигүүлслийн цом болжээ.

Өндөр Бурханы охид та нарыг би худлаас эргэж, “Чи яллагдаагүй, харин

уучлагдсан” гэдэг Бурханы үнэнийг хүлээж авахыг урьж байна. Чи нүгэл, шившгийг ардаа орхиж, дахиж нүгэл үйлдэлгүй амьдарч чадна. Хамтдаа залбирцгаая:

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Надад зориулсан Таны үзэсгэлэнтэй Үг, амлалтад зүрх минь догдлон байна. Таны Үг мөнхийн гэдэгт би итгэж байна. Таныг өчигдөр, өнөөдөр, үүрд мөнхөд хэвээрээ Нэгэн гэдэгт ч итгэж байна. Та миний бүхий л бохир заваан нүгэл, ичгүүрийг үзэхдээ “Би чамайг яллахгүй!” гэдэг. Би шийтгүүлэх ёстой боловч, Та намайг уучилсан. Би Таны уучлалыг хүлээн авч, Танаар нүгэл, ичгүүрийн хувцсаа тайлуулж байна. Би өнгөрснөө гэмшиж, Таны зөвтгөлийг өмсөөд, бүхий л бурханлаг бус явдал, дэлхийн тачаалд эрс тэс “Үгүй!” гэж хэлж байна. Би одоо өөрийгөө хянаж, бурханлаг бөгөөд зөвт амьдарна. Би цаашид Тантай сүнсээр болоод биеэр уулзахаас айхгүй. Есүс Та намайг Өөрийн болгохоор муу бүхнээс авран сэргээж, цэвэршүүлэхийн тулд миний төлөө амиа өгсөн. Нүгэл намайг эрхиээхээ больсон учраас, би сайныг л үйлдэхийг хүсэн тэмүүлж байна. Та миний Аврагч бөгөөд Эзэн. Энэ номыг үзэж байхад, зүрхтэй минь зөөлөн яриач. Үүнийг Танаас өөр хэн ч хийж чадахгүй. Би хүлээсийн бүх гинжийг зайлуулж, ирээдүйгээ Танд даатгаж байна.

Таны хайрт охиноос.



4 *Хайр сэрсэн нь*

Долдугаар сарын намуухан сайхан орой байлаа. Би найзындаа зочилж, амттай сайхан оройн хоол идчихээд, харихаар давхиж явав. Хэн, хэний маань нөхөр гадагшаа явчихсан байсан учраас, бид хоёр зургаан хүүхэдтэйгээ найр хийсэн маань энэ. Хүүхдүүд маань гэрийнхээ үүдэн дээр хэдэн цаг наадаж, харин бид хоёр багуудынхаа нойрыг хүртэл довжоон дээрээ оддын дор шавайгаа ханатал хууч хөөрөв. Манай дөрөв ядарсан болтой, харих замдаа чимээгүй байлаа. Тэгж байтал нэг хүү маань хармаанаасаа хуурцаг гаргаж ирснээр нам гүм эвдэгдэв.

– “Ээж ээ, би энэ дууг сонсмоор байна.”

Тэгтэл тэр даруй арын суудалд дуу дуугаа авалцан эсэргүүцэл дэгдэв.

– “Үгүй ээ, наад дууг чинь сонсохгүй!”

– “Чи наад дуугаа хорин удаа сонсчоо биз дээ!”

– “Би наад удаан дууг чинь сонсохгүй!”

Тийм боловч миний хувьд зунжин зарим нэг Христэч рэппэрийн орилж чарласан, хүнд хүнд хэмнэлтэй дууг сонсож, чих амраагүй болохоор, ядаж л ийм намуун орой тэр уянгын дууг нь сонсьё л доо гэж бодогдлоо.

– “Чшшш, залуус аа, чимээгүй. Ээж нь наад дууг чинь сонсоогүй ш дээ. Ээж нь сонсьё л доо. Миний хүү тавь, тавь” л гэлээ.

Үүний маань хариуд мөнөөх эсэргүүцлийн авиа дахин хэд, хэд сонсогдоод намжив. Тэд надтай маргах ч тэнхэлгүй болжээ. Хүү маань кассетаа хийтэл, орчин үеийн Христэч хамтлагийн их л уянгалаг, халуун хайрын дуу эгшиглэв.

Хүү маань үг бүрийг нь, өнгө хэмнэл бүрийг нь цээжилсэн байгаа нь нүдний буланд туслаа. Хүү маань ягштал цээжилсэн болтой, чин

зүрхнээсээ даган дуулахыг нь үзээд, дотор жаахан тавгүйтээд явчихав. Тэр дуу дуучны үхэшгүй хайрын хүчийг, хайртай зүйлийнхээ төлөө амиа ч өгөхөд бэлэн гэдэг амлалтыг нь тунхаглаж байв. Энэ нь чин зүрхний амраг бүсгүйгээ хайрлах залуу эрийн андгай тангараг ажээ. Тийм боловч надад нэг л итгэл төрсөнгүй. Хэдийгээр ийнхүү баатарлагаар дуулах амархан ч, хэлсэн ярьснаараа амьдрах хэцүү гэдгийг би мэдэх насан дээрээ ирсэн хүн. Тэрхэн зуур өдий олон юм бодогдоод амжлаа. Жаахан хүү маань энэ дуунд чин зүрхээрээ орсныг нь ухаарсан болохоор, би түүнтэй үгээ зөв сонгож, маш бодолтой ярих хэрэгтэй байлаа.

– “Гоё дуу байгааз?” хэмээн хүү маань алсаас асуув.

– “Тийм байна, хөөрхөн дуу байна... гэхдээ энэ дуучин юу хийнэ гэж амлаад байна?” хэмээн би тандлаа.

– “Тэр охиныхоо төлөө бүгдийг хийнэ гэж байна. Үүнийгээ батлахын тулд үхсэн ч чадна” – хэмээн хүү минь хариулж байна.

– “Тэр амлалтаа биелүүлж чадах болов уу? Энэ дуу яриангүй сайхан дуу байна. Гэхдээ дуучин охиныгоо ямар байр сууринд тавьсан байна? Залуугийн амьдралыг охин нь захирч байна уу эсвэл Бурхан захирч байна уу?”

Тийм ээ, чи ч бас миний хүү шиг л “Энэ чинь зүгээр л хайрын дуу шүү дээ! Зүгээр л нэг залуу бүрэн үнэнчээр хайрлахаа л амласан дуу” гэж бодож байгаа байх. Тэгэлгүй яахав. Тийм боловч би энэ явдлын талаар бодол болов. Хүү маань хэн нэгнийг яг л тийм халуун хайр, үнэнч сэтгэл, баатарлаг золиосоор хайрлахыг хүсч байгаа учраас, тэр дууг тэгтэл сэтгэлээсээ дуулж байна. Энэ дуу хүүгийн минь дотор амгалан нойрсож байсан нэгэн хүслийг сэрээн бадраасныг би мэдэж байлаа.

Би тэр оройн явдлыг ахин дахин бодлоо. Бусад хүүхдүүд гадаа тоглож

байхад, хүү маань дотор үлдээд, тэр дууг ахин дахин, ахин дахин тоглуулж байжээ. Хүүхдүүд түүнийг хамт тоглоё гэхэд, хайрын гоо сайхан, идеологид автсан хүү маань тэр зүйлээ насаараа ч хамаагүй хайхад бэлэн, нэгэнт олбол амиараа ч хамаагүй хамгаалахад бэлэн байж.

Би сэрэлтийг... бас боломжийг харав.

~ Би сэрэлтийг...
бас боломжийг харав.

“Миний хүү чинь хайр сэрдэг насан дээрээ яваа. Чамд сонголт байна. Чи уянгын хайрыг сэрээгээд, дараа нь жинхэнээсээ гэрлэх охинтойгоо учрах хүртлээ таваас найман жил гонсгор явж болно. Эсвэл чи өөр нэгэн төрлийн хайрыг буюу Бурханыг хайрлах хайрыг сэрээж болно. Чи энэ хоёр төрлийн хайрын аль нэгийг сонгох ёстой. Учир нь чи аль нэгийг нь сэрээх цаг хэдийнээ ирчихжээ.”

Соломон үүнийг мэддэг, ойлгодог байсан учраас, залуу нас мөнхөд үргэлжлэхгүйг хэлсэн:

Хүнд өдрүүд ирж “Надад аятай юм алга” гэж хэлэх тийм жилүүд ирэхээс өмнө залуу насныхаа өдрүүдэд, Бүтээгчээ санагтун.
(Номлогчийн үгс 12:1)

Би чамд яриад байгаа зүйлээ тэр орой би хүүдээ арай энгийнээр тайлбарлав.

Залуу насанд хайр сэрж, зүрх зүг чигээ олдог. Ийм ч байх ёстой. Тийм боловч бид ямар төрлийн хайраа сэрээж, зүг чигээ мэдүүлэхээ бодолтой хянаж, шийдэх ёстой. Бид цаг нь болтол уянгын хайраа тайван амрааж, хүний төрөлхийн дур хүслээ нойрсуулаад, харин Бурханыг гэх гал халуун хүсэл, хайраа сэрээж, бадраах ёстой. Бид нэг хайрыг нь зориуд унтаа байлгаж, нөгөө

~ Чи уянгын хайрыг сэрээгээд,
дараа нь жинхэнээсээ гэрлэх
охинтойгоо учрах хүртлээ
таваас найман жил гонсгор
явж болно. Эсвэл чи өөр нэгэн
төрлийн хайрыг буюу Бурханыг
хайрлах хайрыг сэрээж болно.

хайрыг нь сэрээн, бадрааж чадна гэж үү? Би чадна гэдэгт итгэдэг. Яг уянгын хайрыг сэрээдэгтэй адил боловч, арай өөр төвлөрөлтэйгээр ажиллах.

Үүнийг хэрхэн хийхийг тайлбарлахын тулд би хүүхэд насан дээрээ очоод, бага ангид учирч байсан дэгдээхэй насныхаа хайрын талаар ярьж л даа. Би ахлах ангид амин нилээд дурламтгай охин байсан ч, тавдугаар анги хүртлээ хөвгүүдийг огт сонирхдоггүй байлаа. Хөвгүүд миний хувьд, манай хамгийн сайн найз Марси бид хоёрт тоглоомын талбай дээр эсвэл сургууль руугаа явж байхад амар заяа үзүүлдэггүй, хачин “амьтад” байв. Марси, бид хоёр хөтлөлцөөд л, амин нууцаа шивнэлдээд л

~ Залуу насанд хайр
сэрж, зүрх зүг чигээ олдог.

явж байтал, нэг зэрлэг амьтан бид хоёрыг чиглэж ирээд, яг дундуур маань гарахдаа, бид хоёрын атгалцсан гарыг таслаж бас хэн нэгнийх нь малгайг булаагаад зугтчихна (Марси надаас хөөрхөн байсан болохоор голдуу Марсигийн малгайг л булаана). Ингээд дайн эхлэнэ! Бид хоёр ч өмчөө буцааж авах гэсэндээ санаанд орсон бүх аргаараа занан, есөн шидийн, аймаар нэрсээр дуудан, араас нь хөөцөлдөнө. Марси, бид хоёр нилээд эршүүд болохоороо тэр залхаг хөвгүүдэд дээрэлхүүлэлгүй, ана мана үзэлцэнэ!

Биднийг бууж өгөхгүйг ойлгосон хөвгүүд ч сүүлдээ малгайг маань буцааж өгөөд, бид хоёр ч байгуулсан ялалтаа тэмдэглэн гараа савж,

инээж хөхрөлдсөөр харьдаг байж билээ. Гэтэл дөрөвдүгээр ангийн дараа Марсигийнх нүүгээд, би нөгөө хөвгүүдтэй ганцаараа байлдахаар үлдэв.

Тэгтэл тавдугаар ангиас юмс өөрчлөгдөж эхлэх нь тэр. Хөвгүүд надад миний “жагсаалтыг” асуусан зурвас өгдөг болов. “Жагсаалт” гэж юу юм гэж үү? Энэ нь таалагддаг хөвгүүдийн дугаарлалт юм л даа. Эхэндээ би иймэрхүү жагсаалтаас хол, нилээд хойрго байв. Яваандаа энэ талаар мэдээд:

“Лиза чи, Стюардын жагсаалтын гуравдугаарт ... Риккигийн хоёрдугаарт байлээ” гэдэг үгс миний сонирхлыг татаж эхлэв.

Би үүнд нь: “Надад тэр тэнэг жагсаалт хамаагүй ээ!” гэж хариулна.

Гэвч дотроо “Би хоёр, гуравт нь байгаа юм бол, хэн нэгдүгээрт нь байгаа юм бол?” хэмээн сонирчирхана. Би тэдэнд дургүй ч гэсэн, яагаад нэгдүгээрт орох ёсгүй гэж? Би чинь ангийнхаа хамгийн хурдан гүйдэг нь. Энэ тооцогдох л ёстой! Би хэн нэгний жагсаалтын нэгдүгээрт бичигдэх л ёстой. Гол нь хэний?

Дараа нь би тэр жагсаалт нь маш хүчтэй эд болохыг ойлгов. Миний барбигаар тоглодог, шал уйтгартай гэж үздэг охид надтай лааз өшиглөж тоглодог хөвгүүдийн жагсаалт дээр намайг хол хаяж байв. Яагаад гэвэл тэр охид жагсаалт дээрээ тэдгээр малгай булаагч нарыг өндөрт тавьжээ. Магадгүй би өөрийн гэсэн жагсаалт гаргах ч ёстой юм билүү эсвэл ядаж бодож явдаг ганц хүүгээ нэрлэхчхдэг ч юм билүү. Тэр үед надад нэг хүү жаахан таалагддаг юм шиг байлаа. Охид бие биеийндээ хамт хонохдоо тулгадаг нөгөө айхтар асуулт ирэх үед хамгийн түрүүнд тэр хүүхэд л толгойд орж ирнэ. Охидын тулгадаг нэг айхтар асуулт байдаг даа: “Чи хөвгүүдэд дургүйг чинь би мэднэ. Гэхдээ заавал хэн нэгэнтэй гэрлэх *болбол*, хэнийг сонгох вэ? (бараг л буу тулгаж байгаад асууж байгаа юм шиг л асууна шүү дээ)

Тэр хүү ухаантай, алдартай, хөөрхөн... бүх охинд таалагддаг хүү байсан болохоор, түүнийг нэрлэхчхбэл намайг бүгд шоолох учраас, би түүнийг нэрлэдэггүй байв. (Намайг эршүүдээрээ алдартай охин байсныг санаарай) Тиймээс би дандаа л “Хэн ч биш, би гэрлэхгүй!” гэдэг байв.

Гэхдээ шөнө болж аяны хөнжилдөө шургахдаа, түүнийг л боддог байсан бөгөөд тэр, бид хоёрын харилцаа өөрчлөгдөж байв. Тэр намайг тоглоомын талбай дээр бас ангид их шоглоно. Гэхдээ нийгмийн хичээл дээр надтай нэг партанд суухдаа зогсоо зайгүй ярьдаг байлаа. Бид хоёр тэр бүү хэл “Энэ хичээл гоё уу, мангар уу? (Аль нэгийг нь дугуйл)” гэсэн гүн гүнзгий утга агуулгатай зурвас ч солилцоно. Хэсэг хугацааны дараа би түүний жагсаалтад ахиж яваа талаараа сонссон ч, чимээгүй л байлаа.

Тэгтэл нэгэн өдөр нөгөөдөх чинь надад *зурвас* дамжуулав. Тэр миний

жагсаалтын нэгдүгээрт хэн байгааг үнэнгээсээ мэдэхийг хүсчээ. (Гэтэл надад бас л жагсаалт байсангүй!) Би түүнд юу ч хариулалгүйгээр, зурвасыг нь буцааж өгөөд түүний жагсаалтад хэн нэгдүгээрт байгааг асуулаа. Тэр миний хариултыг базаад, “Би эхлээд асуусан!” гэсэн шинэ зурвас илгээв. Тэгэхээр нь би “Тэгээд юу гэж? Би хоёрдугаарт асуусан!” гэсэн хамгаалалтын зурвас илгээв. Тэр намайг хоёрдугаарт жагсаасан байхад, би юу гэж тэр миний жагсаалтад дандаа л нэгдүгээрт байсныг хэлэхэв! Хэрэв тэр намайг нэгдүгээрт тавьбал, би түүнийг нэгдүгээрт бичнэ, тэр намайг хоёрдугаарт тавьбал, би түүнийг хоёрдугаарт тавина – би ийм л тооцоотой байлаа. Тэгтэл миний энэ бодлыг багшийн дуу сарниав. Багш бид хоёрын нэрийг дуудаад, захиа солилцохоо болихгүй бол, аваад бүгдэд нь уншаад өгчихнө шүү гэж сүрдүүлэв! Бид хоёр час улайгаад, нэг хэсэгтээ дээшээ харж чадсангүй.

Тэгтэл тэр “Тэр хүнийхээ нэрийг гутлынхаа улан дээр бич. Би ч бас бичье. Тэгээд зэрэг бие биедээ үзүүлье” гэж шивнэв.

Би ч “Окэй!” гэсэн боловч, түүнийг зальдах санаатай байлаа. Би нэрний оронд өөр үг бичих гэж байв. Миний нэр түүний гутлын улан дээр гарахгүй байх гэхээс би үнэхээр айж байлаа.

Тэр: “Гурав тоолоод, харуулна шүү, за юу?” л гэлээ.

Би толгой дохиод, шал тоохгүй царай гаргах гэсэндээ инээж байсан ч, бяцхан зүрх маань учиргүй бөмбөрдөж байв.

“Нэг, хоёр, гурав!” хэмээн шивнээд, тэрбээр надад “Пи. Би” гэсэн бичгээ үзүүлэв. Энэ нь түүний надад өгсөн хочийн товчлол байв. Би ч түүнд хөлөө удаан өргөсөөр “ШАТАА” гэсэн бичигтэй улаа харуулав. Түүний уурласан гэж. Би ч тэр дороо л түүний тааллаас гарч, жагсаалтаас хасагдлаа гэж бодов. Бид хоёр хоёулаа улайгаад, хичээл тартал тэр надтай ярьсан ч үгүй, над руу харсан ч үгүй. Би ч бүхнийг балласнаа мэдээд, түүнд үнэхээр татагддаг болохоо ойлгов! Гэхдээ тэр надтай дахиж энэ талаар ярих санаагүй байсан юм. Гэтэл бас өөр нэг асуудал байв... манай сургуульд Жон (манай нөхөр биш шүү) гэдэг хүүхэд шинээр ирээд байсан бөгөөд тэр намайг жагсаалтынхаа нэгдүгээрт оруулснаа бүх хүүхдэд тараагаад яваад байв. Тэр шинэ хүүхэд учраас, охид бүгдээрээ л түүнд дуртай байсан ч, харин би түүнд дургүй байлаа. Надад миний нөгөө дургүйг нь хүргэчихсэн хүү л таалагддаг байв.

Би Жонд таалагддагаа мэдэх тусмаа, түүнд улам л дургүйцэж байв. Тэгээд ч тэр чинь манай ангийнх ч биш. Би түүнийг ангиа солихоор корридорoor явж байхдаа тоглоомын талбай дээр байхыг нь л хардаг байлаа. Би түүнээс харц буруулаад, ирсэн бүх зурвасыг нь авахаас татгалздаг байв. Тэгтэл нэг өдөр тэрбээр бүр даврах нь тэр.

Би найзуудтайгаа харьж явтал, нөгөө Жон чинь Эрик гэдэг найзтайгаа

бидний араас дугуйгаараа дагасаар “Жон Лизад сайн, Жон Лизад сайн” гэсэн тээртэй элэглэлээ давтсаар явлаа. Би тэднийг тоохгүй гэж байдгаараа хичээж байсан ч, одоо найзууд маань жиг жуг хийн, тэр дууг даган дуулж эхлэв. Миний нүүр халсаар байлаа. Би тэдэн рүү хамгийн муухайгаараа хялалзаад, урдаас нь зангидсан гараараа занатал Жон хурдаа аваад, малгайг маань шүүрээд давхичихав. Би ч араас нь хар хурдаараа хөөсөөр, модны дэргэд гүйцээд авлаа. Жон дугуйгаа унагачихаад, модны хожуулын ард гараад, малгайгаар минь даллан намайг элэглэв:

“Хэнд сайнаа хэлээч? Хэлбэл, малгайг чинь өгье” хэмээн тулгалаа.

Миний тэвчээр барагдав. Малгайг минь булаачихаад бас дээрээс нь надад тушаана гэнэ ээ? Би хөлдөө байсан том модыг авч өргөөд (үнэндээ жижигхэн мөчир байсан л даа) түүн рүү:

“Малгай өг, өгөхгүй бол дугуйг чинь цохино шүү!” гэж байдгаараа зандран хашхирлаа.

Тэр тоосон ч шинжгүй. “Цохь цохь! Би айхгүй... Би чамд хайртай!”

Юу?! “Хайртай” гэнэ үү? Одоо бүх хүүхэд инээлдэж, би л ганцаараа

~ Бурхан биднийг түрүүлж хайрласан... биднийг Түүн рүү харахаас ч өмнө хайрласан.

дэлбэрэх гэж байлаа. Жон бүх юмыг баллаж байна! Би юу болж байгааг ухаараасаа ч өмнө түүнийг барьж авахаар, модны хожуулыг тойрон гүйв. Тэгээд дахиад л малгайгаа нэхсэн ч, тэр малгайг минь өгөхийн оронд бас л хайраа илчлэв. Гүйцээ. Хангалттай доромжлууллаа... Би том модоо өргөөд, толгой дундуур нь тас хийтэл буулгав. Тэр малгайг минь унагаж, би ч модоо унагаж, найзууд маань дуу алдан, Жоны найз Эрик түүн рүү гүйж очив. Би түүнийг зүгээр эсэхийг ч шалгалгүй, малгайгаа шүүрч аваад, буцааж өмсөөд, найзуудыгаа хөтлөөд, гэр рүүгээ алхлаа.

Нүүр маань шатаж байв. Найзууд маань яахаа ч мэдэхгүй байлаа. Жон хайрын баатар болсон уу? Би муу хүн үү? Би өөрийнхөө зан авирыг л бат хамгаалсан. Би түүнд анхааруулсан... тэр сонсоогүй. Одоо нэг юм намайг тайван байлгах байлгүй! Би гэртээ ороод, ээждээ Жон гэдэг нэг ядаргаатай хүүхэд миний малгайг булаасан тухай хэлчихээд, өрөөндөө орлоо. Тэр бүү хэл Жоны зан байдлыг эсэргүүцсэндээ Жон гэдэг хүнтэй хэзээ ч гэрлэхгүй хэмээн андгайлав (Хэзээ ч гэж хэзээ ч бүү хэл!) Би аюулгүйн өрөөндөө орж тайвшраад, даалгавраа хийж эхлэв. Хэдэн цагийн дараа хаалганы хонх дуугарлаа. Унтлагынхаа өрөөний цонхоор хартал, Жоны ээж зогсож байв.

Би асуудалд орсноо мэдмэгцээ, айв. Тэгээд шатаар сэм гэтсээр, хаалган дээр нэг иймэрхүү яриа өрнөж байгааг олж сонсов: “Хүү маань танай охинд сайн гэдгээ хэлсэн чинь, охин чинь толгой дундуур нь модоор

цохичихсон байна.” Би бараг л эсэргүүцлээ илэрхийлэн хашхирах гэсэн боловч, ээж маань: “Миний ойлгосноор хүү чинь охины маань малгайг булаасан гэсэн” гэв. Тэгээд нөгөө бүрхэг дуу цус, оёдол гэх мэт юм хэлсэн бөгөөд ээж маань уучлалт гуйж эхлэв. Яахаараа?! Дараа нь нөгөө эгч чинь бас баахан юм ярьсан бөгөөд би үүнээс нь ямар ч байсан надтай уулзах гэж байгааг ойлгов. Тэгээд дайсны ээж яваад өгөв.

Хаалгаа хаасныхаа дараа ээж маань том өрөөнд ороод энэ таагүй явдлыг аавд хэллээ. Би ч “одоо орилоод л унах байх” гэж бодож байтал, тэд инээлдэх нь сонсогдов. Тэд миний зан авирын талаар ярьж байлаа. Тэд надтай чухал яриа хийхээр ирж байгааг мэдмэгцээ, би өрөөндөө яг амжиж оров. Аав, ээж хоёр надад хүнийг санаатай байна уу, санаандгүй байна уу – толгой руу нь цохиж болохгүйг чадах ядахаараа ойлгуулах гэж оролдлоо. Жоны хуйх нь ярагдаж, хэдэн оёдол тавиулсан – гэтэл түүнийг алчихаж ч болох байсан байна гэв. Маргааш нь Жоныг толгойгоо боосон байхыг бүгд харна тэгээд хэргийн эзэн би болохыг бүгд мэднэ гэхээс нүүр улайв.

Ээж маань: “Тэр чамд үнэхээр сайн болтой” гэж хэлээд, хаалгаа хаагаад гарав.

Тэгсэн би “Жон надаар толгойдоо тийм аймаар цохиулж, оёдол тавиулчихаад, надад сайн хэвээрээ байх болов уу, чадах болов уу?” хэмээн гайхлаа. Бусад хөвгүүд үүнийг хараад, намайг түүнд сайн юм байна гэж бодбол, яана аа? Эсвэл Жон одоо надаас ухаангүй айх байх! Би ер нь маргааш юу болох бол гэхээс гайхаж бас жаахан ичэж байлаа.

Маргааш нь намайг ангид ортол ангийнхан мань жиг жуг хийж, ангийн багш над руу нөгөө л танил харцаараа харав.

“Чи Жоныг цохиод, толгойг нь хагалчихсан юм уу?” гэсээр хүүхдүүд намайг бүчээд авлаа.

Би ч тэдэнд юун сүртэй юм гэсэн шиг л хэнэггүй царай харуулан: “Тийн!” гэж хариуллаа.

Тэгтэл нөгөө барби хүүхэлдэйгээр тоглодог охидын нэг суудлаасаа: “Тэр яаж чамайг жагсаалтынхаа нэгт байлгасаар байдаг байна аа?” гэлээ.

Жон тэр охины жагсаалтын нэгдүгээрт байдгийг би сайн мэднэ. Тэр жижигхэн шар толгойт охин Жонд үнэхээрийн сайн байлаа. Би ч түүний нэгдүгээрт байсаар байгаа гэдэгтээ итгэсэнгүй! Пөөх! Ээжийн зөв байж... тэр надад үнэхээр сайн болтой. Тэр өдөр би Жонд сайн болж, жагсаалтдаа багтаах талаар бодож байгаа талаараа цуурхал дэгдээхээр шийдэв. (Хүүхдийг тэгтэл гэмтээсэн хүн чинь ядаж л ингэж гэмээ цайруулахаас!) Тэр өдөр би корридорд Жоны дамжуулсан зурвасыг ч хүлээж авав. Гэхдээ үнэндээ түүний наальхай зан надад ядаргаатай л байлаа. Жон гэдэг тэр ялдам хүүхэд дараагийн зун нь нүүж одох хүртлээ надад дэндүү сайн байж

билээ. (Явахдаа бүр уйлсан шүү) Жон манайд бараг шөнө ирээд, бид хоёр манай довжоон дээр зогсоод ярилцаж билээ. Би түүнийг дахиж хэзээ ч цохихгүй... бас би Жон гэдэг хүнтэй ханилчихсныг та нар мэднэ. Эцсийн эцэст би яаж тийм гүргэр, тууштай хайрыг эсэргүүцэх юм бэ? Сайн асуулт шүү. Ер нь хэн чадах юм бэ?

Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг. (1Иохан 4:19)

Бурхан биднийг түрүүлж хайрлаад, аюулгүй болгож өгсөн учраас, бид хайрлаж чаддаг болсон. Бурхан итгэмжтэй, бид бүгдээрээ Түүний жагсаалтын тэргүүнд байдаг. Энэ бол бага, дунд ангийн жил тутам солигдож байдаг эсвэл шинэ охин ирэхээр аюул заналтай тулгардаг дэгдээхэй насны дурлал биш. Бурхан биднийг түрүүлж хайрласан... биднийг Түүн рүү харахаас ч өмнө хайрласан. Үүнийгээ бидэнд мэдүүлэхийн тулд хожим хаягдах жижигхэн цаасан дээр бичээгүй, харин бүхэл бүтэн ном болгож бичүүлсэн. Тэр энэ хайраа өнө мөнхийн гэдэг бөгөөд гэрээний амлалтаар баталгаажуулдаг.

ЭЗЭН түүнд холоос үзэгдэн “Би чамайг үүрдийн хайраар хайрласан. Тиймээс Би чамайг хайр энэрлээр татсан билээ. (Иеремиа 31:3)

Бурхан энд өнгөрсөн цаг хэрэглэсэн байгааг харж байна уу? Яг л “*Би чамайг бүр эртнээс хайрлахаар шийдсэн бөгөөд хайрлахаа ч болихгүй. Тиймээс чамайг Өөртөө ойртуулахын тулд хийж чадах бүхнээ хийсэн. Энэ бүхнийг би Өөрөө шийдсэн гэдгийг чамд мэдүүлж, чиний анхаарлыг татахын тулд би хайр халамжаа харамлаагүй*” гэж хэлж байгаатай л адил.

Тиймээс Бурханыг хайрлах хайраа сэрээхийн тулд хамгийн түрүүнд биднийг гэх Түүний хайрыг ойлгож, хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэдийгээр бидний авир үйлдэл муу муухай, хахир хатуу байсан ч, Бурхан мод эргүүлэн заналхийлсэн, догшин бидэнд ойртож ирээд, чихэнд маань: “Би чамд хайртай” гэж шивнэсэн билээ. Бид Түүний гараас зурвас хүлээж авдаг. Бид үүнийг уншаад, энэ үнэний жинг зүрхэндээ шингээдэг. Бид Түүний гутлын улнаас өөрсдийнхөө нэрийг хайдаг боловч, Тэр бидний харааг өргөөд “Тэнд биш ээ, охин минь, чиний нэр Миний алган дээр байгаа” гэдэг. Тэгээд бидний нэрийг алган дээрээ сийлсэн шархаа үзүүлнэ.

Эсвэл Бурханы энэрэнгүй чанар өөрийг чинь хөглөн гэмшилд хүргэдгийг та мэдэлгүй, Түүний энэрэл, хүлцэл ба тэвчээрийн баяныг басамжлах уу? (Ром 2:4)

Бид ийм үзэсгэлэнтэй, сайхан үнэнийг ойлгосныхоо дараа өөр нэгэн сонголттой тулгарна: Энэ ухааралд хэрхэн хариу үйлдэх вэ? Түүний тэврийг хүлээн аваад, хариу тэврэх үү эсвэл харж, мэдэх зүйлдээ хүрэлцэхийн тулд харагдахгүй юмсын хүрэлцээнээс эргэх үү?

Энэ амаргүй уулзвар боловч, нас хүйс, харилцаанаасаа үл хамааран – хүн бүр босч зогсоод, энэ талаар шийдвэр гаргах ёстой гэдгийг би хүлээн зөвшөөрнө. Христийн дагалдагч – бид сонгох замаа мэддэг ч, тэр замаар хэрхэн явах маань жаахан тодорхойгүй байдаг. Учир нь тодорхой амлалт нь баахан хүлээлгэж ирдэг нандин найдвараас хамаагүй дээр санагдана.

Бурханыг гэх хайраа сэргээхийн тулд хийх ёстой хоёр дахь алхам нь Түүний хайрыг мэдээд зогсохгүй, Түүний араас явах юм. Бид Бурханыг Тэр биднийг мэддэг шиг мэдэхийн тулд Бурханы царайг ширтэнэ гэсэн үг.

Гэхдээ харагдахгүй Бурханд хэрхэн хариулах билээ? Тэр бол амлалтын Ханхүү бөгөөд хараахан баригдахгүй бөгөөд харагдахгүй. Яг л бид цэцэгт талд нарны дулаан илчин дор унтаад сэрэхдээ, дэргэдээ Ертөнцийн Ханхүүгийн Өөрийн гараар бичиж, мөнхийн хайраа илчилсэн зурвасыг олохтой адил. Тэрбээр захидалдаа хайраа илчлээд зогсохгүй, бүр гэрлэлтийн гэрээ байгуулах талаараа ч дурьдсан байна. Бид ч догдлож чичирсэн гартаа захидлаа атгасаар, ахин дахин нэрийг нь шалгана. Тэгээд год хийн, хөл дээрээ босоод... надад хайртай тэр нигүүлсэнгүй Ханхүүг хайн, зүрх маань бөмбөрдөнө. Би Түүнийг мэдмээр байна... Түүний царайг хармаар байна. Тэгээд эргэлдэн хайсан ч, хэн ч байсангүй.

Чи яах уу? Чи түүнийг хайх л байх. Хүмүүсээс ч асуух байх.

Амин голоос хайртай түүнээ шөнөд би орондоо хайнам. Хайлаа гээд түүнийгээ харин би эс олном Хашхирч түүнийг дуудаад ч Хариут тэр эс өгнөм. “Одоо би босож, орон хотоор явсу, Гудам, талбайг гулд хэдчин Голын хайртаа горилж бэдэрсү” Хайлаа гээд би түүнийгээ харин эс олов. Харуулынхан хот эргэж яваад харин намайг олов. “Халуун голын хайртыг минь хараагүй биз”. (Соломоны дуун 3:1–3)

Гэнэт бидний нүд өөрийнхөө жижиг ертөнцөөс өргөгдөн, эргэн тойрноо тэс өөрөөр харж эхлэнэ. Бид Түүнийг олж үзэх гэсэндээ, нар мандахыг цоо ширтэнэ. Тэндээс бид Түүний сайн сайхны хэлтэрхийг үзэж, тэр сайн сайхныг өөртөө шингээнэ. Түүний сүр хүчийг гайхуулах оддыг бишрэн ширтэхэд, Түүний сүр жавхлан бидний дээрээс асгарна.

Бид эргэн тойрон дахь Түүний бүтээлийг гайхан харна. Эдүгээ бид газрын тоосыг хөдөлгөж яваа бас л нэг амьтад байхаа больжээ. Түүний хайрын ухаарал нь энэ бүх өөрчлөлтийг авчиржээ. Эдүгээ бид түүнийх,

Тэр биднийх болсон учраас, энэ бүхэн маш дотно санагдана. Шинэ өдөр бүр бэлэг мэт, цэцэг бүр надад л илгээсэн мэт. Бидэнд ирэх сайн сайхан бүхнийг бид Түүний мутраас хувьчлан хүлээж авсан мэт хүлээн аваад, зүрхэндээ наан, хайранд нь умбана.

Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжиж ойлгогдож, илэрхий харагдаж байгаа тул тэдэнд шалтга байхгүй. (Ром 1:20)

Эдүгээ бид орчин тойрондоо тэс өөрөөр хандах болжээ. Учир нь бид нүдэнд харагдах эргэн тойрныхоо гоо үзэсгэлэнгээс Түүний үл үзэгдэх гоо үзэсгэлэн, мөн чанарыг харж байна. Бид том жижиг, нарийн ширийн – бүгдээс нь Түүний гоо үзэсгэлэнг үзнэ. Бид хайрлагдсан учраас, Түүнийг хардаг. Энэ бүхэн нь миний тавдугаар ангийн “хайр” бид хоёртой л адилхан юм. Корридорт би түүнээс нүүр буруулах биш, харин түүнийг хайж явдаг болсон шиг. Би түүний надад өгсөн нууц захиаг сандран уншаад, дараа нь өрөөнийхөө шүүгээнд хадгална. Тэгээд ганцаараа байхдаа, цаанаа хайрын дуу тавьж байгаад, ахин дахин уншина. Хичээлийн дараа би алхаагаа удаашруулан, найзуудаасаа хоцроод, түүнийг хүлээж байгаад, түүгээр гэртээ хүргүүлнэ. Би түүнтэй хамт байх цагийг хайдаг байсан шиг, бид ч бас Ханхүүтэйгээ хамт байх цагийг хайх хэрэгтэй.

Хөгжим нь хайрын цэцэглэнгийн хүрээлэн юм. Хайр, хөгжим хоёрын хооронд нэгээхэн тэнгэрлэг холбоо оршино. Хайр, хөгжим хоёр бие бие рүүгээ тэмүүлж, бие биеэ илчилдэг. Хөгжим нь биднийг тэвэрлэх хүчтэй. Хайр нь хөгжмөөр жигүүрлэж, зүрхэн дэхь дууг маань сэрээдэг. Хөгжмөөр илэрхийлэгдсэн үгс нь зүрхний маань өөр юугаар ч хөндөгдөшгүй хэсгийг хөнддөг. Бид бүгдээрээ л үлэмж баяр баяслаар мансууран хөөрөх юмуу эсвэл дууны хүчний гүн гунигт живж үзсэн.

Бурханыг хайрлах хайрыг сэрээхэд хөгжим чухал үүрэгтэй. Учир нь хөгжим биднийг өнөөгийн бодит байдлаар маань хөтлөн туулуулж, Бурханы оршихуйд угтан оруулах хүчтэй. Хөгжим бидний чин мэдрэмжийг хөвөөн дээр гаргаж, Бурханы зүрх рүү ойртуулдаг. Насанд хүрэхэд хөгжмийн нөлөө улам л эрчимжинэ. Мэдрэмж оволзож, үгээр илэрхийлэхийн аргагүй болох үед хөгжим бидний өмнөөс ярьдаг. Залуу Давид хонь хариулж байхдаа хөгжмийн хүчээр Бурхан руу ойртож, ганцаардлаас ангид байсан. Тэрбээр цөлд дуулахдаа, Бурханы оршихуйг мэдэрдэг байжээ. Тэрбээр хожим хаан болоод Бурхан, хөгжим хоёрын холбоог ингэж тайлбарласан байдаг:

Хайр, хөгжим хоёрын хооронд нэгээхэн тэнгэрлэг холбоо оршино.

Гэвч Израилийн магтаал дунд сэнтийд залрагч аа, Та ариун юм.
(Дуулал 22:3)

Магтаал бидний амьдрал дахь Бурханы байр суурь, хүч, эрх мэдлийг өргөмжилдөг. Дийлэнх хүмүүс насанд хүрсэн хойноо хөгжмийн нөлөөнд илүү мэдрэг байдгийг дахин хэлмээр байна. Ялангуяа хайр сэрэх улиралдаа хүн хөгжимд ухаан жолоогүй татагддаг. Хайр бидний сэтгэл мэдрэмжийг эмзэг байхад ирдэг. Хүнийг тайтгаруулж, сэдрээх хүч нь хөгжимд л байдаг.

~ Магтаал бидний амьдрал дахь Бурханы байр суурь, хүч, эрх мэдлийг өргөмжилдөг.

Хөгжмийн тосолгоо гэж байдгийг мэдэх үү? Тиймээс бид ямар хөгжим сонсохоо мэргэн сонгох хэрэгтэй. Тосолгоо гэдэг нь юу гэсэн үг вэ? Хуучин гэрээнд хаан, тахилч, эш үзүүлэгчийг томилохдоо, толгой дээр нь тос дусааж томилдог байсан. Энэ нь Бурханы Сүнсний бодит төлөөлөл болдог байжээ. Шинэ гэрээнд тосолгоо нь Христийг илэрхийлэх Ариун Сүнсний оршихуй, хүчирхэгжүүлэл болжээ. Тиймээс Ариун Сүнсээр тослогдсон, бурханлаг хөгжим нь биднийг Түүний оршихуйд ойртуулдаг. Заримдаа магтаал хүндэтгэлийн үеэр би Бурханы оршихуйд автах шиг л болдог. Хэдийгээр би Бурханыг нүдээрээ харахгүй ч, Бурхан намайг тэр чигээр нь эзлэхсэн юм шиг л санагдана. Тэр үед би төгс хайр, төгс аюулгүй байдлыг мэдэрдэг. Цаг зогсож, би тэнгэрийн хэлтэрхийг үзэх шиг болно. Ийм учралын дараа миний Бурханыг хайрлах хайр, Бурханаар цангах сэтгэл улам томордог. Сүнсээр үлээгдсэн, амь өгөгч хөгжим сэтгэлийг эдгээх, сэрээх, тайвшруулах чадалтай. Яг тэр хөгжмийг хэдэн өдрийн дараа дахин сонсохоор, өнгөрсөн учралын дурсамж шууд амилах шиг.

Тиймээс хөгжим нь дурсамж бүтээх хүчтэй. Жон надтай гэрлээд удаагүй байхдаа, намайг Саинт Мартин руу авч явсан юм. Тэнд бид хоёр амарч, хоолон дээрээ бас тагтан дээрээ сарны гэрэл дор дуусахгүй яриа өрнүүлдэг байв. Тэр үед бид хоёр зочид буудлынхаа өрөөнд нэгэн аязыг ахин дахин тоглуулдаг байсан бөгөөд эдүгээ арван найман жилийн дараа би тэр хөгжмийн эхний өнгийг сонсохоор шууд тэр цаг, тэр газар руу оччих шиг л болдог юм. Тэрхэн эгшинд би одтой тэнгэрийн дор “Давалгаа” нэртэй рестораны лаатай ширээний ард нөхөртэйгээ чимээгүй шивнэлдэн суух шиг болдог юм.

Хөгжим чиний сэтгэл санааг өөр газар руу авч явах хүчтэй. Иймээс очих газраа мэргэн сонгох нь чухал. Эх орон, элгэн саднаараа бахархан уйлахад хүргэдэг хөгжим байна. Нэн ялангуяа үндэсний их зовлон, их ялалтын

үеэр төрийн дуулал эгшиглэхээр өөрийн эрхгүй нулимс гардаг. Гэтэл бас найдвар тасрах, үхэх – тэр бүү хэл амиа егүүтгэхийг уриалсан цөхрөлийн, хар хөгжим байна. Зарим дуу нь уур, үзэн ядалт, тэрслэлийг дэврээдэг. Хөгжмийн энэ хүч, нөлөөтэй маргалдах хүн гарахгүй байх аа.

Хөгжим нь уянгын мэдрэмжийг сэрээж, бадраадаг. Тэр байтугай хөгжим нь хүний биед өөрийн мэдэлгүй бэлгийн хариу үйлдлийг өдөөх чадвартай. Хүний биеийг хүчтэй өдөөдөг, янз бүрийн хэмнэлт, цохилт нь сексийн сэдэлтэй үгтэй хоршоод ирэхээрээ эсэргүүцэхийн аргагүй хүчтэй нөлөө үзүүлнэ.

Чи цэвэр амьдармаар байгаа бол, ийм төрлийн хөгжмийн нөлөөнөөс биеэ хамгаалах ёстой. Эс бөгөөс чи өөрөө хүсээгүй байсан ч, энэ нь чиний анхны хамгаалалтыг даван, тархинд чинь суурьшаад авна. Үгийг нь цээжлээгүй байсан ч, тэр утга санаа тархинд чинь ахин дахин тоглогдсоор байна. Хүмүүс: “Тэр мангар дуу толгойноос гардаггүй ээ!” гэж гомдоллохыг сонссон л биз дээ.

Хүсэхгүй байгаа дуунаасаа ангижрах шилдэг арга зүй нь өөр дуу дуулах юмуу сонсох. Газрын дуу гэж бий, тэнгэрийн дуу гэж бий. Газрын дуунууд бүгдээрээ муу биш боловч, ихэнх нь чамайг Бурхан руу ойртуулахгүй. Тэгвэл тэнгэрийн дуунууд Бурханд ойртуулна. Бид эдгээр дууг дуулахдаа, Бурханыг хайрлах, Бурханыг хүсэх сэтгэлээ мэдэгддэг. Энэ нь хүндэтгэлийн хэлбэр бөгөөд харин хүндэтгэл нь хүндэтгэл өргөж байгаа хүнд хүндэтгэж байгаа объектыг нь улам том томруунаар илчилдэг. Өнөөгийнх шиг Сүнсээр амьсгалагдсан, өөрчлөгч хөгжим урьд урьдын түүхэнд хомс байсан байх аа. Бурханы оршихуйг эдлэхийн тулд магтаалын хөгжмийг ашигла. . . энэ нь чамайг Бурханд ойртуулна. Учир нь хөгжим нь дурлалт хосыг хэзээд ойртуулдаг.

Бурханыг гэх хайраа сэрээж, бэхжүүлж, тордох нь яг л уянгын хайрыг хөгжмөөр бадраадагтай л адил зарчимтай. Чи Бурханд зориулсан, Бурханы талаарх хайрын дууг сонссоноороо, Бурхан руу улам ойртоно. Сүнсээр дүүрэхийг Паул хэрхэн тайлбарлав:

Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй. Харин Сүнсээр дүүр. Ингэхдээ дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар өөр хоорондоо ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиож. . .

(Дуулал 5:18–19)

Биднийг Сүнсээр дүүрэхийг ятгажээ. Бид зүрхэндээ юмуу чангаар дуулсаар байгаа цагтаа Сүнсээр дүүрнэ. Гэвч энэ ишлэл нь Бурхантай тогтоосон бидний харилцааг бусдад таниулах түлхүүр болжээ. Энд гэрчлэх нэгэн төрлийн ариун хэлбэрийн талаар яриагүй байна. Учир нь

хүн хэлбэртэй амархан зууралддаг. Энд дүүрсэн зүрхнээс ундрах хайр, үгсээс төрдөг харилцан ярианы талаар ярьж байна. Хайрлуулах нь дэндүү сайхан учраас, чи энэ сайхныг бусадтай хуваалцахыг хүснэ.

Чи хэн нэгэнд хайртай бол, тэр хүнийхээ хандлагаар л бусдад хандана. Найзууд нийтлэг дур сонирхлоороо холбогддог. Үүнийг аяллаар яваад, түүдэг асаагаад, харанхуйг гэрэлтүүлж, зэрлэг амьтдыг үргээх түүдгээ тойрон илчинд нь ээгдэн, сайхныг нь бишрэн ширтэж суухтай л адилтгаж болмоор. Та нарыг бие биеэ босгон байгуулж, үнэн дотор нэг нэгнээ бэхжүүлэхэд хүргэдэг нэгэн холбоо бий. Бурханыг хайрлах хайраа сэрээж, бэхжүүлэх өөр нэг арга нь Бурханд хайртай найзуудаар хүрээлүүлэх юм.

Чи эсрэг хүйсийн хүнээ хүсэх дур хүслээ бус, харин Бурханыг хайрлах хайраа сэрээхийг баттай сонгосон бол, найзуудаа ч зөв сонгоно. Чи өнөөдөр газрын, жирийн хайртай хөөцөлдөх юм бол, илүү эрх чөлөөтэй байж магадгүй. Харин Ханхүүгийн мөрөөдлийн араас хөөх юм бол, өөрийгөө чамтай л адил хүлээж байгаа бүсгүйчүүдээр хүрээлнэ. Хэлэхэд амархан, хийхэд хэцүү ч гэлээ, ийм л сонголт байдаг. Христийн жинхэнэ найзууд чиний ч жинхэнэ найзууд болно. Тэд сайн амьдардаг учраас, сайн ярьдаг.

~ Бурханыг хайрлах хайраа сэрээхийг баттай сонгосон бол, найзуудаа ч зөв сонгоно.

Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн. (Иохан 15:14)

Есүс энд тодорхой өгүүлрүүн. Есүсийн найзууд Түүний тушаалыг сахиж, бусдыг ч үүнд урамшуулдаг. Жинхэнэ найзууд чамайг үргэлж илүү дээш нь гаргаж, Эзэнд таалагдах арга замаар амьдрахыг уриалдаг. Чи найзуудтай Есүсийг дагахдаа, та нар бүгдээрээ нэгэн зүг чиглэж, нэгэн газрын зургаар явж байна. Энэ зарчим хөгшин, залуу бүх хүнд хэрэгжинэ... жинхэнэ найзууд чамайг сайн үйлсэд өдөөнө.

~ Жинхэнэ найзууд чамайг үргэлж илүү дээш нь гаргаж, Эзэнд таалагдах арга замаар амьдрахыг уриалдаг.

Төмөр төмрийг ирлэдэг.
Хүн хүнээ хурцалдаг.
(Сургаалт үгс 27:17)

Нэгэн сүнс, зорилготой хүмүүсээр өөрийгөө хүрээлэх нь амин чухал. Энэ нь та нар цаг үргэлж бүх зүйл дээр зөвшилцөнө гэсэн үг бус, харин та нар Сүнстэй нөхөрлөдөг учраас, бүгдээрээ бие биеэсээ суралцаж, нэг нэгнээ хамгаална гэсэн үг.

Зүрх юугаан урьтан хамгаал

Амийн булгууд түүнээс ундарюу.

(Сургаалт үгс 4:23 тодруулгыг нэмэв).

Зүрх нь хамгийн чухал байхаар өгөгджээ. Танай гэрт хулгай ороод, үнэтэй эд хогшлыг чинь цөлмөсөн ч, зүрхэнд чинь хүрээгүй учраас, үнэндээ тэд юу ч аваагүй ажээ. Зүрхийг хулгайлах цорын ганц арга нь зүрхээ өөр нэгэн зүйлээс уях арга юм. Тэр цагт чи өндөр алдагдал хүлээнэ. Тиймээс л Бурхан бидэнд Өөрийг нь бүх зүрхээрээ хайрлаарай гэдэг. Учир нь Түүний дотор л бидний зүрх аюулгүй оршино. Зүрхээ хамгаалах нь өөр бас нэгэн шалтгаантай: учир нь зүрхнээс амийн булаг урсдаг юм.

Библийн өөр нэгэн хувилбар дээр:

“Бусад бүх юмсаас дээгүүр дур хүслээ хамгаал. Учир нь тэдгээр нь чиний амьдралд буй бусад бүх юмст нөлөөлдөг юм” гэдэг
(Сургаалт үгс 4:23, ТиЭлБи)

Үнэхээр ч зүрхийг бас “дур хүсэл” гэж хэлж болох юм. Дур хүслийн чинь байршил шийдвэрийн чинь зүг чигийг жолоодно. Чиний дур хүсэл эцэстээ амьдралын чинь тал бүрт нөлөөлнө.

*~ Дур хүслийн чинь
байршил шийдвэрийн чинь
зүг чигийг жолоодно.*

Энэ бүлэгт бид Бурханыг хайрлах хайр, дур хүслээ сэрээх талаар ярьж байгаа бөгөөд бид зүрхээ Түүн дээр тогтоосноороо л үүнийг хийж

чадна. Тэгвэл мөн л би харж чадахгүй Бурхан дээрээ яаж зүрхээ тогтоох юм бэ гэсэн асуулт гарч ирнэ.

Чи ямар нэг зүйлийг хэрхэн хийхийг мэдэх гэж байгаа бол, яаж хийхийг мэддэг хүнээс нь зөвлөгөө авдаг бус уу? Давид хаан хэрхэн Бурханы араас явж, Түүнийг хайрлах хайраа хадгалахыг мэддэг байсан. Давид хэний ч араас гүйгээгүйгээрээ Бурханы араас гүйсэн. Тэрбээр хар залуугаараа Бурханы араас гүйж эхлэсэн бөгөөд өтөл болохдоо ч гүйсээр байжээ. Давид Бурханы хайр, итгэмжтэй чанарт хэзээ ч итгэл алдраагүй бөгөөд Бурханд хариулж, талархаж амьдарсан билээ.

Намайг хамгаалаач Бурхан, Учир нь Таны дотор би хоргоддог.

Би ЭЗЭНд “Та миний Эзэн Танаас өөр сайн сайхан гэж надад үгүй” гэж хэлэв. ЭЗЭН өмнө минь үргэлж байсан. Тэр миний баруун талд байдаг учраас Би ганхахгүй. Тиймээс зүрх минь баярлаж, Алдар минь баясна. Бие махбод минь ч Аюулгүй оршино. (Дуулал 16:1–2, 8–9)

Давид юу хийж байна? Бурханыг өмнөө тавьж байна. Тэр үүнийгээ хэрхэн хийж байна? Амныхаа үгээр зүрхнийхээ мэдэгдлийг хийх замаар. Чи харагдахгүй зүрхээ үгээрээ тогтооно. Учир нь бидний зүрх ямагт бидний хэл яриагаар илчлэгддэг юм. Тонгоруулбал, зүрх нь бидний ярьдаг үгсээр хувьсдаг ажээ. Давид бидэнд юу хийснээ хэлээд зогсохгүй, биднийг давтан хэлээсэй гэсэндээ хэлсэн үгээ ч мэдүүлжээ. Энэ дуулал дээр Давидын гаргаж ирсэн хүчирхэг үнэнийг бид өөрийн болгох хэрэгтэй:

Бурхантай тогтоосон гэрээ, хайраа мэдэгдэх үед та хоёрын холбоо зузаарна.

1. Хаад хүртэл өөрийгөө хамгаалахгүй... Бурханыг хорогдох газраа болго.
2. Түүнийг өөрийнхөө гэж, өөрийнхөө Эзэн гэж дууд... өөр дээрээ хувьчлан тусгаж хэл.
3. Түүнээс илүү юу ч хүсэхгүй гэдгээ хэл.
4. Түүнийг өөрийнхөө өмнө мөнхөд байлга.
5. Түүнийг дээдлэн, амьдралаараа хүндэтгэ.
6. Үйлс болгоноороо Түүнийг дага.
7. Тэр чамайг дааж байгаа учраас, чи зогсох болно.
8. Чи өөрийгөө хариуцахгүй учраас, амар тайван, баяр хөөртэй бай.
9. Түүний дотор амар.

Бурхантай тогтоосон гэрээ, хайраа мэдэгдэх үед та хоёрын холбоо зузаарна. Бурхан хэдийнээ чамд бүрэн зориулагдсан. Гэхдээ чиний зүгээс зориулалтаа ахиулах хэрэгтэй. Бид яаж аврагдсан, яг л тэр замаараа Бурхантай тогтоосон хайрын харилцаагаа авч явна.

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ. Учир нь Бичвэр «Түүнд итгэгч нь ичгүүрт орохгүй» гэдэг. (Ром 10:9–11)

Бид амьдралынхаа харилцаа бүрт үгээрээ болоод зохих үйлдлээрээ нэвтэрч, харилцаа бүрээ үгээрээ болоод зохих үйлдлээрээ өргөжүүлэн тэлдэг. Эдгээр нь амлалт, андгай, тангараг зэрэг бүрэн зориулалтыг мэдэгдсэн үгс байж болно. Эсвэл гэр бүл, найзуудын дунд яригддаг, албархаг бус боловч, ялгаагүй л хүчирхэг үгс байж болно. Үгс нь хайрын, аюулгүй уур амьсгалд бидний зүүд, айдсыг тайлж өгдөг. Үгс нь бидний оршихуйн цөмийг бохирлож, шархлуулж чаддаг шигээ амьдралын нууц газруудад эдгэрэл, цэвэрлэгээ авчирч чадна.

Найзуудаа мэргэн сонгодог шигээ, зүрхэн дэхь Бурханы дур хүсэл, оршихуйгаа хамгаалахын тулд үгээ мэргэн сонго. Цөөн боловч үнэт үг ярьж бай.

Энэ бүхэн чамд илчлэл биш байж болох. Тийм боловч дийлэнх хүмүүс төрөлхийн амиа бодсон чанартай байдаг. Хүн төрөлтөн бид яаж жинхэнээсээ хайрлахыг мэддэггүй. Бурхан бидний төгс бус хайрыг тэр чигээр нь хүсдэг бөгөөд хариуд нь чамд төгс хайраа өгөхийг хүсдэг. Тэр бүү хэл Бурхан биднийг Өөрийг нь хайрлах хүчтэй болгоно. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань

ц

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Сэтгэл зүрх минь булгилж байна. Та намайг хайрласны хариуд би ч бас Таныг хайрламаар байна. Та надад үргэлж итгэмжтэй байсан. Гэтэл би Таныг дандаа л хөсөрдүүлсэн. Би Давидын үгээр залбирч, зүрх маань Таныг дагаж байна. Та л миний хорогдох газар учраас, Эзэн минь, намайг аюулгүй байлгаач. Та миний Эзэн бөгөөд Танаас ангид сайн сайхан юм надад үгүй. Би зүрхээ Таны эрдэнэсийн авдарт нууж байна. Би Таныг өмнөө тавьж байна. Та миний баруун талд алхдаг учраас, би ганхахгүй. Би үүнд итгэж байна, зүрх минь ч баярлаж байна. Би Таныг зүрх, сэтгэлээрээ чангаар магтан дуулж байна. Би Таны жигүүр дор хорогдон, нөмөрт тань байх учраас, амар тайван, аюулгүй хэвтэж амрах болно.

Таны хайрт охиноос.

5 Нойрсож буй гоо бүсгүй

Зүүд бол унтаж буй зүрхний хүсэл юм –Үнсгэлжин. Бид уруулаараа зүрхнийхээ хүсэл тэмүүллийг дуулан, хүүрнэдэг. Бүлгийн маань гарчиг чамайг жаахан гайхшруулаа байх. Гэхдээ Бурхан Өөрөө анхлан энэ ойлголтыг бий болгосон учраас, гайхах хэрэггүй. Тэгээд ч Бурхан л ертөнцийн цорын ганц Хаан бол, Түүний Хүү Есүс ину хорионд байгаа бүх гоо охидын туйлын авран сэргээгч, жинхэнэ Ханхүү болой. Энэ бол Бурханы хайрын олон түүхийн нэг бөгөөд сайхан хайрын үлгэр болгонд цэцэрлэг цайз, өргөс жимс, хаалга хэрэм, ой тал, сайн муу, сүр жавхлант ханхөвүүд, нойрсож буй гоо бүсгүйчүүд гардаг.

Үлгэр болгонд сэрэх цагаа хүлээж буй нойрсогч гоо бүсгүй гарна. Чи энэ үлгэрийг надтай хамт илүү ухаж уншбал, тэнд эмэгтэйчүүд бидний үлэмж айдас, зүрхний гүн цөхрөл зэрэг үй олон сэтгэл мэдрэмж гарахыг мэднэ. Эртний энэ үлгэр эрчүүд, эмэгтэйчүүдийг газрын хязгаарлагдмал үзэл бодлынхоо сүүдрэвчийг өргөж, тэнгэрийн хамгийн баталгаатай амлалтын сүр жавхлан, нууц руу хальт өнгийхийг уриалан дууддаг. Хүүхдийн үгээр бичигдсэн энэ үлгэрт эмэгтэй хүний хамгийн гүн, хамгийн нандин хүсэл оршино: одоогийн хар

~ Бурхан л ертөнцийн цорын ганц Хаан бол, Түүний Хүү Есүс ину хорионд байгаа бүх гоо охидын туйлын авран сэргээгч, жинхэнэ Ханхүү болой.

~ Хүүхдийн үгээр бичигдсэн энэ үлгэрт эмэгтэй хүний хамгийн гүн, хамгийн нандин хүсэл оршино: одоогийн хар дарсан зүүднээсээ сэргэж, мөрөөдөл рүүгээ нэг мөр одох.

дарсан зүүднээсээ сэргэж, мөрөөдөл рүүгээ нэг мөр одох.

Энэ найдвар нь жаахан охидын ч, настай эмэгтэйчүүдийн ч зүрхийг ялгаагүй булгилуулна. Чиний амьдралыг хүрээлсэн сэтгэл мэдрэмжийн гүн ангальг ялах, ямар ч гинжнээс аугаа, хүчтэй хайраар аврагдана гэж ямар байдгийг төсөөлж байна уу? Энэ хайр нь чиний зүрхний атаат дайсан – луутай халз тулалдах эр зоригтой хайр. Энэ аврал чамайг өөрийн гараар босгосон хар цайзаас чинь аварна. Үнэндээ бид өөрийгөө сүйрүүлэх ажлаа өөрийнхөө гараар босгох маань олонтаа. Өөрийгөө хамгаалах гэж босгосон тусгаарлагч ханыг энэ хайр л нураана. Биднийг харанхуй зүүдэндээ хүлээж байхад, үгээр илэрхийлэшгүй хайрт Ханхүү маань биднийг үнсэлтээрээ сэрээх гэсэн халуун хүсэлдээ хөтлөгдөхдөө, замдаа таарсан үй түмэн бартааг ялаад иржээ. Би чамд энэ үлгэрээр дамжуулан тэр Ханхүүгийн талаар тайлбарлаж өгмөөр байна:

Энэ үлгэр олон хувилбартай боловч, бүгдээрээ нэгэн хаант улсын хаан, хатан хоёр хүсэн хүлээсэн шинэ охиндоо зориулан их найр наадам хийж байгаагаар эхлэнэ. Тэд яарсандаа найрандаа тэнд байдаг шулмыг урихаа мартсан нь шулмыг ихэд хилээнүүлэв. Гэтэл шулам өөрөө найранд нь хурч ирээд – бусад зочид нь шинэ хүнийг ерөөж байхад – шулам харааж орхино. Хараалынх нь үр нөлөө тэр даруй ажиллалгүй, охиныг насанд хүрмэгц нь ажиллахаар, хамаг л ирээдүйг нь харанхуйлжээ. Хараалд хэлснээр, охин арван тав хүрэхээрээ ээрүүлийн зүүнд хурууныхаа өндгийг хатгаад, үхэдхийн унах ажээ.

Өөр нэгэн үлгэрт охин үхээгүй, харин сэришгүй гүн нойронд автсан гэдэг. Айдас автсан хаан, хатан хоёр тэр даруй охиноо хамгаалах хууль гарган, улс даяараа ээрүүл, зүү болгоныг шатааж, цаашид шинээр үйлдвэрлэхийг хориглов.

Тийм боловч саатсан хараал хамгийн аюултай. Учир нь цаг хугацаа өнгөрөх тусам, хүмүүс энэ талаар мартагнаж, сэрэмжээ алдахад хүрдэг. Үүнээс хойш арван таван жил өнгөрч, хаан, хатан хоёр ч бүх ээрүүлийг устгасандаа, охиноо аюулгүй хэмээн санаа амрав.

Хаан, хатан хоёр хамаг ээрүүлийг устгаж байхаар, охиндоо ээрүүлд хүрэхгүй байхыг заагаад өгчихгүй гэж бодогдох. Тэгээд ч ээрүүл чинь муу биш, сайн эд шүү дээ. Охин нь ээрүүл дээр тун үр нөлөөтэй, чадварлаг ажиллаад сурчихаж болох л байсан шүү дээ. Охин нь ээрүүлтэй харилцаад сурчихсан бол, анх харуутаа л зүүнээс нь бариад авахгүй байж болох л байсан.

Тэгвэл яах байсан? Мэдээж бүх зүйл өөрөөр эргэж, хориотой зүйл нь охины дур сонирхлыг тэгтэл татахгүй байх байв. Гэхдээ хаан, хатан хоёр ихэнх аав, ээж шиг л айдсыг сонссон бөгөөд харин айдас нь хэзээ ч мэргэн зөвлөх болдоггүй. Айдас биднийг мэргэн ухаан, ухаалаг зөвлөгөөгөөр чиглүүлдэггүй, харин ямагт эрс тэс арга зааж өгдөг. Бид ч бас ингэдэг. За, түүх рүүгээ эргээд орё.

Охин маш үзэсгэлэнтэй, ухаантай, хайр булаам залуу бүсгүй болж торнисон бөгөөд аав, ээж нь охиноо тэднээс хол байхдаа ч, дэргэд нь байгаа юм шиг л дуулгавартай байна гэж боджээ. Тэд энэ худлаа баталгаандаа найдан сэрэмж алдаж, цайз доторх ээрүүл хадгалдаг нууц өрөөгөө шалгахдаа умартав. Охины арван таван насны төрсөн өдрөөр хаан, хатан хоёр өөр нэгэн хааны найрамдалт урилгаар харийн хаант улс руу аялахаар явахдаа, охиндоо аав, ээжийгээ эзгүйд томоохон байж, цайзнаасаа гарахгүй байхыг захиад, хурдан буцаж ирэхээ амлажээ.

Гэтэл урьд нь дураараа байхыг үзээгүй охин нь ордонг самнаж үзэхээр шийдэхдээ, аав, ээжийнхээ битүүмжлэлгүй үлдээсэн, яг тэр цайзыг олчихов. Сүйх тэргийн бараа тасармагц охины зүрх яаран догдлов. Өнөөдөр адал явдлын өдөр. Учир нь тэрбээр нууц хаалга болгоны цаана юу байгааг олж мэднэ! Тэгээд мэдээж төд удалгүй утас ээрч байгаа, хуучны ээрүүлийг олов. Гүнж амьдралдаа ийм юм харж байгаагүй учраас, нүд нь орой дээрээ гарлаа. Тэгээд хөвөн зөөлөн ноос тасралтгүй эргэлдэх эрүүлээр дамжин бат бөх утас болон гарахыг нүд салгалгүй харав. Хажууд нь суугаа бөгтөр эмээ ч түүнийг ойртохыг даллав.

Гүнж ойртоод, гараа сунгахад, эмгэн: “Нааш ир, хүрээд үз, ээрүүлийг ав” гэж шивнэнгээ, охиныг улам ойртож ирэхийг зангав. Охин ч үгэнд нь ороод, өндгөө хатган, цусаа гаргалаа. Охин сарвас хийн гараа хойш татсан ч, оройтжээ – толгой нь эргэж, ухаан балартав. Эмгэн жуумагнаад, охиныг сүүдэрт байгаа ор руу дагуулав. Тэр нь нээх муухай хар ор байсан ч, охин эсэргүүцэх ч тэнхэлгүй болжээ. Охин модон шалан дээр унахгүйн тулд орон дээр уналаа. Тэгээд чихэнд нь эмгэний гэнгэнэсэн муухай инээд орж гарсаар, гүн нойронд автав. Түүний ордныг түнэр харанхуй хучин, цайз нь бөөн, бөөн өргөст ургамалд бариулан, олны нүднээс алга болов.

Үүнээс хойш олон жил өнгөрсөөр нойрсож буй гоо бүсгүйн түүх энэ дэлхийн хамгийн эр зоригт, сайхан сэтгэлт, үзэсгэлэнтэй ханхүүгийн ордонд хүрчээ. Өнө эртний энэ түүх нь ам дамжин яригдсаар яваад, сүүлдээ жинхэнэ үү, домог уу гэдэг нь ч мэдэгдэхээ больжээ. Гэхдээ ханхүү мэдэж байв. Ханхүү гүнжийн цөхрөлийг мэдсэндээ, бүх зугаа цэнгэлээ орхиод, маргааш нь ургахын улаан нарнаар гүнжийг аврах аяндаа гарахаар болов. Тэрбээр яарч байв... учир нь гүнжийн сэрэх цаг хэдийн болжээ.

Ханхүү гэрээсээ гараад олон хоног явсаар, алсын нэгэн улсын харанхуй хилд тултал түүнийг таатай угтсангүй. Эцэст нь нэгэн эмгэн хүүхэд байхдаа ээжээсээ хотыг нь хүрээлсэн хязгааргүй, зэрлэг талын цаана байх хар ойд төөрсөн, ганцаардмал гүнжийн түүхийг сонсож байснаа ярьжээ. Ханхүү талархаад, эртний цөлийг ганцаараа гатлав.

Энэ нь маш урт, хүнд аялал байсан тул ханхүүгийн базаасан хүнс дуусав. Ханхүү “зорилгоосоо ухарбаас, хоол хүнсээр дайлаад, дараа нь харанхуйн хаанчлалынхаа титмийг өгөхөөр” амласан дайсантай таарсан ч, сонсолгүй урагшаа давшив. Дайсны санал нь түүний гүнжтэйгээ хамт аавынхаа хаанчлалын алдрыг хуваалцах хүслийн дэргэд юу ч биш байв.

Ханхүү явсаар ойд тулахдаа, энэ нь битүү өргөсөн ширэнгэ байхыг үзэв. Тэрбээр өргөст бут дундуур зам гаргах гэж олон хоног зүтгэсээр, эцэстээ цайзад хүрэв. Цайзын хана туургыг төмөр ороонго битүү ширж ороогоод, хамаг сүр жавхланг нь дарж, зүгээр л нэг аймгийн газар болгожээ. Тэр өргөст бутнууд ганц л өндөр цайзанд хүрээгүй байсан бөгөөд тэр нь мөнөөх гүнжийн нойрсож буй цайз болохыг Ханхүү мэдэв.

Өргөст ширэнгэ дээгүүр хөвөн халих нам гүм: “Эндээс яв, чи хэзээ ч түүнд хүрэхгүй! Тэр минийх” гэж шивнэсэн боловч, Ханхүү тэр нам гүмийг сонсолгүй, өөр нэгэн дууг сонссон нь нойрон дундаа даллан дуудах гүнжийн цөхөрсөн хаихираа байлаа. Ханхүү гүнжийн эцсийн найдвар байв. Ханхүү дахин хүчээ аваад, хүчит илдээ далайгаад, замд нь тээглэж байгаа өргөсүдийг цавчив. Цавчилт болгон Ханхүүг гүнж рүү нь улам ойртуулж, гүнжийг Ханхүүгийнх болгож байв. Ханхүү хаалгыг тийрэн онгойлгов.

Цайзын дотор төө зузаан тоостой, манантаж бүрэлзсэн тогтуун

агаар угтав. Ханхүү гүнжийн цайз руу цагирган шатаар авирсаар, хаалгаар нь ороод, цонхыг нь нээж харанхуйг хөөв. Орон дээр нойрсох гүнжийн дээр нарны алтан цацраг туслаа. Гүнж нэг ч ялзраагүй, нэг ч өтлөөгүй, харин ч улам гоо сайхан болсон мэт.

Олон тулаан хийсэн Ханхүү амьсгаагаа дарсаар гүнж рүү ойртож очоод хартал, гүнж амьсгалж байв. Ханхүү сэтгэл хөдөлсөндөө өмөгнөн уйллаа. Аян замын турш сэтгэлд нь унтрах нь бүү хэл, улам бадарсан хайраараа Ханхүү гүнжээ тэврэн аваад, бүлээн уруулаа гүнжийн амьгүй уруулд хүргээд, юу болохыг нь харахаар гэдрэг зогслоо.

Гүнжийн нүд хүнд зовхин дороо хөдлөн, зөөлөн нээгдээд, тэрбээр толгойгоо эргүүлэв. Гүнж Ханхүүгээ үзээд, нойрмог нүдээрээ хөөрхөн гэгч нь инээмсэглээд, Ханхүүгийн нулимстай хацрыг арчихаар гараа явуулав. Гүнж хуруугаа Ханхүүгийн нулимсанд хүргээд, өөрөө уйлж эхлэв. Тэр зүүдлэж байсан Нэгэнтэйгээ бодитоор учирчээ. Хэзээ ч хараагүй боловч, зүрх сэтгэлдээ мэддэг байсан Нэгэнтэйгээ. Энэ Ханхүү байжээ! Тэр хоёрын хэн, хэнд эргэх зам байхгүй. Гүнж ганцхан харцаараа л Ханхүүгийн зүрхийг олзолжээ. Ханхүү хацар дээрээ буй гүнжийн гарыг бариад, хайрлан үнсэв.

~ Бүх буруу нь зөв болгогджээ. Гүнж хар дарсан зүүднээсээ аврагдаж, зүүд, гэрлийн хаанчлалд аюулгүй хүргэгдсэн.

Тэгээд гүнжээ сэн хийтэл тэврэн харанхуй шоронгоос гаргаад, морин дээрээ сундлав. Урьдын хараал, өгөршсөн цайз ул болжээ. Өнгөрсний хар сүүдэр Түүний хайрын гэрлээс дайжин зугтжээ.

Ханхүү Өөрийнхөө махны мах, ясны ясаа олжээ. Гүнж Ханхүүгийн мөрөөдөл байсан бөгөөд гүнж ч Ханхүүгээ зүүдэнд ч оромгүй хайраар хайрлав. Гүнж дахиж хэзээ ч ганцаардахгүй. Учир нь тэр хоёр нэг болжээ. Тэд даруй хаант улсдаа очоод, Ханхүү сүйт бүсгүйгээ Аавынхаа бүлд танилцуулав. Аав нь тэдний нэгдлийг ерөөн хуримлуулж, анхныхаа шөнө тэдний биес бие биедээ уусч, эдүгээ тэр хоёр бүрэн болжээ. Тэгээд чи төгсгөлийг нь мэднэ – тэд амар сайхандаа жаргасан. Бүх буруу нь зөв болгогджээ. Гүнж хар дарсан зүүднээсээ аврагдаж, зүүд, гэрлийн хаанчлалд аюулгүй хүргэгдсэн. Тэр хоёр бие биеэ олсон. “Амар сайхандаа жаргасан” гэдэг

~ Учир нь Тэр бол амийн Эзэн бөгөөд тэр хосын бүжиг хэзээд өөр цагт ... өөр газар үргэлжилнэ.

нь өдгөөгөөс өнө мөнх гэсэн үг. Учир нь Тэр бол амийн Эзэн бөгөөд тэр хосын бүжиг хэзээд өөр цагт, цаг хугацаа дуусдаггүй, үгээр хэлиггүй баяр хөөртэй, үгээр дүрслэшгүй гоо үзэсгэлэнтэй өөр газар үргэлжилнэ.

Энэ чиний хүсэл, мөрөөдөл, түүх мөн үү? Би Есүс бол чиний Ханхүү бөгөөд чи гүний гүндээ Түүний хайрыг хүснэ. Энэ бол өнө мөнхийн, үзэсгэлэнтэй түүх. Энэ мөрөөдөл эмэгтэй хүн бүрийн эд эсэд даавуу мэт нэхээстэй байдаг. Эсэргүүцэхийн аргагүй хүчирхэг энэ хүсэл нь бидний дотор байх сүйт бүсгүй болгоныг Сүнстэй хамт: “Эзэн Есүс минь, ирээч. Намайг Өөр рүүгээ татаач. Би Тан руу гүйе” хэмээн хашхируулдаг.

Зарим нь: *“Надад ийм түүх, мөрөөдөл, Ханхүү заяахгүй. Би ордонд өсөөгүй. Би олон удаа зүүнд хатгуулсан ч, хэн ч намайг хар дарсан зүүднээс минь сэрээгээгүй”* гэж хэлэх байх. Чи цөхрөлийн сүүдэрт дэндүү удсандаа, насанд хүрээд хүүхэд насны мөрөөдлөө мартсандаа л энэ үнэнд итгэж чадахгүй байгаа аж. Түүний дуудлагад хариулж, дахин мөрөөдөж эхлэх цаг ирээд байна. Тэр чиний дэргэд зогсоод, чамайг Өөр рүүгээ эргээсэй гэж хүсч байна. Юмс дуусчихаагүй байна. Хайртай, үнэнч Ханхүүтэйгээ уулзана гэсэн бат амлалт бидэнд бүгдэд маань бий. Тиймээс тэр өдөр ирэх л болно.

Тиймээс ч Бурхан үлэмжийн дээдээр Түүнийг өргөмжилсөн бөгөөд Алив нэрээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд Тэнгэр, газар дээр, газрын доорх бүгд өвдөг сөгдөж, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж Хэл бүхэн хүлээн зөвшөөрөхийн учир ажээ. (Филиппой 2:9–11)

Тэр л ганцаараа олзонд байгаа сүйт бүсгүйнхээ төлөө тэнгэрийн хаанчлалаа орхиж гарсан, гайхамшигтай, үнэнч, жинхэнэ Ханхүү. Тэр бол: *“Хайрт минь, Над руу ир!”* хэмээн эрин зуунуудыг даван биднийг дууддаг, сэтгэлийн минь Хайрт! Тэр хайртай хүмүүсийнхээ нүглийн хүлээсийг тасдаж, үхлийн нойрыг үлдэн хөөгөөд, сүйт бүсгүйгээ Өөрийнх нь ирэлтэд баяр хөөртэйгээр бэлтгээрэй гэдэг.

Тэгэхээр, бид энэ бүхэнд хэрхэн хариу үйлдэх вэ? Бид Түүн рүү гараа сунгаад, тэврүүлэх үү? Эсвэл биднийг Өөрийн болгохын төлөө хийсэн бүгдээс нь буруулаад, үл итгэлийн, муухай орон дээрээ эргээд хэвтээд өгөх үү? Түүнийг ирэх үед бид Түүнийг өвдөг сөгдөн бишрээд, амлалтынх нь сүр жавхлантай биелэлд баясах уу эсвэл айж сүрдсээр зогсох уу? Чиний дотор үнэн гийж, царай чинь гайхшралаар гэрэлтэж байгаа байх. Чи Ханхүүгээ хүсэн хайж байгаа учраас л энэ номыг уншиж байгаа бус уу?

Библид өөр нэгэн нойрсож буй гоо бүсгүй гардаг. Энэ нь бидний бэлгийн дур хүсэл юм. Бид бэлгийн дур хүслээ цаг нь болтол амар тайван нойрсуулж, зөв цагийг нь болтол унтуулж байх ёстой. Хэзээ сэрэхийг нь бид шийдэхгүй. Хүн цагийг огоордог ч, Бурхан огоордоггүй. Хүсэх хүртэл нь хайрыг сэрээхгүй байх үүрэгтэй бид (Соломоны дуун 2:7). Тиймээс бидний бэлгийн дур хүсэл, хариу үйлдлийг нойрсож буй гоо бүсгүйтэй адилтгаж болно. Мэдээж энэ гоо бүсгүй маань хараал дор унтаагүй, харин цагаа хүлээн унтаж байгаа юм. Ханхүү маань биднийг хүлээснээс чөлөөлнө гэдэгт итгэж байгаа бол, сайн сайханд ч сэрээнэ гэдэгт итгэнэ. Үүнийг лавшруулан ойлгохын тулд Соломоны дуун номын цэц ухааныг харъя.

Иерусалимын охид оо, Талын гөрөөс, марал бугаар андгайлъя. Таашаал дурыг бэлэн болтол нь биттий өдөөж сэрээ.
(Соломоны дуун 2:7)

Энд нүдэнд харагдам дүр зураг байна. Тэртээх алсад гөрөөсийн сүрэг намуухан горхины дэргэд тааваараа идээшлэн, айх аюулгүй зогсоно. Зарим нь найгах мөчирсийн доогуур, зөөлөн өвсөн дээгүүр ганц хоёр гишгэлэн, ганган хүзүүгээ хаяа нэг ихэмсгээр өндийлгөн, энд тэнд аюул байгаа эсэхийг нягтлан шалгана. Тэд дахин шинэхэн өвс зулгаахаасаа өмнө гэрэлт алаг нүдээрээ сэтгэлийг чинь цоо ширтэв.

Тийм боловч эдгээр талын эрхэмсэг номхон гөрөөсүүд, тэдний том алаг нүднүүд дур хүсэлтэй ямар хамаатай гэж? Иерусалимын охидод хандсан энэ үгс бидэнд ямар хамаатай гэж? Бид дөнгөж сая Ханхүү маань нэг л өдөр бидний гоо сайхан, найдварыг сэрээх талаар ярьсан. Тэгвэл энэ хэсэг дээр бидэнд төрөлх хайраа албадан сэрээлгүй, хүлээхийг үүрэгдэж байна. Бидэнд энэ үүргийг Соломоны дуун дээр нэг бус, харин гурван удаа өгчээ. Нью Ливинг Трайнслэйшн дээр амлалтын хүсэлтийн заавар өгсөн байна:

Өө Иерусалимын эмэгтэйчүүд ээ, хурдан гөрөөснүүд, талын бугаар надад зөв цаг нь иртэл хайрыг сэрээхгүй гэж амлаач.
(Соломоны дуун 3:5)

Энд хайрыг сэрээж болохгүй цагийг маш тодорхой заажээ: “Зөв цаг нь иртэл...” Энэ ятгалгад дээрхээс илүү эрч хүч оршиж байна. Талаар хурдан гэгч харайлган давхилдаж, бараагүй одох гөрөөсийн сүрэг харагдах шиг. Түүнчлэн бас өндөр ургамлыг сэтлэн гарахаар догшрон оволзох зэрлэг буга харагдах шиг. Гөрөөсүүд толгойгоо өргөн, эврээ бэлтгээд, аливаа дуу чимээг олзлохоор чихээ сойтоолгох бөгөөд навчис шарчигнахын төдийд л

ухас хийлдэн алга болно. Яагаад гэдгийг мэдэхгүй. Гэхдээ надад энэ ишлэл дээрх дөрвөн хөлт нөхөд маань ямар нэг зүйл рүү бус, харин ямар нэгэн юмнаас дөлж зугтаж байгаа мэт санагддаг юм. Гурав дахь анхааруулгыг 8-аар бүлгээс олж болно:

Иерусалимын охид оо, Таашаал дурыг, бэлэн болтол нь битгий өдөөж сэрээ. (Соломоны дуун 8:4)

Энд мөн л охид, эмэгтэйчүүдэд хайрыг нойрноос нь сэрээхгүй байхыг үүрэгджээ. Үүнийг бид биш, Ханхүү л хийнэ. Бид хайрыг цагаас нь өмнө сэрээчих юм бол, хайр нь уулын буга шиг нэг харахад байж байснаа, дахиад харахад гоо үзэсгэлэнгээ аваад талийна. Бэлгийн таашаалыг айлгалгүйгээр эдлэхэд тэвчээр хэрэгтэй.

Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. Итгэлийн чинь шалгуур хатуужилд хүргэдгийг та нар мэдэх билээ. Хатуужил нь төгс үйл байг. Тэгвэл та нар төгс, бүтэн юугаар ч дугахгүй байна. (Иаков 1:2-4)

Бурхан бидэнд төгс төгөлдрийг хүсдэг. Бас төгс цагийг хүсдэг. Хайр сэрэх үед биднийг зөв газраа бэлэн байгаасай гэж хүсдэг. Тэр биднийг

ял, шившиггүй, таашаалын цэцэрлэгээс эрх дураараа хүртээсэй гэж хүсдэг. Хүлээлтийн үе нь дурлалт хосын дунд санагалзал, хүслийг төрүүлдэг бөгөөд хүсэл нь том байх тусам, дур хүсэл, эцсийн биелэл нь том байна. Амьдралын хамгийн чухал зүйлс хүлээлтийн ачаар л ирдэг. Гэхдээ

~ Хүлээлтийн үе нь дурлалт хосын дунд санагалзал, хүслийг төрүүлдэг бөгөөд хүсэл нь том байх тусам, дур хүсэл, эцсийн биелэл нь том байна.

эцсийн дүнд хүлээсний гавъяа гарна. Биелсэн санаашрал нь амийн мод болой (Сургаалт үгс 13:12). Бурханы амлалт нь ямагт амийг дагуулдаг.

Үүнийг илүү сайн ойлгохын тулд анх эр, эм хоёрын дунд хайр сэрсэн түүхийг үзье. Адам өөртөө хань болох нэгнийг амьтдын ертөнц дундаас цөхрөнгүй хайсан боловч, Цэцэрлэгийн гоо үзэсгэлэнгээс ч, араатан амьтдын дундаас ч олоогүй. Тэгээд ямар ч үр дүнгүй, туйлдмаар хайгуулын дараа Бурхан Адамыг амар гэжээ.

Бурхан Адамыг гүн нойрсуулаад, амрах хойгуур нь Еваг гаргаж авсан. Адамын мөрөөдөл биелжээ. Адам өмнө хайрлаж дурлаж үзээгүй боловч, Еваг харуугаа л хайрлан дурласан. Бурхан Адамд: “Одоо тайван амар. Учир нь чи хичнээн хайлаа ч, хайгуулаа олохгүй. Надад итгээд, унтаад,

амраад, зүүдлэ. Чиний хүслэн болоод байгаа зүйлийг чинь Би чиний яг хажуугаас гаргаж ирнэ” хэмээв.

Адам Бурханд найдан, хэвтээд энэ бүхэн ямар байхыг, ямар байх ёстойг зүүдлэжээ. Учир нь хайр зүүдээр эхлэдэг. Зүүдийг шөнийн харанхуйгаас өдрийн гэрэл рүү нүүлгэхийн тулд Бурханд өргөх хэрэгтэй. Бид зүүдээ Бурханы тахилын ширээн дээр тавихдаа, биелэл болгодог юм. Бидний гүн хүсэл биелэхийн өмнө ихэвчлэн үхэл, гутрал хоёр ордог.

Адам толгой тавихтайгаа зэрэгцэн хайгуулаа тавьжээ. Адам амиа орхисноороо, өмнөө зүүднийхээ биеллийг харна гэж итгэжээ. Хайр ямагт бидний хүсэл, мөрөөдөл байдаг. Тийм боловч үүнийг хайрын Ханхүү Өөрөө сэрээх хүртэл нь амраах ёстой ажээ. Тэр бидний дотор Өөрөө суулгасан зүйлээ няцаахгүй.

Та түүнд зүрхнийх нь хүслийг өгсөн бөгөөд Уруулынх нь гуйлтад татгалзаагүй. (Дуулал 21:2)

Бэлгийн дур хүслээ амраагаад, Бурханы зүүдийг зүүдлэ. Бурхан амлалтаа итгэмжтэй биелүүлдэг. Бурхан биднийг Өөрт нь гагцхүү итгэхийг л хүснэ. Найдваргүй амьдрал, хар дарсан зүүднээсээ сэргэж, Түүний амлалт дотор амар. Бурхан бүх зүйлийг хянаж байгаа гэдгээ амласан.

Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм. (Иеремиа 29:11)

Тэр худлаа ярьж чадахгүй учраас, Түүний үг баттай. Бүгдээрээ Бурханд дараах залбирлыг өргөө:

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Намайг хар дарсан зүүднээс сэрээж, Өөрийнхөө зүүдэнд оруулахын тулд хүлээс бүрийг тасдаж, хана бүрийг нураахаар Хүүгээ илгээсэнд баярлалаа. Би зөвт байдалд сэрж, үнэний гэрлийг хүлээн авч байна. Та Өөрөө сэрээх хүртэл би дур хүслийн талбараа унтуулах болно. Намайг хэтэрхий эрт сэрээх алив сэрүүлгийг унтрааж, Таны амлалтаар сэтгэлээ тайтгаруулъя. Таны төлөөлөгөө намайг хохироохгүй. Та надад найдвар, ирээдүй өгөхдөө дуртай байдаг гэдэгт би итгэж байна. Та намайг надаас ч илүү мэддэг учраас, би биелээгүй зүүд бүрээ Таны тахилын ширээн дээр тавина. Би Танд бүх айдас, гутралаа өргөж байна. Би Таны мутарт аюулгүй амрах болно.

Таны хайрт охиноос.



6 *Жинхэнэ Үнсгэлжин*

Ханхүү яаж сүйт бүсгүйгээ сонгодог вэ? Гоо бүсгүйчүүдийг шалгаруулдаг журмаар уу? Нэгэн газар энэ дэлхийн хамаг л гоо бүсгүйчүүд цугларчээ. Тэд бүгдээрээ л гоо үзэсгэлэн, бие галбираараа төгс, авъяас бэлэгтэй, мөнгөтэй, боловсролтой, залуу бөгөөд хүчтэй. Тэд Түүний өмнө дуу алдам гоо үзэсгэлэнгээ гайхуулна. Хүн бүр яагаад чухам тэр л Түүнийх байх ёстойг үнэмштэл ярина. Ханхүү анхааралтай сонсоод, тэднийг үнэхээр хайр татмаар болохыг нь зөвшөөрнө. Тэдгээр эмэгтэйчүүд ялзууртан бүсгүйчүүд ажээ. Тэд бол бидний даган дууриахыг хүсдэг анги ажээ. Тэд бол энэ дэлхийн сор болсон хүүхнүүд ажээ. Тийм боловч тэдний гоо үзэсгэлэн ч Түүний эрхэмсэг төрхийн хажууд бас л жулдах. Түүнтэй хэн ч эгнэшгүй.

Гэтэл Тэр сүйт бүсгүйгээ Өөрөө сонгоно гэв. Сүүлчийн бүсгүй ярьж дуусахад, Тэр дараагийнх нь гэж дуудсан боловч, хүн гарч ирсэнгүй. Ханхүү суудлаасаа босоод, энэ их гоо үзэсгэлэнгийн далай дээгүүр өнгийгөөд, тэртээ мухарт сүүдэрт суугаа, Түүний өмнө гарч ирж зүрхлэхгүй байгаа охидын зүг харав. Тэрбээр харанхуйг хага яран зөөлөн алхалсаар, царай муутай, бөгтөр, үзэшгүй муухай, хэн ч биш хүмүүсийн дунд нэвтэрч ороод, Өөрийнхөө хайж байсан нэгнийг олно. Тэр огт хөөрхөн биш... царай муутай, хэлбэр галбиргүй, үхлүүт царайтай. Түүнд язгууртан төрх ч байхгүй. Тэрбээр нүглээс бий болж, өөрийнхөндөө ч гадуурхагдсан амьтан. Ханхүү маань түүний бөгтийсөн хэлбэр дээгүүр тонгойж ирээд, түүнийг Өөрийнхөө сүйт бүсгүй гэв!

Бидний Ханхүү энэ дэлхийн язгууртан хагагтай нартай хөөцөлддөггүй... Тэр тийм биш. Тэр шоовдрыг хайдаг. Тэд голдуу хамгийн бузар газар нуугдаж,

хамгийн дорой нөхцөлд амьдардаг учраас, тэднийг л хайдаг. Тэдгээр шоовдор, хүлээтэй, хаягдсан хүмүүсийг хайх нь Түүний даалгавар бөгөөд Тэрбээр итгэл найдваргүй, дорой газрын оршин суугчдыг л хайрлан халамжилдаг юм.

Би, төөрснийг нь хайн туугдсаныг нь буцааж, гэмтсэнийг боож өвчтэйг тэнхрүүлнэ. Харин тарган ба тэнхлүүнийг Би устгах болно. Би тэднийг шударга ёсоор тэжээнэ. (Езекиел 34:16)

Өөр нэгэн Бичээс дээр:

“Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв”
(Лук 19:10) гэдэг.

Түүний хайгуулыг дагацгаая. Энд нэгэн цонх байна. Тэр цонхоор та нарын огт мэдэхгүй нэгэн бүсгүйн амьдрал руу өнгийе. Тэр бол хүсээгүй хүүхэд. Түүнийг төрөхөд хайраар өлгийдөж авалгүй, хар сэтгэлээр угтжээ. Ийм охидын тавилан яадаг билээ? Тэднийг энэ дэлхий дээр төрөөсэй гэж хэн ч хүсээгүй, тэдний төлөө хэн ч залбираагүй. Тэд ганц удаагийн ойртолт юмуу хүчирхийллээр эхийнхээ хэвэлд олджээ. Ийм охид яадаг билээ?

Бяцхан амьтан хүний нүднээс далд төрж, дараа нь хаягджээ. Ээжийнхээ хайр, зөөлөн хөхнийх нь илчийг, аавынхаа царайны дүр дүрсийг ч мэдэхгүй.

Эцэг нь хувь заяаг нь нэг ч хайхраагүй, ээж нь нэг ч удаа бүүвэй аялж, нулимсыг нь арчиж, зөөлөн гараараа илбээгүй. Харин ч бүр үхэг гээд хахир хүйтэнд хаяжээ... нэг ч эргэж харсангүй, нэг ч сэтгэл хорогдсонгүй.

Тийм нэгэн нялх охин үрийг харцгаая.

Харж байна уу? Тэрбээр хээр, замын хажууд хаягджээ. Хэн нэг нь олоод, хөөрхийлж авалгүй л бол, үхнэ. Гэхдээ ийм гологдмол хувь тавиланд хэн санаа тавьдаг вэ? Бурхан нүглийн үрээс нүүрээ буруулж, түүнийг шившгийн өв болгодог уу?

~ Бурхан нүглийн үрээс
нүүрээ буруулж, түүнийг
шившигийн өв болгодог уу?

Төрсний чинь тухайд бол төрсөн өдөртөө хүй чинь таслагдаагүй, цэвэрлэх гэж чамайг усаар ч угаагаагүй. Чи давсаар ч үрүүлээгүй, даавуугаар ч өлгийдүүлээгүй. Чамайг өрөвдөн эдгээр үйлийн нэгийг ч болов чамд үйлдэхээр нэг ч нүд чамайг энэрэн хараагүй. Харин чамайг хээр талд хаясан. Учир нь чи төрсөн тэр өдөртөө жигшигджээ. (Езекиел 16:4–5)

Үнэхээрийн зурх зүсэгдмээр үзэгдэл ажээ. Шинээр мэндэлсэн нялх охин хатсан ихсээсээ тасраагүй хүйтэйгээ орооцолджээ. Нэгэн цагт түүнийг амьдруулж байсан зүйл нь эдүгээ могой мэт ороожээ. Наранд хүй нь улам хатсаар, нялх амьтны хөдөлгөөн бүртэй зэрэгцэн өөдсийн чинээ биеийг нь улам л чангална. Нярай төрөхийн ус, цусан шалбааг дундаа хэвтэнэ. Зулай дээр нь эхийнх нь цус халтартаж, боогоогүй хүйнээс нь өөрийнх нь цус шүүрнэ. Энэ бүх шингэн нь шороотой хутгалдаад, бөөн шавар болжээ.

Одоо бүгдээрээ энэ түүхийн өөр нэгэн дүрийг харцгаая. Энэ яг үеэр тэр талбайгаар Ханхүү явж таарав. Магадгүй шинэ өдрөө эхлүүлэн бясалгаж явсан ч юм билүү. Бүгдээрээ энэ язгууртан залуугийн нүдээр үйл явдлыг харцгаая. Товчхондоо Ханхүү охиныг олжээ. Эсвэл бүр магадгүй зориуд хайж явсан ч байж мэдэх. За ингээд Ханхүүг явж байтал, хаа нэг газраас нялх хүүхдийн уйлах дуу бас тариан түрүүн шарчигнах чимээ чих дэлсэв. Ханхүү зогсоод, талбайг нэгжив. Дахиад л нөгөө чимээ... шархадчихсан амьтны гийнаан юм болов уу? Үгүй ээ, хүний үр төл байна. Гэхдээ ойр хавьд амьд амьтан алга. Ээж нь ч харагдсангүй. Дахиад чих тавив. Нар хөөрсөөр зулай дээр гарахад, тэртээ холоос нялх амьтны уйлаан дөнгөж дуулдав. Ханхүү талбайг сайтар самналаа. Түүний хөдөлгөөнийг даган тариан түрүү шарчигнах учраас, хүүхэд чухам хаанаас дуугараад байгааг олох түвэгтэй байв. Тэгтэл тэр байна!

“Би дэргэдүүр чинь өнгөрч, чамайг цусандаа тийчлэн байхыг харсан. Цусан дундаа хэвтэж байхад чинь Би чамд “Амьдар!”... гэж айлсдан билээ (Езекиел 16:6).

Шороо, шавартай хутгалдсан шалбааг дунд дөнгөжхөн тийчигнэн уйлагнах нялх охин! Ханхүү энэ амьтанд амьд гарах боломж байгаа эсэхийг гайхан, охиныг шалгах хооронд байдал даанч найдваргүй, даанч ирээдүйгүй харагдаж байв. Тэр охин харанхуйд амьдардаг, хотын янханы охин гэдэгт Ханхүү эргэлзсэнгүй. Цөхөрсөн тэр эхэд энэ хүүхэд юу ч биш. Энэ охин тариачны охин биш... тэд үр хүүхдээ ингэж хаяхгүй.

~ Духан дээр нь нэг бичиг байхыг үзэв. Энэ нь эхийнх нь “Үх!” гэсэн тунхаг байв.

Ханхүү бодлоо... энэ хүүхэд ингэж нууцаар төрөөд, нууцаар үхэх нь дээр ч юм болов уу? Ханхүү дахиад л мөнөөх амь тэмцэж буй, халтар охиныг хараад, духан дээр нь нэг бичиг байхыг үзэв. Энэ нь эхийнх нь “Үх!” гэсэн тунхаг байв.

Ханхүү охин руу илүү ойрттол, нүдээ ч нээж амжаагүй байгаа

охин гэнэт Түүн рүү харах шиг болов. Ханхүүгийн сэтгэл урагдаад явчихав. Ханхүү охиныг бохирос нь аваад: “Амьдар!” хэмээн тушаав. Голоос нь олгойдон гарсан ганц хаиххираа үхлийн ялыг амийн хүч болгожээ. Түүний тэр дуунд нярай охин бондгос хийн цочихдоо, Ханхүүгийн нүүрэнд сарвас хийн хурэв. Ханхүүгийн тусгал дор нялх охин амьд явах утга учраа олжээ.

~ Ханхүүгийн тусгал дор нялх охин амьд явах утга учраа олжээ.

Ханхүү охины хүйг түргэхэн гэгч боогоод, цусыг нь тогтооход хамаг гар нь цус болсон байв. Тэгээд нөмрөгөө ганцхан сэт хийтэл тайлаад, хааныхаа нөмрөгөөр охиныг өлгийдөв. Ханхүү давхисаар ордондоо ирээд, өөрийг нь өсгөж бойжуулсан асрагчийнхаа гарт охиныг даатгав. Ханхүүгээс хэний хүүхэд болох... хэдий хүртэл байхыг нь асуухад, Тэрбээр шууд л: “Энэ охин хэнийх байсан нь хамаагүй... одоо Минийх болсон. Төрсөн үрээ нэр ус ч үгүй, үхүүлэхээр хаясан хүмүүс түүний эцэг эх байх эрхгүй. Гэхдээ би түүнийг авран сэргээсэн. Би түүний Асран хамгаалагч бөгөөд Өмгөөлөгч” гэжээ.

Охиныг угааж, төрөхийнх нь шившигийн бохирыг арилтал нь давсаар үрэв. Охин Ханхүүгийн зарц нараар сувилуулан асруулж, овоо хөөрхөн болмогц нь Ханхүү түүнийг Хааны талбай, цэцэрлэгийн сахиулын гэр бүлд өгчээ. Охин эрүүл саруул өсч торнисоор, цустайгаа хутгалдан хэвтэж байсан тэр л тариан талбай дундуураа хөгжилдөн гүйнэ. Гэхдээ охин өнгөрснөө огт мэдэхгүй. Тэрбээр гагцхүү Ханхүүгээр авруулж, Түүнийх болсон гэдгээ л мэддэг байв. Ханхүү охиныг байн байн эргэж, алсаас халамжилсаар, хэрэгцээ бүрийг нь хангана.

Тэгээд чи өсөөд, өндөр болж, сайхан чимэглэл зүүх насанд хүрчээ. Хөх чинь томорч, үс чинь ургаж гүйцэв. Гэсэн ч чи нүцгэн, шалдан байв. (Езекиел 16:7)

Тэр их хангалуун байдал, гоо үзэсгэлэн дунд охин Хааны талбайн үр жимс шиг л цэцэглэв. Учир нь Хаан түүнийг цэцэглүүлжээ. Тэр юугаар ч дутаагүй, аз жаргалтай хүүхэд насыг үзэв. Түүнд ичгүүрийн ул мөр ч үгүй. Тэр яг л Хааны охин шиг харагдана. Тэрбээр хайранд нүд баясгам, гялалзсан эрдэнийн чулуу мэт умбаж өссөн бөгөөд эдүгээ энэ их хайр, гэрлээ түгээн гайхуулна. Түүний хөх хэлбэршин бондойж, урт гэзэг нь цэцэглэж буй бүсгүй чанарыг нь нууцлана. Тэрбээр дотроо бас л хүүхэд хэвээрээ бөгөөд хайрлаж дурлах нас нь айсуу боловч, хараахан болоогүй ажээ. Цаг хугацаа өнгөрсөөр.

Би чиний хажуугаар өнгөрч, чамайг харсанд, үзэгтүн, чи хайрлуулах насан дээрээ байжээ. Тиймээс Би хормойгоо чиний дээгүүр дэлгэж нүцгэнийг чинь халхалсан. Би бас чамд тангараглан чамайг Минийх болгохоор чамтай гэрээнд нэгдсэн» гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. (Езекиел 16:8)

Нэгэн удаа Ханхүү охин дээр ирэхдээ, өөдөөс нь угтан намбалзан гүйх бүсгүйг хараад, цаг нь болсныг ойлгожээ. Охин бүсгүй болжээ. Шилжилт гүйцжээ... охин одоо бүсгүй болжээ. Хөх нь бүрэн гүйцэт ургаж, ташаа нь дугуйран, хөл нь урт нарийхан болжээ. Тэрбээр бүсгүй хүний хайраа өгч, эр хүний хайрыг хүлээн авахад бэлэн болжээ. Тийм боловч тэр битүүмжлэлтэй байна. Тэр шинэ гэрээнд бэлэн болжээ.

Ханхүү дахиад л нөмрөгөө тайлан, охинд нөмрүүлээд, хамтдаа зугаалав. Тэрбээр энэ удаа охинд Асран хамгаалагчийнх нь хувьд биш, харин эр нөхрийнх нь хувьд амь амьдралаа зориулах амлалт өгөв. Тэрбээр энэ талбайд хаягдсан охины төлөө хаадын язгууртан охидоос татгалзжээ. Охин Өөрийг нь ах, аврагч, хангагчийнх нь хувьд хайрлагчийг Ханхүү мэднэ. Тэгээд энэ удаа охиноос сүйт бүсгүйнх нь хайрыг хүснэ.

~ Тэрбээр энэ талбайд хаягдсан охины төлөө хаадын язгууртан охидоос татгалзжээ.

Гэтэл охин өөрийнх нь хамгийн том мөрөөдөл биелж байгаад итгэж ядав. Ханхүү түүний гарыг гүйжээ. Охин бүх зүрхээрээ зөвшөөрөөд, ариусгал, гоо сайхны үйл явцаа эхлүүлэхээр сахиулын гэрийг орхин, хааны ордонд хүргэгдэв. Эмэгтэй зарц нар охины хэрэгцээ бүрийг хангаж, түүнийг Ханхүүд зориулан бэлтгэнэ.

Тэгээд Би чамайг усанд булхан чамаас цусыг чинь угаан чамайг тосоор тосолсон. (Езекиел 16:9)

Охины гоо сайхны ёслол—амийн Эзэн рүү тусгаарлах бэлгийн ариусгал нь сарын тэмдгийн цусыг цэвэрлэх энгийн үйл явцаар эхлэв. Түүний дөнгөж цэвэрлэсэн арьсан дээр анхилуун үнэт тос түрхэн, хуурайшиж, загатнаж, улайсан хэсэг бүрийг зөөллөн чийгшүүлэхээр үрж илбэнэ. Охин яг л шинэ дарсанд бэлтгэгдэн буй дарсны тулам шиг байлаа.

Охин одоо гүн нойрсож, Ханхүүтэй туулах ирээдүйгээ зүүдлэнэ. Ханхүү бол түүнийг тэгтэл хайрласан цорын ганц Эрэгтэй. Ханхүү бол түүнтэй тийм эелдэг зөөлөн ярьсан цорын ганц Эрэгтэй. Охин Ханхүүг ямар их хайр, дур хүсэл, хангамж, сайн сайхнаар дүүрэн болохыг мэднэ. Охин энэ бүхэн дунд дулаацна.

Одоо хувцсаа сонгох цаг болжээ. Ихэнх сүйт бүсгүйчүүд хуримын хувцсаа өөрөө сонгодог бол, охины хувцсыг Ханхүү сонгож өгчээ.

Би бас чамайг хатгамалтай хувцсаар хувцаслаж, хөлд чинь далайн гахайн арьсан шаахайг өмсгөсөн. Би чамайг нарийн маалингаар ороож, торгоор бүрэв. (Езекиел 16:10)

Ханхүү тэр хувцсанд мөнгө хайрласангүй. Тэр хувцас яг л Ханхүүгийн цэцэрлэгийн цэцэгс шиг л тансаг ажээ. Охин дотуураа хамгийн тансаг маалинган хувцас өмсөж, дээгүүр нь Ханхүүгийн Өөрийнх нь хувцаснаас ч тансаг хувцас өмсөв. Охин үүн шиг тансаг юм үзээгүй. Тэр хувцас болгоноо илбэж үзэн, өөрийнх нь гэдэгт итгэж ядна. Хувцас болгон нь түүнд зориулсан Ханхүүгийн хайр, түүний язгууртны байр суурийн мэдэгдэл ажээ. Охин Ханхүүтэй оройн зоог барихдаа, хувцас болгоноо Ханхүүдээ өмсөж үзүүлнэ. Охин гэрэлтэж байв. Гэхдээ бас болоогүй ээ:

Би чамайг гоёлоор гоёхдоо гарт чинь бугуйвч хийж, хүзүүнд чинь зүүлт зүүлгэж Би бас хамарт чинь гархи хийж, чихэнд чинь ээмэг зүүгээд, толгой дээр чинь үзэсгэлэнт титмийг тавилаа. (Езекиел 16:11–12)

Ханхүү түүнийг улнаасаа зулай хүртлээ үзэсгэлэнтэй хэмээв.

Шинэ өдөр болгон шинэ гэнэтийн бэлэг ирнэ. Ханхүү охины нарийнхан гарыг бугуйвчаар

ороож, гоолиг хүзүүнд нь тансаг зүүлт зүүж өгөв. Бас чихэнд нь ээмэг, хамарт нь гархи зүүгээд, толгой дээр нь титэм тавив. Ханхүү түүнийг улнаасаа зулай хүртлээ үзэсгэлэнтэй хэмээв. Түүний учир битүүлэг төрөлтийг хэн ч таамаглахгүй. Охин Ханхүүгийн нандин халамж, гал халуун хайрын гялалзсан тусгал буюу.

Ийнхүү чи алт, мөнгөөр гоёж, өмсгөл чинь нарийн маалинга, торго ба хатгамалтай даавуугаар хийгджээ. (Езекиел 16:13а)

Охин нарны гэрэл шиг алт, сарны гэрэл шиг мөнгөөр гоодов. Энэ их гоёл түүний арьсан дээр бүжээд байх шиг л. Түүний маалинган дотуур хувцас хамгийн үнэт торго, тансаг даавуун оруулгатай бөгөөд бүгдийг нь ганцхан түүнд л тусгайлан урлажээ. Ханхүү л үүнийг тушаасан. Охины гоо үзэсгэлэнтэй хэн ч, юу ч эгнэхгүй.

Чи сайн гурил, зөгийн бал, тосыг идэв. Тиймээс чи ихэд үзэсгэлэн гоо, хатан мэт тэргүүн алдартай болсон. (Езекиел 16:13б)

Ханхүү охиныг хамгийн сайн буудай, тунамал бал, баялаг тосоор хооллоно. Охин Ханхүүгийн сайн сайхнаар найрлаж, улам л үзэсгэлэн төгөлдөр болсоор. Хайрыг тэмдэглэх цаг нь болсон болохоор, хурим найрын өдрийг товлож, зочид төлөөлөгчид иржээ. Ханхүүгийн бүсгүй хэн болох талаар бүгд л жиг жуг хийж, гайхна. Тэр хаанаас гаралтай... ямар бүсгүй вэ? Олон хүн Ханхүүгийн цэц ухаанд эргэлзэнэ – Яагаад хааны, язгууртан охинтой гэрлэсэнгүйв? Яагаад борчуудын охинтой гэж? Тэгтэл тэд охиныг үзээд, тэрбээр Ханхүүгийн хайрынх нь төгөлдөршил болохыг харна. Тэрбээр Ханхүүгийн далбайг толгой дээрээ мандуулсаар Түүний баруун гарт заларна. Найр дуусмагц, Ханхүү түүнийг гар дээрээ сэвэлтэл өргөөд, Хааныхаа өрөө рүү аваад явна. Тэнд охин Түүний гүнж болно. Тэдний хайр гал халуун, үзэсгэлэнтэй бас янаг. Ханхүү охиныг нууцаар хайрласан ч, энэ хайр төдөлгүй бүгдэд ил болсон. Учир нь Ханхүү хэнийг ч нууцаар хайрладаггүй юм.

Учир нь Ханхүү хэнийг ч нууцаар хайрладаггүй юм.

Дараа нь гоо үзэсгэлэнгээс чинь болж чиний нэр алдар үндэстнүүдийн дунд тархав. Учир нь чамд Миний соёрхсон сүр жавхлангаас минь болж энэ нь төгс байсан» гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. (Езекиел 16:14)

Бүсгүй хүн бүр төгс байж, төгс хайрлуулах санаашралтай. Үүнийг тэрбээр ганцаараа хийж чадахгүй. Тийм ээ, охин хөөрхөн байсан ч, гагцхүү Ханхүү л охинд Өөрийнхөө эрхэмсэг чанарыг хайрласнаараа, охиныг улам гоо болгожээ. Эрхэмсэг чанар нь газар дээр тэнгэрийн хэлтэрхийг харуулсан, дээд ертөнцийн ойлголт. Эрхэмсэг гэдэг үг нь газрын ойлголтоос хол давсан сүр жавхланг тээдэг. Үүний нүд гялбам, гайхамшигтай сүр жавхлан нь биднийг алмайруулдаг. Бурханы бүтээсэн Цэцэрлэг дотор Еваг ямар гоо үзэсгэлэн халхлаж байсан бэ? Магадгүй эрхэмсэг байдал нь арилсан учраас, Ева нүцгэнээсээ ичэж, биеэ халхласан юм болов уу? Магадгүй л юм.

Энэ бол хавьгүй гүн утга агуулгатай Үнсгэлжингийн түүх. Энэ түүхэнд нас барсан аав, ээж биш, харин хайрлах сэтгэлгүйдээ хаяад явсан аав,

*Энэ бол хавьгүй
гүн утга агуулгатай
Үнсгэлжингийн түүх.*

ээж гарч байна. Энэ түүхэнд үнсэн царайтай халтар охинд зуух бараадаж дулаацахыг ч зөвшөөрдөггүй, харгис муу хойт эх ч байхгүй. Бас Үнсгэлжинг Ханхүүгийн зүрхийг булаатал нь гоёж гоодоод өгсөн шидэт авхай ч алга.

Энд ямар ч гавьяагүй, зүгээр л үхэж буй, нэр ус ч үгүй, өрөвдмөөр амьтан байгаад сайхан сэтгэлт Ханхүүгийн ачаар аврагдаж, хайрлуулсан охин л гарч байна. Тэнд шөнийн арван хоёр цаг гэдэг хугацаа байхгүй. Тэнд мөнхийн гэрээ л бий. Түүнчлэн хэврэг, шилэн гуталны оронд охины үүсэл гарлын талаарх бүх асуултын амыг таглах гэрлийн хувцас... эрхэмсэг байдал бий.

Хэдийгээр бид төрөхдөө хээр хаягдаж, үхэх шахаагүй боловч, энэ түүх их бага хэмжээгээр бидний мөрөөдлийг дүрслэж байна. Магадгүй Бурхан Өөрийнхөө зүүдийг эмэгтэй хүн бүрийн зүрхэнд суулгасан учраас тэр байх. Энэ түүх нь зүгээр нэг гологдож, хаягдсан охины авралын түүх биш юм. Тэр бүү хэл Израильд болоод Чуулганд хамаатай, эш үзүүллийн хэрэгжүүлэлт төдийхөн ч биш юм. Энэ үг бидэнтэй өнөөдөр ч ярьж, биднийг нүгэлдээ үхэлгүй, харин Ханхүүтэй амьдрахыг тушааж байна. Ийм аугаа хайр дурлалын түүхэнд ямар ч эргэлзээ байхгүй мэт. Тэр хаягдмал охин Ханхүүгийн өршөөл, нигүүлслийг мэдэхийн дээдээр мэднэ. Мэдээж тэр хоёр амар сайхандаа жаргах ёстой. Гэтэл энэ түүхийн төгсгөлийг би үзэн яддаг. Учир нь төгсгөл нь эхэлбэрээсээ ч илүү эмгэнэлтэй.

«Даанч чи, гоо үзэсгэлэндээ найдаж, нэр алдраараа садарлан хажуугаар өнгөрөгч болгон дээр янхандалаа асган өөрийгөө тавьж өгсөн.
(Езекиел 16:15)

Аймшигтай! Яаж ингэтэл хайрлуулж халамжлуулсан хүн тийм аугаа, өгөөмөр, цэвэр хайраас буруулдаг байна аа? Охин Ханхүүдээ итгэхийн оронд яагаад Ханхүүгийн түүнд өгсөн гоо үзэсгэлэнд итгэнэ вэ? Яагаад хүндэтгэл, алдраа эрчүүдийг татахын төлөө ашиглаж, өөрийгөө гүнжээс янхан болгон бузарлана вэ? Яагаад өөрийг нь нүцгэн шалдан үхэж байхад нь хажуугаар нь өнгөрөөд явсан, өөрт нь юу ч өгөөгүй хүмүүсийг илж таална вэ?

Хэрэв бид зүрх, үйлдлээ шударгаар нягтлах юм бол, дийлэнх маань Ханхүүгээсээ их бага хэмжээгээр урвасан л байдаг. Бид гоо үзэсгэлэн, алдартаа найдаагүй байж болох ч, энэ итгэмжгүй дэлхийд таалагдахын тулд анхныхаа жинхэнэ хайраас аажмаар буруулсан байж болох.

Ханхүү маань хаягдсан, гологдсон эмэгтэйчүүдийг цэвэрлэж, гоодоход хэзээд бэлэн. Тэрбээр биднийг нэг бүрчлэн нүглээс авраад, бидний үхлийн ялыг хүчингүй болгосон. Тэр биднийг өнгөрснөөс маань таслаж, бидний завхарсан харилцаа, үр хөндөлт, айдас, цусны асуудлыг шийдвэрлэсэн. Бид Түүний хайрыг бүрэн зөвшөөрөх үү? Эсвэл өөр газраас хайр хайх уу? Бид өөрсдийг маань эрхэмсэг чанараараа ариусгаж, төгс болгосон Түүнд л татагдсаар байх уу эсвэл таалал, ерөөлд нь нүд унагаж, ухаанаа алдах уу? Бид Түүний сайн сайхан, өршөөлд хэрхэн хариу хандах вэ? Бид эсэргүүцлийн хувцсаа тайлаад, үрчлэлийн сүнсэнд зам тавьж өгөх үү эсвэл өөрийгөө гоё сайхан гэдгийг батлуулахын тулд олон тооны бэлгийн харилцаанд орох уу?

*Ханхүү маань
хаягдсан, гологдсон
эмэгтэйчүүдийг цэвэрлэж,
гоодоход хэзээд бэлэн.*

Бид: “За боллоо, би бүрэн болчихлоо!” гэж хэлэхийн тулд хэдэн хүний өвөрт орох ёстой вэ?

Бид: “За боллоо, би бүрэн болчихлоо!” гэж хэлэхийн тулд хэдэн хүний өвөрт орох ёстой вэ?

Бид гоо үзэсгэлэндээ найддаг бол, үнэ цэнэтэй, хүсүүштэй эмэгтэй гэдгээ батлуулах гэж цаг ямагт бусдын араас гүйнэ. Бидний өөрийгөө үнэлэх үнэлэмж цаг үргэлж бусад эмэгтэйчүүдтэй өрсөлдөж, ямагт аюултай нөхцөлд байна.

Тэр хаягдсан охин ямар хангамжинд байсныг дахиад харна уу: ер бусын, баялаг, бялхсан. Бид түүнийг ийм сайхан хайрыг хаяж явдаг, зохисгүй, тэнэг хүүхэн гэх байх. Тийм боловч эхлээд өөрсдөө түүнээс сургамж авцгаая.

Энэ бол авралын түүх бөгөөд энд гавьяатай хүн байхгүй. Энэ бүхнийг хайр, хангамжиндаа умбуулах сүйт бүсгүйгээ үгүйлэн санасан Ханхүүгийн сэтгэл л хийсэн билээ. Өөрт нь талархаж, эргээд Өөрийнх нь үзэсгэлэнт дүрийг хараад, өөр хэний ч царайг хүсэмжлэхгүй сүйт бүсгүйг.

Энэ бол бидний тухай түүх. Бид амьдралынхаа эхэн дээр найдвар тасраад, үхэж байсан. Гэтэл хээр талд өвдөж, зовж, нүгэлдээ амь тэмцэж байгаа чиний уйлааныг Ханхүү сонссон. Тэр чамайг нүглийн цус, гологдлын шалбаагтаа амь тасарч байхыг харсан. Тэр чамайг өрөвдөн, үхлийн хараалыг хүчингүй болгоод, өнгөрсний нүгэл, бохирос чинь угаасан. Тэр чамайг тэжээж, энхрийлэн халамжлахад, бид Түүний хайр дотор цэцэглэсэн ч, заримдаа Ханхүү маань харуулдан хүлээх мөрөөдөл шиг л алс хол, зайдуу байдаг байв.

Энэ үед л бид өөр нэгэн рүү эргэх өдөөлтөд ордог. Бид хүлээхийн оронд яг одоо хүрэлцэхийг хүсдэг. Бид эрхэмсэг хувцсаа тайчаад, эрээний хувцсаар гоёод, алдарт эрдэнэсийн талаарх амлалтыг умартаад, амрагуудаасаа авсан насгүй бараагаараа нүдээ хуурч эхлэдэг. Тэгээд энэ бүх баялгийн хуурмаг байдал, эд юмсын тачаал нь Ханхүүгийн амлалтыг устгах нь олонтаа. Зарим маань эрэгтэй хүний нүцгэн биеэр өөрийгөө бүтэн болгох гэсэндээ, гэрээгүй хүний дэргэд нүцгэлсэн ч, тэр хүмүүсийн гар Ханхүүгийн энхрий зөөлнөөр цэвэрлэсэн газруудыг нь эргээд бохир болгоно.

Гэхдээ чи тийм биш гэдэгт найдаж байна. Чиний гарт энэ ном, чиний зүрхэнд Ханхүүгийн нэр сийлээстэй байна.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Таны өршөөлийн сайхан, хайрын гүнийг биширч байна. Та намайг нүгэлдээ үхэж байхад олж аваад, гэртээ авчирсан. Та миний нүцгэнийг хууцаслаж, нүгэл, цусны асуудал болгоныг цэвэрлэсэн. Таны уучлал, өршөөл, энхрий халамжинд баярлалаа. Би Тантай эрхэмсэг байдлын гэрээтэй. Надад өгсөн Таны гоо үзэсгэлэнгээр даллан, газрын хөвгүүдээс баталгаа хайсанд өршөөгөөрэй. Би бусад амрагуудаа хаяж, ганцхан Таныг дагана. Намайг сайхан биш, муухай байхад хайрласанд баярлалаа. Би бол Таны үнснээс татаж гаргасан Үнсгэлжин байна. Би зүрхээ Тан дээр тавьж байна, Та миний цорын ганц жинхэнэ Ханхүү.

Таны хайрт охиноос.



7 *Бэлгийн хайр сэрчихсэн бол, яах вэ?*

Ханхүү маань Өөрөө ирж сэрээх хүртэл уянгын хайр, сэрлээ амар тайван нойрсуулах талаар бид ярьсан. Гэтэл өөр нэгэн хүчлэн сэрээсний гайгаар хайр, дур хүсэл маань жолоогоо алдбал, яах уу? Хичнээн бүүвэйлсэн ч, бэлгийн сэрэл маань нойрсож өгөхгүй, ноцолдоод байвал, яах уу? Чи ийм байдалд орсон бол, нойрноосоо сэрсэн сэрлийг буцааж унтуулах амаргүй гэдгийг мэдэж байгаа байх – ялангуяа цагаас нь өмнө гэнэт цочоож сэрээсэн сэрлийг. Үүнээс болж бидний баярласан эсвэл айсан адреналины урсгалыг тогтоох аргагүй болдог.

Ер нь ямар нэгэн юмнаас хоцорчихгүйн тулд сэрүүн байхыг сануулсан сэрүүлгүүд эргэн тойронд дуугараад байхад, дахиж унтах хэцүү! Гүн нойрсохын тулд орчин тойрон маань нам гүм, тайван байх хэрэгтэй. Сэрсэн хүслийг дахиж нойрсуулахад болгоомжтой хандах хэрэгтэй.

Хүний хүсэл унтрах гэж бадардаггүй юм.

Учир нь нэгэнт бадраасан айдас, хүсэл нь намжихдаа хэцүү. Энэ нь ч шалтгаантай: Хүний хүсэл унтрах гэж бадардаггүй юм. Энэ үнэн хүний бүх хүсэлд хамаатай.

Би хөвгүүдээ зургаан сар хүртэл нь хөхөөрөө хооллоод, зургаан сараас хойш бор хоолтой танилцуулснаа санаж байна. ...Бор хоолтой танилцсанаасаа хойш тэд тэс өөр хүмүүс болцгоосон. Түүнээс өмнө тэд ресторанд ээжийнхээ өвөр дээр сууж байхдаа, ширээн дээр байгаа ямар ч тансаг хоолыг тоодоггүй байв. Зүгээр л зөөгч, рестораны ажилчдыг ажиглаад л мишээгээд л сууж байна. Тэд янз бүрийн үнэрийг мэдрэв ч, юунаас хоцорч байгаагаа мэдэхгүй учраас, ямар ч тансаг хоолыг үл тооно. Гэтэл анх хоол амтлаж үзээд... бүх зүйл өөрчлөгдөв!

Үүний дараа хоолны үнэр тэднийг галзууруулдаг болов. Нэгэнт хоолны дуршил нь сэрчихсэн нөхөд чинь хажуугаар өнгөрөх хүмүүсийг ч тоож харж, инээмсэглэхээ болив. (Санаандаа хүрэхийн тулд худлаа инээж, инээдээрээ хуурдгийг нь эс тооцбол) Тэд хоолонд ухаанаа алджээ! Хэрэв би тэднийг өвөр дээрээ суулгаад идбэл, халбага сэрээтэй маань барилдах юмуу эсвэл ширээн дээрх хоолыг өөртөө ойртуулах гэж ширээний бүтээлэг зулгаана. Хүүхдийн сандал дээр суулгачихбал, өмнө нь хоол тавьж өгөхгүй л бол, хоолонд хүрэх оролдлогоо зогсоохгүй. Тэдний толгойд хоол гэсэн ганц л зорилго бий. Тэд амтлаж үзээд, хоол гэдэг сайхан зүйлтэй танилцжээ. Тэдний хоолны дуршил нь хөгжсөн учраас, хоолоо авахаас нааш зогсохгүй!

Тиймээс би хөвгүүдээ нэгдүгээрт – бор хоол боловсруулах насанд хүртэл нь, хоёрдугаарт – байнга хоол идэх чадвартай болтол нь хоолтой танилцуулаагүй билээ. Энэ нь хоолны сайхантай ямар ч холбоогүй... хөвгүүд маань зургаан сар хүрээгүй байхдаа хоол идсэн бол, хоолонд хичнээн дуртай байлаа ч, хоол боловсруулах эмзэг систем нь хүнд хоолыг даахгүй байв. Хоол нь сайхан зүйл бөгөөд бидний тэжээл, өсөлт, хөгжилд хэрэгтэй ч, хэтэрхий эрт өгчих юм бол, янз бүрийн өвчин үүсгэх магадлалтай. Хоол хэдийгээр сайхан боловч, үүнийг амьдралын буруу цагтаа хэрэглэбэл, хоолны дуршил, дур хүсэл маань биднийг хоолыг буруу юмуу хэтрүүлэн хэрэглэхэд хүргэж болзошгүй. Бид биед маань шим тэжээл болохгүй ч, дуршлыг маань хангадаг зарим төрлийн хоолонд хэт шунан, хэтрүүлж болох.

Энэ төрлийн дур хүсэл нь эцэстээ хоолны буруу, хэтрүүлсэн хэрэглээнд хүргэнэ. Ямар ч зүйлийг хэтрүүлэх нь буруу. Тиймээс хоолонд буруу байхгүй ч, хоолыг буруу хэрэглэх боломжтой. Сайн зүйлийг буруугаар хэрэглэх үед энэ нь бидний амьдралыг сүйрүүлэх хүчин зүйл болдог. Тэгээд дур хүсэл, дуршил маань цаашид бидний зарц биш, харин байнга нэхэж

*Сайн зүйлийг
буруугаар хэрэглэх үед
энэ нь бидний амьдралыг
сүйрүүлэх хүчин зүйл болдог.*

шаардаж байдаг эзэн болж хувирна.

Бидний сексийн дур хүсэл нь хоолны дуршилтай л адил...гадаадын хүчин зүйлээр сэрээгдэх хүртлээ унтаа байдалтай оршдог. Бид хоолгүйгээр амьдарч чадахгүй шиг бэлгийн харилцаагүйгээр нөхөж үржиж, амь өгч чадахгүй. Тэгэхээр хүний амьдралд энэ хоёр нь хоёулаа л чухал байх нь. Тийм боловч бид хянаж захирахгүй аваас, хоолны дур хүсэл маань биднийг жолооддог шиг сексийн сэрэл ч биднийг аваад давхичихаж чадна. Энэ бүлгээрээ сексийн бадарсан сэрэл хүслийг шийдвэрлэх сүнсний бөгөөд практик арга замын аль алийг үзье.

Өдөр тутмын амьдралын жирийн зүйлээс илүү эмзэг сэдэв рүү шилжихийн тулд бүгдээрээ нөгөө хоолны талаарх яриандаа эргэж орё. Тэгээд хүний ямарваа нэгэн зүйлийн төлөөх дур хүсэл, дуршлын өсөлт хөгжлөөр яриагаа эхлэе. Энд би өөр дээрээ жишээлэн ярьмаар байна. Би хэзээ ч хар шоколад идэж үзээгүй бол, үе үе хар шоколад идмээр санагдахгүй биз дээ? Эсвэл кофе? Хэрэв би анх өглөө нойрноосоо сэрэх гэж халбага дүүрэн Breuer's кофены зайрмаг овоолж, орой дээр нь шанцай цацсан аяга дүүрэн ява кофе ууж үзээгүй байсан бол, арван хоёр жилийн дараа ингээд л мока латте уусаар байх уу?

~ Бидний сексийн дур хүсэл нь хоолны дуршилтай л адил... гадаадын хүчин зүйлээр сэрээгдэх хүртлээ унтаа байдалтай оршдог.

Мэдээж үгүй! Тэр сайхан амтыг хэзээ ч олж мэдэхгүй байх байв. Энэ сайхан амтганыг хүсэх дур хүсэл маань ч хөгжихгүй байх байв. Кофе чинь гашуун, өтгөн, хар ус гэж боддог байхдаа, би кофег жигшдэг байлаа. Сүүтэй, цагаан гэсэн хоёр төрлөөс өөр шоколад байдгийг мэддэггүй байхдаа би шоколадыг тоодоггүй байлаа.

Ямар ч дур хүсэл байхгүй! Би хааяа хааяа иддэг хар шоколад, өглөө бүр ёслол болгон уудаг амтат кофегоо хүсэх хүсэлтэйгээ зөрчилддөггүй, харин таашаал авдаг! Тэдгээр нь миний эзэн биш, харин нэгэн төрлийн амралт, тайтгарал болдог гэх үү. Би долоо хоног хар шоколадгүй байж чадна. Ингэлээ гээд хэн ч хохирохгүй. Би хар шоколадгүйгээр үхчихгүй. Гэхдээ би хар шоколаданд дуртай. Би нойрноосоо аажмаар биш, бушуухан сэргэхийг хүсбэл, кофе уудаг.

Эдгээр жишээг ярих нь шударга бус байх л даа. Эдгээр нь тийм ч шим тэжээлтэй биш, зүгээр л татгалзахын аргагүй, таатай хоол. Гэхдээ хэрэв би өөр эрүүл хүнс идэхгүй, энэ хоёрыг л идээд байвал, яах уу? Хэрэв би хар шоколаднаас авдаг мэдрэмжийн таашаал, кофеноос авдаг сэргэг байдлаа амьдралынхаа бусад бүх мэдрэмжээс дээгүүр тавиад эхэлбэл, яах уу? Тэгвэл надад шоколад шиг мэдрэмж өгдөггүй ногоо цагаа заваан санагдаж эхлэнэ. Тэгээд ч салат чинь шүдэнд торсон, хүйтэн хоол бол, шоколад чинь торго шиг зөөлөн бас бүлээн амтай. Ус нь кофе шиг дулаацуулж, сэргээж, цочроо өгдөггүй учраас, би усанд дургүйцэж мэдэх.

Би бусад хоолыг шоколад шиг амтгүй, кофе шиг сэргээдэггүй, уйтгартай, байдаг л юмс хэмээн голно. Тэгээд хэрэв би амьдралаас тасраад, хоёр долоо хоног зөвхөн шоколад, кофе хоёроор л хооллобол, яах бол? Нэг хэсэгтээ жигтэйхэн жаргалтай, гоолиг, сэргэг байна байх. Дараа

~ Бид өөрийн гэсэн дуршил, хүслээ хөгжүүлдэг.

нь бүх зүйлс тэнцвэрээ алдаж, миний дур хүсэл асуудалд орно.

Би энд нэг л зүйлийг хэлэх гэлээ – бид өөрийн гэсэн дуршил, хүслээ хөгжүүлдэг. Бид тухайн зүйлийг чухалчилсан хэмжээгээрээ, түүний нөлөөг өсгөх юмуу бууруулна. Бид хувиа бууруулснаараа тэдгээрийн нөлөөг хянаж чадна. Жишээлбэл:

Би “*Out of Control and Loving It*” гэдэг анхны ном дээрээ ажиллаж байхдаа, дөрөв дэхь хүү Арденаа төрүүлээд удаагүй байсан болохоор кофетой үй зайгүй найзлаж байлаа. Манайх цэцэрлэгийн хоёр хүүхэдтэй байсан болохоор, миний хувьд 22–02 цагийн хооронд ажиллах нь хамгийн аятай цаг байв. Би өглөө сэрээд том аягаар нэг бүтэн, нэг хагас кофе уугаад, үдээс хойш нь нойрмоглож эхлэхээрээ дахиад нэг аягыг явуулчихдаг байв (Англи цай ууж байгаа юм шиг л). Үүнийхээ хүчээр өглөөний хоёр, заримдаа гурав хүртэл тэсчихнэ. Тэгээд унтаад, өглөө зургаа гучид сэрээд, яг энэ маягаараа бүхнийг давтана. Тухайн үед надад кофегоо бэлтгэх нь л хамгийн хэцүү байв. Харин ганц, хоёр сорсны дараа бүх зүйл хөнгөрөөд явчихна. Энэ явдал хэдэн долоо хоног, дараа нь хэдэн сар үргэлжлэв. Миний судсаар ява гүйгээгүй цагт царай маань тэс өөр хүн шиг л харагдана.

Тэгтэл нэг шөнө бүх зүйл өөрчлөгдөв. Би өдөр тутмынхаа цагийн хуваарийн дагуу Арденыг 22 цагт хөхүүлэн, амжилттай унтуулчихаад сууж байлаа. (Заримдаа унтуулж чадахгүй учраас, хөхүүлэнгээ номоо бичдэг байв) Би нэг сайн амьсгаа аваад, залбирчихаад, номоо бичихээр суулаа. Үгс маань урссаар байв. Тэгтэл 02 цагийн үед бие маань нэг тал руугаа учиргүй далийгаад байгаа нь анзаарагдав. Би биеэ эгцлээд, бичих гэсэн боловч, бие маань дахиад л зүүн тал руугаа хазайгаад уналаа. *Яагаад байгаа юм бол?* Би босоод суниах гэсэн боловч, ухаан санаа маань бүрэн сэргэг байсан ч, өрөө тэр чигээрээ эргэлдээд явчив. Би бодсоноосоо илүү ядарчихсан юм байлгүй гэж бодоод, компьютераа хаагаад, орондоо орохоор, доошоо буулаа. Би шатаар хөлөө олох гэж зүдрээд, дараа нь маш тодорхой хараад байгаа хэрнээ унтлагынхаа өрөөний хаалганы модыг мөргөчихөв. Орондоо орж хэвтэхдээ, бие маань ч, тархи маань ч эргэлдэж байлаа. *Нэг л биш ээ.* Мэдээж бие маань туйлдчихсан боловч, тархи маань ажилласаар байв. Би унтаж чадахгүй, тархиа амрааж чадахгүй олон цаг дэмий хэвтлээ. Би ядарч байв. Гэхдээ яг сайхан унтах гэхээр л тархи маань намайг дав хийтэл сэрээгээд байлаа. Өглөөний гэгээ цонхоор тусахад, би хамгийн түрүүнд кофе руугаа явах ёстой байлаа.

Хэн ч намайг хэтрүүллээ гэж буруутгаагүй боловч, би эрс тэс шийдвэр гарган, кофеноос бүр мөсөн гарахаар шийдэв. Тэгээд өдөржин толгой манарч, нилээд бухимдуу байлаа. Хүүхдүүд маань надад аягаа өгөх гэсэн боловч, би авсангүй. Орой тийшээгээ нөгөө хэзээ ч толгой өвдөж үзээгүй

хүний толгой чинь задрах шахаж байлаа. Би толгойн өвчинг мэдэхгүй учраас, дотроо тийм хүмүүсийг анхаарал татах гэсэн амьтад л гэж боддог байв. Тэгээд бороотой хүйтэн өдөр хэрэглэх гэж худалдаж аваад, хаашаа ч юм шидчихсэн өвчин намдаагч эмээ хайн, шүүгээнүүдээ онгичиж гарав. Эм толгойн өвчнийг дөнгөж л намдаав. Би кофеинаас гарах синдромд дахиж хэзээ ч өртөхийг хүсээгүй болохоор, бүтэн гурван жил нэг ч кофе уусангүй. Тэгтэл Колорадогийн нэгэн хүйтэн өдөр би дахин кофе оочихдоо, кофетой өдөр бүр сэргэг байх гэж хэрэглэдэг сэргээш шиг биш, цоо шинээр танилцаж билээ.

Одоо би дугтуйг цааш нь задлан, секс, кофе, шоколад гэдэг ойлголтуудыг нэгтгэн, зангидья. Кофетой адил секс нь бидэнд юу юунаас ч илүү амьд, сэргэг мэдрэмжийг өгдөг. Секс шоколад шиг л амттай. Секс нь юунаас ч авашгүй мансуурлыг өгдөг.

Энэ бол үерлэсэн эндорфин, нэгэн зэрэг давалгаалах бөөн бөөн мэдрэмжийн урвал юм. Секс нэгэн зэрэг хэт ачаалал өгч бас тэнгэрийн амтыг мэдрүүлдэг. Иймээс ч бид ийм их таашаал авчирч, биднийг хэсэгхэн зуур ч гэсэн амьд, хүсүүштэй,

— Буруу цагт сэрсэн хүсэл нь тачаал болдог бөгөөд энэ тавирашгүй тачаал нь ичгүүр дагуулдаг.

бүрэн бүтэн болгодог энэ мэдрэмжийг амрааж унтуулахын оронд, харин ч бүр өрдөж сэргээхийг хүсдэг нь ойлгомжтой. Гэхдээ бидний тооцоолох ёстой өөр нэгэн бүтэц бий: хайр, сексийн дур хүсэл нь хичнээн таашаалтай, сайхан зүйл байсан ч, буруу цагт нь сэрээчихбэл, ямагт буруу зүйл болж хувирна. Буруу цагт сэрсэн хүсэл нь тачаал болдог бөгөөд энэ тавирашгүй тачаал нь ичгүүр дагуулдаг.

Хайр ч хожим тачаалын хэлбэрээр бус, харин жинхэнэ гоо үзэсгэлэнтэй хэлбэрээрээ дахин сэрээгдэхийн тулд амрах ёстой. Энэ нэмэлт амралт нь хайрыг зохих цагт нь илүү их таашаал, дур хүслээр шинэчлэгдэн цэнэглэгдсэн байдалтай сэрээнэ. Тэр цагт бид гонсойхгүй, хаягдахгүй, шаналахгүй. Бид тачаалыг үхүүлж, оронд нь хайрын гоо үзэсгэлэнг хулгайлах өчүүхэн ч ял, ичгүүргүй, цэвэр хайрыг амилуулахыг хүсэх ёстой. Энэ бүхнийг яаж хийх вэ?

Энэ үйл явц нь айсан, тайтгарахгүй байгаа хүүхдийг бүүвэйлж, буцааж унтуулдагтай л адил юм. Хөвгүүд маань айх, гэмтэх, өвдөх юмуу эсвэл хэт их хөөрөх үед би тэднийг тайвшруулахыг хичээдэг байлаа. Бүүвэйлэн хөдөлгөх юмуу эсвэл оронд нь хамт хэвтэх юмуу эсвэл их орой болсон байвал, өөрийнхөө оронд өвөртлөөд хэвтэнэ. Ямар арга зүй хэрэглэх нь хамаагүй. Хамгийн гол нь ээж нь дэргэд нь байгаа гэдгийг л хүүхдэд мэдүүлэх хэрэгтэй. Хүүхдүүд маань ээжийнхээ тэвэрт ирэхэд, би тэдний

айдсыг сонсдог. Тэгээд хүүгийнхээ үсийг илбэж, биеийг нь тэврэхдээ, айдас түгшүүрийг нь өөр дээрээ авна. Хүү маань хэт их хөөрөөд, энэ бүхэнд автахгүй шулганаад байвал, би түүнийг шивнээгээрээ тайтгаруулж эхлэнэ.

Энэ шивнээгээрээ би Бурхан түүнд хайртай, ээж нь бас түүнд хайртайг бататган, хүүдээ Бурханы итгэмжтэй хамгаалалтыг сануулдаг. Тэгээд дараа нь би илүү хүчирхэг үнэнийг тунхаглаж, худал хуурмаг, айдсын сүрдүүлэгч сүүдрээс ч том гоо үзэсгэлэнгийн дүр төрхийг бүтээнэ.

Дараа нь хүүгээ гүн нойрондоо амар тайван унттал нь бүүвэй аялж өгнө.

Айсан хүүдээ хандах эх хүний энэ зөөлөн хариу үйлдэл нь Бурханы зүрхнээс эхтэй. Тэдгээр нь бидний шуургыг намдааж, айдсыг үргээх

гэсэн Бурханы хүслийн өчүүхэн тусгал билээ. Бурхан шархлаж, бүтэлгүйтэж, айсан биднийг хэзээ ч түлхдэггүй, харин улам Өөртөө ойртуулдаг. Түүний хүүхдүүд бид Бурханы аюулгүй байдал, хайрын гарт очихоор дуудагдсан. Тэнд Бурхан бидэнд биднийг дахин тайвшруулж, амраах

*Бурхан шархлаж,
бүтэлгүйтэж, айсан биднийг
хэзээ ч түлхдэггүй, харин
улам Өөртөө ойртуулдаг.*

чадалтай гоо үзэсгэлэнгийн алсын харааг өгнө.

Бяцхан охиноо амрааж, эдгээхийн тулд бүүвэйлж байгаа аавын дүр зурагт би дуртай. Энэ хүслийг буцаагаад унтуулсан ч, дахиад хэзээ ч сэрэхгүй юмуу эсвэл биелэхгүй байх вий хэмээн айж байгааг чинь ойлгож байна. Чиний дотор: Би амьдралынхаа энэ хэсгийг тавиад явуулчихбал, дахиад хэзээ нэгэн цагт харах болов уу? Бурхан энэ хэрэгцээг маань хангах болов уу? Бурханд одоо даатгачихбал, Тэрбээр ирээдүйн найдварын талаарх амлалтаараа намайг хангах болов уу гэсэн айдас байгаа байх.

Бурхан Аав чинь Сүнсээрээ бөгөөд энэ номоор чиний төлөө дараах зүйлсийг хийхийг хүсч байгаа гэдэгт би үнэн голоосоо итгэдэг:

- чамтай илүү дотносох
- чамайг ял, ичгүүр болгоноос цэвэрлэх
- айдсыг чинь үнэний гэрлээр үлдэн хөөх
- чамд найдвар, ирээдүй хайрлах
- шуурга намдтал чамайг бүүвэйлэх
- чамайг буцааж амраах
- зүрхний чинь мөрөөдлийг сэргээх

Энэ жагсаалтын зарим нэг сэдвээр ярьсны дараа нэгэн залуухан хөөрхөн

охин надаар залбируулахаар уулзаж билээ. Тэрбээр хөвгүүдэд таалагдаж, анхаарлыг нь татахын тулд буулт хийдэг гэдгээ хүлээн зөвшөөрөөд, энэ байдлаасаа яаж гарч, яаж сэргэж, буцаж амар тайван нойрсохоо мэдэхгүй байгаагаа хэлсэн юм. Би түүнийг тэврээд, түүний төлөө залбирч байхдаа, Бурхан түүнд амлалт шивнэхийг нь сонсов. Бурхан охинд хэрэв тэрбээр магтаал, хүндэтгэлийн дуугаар Түүн рүү ойртсоор байвал, Бурхан түүний дотор сэрсэн зүйлийг нь буцааж нойрсуулахын тулд эргээд түүнд бүүвэй аялж өгнө гэв.

Бурхан охинд хэрэв тэрбээр магтаал, хүндэтгэлийн дуугаар Түүн рүү ойртсоор байвал, Бурхан түүний дотор сэрсэн зүйлийг нь буцааж нойрсуулахын тулд эргээд түүнд бүүвэй аялж өгнө гэв.

Бурхан ямар их хайраар өгүүлж байгаа нь намайг мэлмэрүүлэв. Бурханы дуу хоолойд ямар ч ичгүүр, ял байхгүй, гагцхүү охины айдас, ял, ичгүүрийг үргээх бүүвэйн амлалт л байлаа. Охин Бурхан руу ойртбол, Бурхан охин руу ойртож, охиныг Өөрийнхөө жигүүрийн нөмөр дор аюулгүй нуун хаацайлна. Дараах Бичээс Бурханы өр зөөлөн сэтгэлийг маш үзэсгэлэнтэй харуулж байна:

Чиний Бурхан ЭЗЭН, аврагч дайчин, Та нарын дунд байна. Тэр та нарын дээр баяр хөөртэйгөөр баясна. Тэр хайр дотроо чимээгүй байна. Тэр та нарын дээр баярын уухайгаар баясах болно. (Зефаниа 3:17)

Энэ бол олонд хандсан зураглал ажээ. Бурхан олдошгүй холын Бурхан биш, харин биднийг аврахын тулд тэр даруй ухас хийн ирдэг Бурхан ажээ. Бид айж, тусламж эрэн хашхирахад, Бурхан биднийг түлхдэггүй, ялладаггүй. Эх хүн нялх үрээ уйлагнах үед шүүрч аван, тайтгаруулдаг шиг Бурхан ч биднийг тайтгаруулах дуртай. Гэхдээ эх хүний тайтгарал хязгаартай бол, Бурханы тайтгарал нь Түүний хайртай л адил хязгааргүй юм. Бурхан гүн тайтгарлаараа биднийг тайвшруулаад, дараа нь бүүвэй аялж өгдөг. Бурхан биднийг нэг бүрчлэн Өөр рүүгээ дуудаад, бидний дийлэхгүй байгаа шуургыг намжааж өгөхийг хүснэ. Бурханы дэргэд бид тайвшраад, тун удахгүй Түүнтэй хамт дуулж эхлэнэ.

Ийнхүү би амьддаа Таныг магтана. Таны нэрээр би гараа өргөх болно. Чөмөг, өөхөнд юм шиг Сэтгэл минь цатгалан бөгөөд Ам минь баясгалант уруулаар магтаалуудыг өргөнө. Шөнөжин Таны тухай тунгаан бодохдоо Орондоо Таныг би дурсан санана, Учир нь Та миний тусламж бөгөөд Таны жигүүрийн дор Би баясгалантайгаар дуулна. Сэтгэл минь Танаас

зуурчээ. Таны баруун мутар намайг түшиж байна. (Дуулал 63:4–8)

Бурханыг магтах нь хичнээн чухал болохыг би яаж хангалттай чухалчилж хэлэхээ мэдэхгүй байна. Хөгжим гэдэг гайхамшигтай хүчтэй бөгөөд өнөөдөр бидэнд өнгөрсөн цаг хугацаанд хэзээ ч байгаагүй тийм их хөгжмийн нөөц бололцоо байна. Хөгжим нь бидний оюун ухаанаас давсан, зүрхний хэл гэдгийг бид сурсан. Бид Бурханыг магтахдаа, Түүний итгэмжтэй чанар дээр найрладаг. Бурхан биднийг хүчжүүлэхийн тулд хамгийн тансаг зоогоор дүүрэн найрын ширээ засдаг. Бид орондоо хэвтэж байхдаа Бурханыг санабал, Тэр биднийг харанхуй шөнийн турш манах болно.

Би хөвгүүдийнхээ нэгийг өвөртлөөд хэвтэж байхад, хүү маань ахин дахин сэрээд намайг дэргэд нь байгаа эсэхийг шалгадаг сан. Гэхдээ би тэднийг нам унтал нь хүлээж байгаад, дараа нь өөрийнхөө тухтай ор руу гүйчихдэг байснаа хүлээе. Харин Бурхан тэгдэггүй, Бурхан үлддэг. Бурхан бүүвэй аялангаа, жигүүрийнхээ нөмрөөр биднийг дулаахан хучиж өгдөг. Түүнийг магтана гэдэг нь сэтгэлээрээ Бурханыг тас тэврээд, Түүний баруун гараар тас тэврүүлэх юм. Эзний баяр хөөр бидний хүч чадал болох бөгөөд харин дуршилтайгаа тэмцэж байгаа хүнд Эзний хүч чадал заавал хэрэгтэй.

Естер шиг бид Бурханы найранд очихоосоо өмнө хүслээсээ мацаг барих цаг гаргах хэрэгтэй. Бид өөрсдийнхөө хүслийн зоогийг Бурханы өмнө авчраад, оронд нь Бурханы таашаал, хүслээр солих хэрэгтэй. Бидний магтаал хүндэтгэл нь Бурханыг хүндэтгэх найр бөгөөд тэнд л Бурхан дайснуудын өмнө бидэнд ширээ засдаг билээ. Би энэ үеийн охидыг тэднийг үхүүлэх санаатай сэтгэлийнхээ дайсны сүйтгэлээс Естертэй адил мултраач гэж хашхирч байна. Чи ч бас хашхир. Өнөөдөр эмэгтэйчүүд бид бидний огт мэдэхгүй үй түмэн охидын амийг аврахын тулд өөрийнхөө амийг үл хайрлах цаг ирээд байна.

Хүний хүсэл, тачаал, дуршлыг дарах ганц л баталгаатай арга байдаг нь эдгээрийг амь тасартал нь өлсгөх юм. Чи үүнийг устгаад, хүнсний хангамжийг нь таслах хэрэгтэй. *“Их цэргийг ходоодоор нь давшуулах”* гэдэг үгийг мэдэх үү? Тэгвэл чи одоо дайсны хуарангийн хүнсний хангамжийг таслах гэж байна. Сэтгэлтэйгээ халз тулаад, хэн нь эзэн, хэн нь боол болохыг хэлээд өг.

Дуулал 35:13 дээр Давид хаан хэрхэн мацагар дарууссанаа хэлдэг. Бие, сэтгэл маань хяналтаас гаран босоход, бид тэднийг тахимдаад, бүх хяналт Бурханд байдгийг сануулах ёстой. Тэр чинь зүгээр л махан бие,

~ Хүний хүсэл, тачаал, дуршлыг дарах ганц л баталгаатай арга байдаг нь эдгээрийг амь тасартал нь өлсгөх юм.

бид махан биеийн дуршилд толгойгоо мэдүүлэхгүй.

Амьдралд маань томоохон тэсрэлт хэрэгтэй үед – ялангуяа махан биетэйгээ барилдах үедээ би мацаг барьдаг. Үнэндээ их бага хэмжээгээр мацаг барихгүйгээр сүнсний тулаан хийх ямар ч боломжгүй. Учир нь мацаг бол хүчирхэг зэвсэг. Бурханы Хүү Есүс Өөрөө ч мацаг барьсан. Гэтэл өнөөдөр Христэд итгэдэг хүмүүсийн дийлэнх нь мацаг барихаасаа илүү хоолны дэглэм барихдаа сайн байдаг нь харамсмаар. Тэд дотроо хүлээстэй чигээрээ мөртлөө гаднах үзэмжээ өөрчлөхийг хүсдэг ч, тэр чинь тэс өөр зүйл шүү дээ. Чамайг чөлөөлөх хүчирхэг үнэн болбоос:

Гэм буруугийн хүлгийг мултлан Буулганы оосрыг тайлж, Дарлагдагсдыг чөлөөлөөд Аливаа буулгыг эвдэхийн тулд Би энэ мацаг барилтгыг сонгосон бус уу? (Исаиа 58:6)

Бурханы сонгосон мацаг нь дараах үр дүнд хүргэнэ: энэ нь шударга бусын гинжийг таслана, энэ нь буулганы оосрыг тайлна, дарлагдагсдыг чөлөөлнө тэгээд бүх буулгыг – хамгийн амрыг нь бус, харин бүх буулгыг эвдэнэ. Мацгийн хүчний өмнө бүх буулга мөхөс. Сексийн нүгэл нь буулга мөн үү? Мэдээж! Буулга нь буулганд орсон нэгний хөдөлгөөн, үйлдлийг хязгаарлана. Буулга нь буулганд орсон нэгнээ хүсээгүй газар руу нь жолооддог. Буулга нь жингээрээ туйлдаадаг. Тийм боловч хэрэв бид энэ хүнд байдлын сүнсний эсрэг магтаалын хувцсаа өмсбөл, Бурхан бидэнд цаашдаа буулгатайгаа халз тулж, чөлөөлөгдөхийн тулд хүч өгөх учраас, бид хөнгөрнө!

Би кофе хэт давруулан хэрэглээд, дараа нь огт уухаа больсныг санаж байна уу? Хэрэв чи бэлгийн дуршилд автсан бол, би чамайг эрс тэс арга хэмжээ авч, огт зогсоо гэж зөвлөө.

Сэтгэл татаж, хүсэл төрсөн ч хоолой юундаа хутга тулга.
(Сургаалт үгс 23:2)

Хатуу үг байна. Гэхдээ болоогүй ээ:

Садар самуунаас зугт. Хүний үйлддэг нүгэл бүр биеийнх нь гадна байдаг.
Харин садарлагч нь өөрийнхөө биед нүгэл үйлддэг. (1Коринт 6:18)

Залуу насны дур хүслүүдээс зугт. Цэвэр зүрхнээс Эзэнийг дуудагчдын хамт зөвт байдал, итгэл, хайр ба амар тайвныг мөшгө. (2Коринт 2:22)

Зугт гэдэг хүчтэй бөгөөд яаруулсан үг. Энэ үгийг Библид анх тэнгэрэлч нар Лотод хотоос зугт гэж хэлэхдээ, хэрэглэсэн байдаг (Эхлэл 19:17). Энэ

нь аймшиг, гамшгаас гүйх гэсэн утгатай. Энэ анхааруулгад хэвийн юм юу ч алга. Зугтахын тулд мацаг барих хэрэгтэй!

Чи ёс бус явдлаасаа болж Бурханы шийтгэлийг хүргэж байгаа хотоос зугтан гараад, согтуу толгойлон охидтойгоо бэлгийн харилцаанд орсон Лот шиг болохыг мэдээж хүсэхгүй. Чи зугтахдаа, эргэж харалгүй зугтах ёстой. Архидалт зэрэг өөр нэгэн төрлийн хүлээс рүү биш, харин Бурханы нөмөр рүү гүй. Чи зугтахдаа, ачаагаа хаяад гүй!

Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе.

(Еврей 12:1)

Амьдралын хүнд жинг хөнгөлөхөд мацаг амин чухал. Мацагар бид биднийг газартай гагнаж, түүртүүлж байгаа бие сэтгэлээ тайлна. Мацаг барих үед бидний ачаа хөнгөрч, сүнс чөлөөлөгддөг! Мацаг нь Бурханд захирагдаж байгаагийн маань туйлын үлгэр жишээ, илэрхийлэл бөгөөд Бурханд захирагдаж байгаа хүн аймшигт автан зугталгүй, зорилготой гүйдэг бол, харин дайсан зугтдаг!

Тиймээс Бурханд захирагдагтун. Дяаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. (Иаков 4:7)

Бид өөрийгөө даруусгаж, Бурханы жигүүрийн нөмөрт хорогдохдоо нуугддаг учраас, дайсан биднийг ололгүй, гагцхүү Бурханыг л хардаг. Түүний жигүүрийн нөмөр дор эрх мэдэл, хүчний гачигдал байхгүй. Амьдралынхаа бусад хэсгийг тэжээхээ зогсоогоод ирэхээрээ бид Бурханаар улам өлсөж цангана. Бурхан бидний дуршлыг өөрчилж, газрын амттанаас хавьгүй өндөр чанарын сайн сайхан, зөөлөн хайраар тэжээнэ. (Үүний амт кофе, шоколадыг хол хаяна)

Мацгийн тухайд би чамд хэдэн санаа өгье. Нэгдүгээрт – мацаг нь чамайг няцаах бус, сэргээх зорилготой. Сүнс чинь хүсч байхад, харин махан бие чинь дургүйцэхийг санаарай. Тиймээс сүнсний хувьд энэ нь баяр наадам мөн! Естер мацаг барихдаа, хаанд зориулан тансаг найр зэхсэнийг санаарай. Чи махан биеийг биш, харин Хааныгаа баярлуулна. Чи хааныг хүндэтгэбэл, Хаан оршихуйгаараа ирж, чамайг хүндэтгэнэ. Тиймээс үүнийг

~ Чи махан биеийг биш,
харин Хааныгаа баярлуулна.

шийтгэл бус, завшаан гэж үз.

Мацаг нь үхэх сэхэхийн асуудал гэдгийг ойлгоорой. Чи хүлээсийг үхүүлнэ.

Учир нь хэрэв та нар махбодын дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно. (Ром 8:13)

Энэ үйл явцаар ямар нэгэн зүйл үхнэ. Тиймээс үхэх зүйл нь биеийн нүгэлт чанар, буруу үйлс байг. Үүнд Естер шиг л нухацтай ханд. Болж өгбөл, гурван өдрийн мацгаар эхлэ. Ажилтай бол, дөрөв дэхь өдрийн оройноос эхлээд, Бүтэн сайныг дуустал мацаг барьж болно. Би шүүс юмуу усаар мацаг барихыг санал болгомоор байна. Энэ талаар ямар ч эрүүл мэндийн дэлгүүрээс мэдээлэл авах бүрэн боломжтой. *Энэ ном чамд анагаахын зөвлөгөө өгөх юмуу эмчийн оронд эмч болох зорилгогүй. Тиймээс мацгийн талаар асуулт байгаа бол, өрхийнхөө юмуу өөр мэргэжлийн эмч нараас зөвлөгөө аваарай. Хэрэв чи арван найман нас хүрээгүй бол, аав, ээжтэйгээ зөвлөлдөлдөггүйгээр мацаг бүү бариарай.* Би л хувьдаа мацгийн үеэр хүчиллэг биш шүүс, цэвэр ус уудаг.

Бурханыг эрэн хайхгүй бол, хоосон хоол хориод ямар ч утга байхгүй. Тиймээс мацаг барихаасаа өмнө бүх бэлтгэлээ хийгээд, мацгийнхаа үеэр амраарай. Утсаа унтраа, зурагтаа унтраа, сонин сэтгүүлээ цааш нь хий. Зөвхөн магтаал хүндэтгэлийн хөгжим л сонс. Дэлхийн хайр дурлалын дуунаас хол байж, Бурхантай хоёулханаа уулзаж учирч, хамт байх цаг гарга. Энэ бол Саббатын цаг. Тиймээс өөр зүйл бүү хий. Амар, унт, Түүн рүү ойрт. Үгийг унш – ялангуяа Естер номыг бас мацгийн талаарх амлалтуудыг юмуу өөртөө хэрэгтэй Христэч ном унш.

~ Бурханыг эрэн хайхгүй бол, хоосон хоол хориод ямар ч утга байхгүй.

Мацгийн үеэр чи зүгээр нэг биеэ өлсгөөгүй, харин сүнсээ бэхжүүлж байгаа юм. Энэ үеэрээ залбирлынхаа сэдвийг дэвгэртээ бич. Тэгээд мацгийнхаа үеэр эдгээр гуйлтаа мэдүүл. Эзний өмнө зүрхээ яг л ус шиг асга. Айдас, найдвар болгоноо гаргаж хэлээд, Түүнтэй нээлтэй, шударга бай. Бичээсээр болоод залбирлаар дамжуулж Бурханы хэлсэн зүйлсийг тэмдэглэж ав.

Түүний өмнө зоригтой ир. Естер шиг хатантны нөмрөгөө (энэ бол Христ доторх зөвтгөл) өмсөөд, хааны өргөөний дотоод ордонд хааны танхимын өмнө зогс (Естер 5:1). Тэр чамайг хараад баярлаж, чиний зүг таягаа дохино гэдгийг мэд. Хаан чиний хүслийг асуухад, Түүнийг хүндэтгэл, бишрэлийн найрандаа уриарай. Тэгээд Түүнтэй найрлаж байхдаа, хүсэлтээ мэдүүлдэг

юм шүү.

Энэ үеэргэрээ нэгжиж, Эзэнд тааламжгүй бүхнээсээ ангижир. Эдгээрийг Ариун Сүнс чамд илчлэх учраас, Түүнд мэдрэг байж, дуулгавартай дагаарай. Эдгээр нь зохисгүй видео, ном, захидал, хөгжим, тэр бүү хэл хуучин найз залуугийн чинь зураг ч байж болно. Бохир зүйлийг дэмжиж байгаа аливаа зүйлийг зайлуулах хэрэгтэй. Чи сексийн талаа Эзэний өмнө анхилуун хүндэтгэл болгон өргөхдөө, Түүнээс өөр ямар нэгэн талбарыг чинь авахыг хүсч буй эсэхийг асуугаад, түүнийгээ ч бас өргөөрэй. Энэ цагаар Бурханыг бүх эд эс, оршихуйгаараа хайрлалал, Тэр чамд хэзээ ч үзээгүй амьд ус, тэжээлийг өгөх болно.

За, том аялалд гарахаас чинь өмнө хамтдаа залбирья.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Таны эрэлд гарах гэж байгаа эгч, дүүсийнхээ төлөө санаа нэгдэн залбирч байна. Түүнийг Өөртөө ойртуулж, бүх ял, ичгүүрийг нь угааж, зугтаахад хүргэсэн айдсыг нь үнэнийхээ гэрлээр үргээгээч. Түүнд шинэ найдвар, ирээдүй хайрлаач. Тэвэртээ чанга наагаад, шуургыг нь бүрэн намжтал бүүвэйлээч. Түүнийг амрааж, түүнд хандсан шинэ Зүүдээ хайрлаач. Жигүүрийнхээ нөмөр дор нууж, зүрхэнд нь дуу өгөөч. Хайраараа тайвшруулж, бүүвэйлээч. Ичгүүрийн хувцас бүрийг нь зөвтгөлийн, сайхан нөмрөгөөр сольж өгөөч. Түүнд зориулж тансаг цэцэрлэг ургуулж, үүнийг онцгой, дотно нөхөрлөлийн эхлэл болгооч. Та түүнийг Өөрийнхөө дотор амраагаад, түүний өмнөөс тулалдах болтугай. Бид Танд хайртай Аав аа. Биднийг чөлөөлсөнд баярлалаа! Буулга бүрийг эвдэж, хүлээс бүрийг тайлаач. Биднийг энэ үеийнхэний бамбар болгон бадраагаач.

Таны хайрт охиноос.

Энэ залбирлаас гадна өөрийнхөө үгээр залбирч болно. Гэхдээ бичиний төлөө хэдийнээ залбирч, бидний зүрх нэгэн дуунд нэгдсэн гэдгийг мэдээрэй.

8 Аавыгаа хүндэтгэх

Саяхан нэгэн шаналсан ээж надтай ярив. Охин нь тун аюултай залуутай бэлгийн харилцаанд орсноо хүлээжээ. Ээж нь юу юунаас илүү охиндоо л санаа зовж, охиноо л хамгаалахыг хүсч байв. Өмнө нь тэрбээр мэдэхгүй явж байгаад, охиноо аюулд өртүүлж явжээ. Тэгтэл одоо дахиад л давтагдсан байна. Тэр ээж охиноо аюулаас сэргийлэхийн тулд надтай уулзуулж, надаар залбируулахыг хүсэв.

Гэхдээ би тэгж бодсонгүй. Хүмүүс зөв бурууг мэддэг атлаа бурууг нь сонгож байгаа бол, тэдэнтэй уулзаж залбирах нь тэдний зүрхийг өөрчлөхгүй, чиний царайг хүрэнтүүлэхээс өөр ямар ч ашиг авчирдаггүйг би сайн мэднэ. Тиймээс би цааш нь лавлалаа.

“Залуу нь Христэд итгэдэггүй, харин охин чинь буруу зүйл хийж байгаагаа мэдэж байгаа юм бол, өөрөө түүнээс салах хэрэгтэй юм байна. Та мэдээж охиндоо үүнийг хэлсэн байх. Тэгвэл би хэлээд нэмэртэй гэж үү? Охин чинь энэ уулзалтыг хүсч байгаа бол, би уулзъя. Харин хүсэхгүй байгаа бол, хэн хэний маань цагийн гарз болох байх.”

~ Хүмүүс зөв бурууг мэддэг атлаа бурууг нь сонгож байгаа бол, тэдэнтэй уулзаж залбирах нь тэдний зүрхийг өөрчлөхгүй, чиний царайг хүрэнтүүлэхээс өөр ямар ч ашиг авчирдаггүйг би сайн мэднэ.

Тэр ээж ихэд шаналж цөхөрчээ. Охин нь надтай уулзахыг үнэхээр хүсч байгаа, надтай уулзах гэж сургуулиасаа чөлөө хүртэл авсан гэж хэлэв. Тиймээс би үдээс хойш тэдэнтэй уулзахаар тохиролцлоо.

Би ч өдрийнхөө хэдийнээ битүү цагийн хуваарьт нэгэн төлөвлөөгүй уулзалт багтаах ажилтай болов. Шүршүүрт орчихоод, бушуухан гарлаа. Уулзалт руу явж байхдаа, би Бурханаас цэц ухаан, чиглүүлэг, тосолгоо

гуйн залбирав. Ээж, охин хоёр намайг ресторанд хүлээж байлаа. Намайг суусны дараа охин нь хоёр долоо хоногийн өмнө шатахуун түгээх газарт нөгөө залуутай танилцахдаа, бүтэхгүй хүн болохыг нь шууд л мэдсэн гэдгээ ярих. Тэрбээр “Түүнээс хол бай” гэсэн дуу сонссон ч, дагаагүй ажээ. Залуу тэр даруй охины толгойг эргүүлээд, дансанд нь гараа дүрж амжжээ. Залуу сургуулиасаа хөөгдсөн бөгөөд залуугийн аав нь хүртэл тэр охинд хүүгээсээ хол явахыг анхааруулжээ. Гэтэл охин сонссонгүй. Охин залууг өөр хүн болоход нь туслахыг хүссэн юмсанж. Одоо охин залуугаа хэрэгт орооцолдоод, өөрийг нь давхар оролцуулсан байж магадгүй гэдгээс айж байв. Тэрбээр стрессээ дааж дийлээгүй учраас, ээждээ хамаг явдлаа дэлгэжээ. Залуу нь түүний гар утас руу зогсоо зайгүй залгадаг учраас, охин түүнээс салж чадахгүй гэдгээс айж байв.

Би яриаг нь таслалаа: “Миний бодлоор тэр залуу өөрийгөө тун дажгүй янханы “ЗБ” (зохион байгуулагч) болно гэж бодсон болтой. Янханууд ер нь “ЗБ” – гээ хамгаалж, туслахыг л боддог. Чи арван долоотой, тэр хорин хэдтэй. Битгий гомдоорой. Гэхдээ түүнд чиний бодсон тусламж хэрэггүй. Чи эхлээд өөрөө Бурханаар эдгээлгээд, дараа нь яагаад эрчүүдийн тал дээр ийм муу сонголт хийдгээ ойлгох хэрэгтэй.”

Ээж, охин хоёр толгой дохив. Тиймээс би үргэлжлүүлээ:

“Чи дансаа хаа. Гар утасны дугаараа өөрчил. Түүнтэй дахиж уулзахгүй гэж хэл.”

Охин эргэлзэж байгаа нь тодорхой байлаа. “Би сайн мэдэхгүй байна аа. Би түүнтэй уулзахаараа “үгүй” гэж хэлж чаддаггүй.

“Чи түүнтэй байхгүй. Чи садар самуунаас зугтана. Өөрөө утсаар хэлж чадахгүй байвал, ааваасаа тусламж гуй. Аав чинь ямар ч асуудалгүй хэлчихнэ. Магадгүй аав чинь тэр залуутай үүдэн дээрээ буутай уулзаад, хэлж болно. Аав чинь чамайг хамгаалаг. Үүний төлөө л аавууд байдаг.”

Ээж, охин хоёр харц солилцоход нь аав нь энэ тухай юу ч мэдэхгүй явааг би ойлгов.

Би ээжээс нь: “Нөхөр чинь юу ч мэдээгүй хэрэг үү?” гэж асуулаа.

Ээж нь энэ талаар өөрөө дөнгөж саяхан мэдсэнээ учирлаад, аав нь эхний залуугийнх нь талаар мэддэг байсан ч, энэ залуугийн талаар огт мэдэхгүй гэв. Энэ залуу анхнаасаа л аавд нь таалагдаагүй учраас, байдал үүндээ тулсныг мэдбэл, маш их гонсойж, шаналахыг тэр хоёр мэдэж байлаа.

Би охиноос гурван зүйл хийнэ гэдэг амлалтыг нь авав. Нэгдүгээрт – аавдаа энэ муухай явдлыг үнэнээр нь хэлэх. Хоёрдугаарт – ааваасаа өөрийг нь хамгаалахыг хүсэх. Гуравдугаарт – Бурхан түүнийг энэ үйл явц дундуур авч гарах хугацаанд миний зааж өгсөн нэгэн номыг бас Библиэ өдөр бүр тогтмол унших. Тэгээд би түүнд нэгэн дан шигтгээ өгөөд, хэрэв

тэр сургамж авах юм бол, энэ муухай түүх түүний хувьд эрдэнийн чулуу болох болно гэж хэлэв. Тэгээд бид гурав миний машинд ороод залбирлаа.

Тийм боловч надад амар тайван байсангүй. Би охины хүсээд байгаа зүйлийг нь хүчээр зайлуулсан боловч, тэрбээр нэг л өдөр дахиад л энэ зүйлтэйгээ хутгалдана гэдэг айдас төрөөд байв. Тиймээс хэдийгээр охин миний хэлснийг бүгдийг нь хийнэ гэж ам гарсан боловч, сэтгэл минь гонсгор байлаа.

Тэд надтай дахиж холбогдоогүй ээ. Гэхдээ дараагийн долоо хоногт нь миний нэг найзад хандсан талаар олж сонсов. Ээж нь нөгөө л янзаараа шаналж, охин нь надтай уулзсан Хагас сайныхаа орой нөгөө л янзаараа залуутайгаа яваад, гэртээ ирээгүй ажээ.

Чи бас гайхаж байна уу? Надад охин байхгүй. Хэрэв хөвгүүд маань охидтой холбоотой ийм түүх ярьсаар гэртээ ирбэл, би Хагас сайнд хүүгээ тийм охинтой уулзуулна гэж бодож байна уу? Манай гэрт байгаа цагтаа хөвгүүд маань миний мэдэл дор байгаа учраас, би тэднийг хамгаалах үүрэгтэй. Тэр залуу охин яасныг бүү мэд. Тэр аав, ээждээ хэлэлгүй зугтсан уу эсвэл аавдаа огт хэлээгүй юу, мэдэхгүй. Эсвэл охин аав, ээжийгээ сүрдүүлэхэд, аав, ээж нь өнгөрсөн удаа охиноо хамгаалж чадаагүй учраас ирээдүйд ч хамгаалж чадахгүй хэмээн хүчин мөхөсдсөн үү, мэдэхгүй.

Гэхдээ оройтоно гэж хэзээ ч байхгүй. Бид орь дуу тавих ёстой. Аав, ээжүүд ээ, хүүхдүүдээ хамгаал. Эмэгтэйчүүд ээ, хүчээ өмсөж, бурханлаг замаар яв. Энэ бүхэн нь Бурханы цэц ухаан, зөвлөгөөг хэрэгжүүлэхээс эхлэнэ. Бид өөрийгөө даруусгаж, Бурханы зам үнэхээр биднийхээс өндөр гэдгийг хүлээх ёстой. Эцсийн эцэст бидний бодол, цэц ухаан нь Бурханы зөвлөгөөний гэрлийн өмнө зүгээр л мунхаглал билээ.

~ Аав, ээжүүд ээ, хүүхдүүдээ хамгаал.

Охид чинь өмч болж, хүчирхийлэгдэж, хүчиндүүлж байгаад аавууд элэг эмтэрч, хилэгнэн босох ёстой. Тэд сул дорой байгаагаа гэмшин босоод, охидоо хамгаалж, эмзэг газарт нь эдгэрэл авчрах ёстой. Эмэгтэйчүүд амьдралдаа байгаа эрчүүдэд хүчирхийлэгдэх биш, хамгаалуулах ёстой. Аавтайгаа эрүүл, амьд харилцаатай охид хүчирхийлэгч эрчүүдийн гарт өртөх нь бага. Гэрт нь эрүүл үлгэр жишээ байсан учраас, тэд эрүүл бус харилцааг хараад таньдаг. Хааны язгууртан охид шиг амьдарсан охид өөрийг нь дорд үзэхийг хэнд ч зөвшөөрөхгүй. Өөрийг нь магтаж, хамгаалдаг байсан аавтай охид бусад эрчүүдээс ийм л хандлагыг хүснэ. Хүүхэд

~ Охид чинь өмч болж, хүчирхийлэгдэж, хүчиндүүлж байгаад аавууд элэг эмтэрч, хилэгнэн босох ёстой.

байхдаа ямар найзуудтай байснаа санадаг аавууд буулт хийхийг охиддоо зөвшөөрөхгүй. Эрчүүд, эмэгтэйчүүдийн харилцааны талаар охидоо ний нуугүй дасгалжуулдаг аавууд нь охидоо өдөөлттэй нөхцөлд сайн шийдвэр гаргах мэдлэгээр өсгөн боловсруулж байгаа юм. Эсрэгээрээ өөрийг нь ямагт голдог, ууртай аавтай охид өөр эрчүүдийн баталгааг хайдаг.

Намайг коллеж явах үед бүх зүйл өөрчлөгдөж билээ. Би баруун эргийн төвд байрлах, хүйтэн Индиана дахь гэрээсээ нарлаг Аризона руу явав. Аав, ээжийнхээ хяналтаас бүрэн гарч, шинэ найз нөхөдтэй болно гэхээс хөөрч байлаа. Би хуучнаа ардаа орхиод, шинэ эхлэл тавина. Семестр эхлэхээс ч өмнө би хуурай эгч дүүстэй болоод, тэдэнд үнэнч байх тангаргаа өргөв. Тэд ч намайг шинэ найзуудын бүлэгт орууллаа. Би хөвгүүдийн байнгын анхааралд өртөж байгаадаа үнэхээр дуртай байлаа. Намайг огт тоодоггүй байсан ахлах сургуулийн үеийнхээс тэс өөр. Кампусаар юмуу анги руугаа явж байхад, хөвгүүд исгэрч, дуудаж, өдөж эсвэл болзоонд урина. Өмнөх дөрвөн жил янз бүрийн нэр хочоор дуудуулахаас өөр анхаарал хүртдэггүй байсан хүн чинь энэ их анхааралд толгой эргэв.

Би өөрийгөө энэ бүхнийг тун сайн зохицуулж чадаж байна гэж бодож байсан боловч, дотроо өөртөө итгэлгүй, бөмбөгнөж байлаа. Хэдийгээр заримдаа аймаар байсан ч, эрчүүдийн анхаарлыг татах нь миний хүч болж эхлэв. Би тэднийг надтай дотносоод ирэхээрээ худлаа л мундаг болох гэсэн бүтэлгүй амьтан болохыг маань мэдчих вий гэхээс айж байлаа. Үүнээсээ болоод болзож байсан хөвгүүдээрээ зүгээр л тоглодог байв. Тэд надад үнэн сэтгэлээсээ дурлаад ирбэл, хаячихна. Тэгээд эрчүүдийг дотуур хувцас солихтой л адил өдөр бүр сольж байгаагаараа гайхуулна. Нэг удаа би семестрт дөчин таван залуутай болзсон гээд л бод! Энэ маань би дотно явдлаас хичнээн их айдаг байсныг л хэлнэ.

Тийм боловч жилийн төгсгөлд би өөрийнхөө хосыг олов. Би арван наймтай, тэр хорин долоотой байлаа. Тэр дур булаам, өндөр, хөөрхөн залуу байсан бөгөөд түүнийг сексийн араатан байсныг би хожимдож мэдсэн юм. Тэр шинэ охидыг онилдог байсан бөгөөд энэ удаа намайг байгаа болгожээ. Тэр оюутан биш, зүгээр л шөнө “идшээ” хайн, кампусаар эргэлддэг залуу байв. Тэгээд намайг боломжийн охин гэж боджээ. Харамсалтай нь би түүний талаар бүр хойно л мэдсэн юм. Намайг эргүүлдэхийг нь харсан хуурай эгч дүүс маань надад анхааруулж л байсан. Гэхдээ би дэлхийн хамгийн төгс, хосгүй залуусын нэгний хараанд өртсөндөө оодроод, тэднийг сонсоогүй юм. Тэр Европоор аялдаг бас мундаг тамирчин байв. Түүнийг хаа ч явсан, охид эргэж хардаг байлаа.

Тэр намайг хэд хэдэн удаа гуйсан боловч, би татгалзсан нь түүнийг бүр ч тууштай үзэхэд хүргэжээ. Би аюулгүй зайнаас түүний анхаарлыг

татаж байгаадаа дуртай байлаа. Нэг орой би ээж рүүгээ яриад, надаас хавь илүү залуугийн анхаарлыг татсан баяр хөөрөө хуваалцлаа. Тэгээд ч тэр надаас хөөрхөн, ухаантай дээрээс нь олон ах. Тэр намайг болзоонд урьсан ч, би явах үгүйгээ мэдэхгүй байгаагаа би ээждээ хэллээ. Магадгүй битүүхэндээ ээжээсээ “болохгүй” гэдэг хариултыг л хүссэн байх. Гэхдээ би урьд нь үерхэхдээ хэзээ ч ээжээсээ зөвшөөрөл авч байгаагүй. Ээж хэсэг дуугаа хурааснаа намайг ухаантай шийдвэр гаргаж чадна гэдэгт итгэлтэй байгаагаа хэлэв. Би ээжийн үгэнд гайхснаа сайн санадаг юм. Утсаа тавихдаа, ээж зүгээр гэж байгаа бол зүгээр л гэж бодлоо. Ааваасаа асууж зүрхлэсэн бол, аав мэдээж үгүй л гэх байв. Аав нэг л биш гэдгийг шууд л мэдрэх байсан учраас, шууд л хориглоно. Аав маань юу гэж хариулахыг мэдсээр байж – тэрийгээ дагасан бол, би тийм аюулд өртөхгүй байв. Гэхдээ би тэгж чадаагүй юм.

~ Ааваасаа асууж
зүрхлэсэн бол, аав
мэдээж үгүй л гэх байв.

Дараагийн хэдэн сар нь тэр залуу намайг тун бодлоготой эргүүлж, арван есөн насныхаа төрсөн өдрийн дараа би охин байхаа болсон юм. Би Аризонад зуныг өнгөрөөх гэж байсан ч, тэр хүний атгаас зайлахын тулд бушуухан гэр рүүгээ зугтаж билээ. Би аав, ээж хоёртоо юу болсныг хэлээгүй л дээ. Аав намайг есөн насаар ах хүнтэй болзож байгааг сонсоод, тас хориглосон ч, оройтсон байлаа. Тэр намайг хэдийнээ чанга атгасан байв. Надад зугтах орон гэр байсанд Бурхандаа талархъя. Гэтэл яг над шиг байдалд орсон олон охид зугтах ч газаргүй байдаг.

Тэр үед би Христэд итгээгүй байлаа. Аав маань ч адил. Тийм боловч аав намайг аюултай нөхцөлд байгааг мэдэрч байжээ. Аавууд Христэд итгэдэг байна уу, итгэдэггүй байна уу хамаагүй, цаанаасаа л охидынхоо хамгаалагч, өмгөөлөгч байхаар төрсөн гэдэгт би итгэдэг.

Гэхдээ чи хэцүү газар байгаа бол, яах уу? Аав чинь хамгаалдаггүй. Нэг бол байдаггүй эсвэл өөрөө хүчирхийлэгч бол, яах уу? Эсвэл өөрөө чамайг хүчирхийлсэн учраас, чиний хувьд энэ дэлхийн хамгийн аюултай хүн болсон бол, яах уу? Чи ийм байдалд байгаа бол, дарааллаа солих цаг болжээ. Аав чинь чиний амьдралд эрүүл үлгэр жишээ болоогүй байсан ч, чамд тэнгэрийн Аав бий.

Тэнгэрийн Аав чинь чамайг хүчирхийлэлд өртөхийг хэзээ ч хүсэхгүй. Тэр чамайг хамгаалж, нандигнахыг хүснэ. Энэ нь чи тулгарсан нөхцөлдөө: “Тэнгэрийн Аав маань намайг яагаасай гэж хүсэх бол? Тэр энэ талаар мэдсэн бол, зөвшөөрөх үү?” гэж асуух хэрэгтэй гэсэн үг. Тэр чамайг янхан шиг

~ Тэнгэрийн Аав чинь
чамайг хүчирхийлэлд
өртөхийг хэзээ ч хүсэхгүй.

байгаасай гэж хүсэхгүй. Тэр чамтай хамт байж, чиний шийдвэрийг тулна гэдэгт бат итгэж болно. Тэр хэзээ ч: “Хохь нь ээ. Ингэх гээд байсан юм” гэж хэлэхгүй. Хэзээ ч! Тэр: “Наанаасаа яв, гэртээ харь, аюулгүй бай!” гэж л хэлнэ.

Хэрэв чи захиргаадагч хүнтэй орооцолдоод, түүнтэй нүүр тулж ярьж чадахгүй гэдгээ мэдэж байгаа бол, хувьчлан уулзахаа боль. Би коллежд элсэхээсээ өмнө өөр нэгэн ахтай үерхдэг байв. Тэр магистраа хийж байсан бөгөөд намайг зүгээр л хурууныхаа үзүүрээр л хөдөлгөдөг байв. Тэр үерхэл маш муухай харилцаа байсан боловч, би тухайн үедээ энэ харилцааг шагнал л гэж боддог байлаа. Аав, ээж хоёр санаа зовнив ч, би Аризонад, тэд Индианад байв. Тэр хоёрын дургүйцэл нь энэ харилцааг болгож бүтээх гэсэн гүргэр занг маань улам л хөдөлгөсөн юм.

Гэтэл ээж маань миний нүд нээгдэж, ийм харилцаанаас зугтахын төлөө залбирч эхлэжээ. Ээжийн чин сэтгэлийн залбирал, гуйлтын ачаар хэдэн долоо хоногийн дараа юмс өөрчлөгдөж эхлэсэн юм. Бид хоёр салахын оронд үерхлээ зарлаж, тэр надад хуурай ахан дүүсийнхээ холбооны тэмдгийг өгөв. Тийм боловч дотор *нэг л биш санагдсаар*.

Хэдэн өдрийн дараа бид хоёр шөнийн үдэшлэгт явсан ч, надад шал муухай байлаа. Хүмүүс бидний үерхэлд баяр хүргэв ч, надад ямар ч баяр төрсөнгүй. Би инээж ч чадахгүй байлаа. Хундага хундгаар нь архи уусан ч, огт согтохгүй байснаа санадаг юм. Гэтэл тэр бүр уугаад байдаггүй найз залуу маань учиргүй ууж согтуурав. Захиргаадагч хүн чинь согтохоосоо биш, согтож хяналтыг алдахаасаа айдаг юм билээ. Тэр орой түүнд баяр хүргэж үнссэн нэг бүдүүн охин манай хүнийг дээрээс нь дарж унаад налчийлгачихав. Тэгээд газар дээр бүдүүн охины доор дээшээ харан ухаангүй хэвтэх залуугаа харахдаа л би ухаан орсон юм.

~ Тэгээд газар дээр
бүдүүн охины доор дээшээ
харан ухаангүй хэвтэх
залуугаа харахдаа л
би ухаан орсон юм.

– Би ийм бүтэхгүй амьтнаар яах билээ?

Би тэднийг босох гэж шалан дээгүүр өнхрөлдөхийг нь хараад “Би энэ хүний юунд болсон юм бол?” гэж бодов.

Надад шууд л явмаар санагдлаа. Түүнээс аль болох хол баймаар. Харамсалтай нь бусад тав маань шал согтсон учраас, надаас өөр тэднийг хүргэж өгөх хүн байсангүй. Түүний байрны гадаа очоод би түүнд: “Буу!” гэв.

Тэр гайхаад: “Чи үлдэхгүй юм уу?” гэлээ.

Би үгүй гэж хэлээд, юу ч тайлбарлалгүй, давхиад явчихав.

Гучин минутын дараа нөгөөх чинь манай байрны доор ирчихээд,

намайг уулзъя гэж гуйв. Тэр угаасаа хүнийг уяраах увидастай байсан учраас, намайг дуудаад гаргаад ир гэж нэг охиноос гуйжээ. Тэр надад маш их хайртайгаа дамжуулж, яаран хожим харуусах шийдвэр гаргахгүй байхыг гуйсан байв. Нөгөө охин намайг бууж уулзахыг ятгахаар ирсэн боловч, би “уулзахгүй, зүгээр л харь” гэж дамжууллаа. Гэтэл түүнийг гарсны дараа үүдэнд зогсож байхдаа, яриаг маань сонсчихсон өөр нэгэн охин орж ирээд:

– “Лиза цаадах чинь бүтэхгүй амьтан. Тэр түүнтэй аз жаргалтай байхыг би нэг ч хараагүй. Түүнийг хая!” гэсэн юм.

Тэр яг миний бодлыг мэдэж байгааг нь хараад би гайхлаа.

Би түүнтэй санал нийлэв: “Тийм ээ, би аз жаргалтай байгаагүй! Би тэр хүнээр яах ч юм билээ. Би түүний тэмдгийг нь буцааж өглөө. Чи надтай хамт явах уу?”

Нөгөө охин зөвшөөрөв.

Түүнийг яваад өгсний дараа бид хоёр байрных нь гадаа очоод, “Бүх юм дуусаа!” гэсэн цаасан дотор түүний хуурай ахан дүүсийнх нь тэмдгийг шургуулаад, шуудангийн хайрцагт нь хийчихээд, гэртээ харьлаа.

Маргааш өглөө нь сэрэхдээ би тэс өөр хүн болсон байв... эрх чөлөөтэй хүн! Эхлээд яагаад ийм байгаагаа гайхснаа, гэнэт өчигдөр орой юу хийснээ санав. Би харууссангүй. Би дотно сайн найз дээрээ гүйж очин, тэврээд “Би эрх чөлөөтэй!” гэж хэлэв.

Би өглөөний цайгаа ухаар буухдаа, бараг л хөөрч байлаа. Цайгаа ууж байтал, намайг утсаар ярья гэж дуудуулав. Би түүнийг гэж мэдсэн болохоороо “Цаасаа унш!” гэж хэлүүлэв. Би улам л хүчтэй болж байлаа. Дараа нь усанд орж, барьцааны зөвлөхийн ярилцлагадаа бэлдээд, шууд тэнцэв. Гэртээ иртэл, өөр нэгэн охин намайг зогсоов.

– “Лиза, цаадах чинь номын санд байлээ. Энэ бичгийг чамд өгөөрэй гэсэн.”

Тэрбээр зурвасдаа миний урьд шөнийн үйлдлийг ойлгосонгүй бас салж чадахгүй гэсэн байлаа. Тэгээд орой уулзаад ярилцъя гэжээ. Хэзээ, хаана уулзахаа утсаар товлох ажээ. Гэхдээ би түүнтэй хаашаа ч явах санаагүй байлаа. Ер нь тэр миний толгойг эргүүлэхдээ сайн байсан учраас, би ч үг дуугүй л дагадаг байв. Есөн сарын хугацаанд би анх удаа өөрийнхөө толгойгоор бодсон маань энэ бөгөөд би бууж өгөх санаагүй байв. Түүнийг залгахад нь би ярьсангүй.

Гэтэл тэр намайг кампусаар элдэж эхлэв. Намайг явган хүний замаар түүнийг огт хайхрахгүй явахад, тэр аргадаж, хашхирч, заналхийлж, уучлал гуйж, дахин аргадана. Намайг ангидаа ороход, тэр хичээл тартал хүлээж байгаад, дахиад л нөгөө мөрдлөгөө эхлүүлнэ. Гэтэл манай ангид

маш гайхамшигтай, ухаантай дээрээс нь том биетэй нэгэн хөл бөмбөгчин залуу байж таарсан юм. Тэр миний байдлыг хараад, арай л дэндлээ гэж бодсон болтой. Тэгээд хичээлийн жил дуустал намайг ангиас орж гарахад бараа болж билээ. Хуучин найз залуу маань тэр хөл бөмбөгчний гуятай ч тэнцэхгүй гэдгээ ойлгох ухаантай хүн байсан минь яамай! Тэр намайг зун гэртээ харьж, түүнээс бүрэн холбоо тасартал тайван орхив.

Хүчирхийлэгч, дарангуйлагч залуус өөрөөсөө том хүмүүсийг л хүндэтгэдэг. Хүчирхийлэгч нар өөрсдөө ер нь аймхай амьтад байдаг. Хүчирхийлэгч аймхай амьтдыг битгий сонсоорой. Гүйцээ л бол, гүйцээ.

Тэр зун намайг харихад, ээж маань надад миний төлөө залбирснаа хэлж

Хүчирхийлэгч аймхай амьтдыг битгий сонсоорой. Гүйцээ л бол, гүйцээ.

билээ. Хоёр сарын дараа би аврагдаж, Жонтой учирсан боловч, миний бие хамгаалагч сургуулиасаа гараад ажилд орчихсон учраас, сургуульдаа буцаж очихоос эмээж байлаа. Одоо намайг хэн хамгаалах билээ? Би энэ талаар үнэн голоосоо залбирч байлаа. Ингэж

залбирч байхдаа, сургуульдаа эргэж очоод эхнийхээ долоо хоногтоо л хуучин найз залуутайгаа тааралдчихав. Гэхдээ би түүний нөлөөнөөс бүрэн гарчихсан байв. Би түүнд зун Христэд итгэсэнээ хэлтэл, тэр намайг гайхсан янзтай хараад, яг ийм зүүд зүүдлэсэнээ хэлэв. Тэр надаас бүр хамт Библи судлахыг гуйв. Тийм боловч би аятайхан талархаад, татгалзлаа.

Би түүнд бид хоёр ямар ч харилцаагүй байвал, хэн хэнд маань хэрэгтэй гэдгийг хэлтэл, тэр зөвшөөрсөнгүй. Гэхдээ тэрбээр дахин хэдэн долоо хоног надтай хөөцөлдөөд, дараа нь бүр мөсөн салж билээ. Бурхан миний бие хамгаалагч болж, тэр залууд зүүд хүртэл зүүдлүүлжээ. Энэ бүхэн Бурханаас л байх ёстой. Яагаад гэвэл би аврагдахаасаа өмнө Христэд итгэх итгэлээс хамгийн хол хүн байв!

Тэнгэрийн Аав чинь чиний төлөө тулалдана. Тэр чамайг сүүдэр, аюулаас хамгаална. Түүнд зөвшөөр.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Та миний жинхэнэ Аав, туйлын хамгаалагч, нандин чанарын минь өмгөөлөгч учраас баярлалаа. Та надад сайн сайхныг л хүсдэг гэдэгт би итгэж байна. Би хэзээ ч ганцаараа биш. Та намайг тэнгэрэлч нараараа хамгаалж, Таны Үг намайг сахидэг. Та миний хамгийн муухай нууц, айдсаа бариад, гүйгээд очдог Аав минь. Та намайг судлаж, намайг мэддэг. Надад намайг хамгаалан сахидэг Хаан гэдгээ мэдүүлээч. Жигүүрийнхээ нөмрөөр намайг хучаач.

Таны хайрт охиноос.

9 Амьд өргөл

Секс нь Бурханы анхаарлыг онцгойлон татдаг талбар гэдгийг анх яаж ойлгосноо би санаж байна. Яагаадыг бүү мэд, гэхдээ би анхнаасаа л сексийг муу *охидод* зориулсан муу *зүйл* гэж ойлгодог байлаа. Би ч өөрөө нилээд олон жил жинхэнэ муу охин явсан учраас, Христэд итгээгүй байхдаа, энэ талбарыг ардаа орхих ёстой гэж бодож явсан бол, Христэд итгэснийхээ дараа энэ нь миний амьдралын салшгүй хэсэг болохыг ойлгосон юм. Би энэ сэдвээр хэзээ ч, хэнтэй ч – тэр бүү хэл Бурхантай ч ярилцахыг хүсээгүй юм. Тэгээд ч би Христэд итгэдэг, сайн охид чинь дур хүслийн асуудалд орж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрээд байв. Халз тулж шийдээгүй асуудал чинь хэзээ ч дуугаа хураахгүй. Тэдгээрийг илчилж, загалмай дээр авчрах хэрэгтэй.

Тэр үед “Христэд итгэдэг охид” гэхээр л надад тэнгэр өөд ширтсэн, толгой дээрээ цагирагтай, ариун бүсгүйчүүдийн дүр зураг буудаг байв. Би дээд амьдралаар амьдрахыг хүсэв ч, газрын бодолтойгоо зогсоо зайгүй зөрчилдөж байлаа. Би коллежийнхоо кампусаар явж байхдаа мэдээж өмнө нь хамтарч сахилгагүйтдэг байсан нөхөдтэйгээ зөрнө. Тэдний хувьд бидний өнгөрсөн явдал харин ч бүр давтаж үйлдбэл зохилтой, зугаатай юмс. Тэдний дэргэдүүр явахад “Сайн уу, санаж байна уу? Чи Есүст итгэсэн гэв үү? Би чамайг мэднэ шүү дээ! Хэн гэдгийг чинь мэднэ! Битгий жүжиглээд бай. Наад жүжгээ орхиод, ухаан ор! Чи хуучнаараа илүү хөгжилтэй байсан юм. Одоо ямар ч сонирхолгүй болчихож” гэж байгаа юм шиг л санагдана.

~ Халз тулж шийдээгүй асуудал чинь хэзээ ч дуугаа хураахгүй.

Мэдээж энэ бол миний л төсөөлөл байв. Гэхдээ би бараг л онож бодсон юм. Хичээлийн шинэ жилийн эхний долоо хоногт олон оюутан шавсан нэгэн лекц дээр профессорыг орж ирэхээс өмнө оюутны зөвлөлийн дарга босч зогсоод, миний сууж байсан эгнээнээс намайг дуудаад: “Хөөе Лиза, үнэн үү? Чи Есүсийнх болсон гэв үү? Бид Есүсийнх биш шүү! Бид чамайг Тета байраас чинь хулгайлаад, секс, хар тамхи, архиндаа хүчээр оролцуулна даа!” гэж хэлэв.

Бүгд харцаараа намайг хайв. Намайг ямар байсныг мэддэг байсан зарим нь инээлдэж, толгой дохиж байлаа. Миний нүүр халуу оргин, час улайв. Би тайван байх гэж хичээсэн ч, өөрийн эрхгүй хамаг бие чичирч байв. Гэтэл Есүсийн үг зүрхэнд цуурайтах шиг болов:

Тиймээс хүмүүсийн өмнө Намайг хүлээн зөвшөөрөгч хүн бүрийг Би тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө мөн хүлээн зөвшөөрнө. Харин хүмүүсийн өмнө Намайг үгүйсгэсэн хэнийг ч болов Би тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө үгүйсгэнэ. (Матай 10:32–33)

Би террас шиг засалтай танхим дотор суудлаасаа босоод, намайг сонсож байгаа хүн бүрт өөрийгөө танилцуулаад, оюутны зөвлөлийн даргын нүд рүү эгцлэн харж байгаад:

“Тийм ээ, үнэн!” гэж хэлээд, дараа нь үүнийгээ батлахаар дайрав!

Дарга ч, ангийн дийлэнх хувь ч инээлдэв. Би суудалдаа суулаа. Тэгтэл профессор орж ирснээр миний шүүх хурал дуусав. Би хичээл дуустал бүх нүднээс нуугдан, урагш харсаар суулаа. Тэгээд би утсан дээгүүр дэнжигнэж явах ёстой болсноо ойлгов. Гэхдээ надад түүнээс өөр аюулгүй зам байгаагүй юм.

Ийм эрс тэс юм хийсэн хүнийг одоо бүгд ажиглаж байгааг би ойлгов. Ангиас орж, гарах болгонд над дээр баахан харц шавна. Миний хувьд урьд нь кампус найзууд, хөгжилдөөн, найз залуусын диваажин байсан бол, одоо өнгөрсөн ичгүүрт амьдралын маань шүүх болов. Би хичээлдээ орохоосоо хоёрхон долоо хоногийн өмнө аврагдсан болохоор яахаа үнэндээ мэдэхгүй байв.

Үүнээс гадна намайг Христэд итгэдэг бусад оюутнуудын хандлага үнэхээр самууруулж байлаа. Тэд надад “*Тайвшраад, Есүсийн тухай ярихаа боль. Чи хүмүүсийг үймүүлж байна. Зүгээр л жирийн “итгэгч” байгаач дээ*” гэдэг санааг ил, далд янз бүрийн аргаар давтдаг байв. Тэд намайг Бурханыг дагахад урамшуулаагүйгээр үл барам, бүр дуугаа тат гэж байлаа. Тэд л ингэж байхад, итгэдэггүй залуус намайг тэгж няцаах нь аргагүй шүү дээ.

~ Би залуу хүмүүсийн
цорын ганц гарц нь
буулт гэж бодож эхлэв.

Би итгэлийнхээ талаар дуугүй байх гэж хичээлээ. Бага багаар итгэлээсээ няцаж, үүнийгээ дагаад бага багаар үхэж байх шиг санагдана. Би залуу хүмүүсийн цорын ганц гарц нь буулт гэж бодож эхлэв. Миний мэддэг итгэгч оюутнуудын дийлэнх нь миний итгэдэггүй байхдаа сонсдог байсан хөгжмийг сонсож, очдог байсан үдэшлэгт очдог байв. Харин миний хувьд, тэдгээр дууны үг нь намайг хүн биш болгодгийг мэддэг учраас, Христээс өмнөх бүх хөгжмөө хаясан юм. Би Христэд итгэдэг болсон ч, бусадтай л адилхан хүн гэдгээ батлах гэж нөгөө хуучныхаа үдэшлэгт очсон ч, одоо цоо эрүүл учраас, ямар ч утгагүй байв. Архигүй бол, энэ бүхэн шал тэнэг санагдана. Одоо энэ тоглоом хөгжилгүй болжээ.

Тиймээс би итгэлээ хуурай эгч дүүсийнхээ холбооноос гадуур эрэлхийлэхээр шийдэж, Кампус Крусэйдтэй холбогдов. Энэ байгууллагаар дамжин хэдэн жилийн өмнө нутгийнхаа гоо бүсгүйгээр шалгарч байсан, хуурай эгч дүүсийн холбооны маань нэгэн хөөрхөн охин намайг нөмөр нөөлөг дороо авч, бид хоёр хамтдаа Библи судлаж, цайныхаа цагаар уулздаг болов. Тэрбээр надад ихэвчлэн яаж гэрчлэхийг л заадаг байлаа. Бид хоёр хамт залбираад, кампус дээрх оюутнуудад хувьчлан гэрчилдэг байв. Энэ сайхан цагаар би маш ихийг сурсан.

*~ Би Эзний зоогийг
ариутгалын ёслол гэдэг утгаар
нь бус, харин амилуулагдсан
Эзэнтэйгээ, сэтгэлийн
Аврагчтайгаа дотносон
нөхөрлөх гэсэндээ барьж байлаа.*

Гэтэл нэг өдөр гадаа наранд ном уншиж байгаа нэгэн охин дээр очтол, тун сонин явдал болов. Бид түүн рүү дөхөнгөө Библи уншиж байгааг нь харав. Тэрбээр итгэгч хүн гэдэг нь тодорхой байлаа. Тийм боловч бид хоёр түүнтэй ярилцав. Биднийг явах болоход нөгөө охин бид хоёрт тус бүрт маань Бичээсийн ишлэл хэлэв. Минийх:

“Сэрж босооч, хайр минь Цэвэрхэн ганц минь гарч ирээч.
Өвөл нэгтээ өнгөрчээ, Бороо ч болиод татарчээ.
(Соломоны дуун 2:10–11) гэдэг ишлэл байлаа.

Би явахдаа түүнд талархсанаа санаж байна. Хамаг зүрх шатав: Энэ ямар утгатай үг юм бол? Утгыг нь олж мэдэхээр амралтын өдрөөрөө Библиэ бие дааж судлахаар шийдэв. Бүтэн сайны ягаарсан, нарлаг өглөө би оюутан хүнд зохимгүй эрт сэрэв. Гал тогоо руу буутал, өглөөний цайнд цагирган боов тавьсан байлаа. Бүтэн сайнд оюутнуудад ганцхан өглөөний цай л бэлтгэж өгдөг байв. Би цагирган боовоо аваад хазах гэтэл, гэнэт Ариун

Сүнс “Байз” хэмээн шивэгнэв. Би гал зууханд надаас өөр хүн байгаа юм болов уу хэмээн гайхшран эргэж хартал, надаас өөр хүн байсангүй. Би хожим бүр их өлсөхөөрөө идье гэж бодоод, цагирган боовоо амны цаасанд боож аваад, өрөө рүүгээ явлаа.

Гэтэл шатаар явж байхад, Ариун Сүнс надад дараа дараагийн зааврыг өгч байгааг мэдрэв. Намайг цагирган боовоо аваад, хүнсний дэлгүүр ороод шүүс ав гэв. Бурхан намайг Эзэний зоогт урьж байв! Алхах тусам дотроос гижигдэх шиг л. Нөгөө Бичээсийн утга хэдийнээ задраад эхлэчихжээ. Бурхан намайг Өөр рүүгээ бас хамт алхъя хэмээн дуудаж байв. Би Библи, дэвтэр, цагирган боовоо бас жаахан мөнгө аваад үүргэвчдээ хийлээ. Дэлгүүр ороод, шүүс худалдаж аваад, кампусынхаа очих хамгийн дуртай газар руугаа явлаа. Тэр маань маш өндөр, хөгшин аварга моддын дор байдаг бандан сандал байв. Би тэнгэрийн зугаалгынхаа хүнсийг гаргаж тавиад бас Библиэ гаргалаа. Би долоо хоног тутам Эзэний зоог барьдаг чуулганд өссөн ч, Христэд итгэснээсээ хойш нэг ч удаа бариагүй байв. Эзэний зоогийг ганцаараа барьж болох эсэхийг мэдэхгүй байсан учраас, энэ талаар юу заасан байдгийг нь олж мэдэхээр Библиэ нэгжлээ.

“Энэ бол та нарын төлөөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд” гэсэн. Тэрчлэн зоогийн дараа мөн аяга авч “Энэ аяга нь Миний цусаар тогтоогдох шинэ гэрээ юм. Үүнээс та нар уух болгондоо Намайг дурсаж үүнийг үйлд” (1Коринт 11:24–25)

Ийнхүү би Есүсийн үгийг анх удаа ухаарахад, дотор маань ариун эмээхүй залран буув. Тэр урилга цаг хугацааг сэтлэн, яг одоо надад: “Энэ бол чамд зориулсан Миний бие” гэж хэлж байна. Би Эзэний зоогийг ариутгалын ёслол гэдэг утгаар нь бус, харин амилуулагдсан Эзэнтэйгээ, сэтгэлийнхээ Аврагчтай дотносон нөхөрлөх гэсэндээ барьж байлаа. Дурсгалын гэрээ болох хугалсан талхаар дамжуулан Эзэн намайг хувьчлан загалмай дээр эрэмдэглэгдсэн биеийнхээ тахил руу урьж байв. Тэр намайг амьдруулах гэж сайн дураараа тахил болсон. Энэ жижиг зүйл биш! Тэрбээр бас надад цусаараа худалдаж аваад, усан үзмийг няцласны үр дүнд гардаг бүтээгдэхүүнээр дүүргэсэн, шинэ гэрээний аягыг сунгаж байна. Миний өмнө байгаа талх, усан үзмийн шүүс нь миний итгэлээрээ ойртож байгаа, өнө эрт хаа нэг газар засагдсан ширээний билэгдэл байв. Би энэ бүхнийг уншиж байхдаа, энэ гүн утга агуулгатай үйл явдлын өмнө эмээн чичирч байлаа.

Тиймд хэн нэгэн нь зохисгүйгээр Эзэний талхыг идэж, аяганаас уух аваас Эзэний бие ба цусны буруутан болно. Аливаа хүн өөрид талхыг идэг, аяганаас ууг Учир нь идэж ууж буй хүн биеийг зөв нягтлалгүй идэж, уувал өөртөө шийтгэл авчирна. Тиймд хэн нэгэн нь зохисгүйгээр Эзэний талхыг идэж, аяганаас уух аваас Эзэний бие ба цусны буруутан болно. (1Коринт 11:27–29)

Би үүнийг урьд нь олон удаа хийж байснаа санаад мэлмэрэв. Би Эзэний биеийг саналгүй, өөрийнхөө зүрхийг шалгалгүй, зүгээр л үйлдийг нь дагадаг байсан. Тэр миний төлөө амиа өгсөн байтал би өөрийгөө хэзээ ч үнэнээсээ шүүж байсангүй. Чуулган дахь Эзэний зоогийн үеэр би ийш тийшээ өнгөлзөөд л, хэн ирсэн, ирээгүйг нь бүртгэдэг байсан ч, хэзээ ч өөрийнхөө дотор руу өнгийж байсангүй. Би миний төлөө урссан Эзэний цусыг тоохгүй атлаа баримлуудаас цус гар байгаа эсэхийг нь шалган ширтдэг байж билээ.

Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. (1Коринт 11:31)

Би нүдээ аниад ойлголтын маань хараа гийж, амьдралынхаа талбар бүрийг олж харахын төлөө залбирав. Дараа нь Ариун Сүнсээр шинжилгээ хийлгүүлж, Бурханы Үгээр үйлдэл, сэдлээ шүүлгүүлэхээр урив. Би тэнд хэдэн цаг эсвэл хэдэн минут байснаа мэдэхгүй. Гэхдээ тэр бол надад цэвэр амьдралыг ухааруулсан, цаглашгүй эгшин байсан юм. Би өмнөө байгаа олон янзын сэдвээр залбирахдаа, нүглээ гэмшиж, зүрхэндээ цэвэршилт, чөлөөлөлтийг мэдрэв. Есүс намайг Өөрт нь бүх амьдралаа өргө гэсэн бөгөөд мэдээж үүнд нь миний бие ч орж байлаа.

*~ Есүс намайг Өөрт
нь бүх амьдралаа өргө
гэсэн бөгөөд мэдээж үүнд нь
миний бие ч орж байлаа.*

Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн хүсье. Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн. (Ром 12:1)

Биднийг Бурханы өршөөлийн нүдэнд цэвэр байхыг ятгажээ. Биднийг айгаад байх бус, харин хэдийнээ хүлээн авсан өршөөлийнхөө гэрэлд хариу үйлдэхийг ятгажээ. Ямарваа нэгэн аугаа учир шалтгаан юмуу учир үүдэл байгаа болоод л Бичээс биднийг *ятгадаг*. Би энэ Бичээсийн утгыг

ойлгохын тулд илүү гүн ухаад, илүү нарийн тунгаа. Миний бие Бурханы өмнө амьд тахил болон өргөгдөх учиртай ажээ. Христэд итгэдэг хүн – миний амьдрал минийх биш болжээ. Учир нь намайг худалдаж авсан.

Мөнчлөн бид энэ дэлхийгээр бохирлогдож, нүглээр бузарлагдсан байлаа ч, Бурхан бидний амьдралын энэ тахилыг ариун, тааламжтай хэмээн хүлээн авахыг Бичээс амлажээ.

Би өөрийнхөө биеэс нуугдаж, үүний урхи, захиргаалтын эрхшээлээс зугтмаар байсан бөгөөд үүнийг хэрхэн хийхийг Бурхан зааж өгчээ. Би биеэ Бурханаар сахиулахаар амьд тахил болгон өргөж, Загалмайг хүлээн авах юм бол, Бурхан Хүүгийнхээ улмаас миний өргөлийг зөвт хэмээн тооцох ажээ.

Би ариун байдал нь зүгээр л “сайн сайхны төлөө” тушаал биш гэдгийг ухаарав. Бас насанд хүрсэн хүний хувьд ариун амьдрах боломжгүй гэдэг ойлголт нь худлаа болохыг ч ухаарав. Ариун амьдрал нь мөргөл ажээ. Ариун байдал нь өөрийгөө няцааж, амьдралаа Бурханы өдөр тутмын чиглүүлэгт өргөж, загалмайгаа авах явдал ажээ. Би Бурханы ясны яс, махны мах байхыг хүсэв. Тийнхүү Түүний Үг миний амьдралд бодитой болно.

Ром 12– аар бүлгийн талаарх Мэтью Хенригийн тайлбарт биеэ амьд өргөл болгон өргөхийг энгийнээр ийнхүү тайлбарлажээ: “Бидний тахилч болох Христээр дамжуулан Бурханд өргөсөн бидний хувь чанар, гүйцэтгэл нь Бурханыг хүндэтгэх тахил болой.”¹

Тахил нь бидний хүслийн тэргээр Бурханы оршихуй руу тээвэрлэгдэнэ. Яг л хүн итгэлээр авралд хүрдэг шиг. Бид Бурханаар өршөөгдсөнийхөө хариуд тэр өршөөнгүй Бурханыг хүндэтгэх ёстой. Ийнхүү бид эргэн тойрныхоо хүмүүст одоо би өөрөө өөрийнхөө эзэн бус, харин биднийг худалдаж авсан Эзэнийх болсноо мэдэгддэг. Дээрх тайлбарт мөн: “Бурхан та нараас мал адгуусыг бус, харин биеийг чинь хүсдэг”² гэжээ.

Би энэ анхааруулгад дуртай. Бурхан цустайгаа хутгалдсан, үхсэн малыг хүсдэггүй. Бурхан хайраар, талархлаар цохилсон зүрхийг, Түүний зорилго, тааллын төлөө зориулагдсан биеийг хүсдэг. Давид үүнийг мэддэг байсан учраас, Эзэний өмнө тахил өргөхдөө, үнэндээ Бурхан цаанаа юу хүсч байгааг мэддэг байв.

Учир нь Та тахилд баярлахгүй. Тийм бишсэн бол би түүнийг өргөхсөн.
Та шатаалт тахилыг таалахгүй. Бурханы авах тахил нь эмгэрсэн сүнс юм.
Эмгэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй. (Дуулал 51:16–17)

Бурхан шашны хөшигнөөс, махан биеийн ажлаас давж хардаг, итгэлээр ойртож Түүнийг үнэнээр бөгөөд Сүнсээр хүндэтгэдэг хүмүүсийг хүсдэг.

Бурхан зүгээр нэг сайн байхаас илүү том хүсэлтэй – Түүнийх байх хүсэлтэй хүмүүсийг хүсдэг.

Зарим нь Есүс хэдийнээ бүхнийг хийж, гүйцэлдүүлсэн учраас, бидний зүгээс өөр янз бүрийн юм хийх шаардлагагүй хэмээн маргах байх. Гэхдээ бид нүглийг тахил болгох талаар яриагүй байна. Бидний эсрэг бичигдсэн зүйл ангийг ямар ч тахилаар хангахгүй. Есүс бидний нүглийг зайлуулахаар Хурга болон нядлуулсан ч, нөгөөтэйгүүр Тэрбээр бас бидний Тэргүүн тахилч бөгөөд бүхний үлгэр жишээ болой. Бүгдээрээ энэ харилцааг харцгаая:

Бурхан шашны хөшигнөөс, махан биеийн ажлаас давж хардаг, итгэлээр ойртож Түүнийг үнэнээр бөгөөд Сүнсээр хүндэтгэдэг хүмүүсийг хүсдэг.

Хэрэв бид Христтэй хамт үхсэн бол мөн Түүнтэй хамт амьдрах болно гэдэгтээ бид итгэдэг. Христ үхэгсдээс амилуулагдсан тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй. Учир нь Түүний үхсэн үхлийн хувьд, Тэр нэг удаа нүгэлд үхсэн бөгөөд харин Түүний амьдардаг амьдралын хувьд, Тэр Бурханд амьдардаг. (Ром 6:8–10)

Бид Христийн үхэлтэй нэгдсэнээрээ, амиллынх нь мөн чанараар амьдрах чадалтай болно. Есүс нүглийн, үхлийн хүчийг эвдсэн. Тэр одоо ч Өөрийнхөө төлөө бус, Бурханы төлөө амьдарч байна. Уралдаанаа амжилттай дуусгасан хүн байгаа бол, тэр нь Есүсээс өөр хэн ч биш. Гэтэл Есүс: “Ашгүй минь, дууслаа! Одоо Би ажлаа дуусгачихсан болохоор Өөрийнхөө хүслээр амьдарна” гэж хэлээгүй. Түүний амь Бурханы дотор нууцлагдсан бөгөөд харин бидний амь Түүний дотор нууцлагдана.

Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаагаа тооц. Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх гэдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог. Биеийнхээ эрхтнүүдийг зүй бусын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсод мэт мөн биеийнхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон Бурханд өргө. Учир нь та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа тул нүгэл та нарыг захирахгүй. (Ром 6:11–14)

“Түүнчлэн” гэдэг нь *яг адилхан* л гэсэн үг. Тэр цусаа урсгасан учраас, бид цусаа урсгах шаардлагагүй болсон. Гэхдээ бидний бие амьд тахил болох

ёстой. Бид Түүн шиг “нүгэлд үхсэн, харин Бурханд амьд” мэт амьдрах ёстой! Бидний биеийг нүгэл захирахгүй... Бурхан захирна. Бид биеэ бус,

~ Бид дуулгавартай дагадаг зүйлдээ өргөл өргөдөг бөгөөд дагадаг зүйл маань бидний эзэн болдог.

Бурханыг дагана. Дуулгавартай байдал бол чухал санаа. Паул биднийг биеийнхээ эртхтэнүүдийг муугийн зэмсэг болголгүй, зөвтийн зэмсэг болгон Бурханд өргөхийг ятгажээ. Бид дуулгавартай дагадаг зүйлдээ өргөл өргөдөг бөгөөд дагадаг зүйл маань

бидний эзэн болдог. Дуулгавартай байдал нь зөвт байдалд өргөх өргөл бол, дуулгаваргүй байдал нь мууд өргөх өргөл юм. Паул үгээ “Нүгэл та нарын эзэн байхаа больсон” гэдэг тунхагаар өндөрлөжээ. Нүгэл бидний өргөл, хүндэтгэлийг авах эрхгүй болсон. Яагаад гэвэл бид хуулиас гарч, нигүүлслийн дор орсон.

Ром 12–аар бүлгийн эхэнд биднийг Бурханы өршөөл дор байж, биеэ амьд тахил болгон өргөх талаар ярьсан. Хууль биш, өршөөл биднийг нигүүлсэл дор тавьдаг бөгөөд энэ нигүүлсэнгүй бэлэгийн хариуд бид Загалмай дээрх Христийн үлгэр загварыг дагах ёстой. Бид өдөр тутам махан биед бөгөөд мууд биш, Бурханд бөгөөд зөвт байдалд захирагдана. Бид сайн дураараа амь, биеэ өргөнө. Тэгээд итгэлээр Бурханы зүрхний араас гүйнэ. Энэ бол Загалмайгаа авах зүйл явцсын нэгээхэн хэсэг билээ.

Тэр тэдэнд бүгдэд нь хандаж —Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр нь өдөр бүр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна. Хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? (Лук 9:23–25)

Загалмайг өдөр бүр авахыг анхаараарай. Энэ нь нэг удаа аваад, мартчих зүйл биш шүү. Энэ нь хүзүүнд юмуу гартаа зүүдэг чимэглэл биш, харин өдөр бүр зүрхэндээ тээх зүйл шүү. Тахилч нар өдөр бүр сүмд Эзэний өмнө өргөл өргөх ёстой байжээ:

Тэгээд үүдний танхимын урд талд өөрийн босгосон, ЭЗЭНий тахилын ширээн дээр ЭЗЭНд зориулан Соломон шатаалт тахилууд тахив. Үүнийг өдөр тутмын журмын дагуу, Мосегийн тушаал ёсоор Амралтын өдрүүд, шинэ сар болон жил бүрийн гурван баяр ёслол болох Исгээгүй талхны баяр, Долоо хоногуудын баяр, Майхан баярын үед тахидаг байв. (2Шастир 8:12–13)

Загалмай нь өдөр бүрийн өргөл юм. Энэ чиглүүлгийг Мосегийн хууль өгөөгүй, Эзэн Өөрөө өгсөн. Бид Түүний Үгийг нэг их хайхрахгүй байгаа мэт. Гэхдээ хэрэв бид итгээд, хүлээж авах юм бол, тэдгээр нь чөлөөлж, аврах амь, хүчтэй.

Бүгдээрээ Эзэний зоогийн урилга руу эргэцгээе. Христийн зоогийн ширээнд уригдана гэдэг нь ямар утгатай вэ? Үүнд хариулахын тулд Эзэний зоог гэдэг үгийн утгыг мэдэх хэрэгтэй. Үүнийг *эв нэгдэл, сүнсний нэгдэл, санаа сэтгэл тавих, нягт холбоо бас харилцаа* гэж тодорхойлдог. Эдгээр үгсийн хоршил нь эмэгтэй хүний жинхэнэ дүрээрээ бүрэн хайрлуулах гэсэн чин сэтгэлийн хүслийг илэрхийлнэ.

~ Загалмай нь өдөр бүрийн өргөл юм.

Тэгэхээр бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ дараа нь би бүрэн мэдэх болно. (1Коринт 13:12)

Жинхэнэ дүрээрээ гэдэг нь өө сэв, алдаа эндэл, мөрөөдөл, санаашрал, айдас, найдвар нь тэр чигээрээ ил байх гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл үйлдлийн цаадахыг харж, зүрхний сэдлийг таних. Өөрөөр хэлбэл бидний харахгүй байгааг харах. Тэгээд өө сэв нь ил харагдаж байсан ч, урвашгүй хайраараа хайрласаар байх явдал юм. Хайр бүгдийг хардаг. Учир нь жинхэнэ ялгах харааны цаад хүч нь хайр билээ.

Эзэний зоогийн урилга нь биднээс хол давсан том амьдралын хүчний нэгээхэн хэсэг болох урилга юм. Энэ нь өөр нэгэн эх үүсвэрээс идэж, ууж, амь хүртэх боломж юм. Биднийг цангааг маань жинхэнээсээ тайлах ус уу гэж урьдаг. Гэхдээ бас биднийг зүгээр нэг хооллоод гарах биш, харин үлдэж, Түүний дотор оршихыг урьдаг.

Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй. ...Эцэг Намайг хайрласны адил Би бас та нарыг хайрласан. Хайранд минь байгтун. Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, хайранд нь байдаг лугаа адил, та нар тушаалыг минь сахивал хайранд минь байх болно. (Иохан 15:5, 9–10)

Энд Христ – Христийн хүмүүсийн харилцааны үзэсгэлэнт дүр зураг байна. Тэр бол бидний амь, гэжээл, хүчээ авдаг усан үзмийн мод. Бид Түүний дотор байвал, маш их үр жимс гаргана. Үр жимс нь юу вэ?

Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайн сэтгэл, итгэмж, дөлгөөн зан, өөрийгөө захирахуй нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй. (Галат 5:22–23)

Бид яаж Түүний дотор үлдэж, усан үзмийн модтой холбоотой байх вэ? Иохан 5:19 дээр хэрэв бид дуулгавартай байвал, үлдэнэ гэжээ. Христ Аавынхаа тушаалыг дагасан шиг, Христийн тушаалд дуулгавартай байх нь биднийг аюулгүй байлгана. Тиймээс дуулгавартай байдал нь Эзэний хайрын зоогийг барих уур амьсгал ажээ.

Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих явдал юм. Түүний тушаалууд хүнд дарамт биш билээ. (1Иохан 5:3)

Би энэ бүлгээрээ дуулгавартай байдлын талаар маш их ярьж байгаагаа мэднэ. Гэтэл өнөөдөр бид энэ талаар бараг ярихаа больжээ. Тэгвэл Есүс энэ талаар байнга ярьдаг байсан. Дуулгавартай байдлыг ганц Шинэ гэрээнд л жаран долоон удаа дурьдсан. Бид бүгдээрээ л их бага хэмжээгээр дуулгаваргүй авирлаж үзсэн бөгөөд энэ нь биднийг Бурханаас салган, зөвт байдлаас нүгэл рүү дагуулдгийг мэднэ.

Би чамайг махан бие, Ханхүү та хоёрын хооронд тээглэх хар сүүдрээс цаадахыг хараасай гэж хүсч байна.

Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд Төгсгөгч болох Есүс өөд харцгаая. Тэрээр өмнө нь тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм. Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе. (Еврей 12:1–2)

Бурхан чиний хайрын түүхийг бичиж, энэ үйл явц, аялал дундуур чамтай хамт явж, чамайг тэжээж, сахина. Би чамайг Эзэний зоогоор Түүнтэй нэгдээсэй гэж хүсч байна. Түүний Үг, итгэмжтэй чанараар хооллох аяллаа эхлэхдээ, Түүнийг амьдралынхаа эх үүсвэр, хүчээ болго.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Тан дээр Есүсийн нэрээр ирж байна. Би Таны ширээнд зоог барьж, хайр, итгэмжтэй чанараар тань найрлах урилгыг хүлээн авлаа. Есүс Сүүлчийн зоог дээр Өөрийгөө амьд тахил болгон өргөсөн шиг, би Бурханы өршөөлийг хүлээн авч, Есүсийн үлгэр жишээг дагаж байна. Би биеэ Таны мэлмийд ариун бөгөөд зохистой амьд тахил болгон өргөж байна. Учир нь би Таны нандин Хүүгийн цусаар угаагдсан. Би цаашид дуулгаваргүй байдал, нүгэлд биеэ захируулахгүй. Би биеэ Танд цоо шинээр өргөж байна. Миний судсаар гүйж байгаа Христийн амийн төлөө баярлалаа. Есүс ээ, Та бол амьд Усан үзмийн мод, харин би мөчир нь. Таны дотор үр жимс гаргах чадвартай болгосонд баярлалаа. Та бол амь бөгөөд хүч. Би тэр хэзээ ч хатдаггүй худгаас ууж байна. Эдүгээ би намайг чангааж байгаа дарамт, нүгэл болгоныг хойш тавьж байна. Таны хайрыг цоо шинээр таниулаач. Байгаа бүхнээрээ Таныг хайрлахад туслаач. Би Сүнс доторх амьдралыг хүлээн авч, өдөр бүр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа аваад, Таныг дагаж байна.

Таны хайрт охиноос.



10 *Хараалыг таслах*

Дав хийн сэрлээ. Зүрх маань чичирч, түргэн түргэн амьсгаадаж байв. Дахин нэг хар дарсан зүүднээс сэрсэн маань энэ байлаа. Би нүдээ аажмаар нээгээд, тааз руу хараад, өглөөний манан суунагласан бүдэг туяа туссан байхыг үзэхдээ, Жон дэргэд байхгүйг мэдэв. Би чимээ чагнасан ч, хөршийнхөө шатаар явж байгаа чимээнээс өөр юу ч дуулсангүй. Тэгсэн ч Жоныг дуудлаа:

– “Жон!”

Би яг л айсан хүүхэд шиг дуудав. Тэгтэл надад хүүхэд байхдаа, хар дарж зүүдлэхээрээ ээжийгээ дууддаг байсан минь санаанд орлоо. Эхлээд шивэгнэж дуудна. Тэгээд өрөөнд над руу дайрах юм байхгүйг мэдмэгцээ, улам чангарсаар, хамаг чангаараа дуудахад, ээж гүйсээр орж ирдэг байж билээ. Гэтэл энэ удаа хэн ч орж ирсэнгүй.

Би Жоныг дахиад дуудангаа, өндийн суугаад цагаа харахдаа хамаг бие маань усан хулгана болсон байхыг мэдрэв. Энэ удаа би асуух маягаар арай нам дуугаар дуудсан ч, Жон хэдийнээ ажилдаа явсныг ойлголоо. Ийм муухай зүүд зүүдлэж байж, яахаараа ингэтлээ их унтдаг байна аа?

Би жихүүцлийг үргээж унагах гэсэн шиг биеэ хөдөлгөлөө. Тэгэхгүй бол өдөржин бие арзайна. Сүүлийн үед би их хар дарж зүүдлэдэг болоод байлаа. Хүүхэд байхдаа л ингэдэг байсан сан. Энэ хар атга намайг хамгийн багадаа жилдээ нэг айлгаж аваад, хэсэгтээ алга болно. Гэтэл одоо энэ аймшиг жилээс сар, сараас долоо хоногийн давтамжтай болж, шөнө бүрийн амар тайвныг минь хулгайлдаг болоод байв.

Би шөнийн харанхуйд тэр зүүдтэй ганцаархнаа тэмцдэг учраас, сүүлийн хэдэн долоо хоног унтахаасаа, нүдээ анихаас ч айдаг болоод байлаа. Жон,

бид хоёр гэрлээд удаагүй байсан бөгөөд шөнө бүр би тэр зүүдийг битгий ирээсэй гэсэндээ Жоноор залбируулна. Шөнө болгон унтахаар хэвтэхдээ, Жон намайг зүүдний хулгайч нараас хамгаалах гэсэндээ чанга тэврээд хэвтдэг боловч, төдөлгүй өөрөө тайвшраад, нам унтаад өгнө. Харин би над руу гэтэж байгаа айдсын шивнээг сонссоор сэрүүн хоцорно. Би унтан унтгалаа Дуулал 91–ийг ахин дахин тунхаглана.

Нойр маань эхлээд аз жаргалтай зүүдээр эхлээд, яваандаа зурагтын суваг солихтой л адил амархан өөрчлөгдөнө. Тэгээд суваг нь гацаад, миний зугтаж гарч чаддаггүй мөнөөх зүүд болж хувирна. Зүүдний хэлбэр нь өөр өөр боловч, цаад утга нь адилхан. Би эхнээс нь шууд таньдаг байлаа. Би зүүдэндээ ч... “*Үгүй ээ, дахиад л биш шүү! Би энэ зүүдийг үзэн ядаж байна!*” хэмээн эсэргүүцнэ.

Тэр зүүдэнд би төрсөн гэртээ байж байх юм. Тэгээд гэрээсээ гараад,

найзынхаа гэр рүү, сургууль руугаа эсвэл дэлгүүр рүү (хаашаа явж байгаа маань хамаагүй) баяртайгаар алхлана. Тэгтэл гэнэт бүх зүйл өөрчлөгдөж, намайг булан тойрмогц тэнгэр харлаж, тэртээгээс шөнийн харанхуй өөдөөс гэтэн үзэгдэнэ. Би бүрэнхий рүү ухраад, шөнийн харанхуйг алсаас харна. Ард хэдхэн

~ Би хэсэгхэн хугацаанд өдөр, шөнийн зааг дээр зогсохдоо, тэр шөнө нь зүгээр л цаг хугацаа, орон зай биш, харин харанхуйн хүч болохыг ухаарна.

алхмын зайтай нарны гэрэл тусдгаараа туссаар л. Би хэсэгхэн хугацаанд өдөр, шөнийн зааг дээр зогсохдоо, тэр шөнө нь зүгээр л цаг хугацаа, орон зай биш, харин харанхуйн хүч болохыг ухаарна. Би эргээд нарны гэрэл рүү, гэр рүүгээ хар хурдаараа гүйх гэсэн боловч, бүрэнхий дунд гацчихсан мэт, урагшилж чадсангүй. Нарны гэрэл яг урд маань байсаар л. Бие маань ямар нэгэн өтгөн лаг дундуур явж байгаа мэт бараг хөдлөж чадахгүй байв. Би гүйсэн чигээрээ толгойгоор эргүүлэн, бүрэнхийн цаана байгаа тас харанхуйг харав.

Тэгэхэд тэр харанхуй дандаа л миний араас ирж яваа харагддаг байлаа. Гурван хар дүрс над руу ядах юмгүй ойртсоор. Би гүйгээд гүйгээд ахихгүй учраас, тэдний алхам болгон бидний хоорондын зайг улам л нарийсгана. Би айсандаа урагшаа хараад, тэр саарал манан дундаас гарах гэж улам түргэсэв ч, тэдний алгуур боловч, ахицтай хурдын хажууд миний самгардсан хурд ямар ч нэмэргүй. Би холоос гэрээ үзсэн ч, олон зуун бээрийн газар байгаа мэт санагдана. Би гэр рүүгээ ойртохгүй байв.

Би дахин хойшоо харахдаа, намайг бараг л гүйцэж ирсэн хар сүүдрийг нэг бүрчлэн тодорхой үзэв. Намайг хөөж яваа тэдгээр сүүдрүүд нь ялзралын өөр, өөр үе шатандаа яваа үхдэлүүд ажээ. Нэг нь бүр үхчихсэн бөгөөд ямар ч амьгүй алхаж байв. Дараагийнх нь хагас ялзарчихсан,

гурав дахь нь үстэй араг яс байлаа. Өмссөн хувцас нь ч бас ялзралын өөр, өөр үе шаттай ажээ. Нэг нь бүрэн хувцастай, дараагийнх нь салбарсан хувцастай, гурав дахь араг яс нь энд тэндээ өгөшрсөн даавуу наалдаатай харагдана. Тэд яг нэгэн зэрэг хөл нийлүүлэн алхана. Тэд бие биетэйгээ ярилцалгүй, ганц л зорилгоор урагшилна: Тэд миний араас яваа ажээ.

Би энэ бүгдийг сүүдрээс зугтах хоорондоо, арагшаа ганц эргэж харахдаа л ажигласан юм. Тэднийг ойртох тусам, миний хөдөлгөөн удааширч, би улам айж, сандрав. Би хүүхэд байхдаа дээгүүр нь явдаг байсан замын хашлага дээрээ тээглэн унана. Эцэстээ тэднээс зугтаж чадахгүйгээ мэдэхдээ, би гүйгээ чигээрээ тэдэн рүү орилж эхлэв:

– “Та нар хэн бэ? Зайлцгаа! Та нар үхсэн. Намайг орхи!”

Тэд надад хариулсан ч үгүй, зогссон ч үгүй. Яг л дүлий мэт. Яг л үл үзэгдэх удирдагчийнхаа тушаалаар хөдлөх мэт. Зүүд болгонд би зугтсаар, харин тэд нэхсээр намайг бараг л гүйцдэг байлаа. Тэгээд тэд намайг гүйцээд ирэхийн даваан дээр би тэдэн рүү харахаасаа айсандаа мод, чулуугаар нүүлгэсэн ч, тэд зогссонгүй. Тэгээд ч үхдэлүүдийг мод, чулуу өвтгөнө гэж үү? Би өөрийнхөө хүчээр хичнээн хичээгээд ямар ч нэмэргүй, улам л доройтсоор.

Тийнхүү тэд намайг гүйцээд, хариугүй барьж авахын даваан дээр би дав хийн сэрдэг байв.

Босоод, жижигхэн байрныхаа гал тогоонд орж суухад минь хариулж чадахгүй түмэн асуулт толгойд эргэлдэнэ.

Би Бичээсийг тунхаглаад, залбираад байхад яагаад ингээд байгаа юм бэ? Бурхан энэ зүүднээс хүчгүй гэж үү? Тэр яагаад үүнийг зогсоохгүй байгаа юм? Би итгэгч хүн байж яагаад ийм өчүүхэн хүч, хамгаалалттай байгаа юм бэ?

Тэгтэл утасны дуу бие арзайтал цочоов. Би харилцуураа аваад:

– “Байна уу?” хэмээн цухалдангүй хариуллаа.

– “Миний хань, сайхан амарсан уу? Сайхан унтаж байсан болохоор чинь явахдаа сэрээсэнгүй. Ойрд сайн амарч чадахгүй байгаа болохоор... жаахан унтаг гэж бодоод” хэмээн Жон ярив.

– “Намайг сэрээчихгүй. Би дахиад л зүүдлэсэн.”

– “Ээ, тийм үү?”

– “Жон, энэ бүхэн яагаад зогсохгүй байгаа юм бэ? Бид шөнө залбирсан биз дээ?” хэмээн намайг эргэлзэнгүй асуухад, Жон:

– “Найз нь мэдэхгүй байна аа” хэмээн үнэнээсээ л хариулав.

Жон ч бас над шиг л гонсгор байгаа нь дууных нь өнгөнөөс илт байлаа.

Бид хоёр дахиж жаахан ярилцаад, утсаа тавилаа. Би том өрөөндөө ороод Библиэ уншин, уншиж байгаа үгийнхээ утга дээр төвлөрөх гэсэн боловч,

нойрондоо дийлдэн, ухаан санаа маань орж гарч, бүрэлзэж байлаа. Яг л дахиад л зүүднээсээ зугтаж байгаа мэт. Нойрны хүнд гар намайг дарж, би сэрүүн байх гэсэндээ бүр л тухгүй, эвгүй байдалд орсоор, тархин дахь манан зузаарсаар байв.

Би “Бурхан минь, надад туслах хүнийг зааж өгөөч!” гэж залбирлаа.

Тэгтэл тэр даруй хариулт ирж, намайг Даллас руу нүүхэд хуурай охиноо болгон “үрчилж” авсан нэгэн хүн санаанд орж ирэв. Би буйдангаасаа босоод, гал тогооноосоо түүн рүү залгалаа. Золоор тэрбээр завтай байж таарсан учраас, би хамаг зовлонгоо уйлан байж уудлаад: “Арай ч дээ, Би Христэд итгэдэг хүн байж, ингэж амьдарч байх гэж... үүнээс олигтой амьдарч чадахгүй байх гэж!” гэсэн гомдлоор дуусгалаа.

Тэрбээр надтай санал нийлээд: “Би чамд гурван хуурцаг илгээе. Чи ганцаараа байхдаа сонсоод, дараа нь над руу залгаарай” гэж хэлэв. Би ч түүнийг хурдан илгээгээрэй гэж захиад, утсаа тавилаа. Анх удаа надад найдвар төрөв. Би хөшгөө яран, Техасын нарыг гэртээ уриад, шүршүүрт орлоо.

Шөнийн аймшиг үргэлжилсээр байсан ч, хэдэн өдрийн дараа би илгээмжээ хүлээн авав. Тэгээд яг л төрсөн өдрийн бэлэг хүлээн авч байгаа мэт баярлав. Би зочныхоо өрөөнд ороод, дэвтэр, Библи, тодруулагч, хуурцаг тоглуулагчаа бүрэн бүрэлдэхүүнээр нь бэлтгэлээ. Тэгээд:

“Аав аа, надад үнэнээ мэдүүлж, намайг үнэнээр чөлөөлөөч! Харах нүд, сонсох чих, итгэх зүрхийг минь нээгээч. Есүсийн нэрээр. Амень” гэж залбирав.

Тэгээд нэгдүгээр хуурцгаа тоглууллаа. Бичлэг нь маш тааруу учраас, би чихээ нааж байж сонсов. Тэнд нэгэн настай хүн миний хэзээ ч сонсоогүй

зүйлсийг зааж байсан бөгөөд яг л миний тэмцэлдэж байгаа зүйлийг мэдээд байгаа юм шиг л ярьж байв. Тэрбээр “Христэд итгэдэг хүмүүс харын хүчийг уурлуулж, догшруулна гэж бодсондоо, сүнсний тулааны талаар ярихаас айдаг. Тэгээд үүнээсээ болоод мууг эсэргүүцэж чадалгүй, айж гэдрэг ухардаг” гэв. Тэрбээр “Сатан хэдийнээ бүх хүчээ дайчлан ажиллаж байгаа учраас, бид түүний харын ажлыг илчилснээрээ, хүчийг нь бэхжүүлэх биш, харин сөнөөнө” хэмээн тайлбарлав. Түүнчлэн “Сатан бидний ахан дүүсийг хуулийн мэргэжилтэн мэт ялладаг, түүнийг гагцхүү итгэл дотор Бурханы Үгийн илдээр мятрашгүй жадлан эсэргүүцэж байж л ялна” гэв. Тэр гурван хуурцагны эхний хоёр дээр нь хичээл, гурав дахь дээр нь залбирал байлаа. Би Библиэ уншихдаа, өмнө харж байсан атлаа хайхралгүй, гүйлгээд өнгөрсөн зүйлсийг үзэв.

~ Христэд итгэдэг хүмүүс харын хүчийг уурлуулж, догшруулна гэж бодсондоо, сүнсний тулааны талаар ярихаас айдаг.

Өнөөдөр чи энэ бүхнийг мэддэг байж болох ч, 1982 онд эдгээр нь тун эрс тэс ойлголт байсан юм шүү. Тэр өдөр миний сурсан хамгийн хүчирхэг, эрчтэй үнэнийг би чамтай хуваалцмаар байна. Тэр нь Бурханы амлалтыг амьдралдаа ажиллуулах зарчим юм.

Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор “За” ажээ. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан “Амен” гэдэг. (2Коринт 1:20)

Энэ бол гайхамшигтай амлалт. Бурханы амлалтын тоо, хүчээс үл хамааран, Түүний хариулт нь Христийн дотор хэзээд “Тийм” байдаг. Үүнийг Хуучин гэрээний жишээгээр дүрслэе. Бурхан Мосе тэргүүтэй Израилийн өмнө ерөөл, хараалыг тулгажээ. Дуудсан ерөөл болгоны дараа ард түмэн хүлээн зөвшөөрөх мэт нэгэн дуугаар “Амень” гэнэ. “Амень” гэдэг нь “ёсоор болог” л гэсэн үг. Дээд хууль номд үүний нэгэн жишээ бий:

Бурханы амлалтын тоо, хүчээс үл хамааран, Түүний хариулт нь Христийн дотор хэзээд “Тийм” байдаг.

Харагтун, өнөөдөр би өмнө чинь ерөөл, хараал хоёрыг тавьж байна. Хэрэв өнөөдөр миний тушааж буй, ЭЗЭН Бурханыхаа тушаалыг та нар дуулгавартай дагавал ерөөгдөх болно. Хэрэв та нар ЭЗЭН Бурханыхаа тушаалыг сонсохгүй, харин өнөөдөр миний та нарт тушааж буй тушаалуудаас хазайж, урьд мэддэггүй байсан өөр бурхдыг дагаваас хараагдах болно. (Дэд хууль 11:26–28)

Эзэний тушаалыг зөрчих юм бол, Хуулийн дор ерөөл бүр нь араасаа хараал дагуулдаг байжээ. Харин Христ Хуулийг цуцласан.

Христ бидний төлөө хараал болсноороо биднийг хуулийн хараалаас зольсон юм. Учир нь “Модон дээр өлгөгдсөн хүн бүр хараагдсан юм” гэж бичигдсэн байдаг. Энэ нь Абрахамын ерөөлийг Христ Есүсээр харийнханд ирүүлэхийн тулд юм. Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм. (Галат 3:13–14)

Бид Христ дотор Абрахамын ерөөлүүдийг өвлөнө. Мосегийн ерөөлийг хүлээж авахын тулд бид Израилийн үр байх ёстой ч, Абрахамын ерөөл нь Харь үндэстнүүдэд хүрчээ. Хуулиас гадуур байгсад нь итгэлээр Христийн

дотор шинэ амьд гэрээ рүү нэвтэрсэн. Тиймээс Христийн дотор “хуулийг дагах юм бол, тийм” гэдэг үгийг бус, харин “Христийн дотор – тийм” гэдэг үгийг сонсоно. 2Коринт 1:20 дээр:

“Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор “За” ажээ. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүтээр дамжуулан “Амен” гэдэг” (2Коринт 1:20) гэж хэлсэн байгааг тэмдэглээрэй.

Бид “болтугай” буюу “амень!” гэж хэлдэг. Бид Үгийг хараад, Үгийг амьдралдаа бодитой болгохын тулд итгэлээр ойртдог. Бид Үгийг итгэлээр амьдралдаа ажиллуулдаг. Бид “Би Таны Үгийг зүрхэндээ сийлж байна. Энэ Үг миний амьдралд ажиллах болтугай” хэмээн Бурханд хүсэл, амьдралаа захируулдаг.

Үг биднийг зэмлэхэд, бид гэмшиж, зөвлөгөөг хүлээн авна. Үг биднийг уриалан дуудахад, бид “Би итгэж байна... Эзэн минь, итгэлгүй байдалд минь туслаарай” гэж хэлдэг. Бид “Эзэний Үг мөнх тогтож, амьдралд маань алдаршиг!” гэдэг.

Би тэр гурван хуурцгийг сонсоод, өмнө харанхуйтай хутгалдаж явснаа хүчингүй болгох хэрэгтэй байгаа амьдралынхаа талбаруудыг Үгийн толинд

маш тодорхой харж, эцэг өвгөдийнхөө нүглийг улайх хэрэгтэй гэдгээ ойлгов. Миний амьдрал дээр, аав ээжийн маань амьдрал дээр, өвөө эмээгийн маань амьдрал дээр харанхуйн сүүдэр суунаглаж байгааг би тодорхой харав. Нөгөөтэйгүүр, Христийн ерөөл миний дээгүүр бас миний үр удам дээгүүр

Христийн ерөөл миний дээгүүр бас миний үр удам дээгүүр элин хальж, ангал дээр зогсоод “Тийм!” гэж хэлэх хүнийг хүлээж байгааг би бас харсан юм.

элин хальж, ангал дээр зогсоод “Тийм!” гэж хэлэх хүнийг хүлээж байгааг би бас харсан юм. Би гайхамшигтай үүрэг хариуцлагыг мэдрэхдээ, Эзэний өмнө сөгдөн, өөрийнхөө болоод гэр бүлийнхээ нүглийг гэмшин, хүчингүй болгов. Би яг л Хезекиагийн үгийг давтах шиг санагдаж байлаа:

Израилийн Бурхан ЭЗЭНТэй гэрээ байгуулах санаа зүрхэнд минь байна. Ингэвэл Түүний дүрэлзсэн уур биднээс эргэх биз. (2Шастир 29:10)

Хезекиа эцэг өвгөдийнхөө алдааг хүлээж, Бурханд үнэнч байхаа тунхаглажээ. Миний бие ч үй түмэн нүгэлтэй, үй олон үеийнхэний үр удам гэдэг нь тодорхой байлаа. Мэдээж би Бурханы өмнө нүглээ гэмшихдээ, эцэг өвгөдийнхөө ч, өөрийнхөө ч нүглийг ширхэгчлэн тоочиж чадахгүй ч,

надад буруутай гэдгээ ухаарсан, ерөнхий хэдэн талбар байв. Тэдгээр нь:

- Астрологиор болоод зарим нэг сэжигтэй ном, тоглоом, киногоор дамжин нууц шүтлэгт гар бие оролцсон явдал.
- Хар тамхи, архи
- Сексийн нүглүүд

Ийм юмстай – нэг их ач холбогдол өгөлгүйгээр – орооцолдох нь хүртэл үхлийн аюултай болохыг би мэддэггүй явжээ. Би астрологийн тэмдэг бүрийг тайлбарласан, аав, ээжийнхээ нэгэн номыг уншиж байснаа санадаг юм. Бас нухацтай ханддаггүй байсан ч, зурхай уншдаг байлаа. Нэг удаа Христмасын баяраар хүлээж авсан Вийжаа тоглоомоороо нилээд нааддаг байгаад, өөрөө хөдлөхийг нь үзээд, үнхэлцгээ хагартал айснаасаа хойш тоглохоо больж билээ. Христэд итгэхээсээ өмнө би аймшгийн түүх, нууцлаг юмст их дурладаг байлаа. Мэдээж Бурханаар өлсөж цангасан зүрхээ цагтах гэсэндээ л эдгээр зохисгүй юмстай хутгалдсан боловч, харамсалтай нь энэ бүхэн нь намайг ерөөл дор биш, хараал дор оруулж амжжээ.

Эмээ, аав хоёр маань архичин байсан бөгөөд би өөрөө ч арван дөрөв, тавтайгаасаа хорин нэг хүртлээ тасралтгүй ууж билээ. Би бас коллежд байхдаа хэд хэдэн удаа марихуан татаж, кокаин туршиж үзсэн. Эдгээр тэрслүү үйлдэл нь миний амьдралыг хараалд нээж өгсөн байв.

Түүнчлэн би өмнөх үеийнхэнээсээ зарим зүйлсийг анзаарав. Эмээ, ээж, бид гурав гурвуулаа хорт хавдар туссан. Гурван үеэрээ. Миний эмэг эх хоёр удаа гэрлэсэн, эмээ нөхрөөсөө салаад, дахиад түүнтэйгээ гэрлэсэн боловч, дахин салж өөр хүнтэй гэрлэсэн. Тэгээд дахин салж, гурав дахь хүнтэйгээ гэрлэсэн ч, тэр хүн нь эмээтэй хэрэлдэж байхдаа зүрх нь хаагдаж, нас барсан юм. Аавын ээж нь хоёр удаа гэрлэсэн. Манай аав, ээж хоёр салсан боловч, гэрлээд бас дахин салаад, аав өөр хүүхэн дагаад арилсан ч, түүнтэйгээ хэзээ ч гэрлээгүй юм. Эмээгийн нэг хүүхэд нь зулбасан бол, нөгөөгөө төрүүлж байхдаа эмээ өөрөө золтой л амиа алдчихаагүй юм. Ээж маань дүү, бид хоёрын дунд гурван хүүхдээ зулбуулж алдсан. Яагаад энэ бүхэн ахин дахин давтагдана вэ?

ЭЗЭН урдуур нь өнгөрч, тунхаглахдаа —ЭЗЭН, ЭЗЭН Бурхан өрөвч, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан, энэрэл хайр ба үнэнээр бялхам билээ. Тэрээр энэрэл хайрыг мянга түмэнд хадгалж, хилэнц, гэмт үйлдэл болон нүглийг уучилдаг. Гэсэн ч Тэр шийтгэлгүй орхихгүй. Эцгүүдийн хилэнцийг гурав, дөрөв дэх үеийг хүртэл хүүхэд, ач нарынх нь дээр буулгадаг гэв. (Гэтлэл 34:6–7)

Ямар нэг зүйл хийхгүй л бол, эдгээр нь миний амьдрал, гэрлэлт тэгээд магадгүй хараахан төрөөгүй байгаа хүүхдүүдийн маань амьдралд ч үргэлжлэн давтагдах юм шиг санагддаг байлаа. Гэтэл Бурхан надад эдгээр хараалын барьцыг хэрхэн зогсоохыг харуулж байв. Бичээсийг хартал, тэнд шалтгаан нь ч, амлалт нь ч байх. Би энэ хараалын тойргийн гурав дахь, зарим талаараа дөрөв дэхь үе нь байв. Энэ мэдээж шалтгаан мөн боловч, би өөр нэгэн Бичээсээс өөрт хандсан амлалтаа олсон юм:

Тэдэнд чи бүү мөргө, бүү үйлчил. Учир нь чиний Бурхан ЭЗЭН хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын хувьд эцгүүдийнх нь хилэнцийн шийтгэлийг гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл Би буулгадаг. Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрэлээ үзүүлдэг. (Гэтлэл 20:5–6)

Би Бурханд хайртай, Үгийг нь дагадаг мянган үеийнхэний эхлэл байхыг хүсэв. Энэ нь миний хувьд эцэг өвгөдийнхөө нүглийг гэмшиж,

өршөөнгүй Бурхантай гэрээ тогтоох боломж байлаа. Бурхан мянган үеэр маань ерөөхийн тулд намайг Өөрийг нь дуудахыг хүлээж байжээ. Би миний өөрийн амьдралд, үр удмын маань амьдралд ирэх гэрээ, дуулгавартай байдлын хүч нөлөөг ухаарахдаа, нэгэн зэрэг айж бас баярлав.

~ Би миний өөрийн амьдралд,
үр удмын маань амьдралд ирэх
гэрээ, дуулгавартай байдлын
хүч нөлөөг ухаарахдаа, нэгэн
зэрэг айж бас баярлав.

Тэр хуурцгаар дамжин би урьд өмнө огт мэдэхгүй байсан нэгэн төрлийн хүлээсээс чөлөөлөгдсөн юм. Энэ нь сэтгэлийн хүлээсийг тасар татах зарчим байсан бөгөөд миний амьдралд тийм хүлээс олон байв. Бид амьдралдаа байгаа зарим хүлээсийг дөвийлгөлгүйгээр, шийдвэрлэж чадна гэдэгт би итгэдэг. Есүс чөтгөрийг хөөхдөө, онолын бага хурал хийлгүйгээр, зүгээр л хөөсөн. Есүс гинжийг харахдаа тасладаг байсан, чөтгөрийг харахдаа хөөдөг байсан, өвчин эмгэгтэй хүмүүсийг харахдаа эдгээдэг байсан, нүглийн хүлээстэй хүмүүсийг харахдаа, уучилж, хүчжүүлээд, дахиж нүгэл битгий хийгээрэй гээд явуулдаг байсан.

Би Есүсийн бодитой, амьдралтай, энгийн занд хайртай. Тэр намайг хүлээстэй гэдгийг мэдсэн учраас, гарт маань намайг чөлөөлөх хүчтэй үнэнийг бариулсан. Харин би одоо энэ үнэнийг чиний гарт өгч байна. Энэ үнэн харьшгүй хүчтэй. Учир нь энэ үнэн хүнийх биш, харин бүгд явж оцоод, хүндэтгэх Чөлөөлөгчийнх болой.

Тэгэхээр сэтгэлийн хүлээс гэж юу вэ? Товчхондоо, бид үүний гогцоонд

яг л хүүхэд шиг яваад орчихдог. Мэдээж энэ хүлээс нь сайн ч, муу ч зүйл байж болно. Эхийн сэтгэл үрд гэдэг. Гэтэл үр нь том болоход, ээж – хүүгийн харилцаа өөрчлөгдөж байж л эр хүн зүрхээ гэргийдээ өгнө. Нөхрийн сэтгэл сүйт бүсгүйдээ байж байж л тэд нэгэн бие болно. Эр хүн ээж, аавыгаа орхиод, эхнэртэйгээ нэгдэнэ. Эдгээр нь бидний зүрхийг хайраар зангиддаг, эрүүл, сайн холбоо юм. Нөхөрлөл дээр ч үүн шиг эрүүл холбоо тогтож болно. Давид, Ионатан хоёр ийм л харилцаатай байсан.

Давид Саултай ярилцаж дуусахад Ионатаны зүрх түүнийхтэй нэгдэн Давидыг Ионатан амь шигээ хайрлалаа. . . Давидыг Ионатан амь шигээ хайрласан тул Давидтай гэрээ байгуулав. (1Самуел 18:1,3)

Ионатан, Давидад —Амар тайван явагтун. Чи бид хоёр “ЭЗЭН чи бид хоёрын дунд болон миний үр удам ба чиний үр удмын хооронд мөнхөд байг!” гэж ЭЗЭНий нэрээр бие биендээ тангарагласан билээ гэв. Тэгээд Давид босож явав. Ионатан хот уруу буцжээ. (1Самуел 20:42)

Энэ холбоо нь Давидын амийг аварсан, хожим Ионатаны удмыг аварсан нөхөрлөлийг зангиджээ. Энэ хоёр хүн байр суурь, тав тухаа золиослон байж байгуулсан гэрээгээр холбогджээ. Ионатан Давидыг хайрлан, түүний дээрх Бурханы мутрыг харахдаа, хаан болох эрхээ огоорчээ. Чиний амьдралд ч бас ийм харилцаа байсан байх. Эгч дүүтэйгээ юмуу эсвэл дотно найзтайгаа. Та хоёрын дунд далд холбоо оршино. Би л хувьдаа хөвгүүдтэйгээ ийм харилцаатай. Заримдаа би ярилцалгүйгээр тэднийг бодлыг мэдэрдэг.

Бид найзууд, аав ээжийн хоорондох эрүүл харилцааны талаар ярьсан. Тэгвэл одоо лавшруулаад, нөхөр – эхнэрийн хоорондох харилцааг авч үзье. Энэ холбоо Адам, Ева хоёроос эхлэлтэй. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэй нэгэн бие болж нэгдэхийн нууц билээ. Есүс үүнийг ингэж тайлбарласан:

Харин бүтээлийн эхнээс Бурхан хүмүүсийг эр, эмээр бүтээсэн. Тиймээс эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог. Тиймд тэд цаашид хоёр бус, харин нэг махбод юм. Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг гэлээ. (Марк 10:6–9)

Энэ нь Эхлэл номын анхдагч төлөвлөгөө байсан нь тодорхой байна – анхнаасаа л ийм цэвэр зорилготой байж. Эхнэр, нөхөр хоёр саланги биш, нэг бие болдог. Энэ нэгдэл нь амь авчрах чадалтай, хүчтэй эд. Нэгдүгээрт

– хоёр сэтгэл хайраар холбогдоно. Дараа нь хайр нь гэрээ болтлоо боловсрон, Бурханы өмнө тангараг болно. Тэгээд сексийн нэгдэл болтлоо хөгжин, тэдний биес нэгдэнэ. Эцэстээ эр хүний үр эмэгтэй хүний умайд таригдан, амь төрнө.

Тэд бэлгийн нэгдлээр дамжин оюун, бие, сүнсээр нэгдэнэ. Дотнослын гурван төвшинд тохиодог, энэ үйл явдал нь зөвшилцлийн хамгийн өндөр төвшин болой. Энэ нэгдлээс өмнө хувь хүн болгон өөрөөрөө л гүйцэлддэг байсан бол, энэ нэгдэл тохиоход хоёр нь саланги байхаа болино. Эдүгээ тэд хамтдаа саланги байхаасаа илүү хүчтэй. Энэ нь хуваагдал биш, харин бүтэн болох үйл явц юм. Тиймээс л нэг байх ёстой хоёр чинь бие биеэсээ урван, завхайрах нь тун аюултай ажээ. Эхнэр, нөхөр хоёр л ийнхүү гурван төвшинд нэгдэж чадна.

Сэтгэлийн холбоо нь гэрлэлтээс гадуур ч, гэрлэлтийн харилцаанд ч тохиож болно. Эрэгтэй, эмэгтэй хоёр бэлгийн харилцаанд орбол, тэдний хооронд

бэлгийн холбоо тогтоно. Өөрөөр хэлбэл үр дагаваргүй секс гэж байхгүй. Энэ холбоо хоёр талыг хоёуланг нь зөвхөн сэтгэлээр биш бас биеэр ч өөрчилнө. Би саяхан зурагтаар ДОХ-ын талаар сонирхолтой баримт сонссон юм: Чи хэн нэгэнтэй бэлгийн харилцаанд орохдоо, биологийн талаасаа тэр хүний сүүлийн долоон жил хавьтсан бүх хүнтэй хавьтдаг ажээ. Хавьтлын физик үлдэгдэл нь бүтэн долоон жил хадгалагдах аж!

Эхлэл номд Иаков Леа хоёрын охин Дина, ханхүү хоёрын түүх бий.

Хивичүүдийн Хаморын хүү буюу тэр нутгийн жонон Шехем түүнийг хараад, авчирч хүчирхийлэн бузарлав. Иаковын охин Динад тэр үнэн голоосоо татагдаж, тэр охиныг хайрлан, энхрий үгээр түүнтэй ярив. —Энэ охиныг надад эхнэр болгон авч өгөөч гэж тэр эцэг Хамораасаа гуйлаа. Охин Динаг нь тэрээр бузарласныг Иаков сонссон боловч хүүхдүүд нь хээр мал хариулж байгаа тул тэднийг харьж иртэл нь дуугүй байлаа. (Эхлэл 34:2–5)

Үүний дараа Шехемийн сэтгэл Динад уягджээ. Тэр Динаг гэргий болгож авахыг хүссэн. Тэр “түүнийг хүчиндсэн” гэж байгааг анхаарна уу. Шехем дараа нь гэрлэх хүсэлт тавьсан байсан ч, Динаг хүчиндсэн гэх баримтыг нь засаагүй байна. Та хоёр сүй тавьсан байсан ч, гэрлэлтээс гадуурх секс нь зүгээр л хүчин юм. Шехем Динатай гэрлэхчээд унтсан бол, хүчиндсэн гэхгүй байв. Тэгсэн бол, энэ бүх явдал орвонгоороо эргэх байж. Энэ үйл

явдлын дэс дарааг авч үзье: Шехем Динаг үзээд, сэтгэл татагдаад, дагуулж яваад, хамт хэвтээд, хүчиндээд, дурлажээ. Шехем Динаг хайрласан, аргадан ярьсан, ааваас нь гуйсан. Тэр бүхнийг тонгоруулж хийжээ.

Шехем эхлээд аавтай нь яриад, охиныг нь гуйсан бол, бүх юм өөрөөр эргэх байж. Тэр Динаг аргахдаа: “Битгий ай. Бүх юм сайхан болно. Би чамтай гэрлээд, бүгдийг засчихна” гэж хэлсэн байх л даа. Энд Динагийн сэтгэл мэдрэмжийн талаар юу ч бичээгүй нь сонирхолтой. Тэр зүгээр л хүчиндүүлсэн үү эсвэл өдөөгдсөн үү? Тэр ер нь Шехемтэй суухыг хүссэн үү? Энэ дунд Дина өөрт нь мэдэгдэлгүйгээр шийдэгдсэн хүчингийн хэргийн хохирогч юм шиг л харагддаг. Эрүүл бус холбоонд нэгдэл, нөхөрлөл биш, харин хяналт, айдас тогтдог. Эрүүл бус холбоонд эмэгтэйчүүд ихэвчлэн хохирогч болдог. Шехем, Дина хоёрын түүх эмгэнэлтэйгээр төгссөн. Ханхүү алуулж, Дина ганцаараа үлджээ.

Үнэндээ, чи нэг л хүнтэй бэлгийн харилцаагаар нэгдэх ёстой. Учир нь секс нь гэрлэлтийн гэрээгээр нэгдсэн хоёр хүнд хамаатай зүйл юм. Тийм нөхцөлд хүчин гэж байхгүй. Бид ямар нэгэн зүйлд зүй бус хандахдаа, үүнийг доромжилж, үнэгүйдүүлж, бузарладаг.

Гэрлэлтээс гадуурх секс нь гэрлэлтийн гишүүн болгоныг бас Бурханыг доромжилдог бол, гэрлэлтийн гэрээ доторх секс нь Бурханыг бас нөхөр, эхнэрийг хүндэтгэдэг. Тиймээс л бидэнд гэрлэлтийн ор дэрийг цэвэр байлгахыг анхааруулжээ:

Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр нь ч бүү бузартаг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ. (Еврей 13:4)

Бид цэвэр амьдарч, ирээдүйн ханьдаа хадгалагдсанаараа гэрлэлтийг хүндэтгэдэг. Бид гэрлэснийхээ дараа урвах (завхайрах) юмуу бэлгийн дотнослын гоо үзэслэнг гутаах зүйлтэй (порно, гар хангалга, гаж дон, цэвэр бус явдал зэрэг) орооцолдохгүй байснаараа гэрлэлтийнхээ ор дэрийг хүндэтгэдэг.

Энэ бүхэн миний хувьд цоо шинэ мэдээ байв. Би өмнө нилээд эрээн мяраан амьдралтай байсан учраас, гэрлэсний минь дараа өнгөрсөн амьдралын маань жигшмээр дүр зураг, дурсгалууд над руу дохиж эхлэсэн юм. Жон, бид хоёрыг хамтдаа байж байтал, гэнэт таван жилийн өмнө коллежд байхад тохиосон насанд хүрэгчдийн аймшигтай киноны дүр

~ Шехем дараа нь гэрлэх хүсэлт тавьсан байсан ч, Динаг хүчиндсэн гэх баримтыг нь засаагүй байна. Та хоёр сүй тавьсан байсан ч, гэрлэлтээс гадуурх секс нь зүгээр л хүчин юм.

зураг харван орж ирнэ. Эсвэл хуучин найз залуутайгаа үйлдсэн ичгүүрт дурсамжаасаа болоод би өөрийгөө таг түгжихдэг байв. Үнэхээр жигшмээр. Би энэ бүхнийг итгэдэггүй, ганц бие байхдаа шал тоодоггүй байсан бол, Христэд итгэдэг, гэр бүлтэй хүн болсноос минь хойш энэ бүхэн яг л цагийн тохиргоотой сексийн бөмбөг шиг л санагддаг болоод байлаа.

Би эр нөхөртэйгээ эрх чөлөөтэй эрхлэн жаргахын оронд өнгөрснийхөө хоригдол шиг л байв. Би өнгөрснийхөө садар самуунд эрх чөлөөтэй байсан атлаа, гэрлэлтийнхээ амьдралд яг л хоригдол шиг байв. Үнэхээр жигшмээр! Би эр нөхөртэйгээ сексийн эрх чөлөөгөө эдлэн жаргаж байх ёстой байтал өмнөх амьдралынхаа нүглийн балгаар хоригдол шиг л байлаа. Би бохир бодол, дүр зураг, харьцуулалт, шившигтэй зөрчилдөж байлаа. Би сэтгэлийн хүлээсийг таслаж, удам дамжсан нүглийг хүчингүй болгох ёстойгоо мэдэх хүртлээ өөртэйгээ эцэсгүй тэмцэлдэж байв. Шинэ гэрээ энэ талаар юу хэлсэн байдгийг харцгаая:

Би эр нөхөртэйгээ эрх чөлөөтэй эрхлэн жаргахын оронд өнгөрснийхөө хоригдол шиг л байв.

Биес чинь Христийн эрхтнүүд гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгвэл би Христийн эрхтнүүдийг авч, тэдгээрийг янхны эрхтнүүд болгох уу? Огт үгүй. Янхантай нийлсэн нь түүнтэй нэг бие болно гэдгийг та нар мэдэхгүй юу? Учир нь “Хоёр нь нэг махбод болно” гэсэн юм.
(1Коринт 6:15–16)

Би хуучин найз залуусаа янхан гэж хэлээгүй боловч, зарчим нь ялгаагүй юм. Би тэдэнтэй хамт байсан, гэтэл одоо өөр хүнтэй гэрээ байгуулжээ.

Бэлгийн тал дээрээ эрэмдэг хүн бүтэн биш учраас, өөрийгөө нөхөртөө бүрэн зориулах хэцүү.

Нийлж, салах бүрийд маань миний сэтгэл тасарсаар, эцэстээ би сексийн тал дээрээ бүтэн биш, шүүр шанага шиг болжээ. Бэлгийн тал дээрээ эрэмдэг хүн бүтэн биш учраас, өөрийгөө нөхөртөө бүрэн зориулах хэцүү.

Ийм эрэмдэг болсон эмэгтэйчүүд өдөөлтийн өмнөөс бат зогсох чадваргүй байдаг. Тэд үгүй гэж хэлмээр байвч, хэлж чаддаггүй. Тэд тачаал юмуу ялдаа эсвэл хоёуланд нь дийлдэх учраас, бэлгийн уруу татлагыг эсэргүүцэх бараг л боломжгүй байдаг. Тэд бэлгийн хүчирхийлэл, ёс бус явдлын соронз, хохирогч болдог. Тэд янз бүрийн эрчүүдтэй явалдсан, урьд өмнийн явдлаасаа болоод тачааддаг. Гэхдээ Бурхангүй байхад боломжгүй юмс Бурхантай байхад боломжтой болдог.

Цэвэр амьдрахын тулд бид бүрэн байх ёстой бөгөөд гагцхүү Бурхан л бидний үйрсэн хэсгүүдийг сэргээж, бүрэн бүтэн болгож чадна. Бидний хүчирхийлэлд өртөж, гутаагдсан бэлгийн ариун нандин чанарыг гагцхүү Бурхан л дахин сэргээж чадна. Бохирлогдож, бузарлагдсаныг гагцхүү Бурхан л цэвэр, ариун болгож чадна. Бидний барьж очсон үнсийг гагцхүү Бурхан л аваад, гоо үзэсгэлэнгээр сольж чадна.

Би тэр өдөр бэлгийн нүгэл, ичгүүрийн шатаах тахилыг Бурханы өмнө авчрах онцгой цаг гаргахаар шийдэв. Тэгээд тэр оройдоо л Эзэний өмнө өргөв. Жон эзгүй учраас, би юунд ч баригдалгүй Эзэнтэйгээ уузлаа. Надад Эзэний өмнө ганцаараа залбирах цаг хэрэгтэй байв. Биднийг иймэрхүү асуудалтай нүүр тулахад бэлэн болох үед Эзэн үүнд бидний анхаарлыг хандуулдаг гэдэгт би итгэдэг. Би бэлэн болжээ! Магадгүй чиний гарт байгаа энэ ном Бурханаас чамд өгч байгаа урилга ч юм билүү.

Итгэмжтэй, хайрын Тэргүүн тахилч маань биднийг дотно мэднэ. Тэр Өөрөөс нь биднийг чангааж байгаа бүхнийг тасар татахаар илдээ далайна. Тэр эрүүлийг нь авч үлдээхийн тулд сэтгэлийн өвчтэй холбоо бүрийг таслахыг хүснэ. Тэр чиний сэтгэлийг эдгээж, сэргээхээр Үгээ илгээнэ. Чиний очихоос айж байгаа газар бүрт Бурханы тэнгэрэлч очоод, тэнд тасарч үлдсэн сэтгэлийн чинь тасархай бүрийг эргүүлэн чамд авчирна.

Тэд бүгдээрээ авралыг өвлөгчдийн төлөөх үйлчлэлд илгээгдсэн үйлчлэгч сүнснүүд биш үү? (Еврей 1:14)

Тэнгэрэлч нар бол сэтгэлийн хамгаалагч нар. Тэдэнд мөргөж болохгүй. Гэхдээ тэд авралыг хүлээж авсан хүмүүстэй холбоотой. Бурхан Өөрөө тэднийг томилсон учраас, тэдний оролцооноос айх хэрэггүй.

Чиний амьдралыг бүрэн цэвэрлэх бололцоог нь Бурханд олгохын тулд залбирцгаая. Амлагч нь итгэмжит. Тэр чамайг шавраас татан гаргаад, хадан дээр тавина. Гэхдээ чи зүрхээрээ Түүний талд байх ёстой. Энэ бол байдаг л нэг зүйл биш. Магадгүй чамд залбирахаасаа өмнө мацаг барьж, хүндэтгэх цаг хэрэгтэй. Ариун Сүнсний удирдамжинд сонор соргог бай. Тэр чамайг энэ үйл явц дундуур алгуур дагуулан гаргасаар, дайсны харанхуй, сүүдрийн бат цайз болгоныг нураахад чинь туслана. Тэгэхээр миний нөгөө хар дарсан зүүд яасан гэж үү? Хараалыг тасласныхаа дараа би дахиж хэзээ ч зүүдлээгүй.

Тэр чамайг шавраас татан гаргаад, хадан дээр тавина.

Эхлэхээсээ өмнө түр амсхийх цаг гаргана уу. Үүнийг яг одоо ч хийж болно. Гагцхүү чи хүсэлт, цуцлалт, “тийм бөгөөд амень” гэдэг хариултаа

чангаар хэлэх учраас, ганцаараа байх юмуу эсвэл чамайг дэмжих ойр дотныхоо хүмүүс, залбирлынхаа хамтрагч нарыг л дэргэдээ байлгаарай.

Би чамд аль болох амархан байлгахын тулд залбирлаа Бичээстэй хавсаргалаа. Учир нь Үг нь Сүнсний хоёр талдаа хурц иртэй, хүчирхэг илд юм. Түүнчлэн чамайг бие дааж судлаасай гэсэндээ залбирлынхаа сүүлд хэд хэдэн Бичээсийг орууллаа.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Таны өмнө Таны эрдэнэт хүү Есүс Христийн нэрээр ирж, талархлаар үүдээр тань орж, магтаалаар таны үүдэн талбайд ирж байна. Надад хэдийнээ үзүүлсэн нигүүлсэнгүй өршөөл, хайранд тань баярлалаа. Бас миний амьдралд хийх гэж буй авралын хүчирхэг ажилд тань ч баярлалаа.

Одоо би Израилийн Бурхан Эзэнтэй гэрээ байгуулмаар байна. Та бол газар тэнгэрийн Бурхан Эзэн. Өөрийг нь хайрлаж, тушаалыг нь дагадаг хүмүүстэй хайрын гэрээгээ сахидаг аугаа гайхамшигтай Бурхан. Та зарцынхаа залбиралд хараа, сонороо хандуулах болтугай. Би Таны эсрэг үйлдсэн өөрийнхөө болоод эцэг өвгөдийнхөө нүгэл, зөрчил бүрийг мэдэгдэж байна. Бид Таны зүг бусармагаар үйлдсэн учраас, биднийг өршөөгөөч. Бид Таны эсрэг нүгэл үйлдсэн учраас, шившиг болсон. Гэхдээ хэдийгээр бид Таны эсрэг нүгэл үйлдэж, Үгийг тань дагалгүй, зарц эш үзүүлэгч нараараа өгсөн хуулийг тань сахиагүй ч, Та биднийг өршөөж хэлтрүүлсэн. Та бидний зүрхийг хозлож, нүгэл, ичгүүр, Египетэд хорогдсон сэтгэлийг арчин зайлуулаач.

Аав аа, би нууц шүтлэг, илбэ шид, ховс увидастай холбоотой өөрийнхөө болоод эцэг өвгөдийнхөө нүглийг мэдэгдэж байна. (Энэ хэсэг дээр түр зогсоод, Ариун Сүнс хүчингүй болгуулахаар чамд ямар нэгэн зүйл сануулах эсэхийг анхаараарай. Энэ дунд астрологи, сеансууд, аймшигийн кино, тоглоом, ном зэрэг маш өргөн хүрээний юмс байж болно) Би иймэрхүү юмст гар бие оролцсоноо цуцлан таслаж, үүнээс үүдсэн хараалыг өөрийнхөө болоод үр удмынхаа хүн нэг бүрийн амьдралаас таслаж байна.

Аав аа, би мансууруулах бодис, архитай холбоотой өөрийнхөө болоод эцэг өвгөдийнхөө нүглийг мэдэгдэж байна. Сүнсэнд маань нүгэл, хүлээс, дарамтыг нэвтрүүлсэн бүх хаалгыг хаагаач. Би . . . (хэрэглэсэн хар тамхи, мансууруулах бодисоо нэг бүрчлэн нэрлэ) хэрэглэж явснаа цуцлан, хүчингүй болгож, өөрийнхөө болоод үр удмынхаа хүн нэг бүрийн амьдрал дээрх тэдгээрийн хараалыг таслаж байна.

Аав аа, би бэлгийн нүгэл, бүхий л цэвэр бус явдал, завхрал, цус холилдох, ёс бус явдалтай холбоотой өөрийнхөө болоод эцэг өвгөдийнхөө нүглийг мэдэгдэж байна. (Хүчингүй болгож байгаа нүгэл бүрээ бөөндөлгүй, нэг бүрчлэн тодорхой нэрлээрэй. Бурханы өмнө ичэж зоволгүй хэлээрэй. Нуух юм юу ч байхгүй— Бурхан тэдгээрийг бүгдийг нь мэдэх бөгөөд тэдгээрийн ял, ичгүүрийн жинг чамаас зайлуулахыг хүснэ. Тиймээс бэлэн болохоороо эхлээрэй.)

Аав аа, Сүнснийхээ илдийг аваад, тэр хүн, бид хоёрын хоорондох сэтгэлийн бурханлаг бус холбоо бүрийг тасар татаарай. (Ариун Сүнсийг анхааралтай сонсож, сонссон зүйлээ нэг бүрчлэн нэрлээрэй. Магадгүй яг бэлгийн харилцаанд ороогүй ч, зөвхөн Аврагчдаа юмуу нөхөртөө хадгалах ёстой харилцаагаа зориулан, дотроо төсөөлөн бодох маягаар бэлгийн юмуу сэтгэлийн харилцаа тогтоосон хүн байж болох.)

Хүн бүрийг нэрээр нь нэрлэснийхээ дараа ингэж залбираарай:

Аав аа, эдгээр эрчүүдээс (эсвэл эмэгтэйчүүдээс) миний сэтгэлийн хэлтэрхий бүрийг авчруулахаар тэнгэрэлч нараа илгээгээч. Намайг бүрэн бүтэн, ариун болгож, Таны тааллын төлөө тусгаарлахын төлөө Ариун Сүнсээрээ авчруулаач.

Аав аа, би завхарсан, булай дүр зураг бүрийн хүлээсийг хүчингүй болгож байна. Энэ бүхнийг харж үзсэнийг минь уучил. Би Дуулал 101:3-ын дагуу гэрээ байгуулж байгаа бөгөөд би нүднийхээ гарцаар зүрхээ хамгаална. Би бузар юмсыг харахгүй. Би цэвэр бус сүнс болгоныг, нөлөө болгоныг амьдралаасаа хөөж байна.

Аав аа, намайг Есүсийн цэвэрлэгч цусанд угаагаач. Учир нь энэ цусанд л цэвэрлэж, угаах хүч бий. Би өөрийгөө Таны сүм болгон тусгаарлаж байна. Сүнснийхээ хүчээр энэ ариун газраас сүнс, сэтгэл, биеийн бохир болгоныг зайлуулаач. Намайг Сүнснийхээ оршихуйгаар дүүргээч. Надад зориулсан бүхнийг харах нүд, сонсох чих, хүлээж авах зүрхийг маань нээгээч. Би Таных. Амьдралд минь ажиллаач.

Таны хайрт охиноос.

Эшлэл: Дуулал 100:4; 2Шастир 29:10–11; Нехемиа 1:5–7; Даниел 9:8–10; Иошуа 5:9; Матай 10:34; Еврей 4:12; 2Шастир 29:5–6.

11 *Халуун зүрхтэй, ариун Бурханаар сонгогдсон*

Чиний араас халуун зүрхтэй, ариун Бурхан гүйж байгаа гэдгийг мэдэх үү? Тэр чамайг хүлээж, Өөрийнх нь зүг хараасай гэж хүсдэг. Тэр чамайг Өөрийнх нь бичсэн хайрын захидлыг уншаасай гэж хүсдэг. Тэр чамайг Өөртөө эргэж ирээсэй гэж залбирдаг. Тэр чамайг энэ дэлхийн харанхуйгаас гаргаж, Өөрийнхөө сүр жавхланта гэрлийн дэлхийд оруулахыг хүсдэг. Тэр чамайг хуурамч амрагуудын гараас шүүрээд, Өөрийнхөө итгэмжтэй, мөнхийн гарт байлгахыг хүснэ. Тэр чамайг Египетийн хатуу эзэд, харгис хүлээсээс чөлөөлж, чамд Өөрийнхөө зөөлөн хайр, өршөөлийг үзүүлэхийг хүсдэг.

*~ Тэр чамайг хуурамч
амрагуудын гараас шүүрээд,
Өөрийнхөө итгэмжтэй,
мөнхийн гарт байлгахыг хүснэ.*

Тэр биднийг амлалтын газар авчрах гэж л Египетээс чөлөөлсөн юм биш. Үнэндээ Тэр биднийг Өөр дээрээ л авчрахыг хүссэн юм. Хуучин гэрээний амлалтууд нь айсуй зүйлсийн сүүдэр байсан билээ. Гэтэл бид яг Израилийн хүүхдүүд шиг л сэтгэдэг. Бид шүүхээс мултарч аврагдсандаа ханаад, биднийг Өөр дээрээ авчрах гэсэн Түүний туйлын зорилгыг умартах. Хайртууд минь, аврал бол гал, амиас хавьгүй том зүйл юм шүү!

Тийм боловч чи яагаад авралыг ингэж ойлгож байсныг чинь би ойлгож байна. Олонх маань “Чи өнөөдөр нас барбал, хаашаа явахаа сайн мэдэх үү?” гэдэг асуултыг сонссон байх. Энэ асуулт нь сонсогч нарыг “Би тэнгэрт очно гэдгээ баттай мэдэж байна уу?” хэмээн бодол хийхэд хүргэх зорилготой. Итгэлгүй байвал, залбираад, мөнхийн байр сууриа баталгаажуулах боломжтой ажээ. Гэхдээ аврал нь үхлийн дараа очдог,

эцсийн зогсоол төдий биш юм. Аврал нь маш баялаг амьдралын арга зам ажээ. Израилийг Египетээс гаргасан Бурханы жинхэнэ хүсэл, зорилгыг сонсогтун:

“Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн Өөртөө яаж авчирсныг та нар өөрсдөө харсан. (Гэтлэл 19:4)

Би энэ эшлэлийн гоо үзэсгэлэнд хайртай. Тэнгэрийн хүчит Бурхан дөрвөн зуун жил боолчлогдсон хүүхдүүдээ аврахаар шуурхайлан бууж иржээ. Энэ үйл явц дунд Тэрбээр энэ дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн Египетийг сүйрүүлээд, сүр сүлдгүй хөөрхийлөлтэй болгож хаяв. Боол Израильчууд Египетчүүдийн алт, мөнгийг хуу хамаад гарчээ.

Энэ дэлхийн хатуу хахир дарлалаас шүүрэгдээд, юутай ч харьцуулашгүй аюулгүй байдал, дотно нөхөрлөл байдаг Бурханы ууланд аваачигдахыг хүсэхгүй хэн байх билээ? Гэхдээ зүрхэнд нь ийм санаашрал байхгүйг олонх маань ухаарах байх. Олон хүн хүлээс, шүүхээс л зугтахыг хүсэхээс биш, Түүнийх болох ямар ч санаагүй байдаг. Бид энэ дэлхийнх байхаа больсон юм бол, одоо хэнийх юм бэ?

Израилийн хөвгүүдийн даяар хотол түмэнтэй ярин “Та нарын Бурхан ЭЗЭН Би ариун учраас та нар ариун байгтун. (Леви 19:2)

Ариун байдал нь үйлчлэгч нарын ажил үүрэг юмуу өөр төрлийн амьдралын хэв маяг бус, харин ариун Бурханы өмнө цугласан *бүхэнд* өгөгдсөн тушаал болой. Бид ариун байх ёстой, учир нь Тэр ариун. Биднийг ариун дүртэй юмуу үйлдэлтэй байгаарай гээгүй, харин ариун *байгаарай* гэсэн. *Байх* гэдэг нь тэр зүйл нь бидний юмуу амьдралын маань нэгээхэн хэсэг болно гэсэн үг. Сүнс маань бидний амьдралыг чиглүүлдэг бөгөөд бид Ариун Сүнсээр дүүрч, удирдуулах ёстой.

~ Ариун байдал нь үйлчлэгч нарын ажил үүрэг юмуу өөр төрлийн амьдралын хэв маяг бус, харин ариун Бурханы өмнө цугласан бүхэнд өгөгдсөн тушаал болой.

Үүнд бидний хувийн харилцаа, олны дундах зан авир ч багтах бөгөөд би үл харагдах, хувийн талбар дээр төвлөрч ярьмаар байна. *Байх* гэдэг нь чиний оршлыг тодорхойлно. Бид ариун *царайлав* ч, ариун биш *байж* болно. Бид ариун юм шиг *үйлдэв* ч, ариун биш *байж* болно. Энэ нь улирсан Хуучин гэрээний заавар биш юм. Нигүүлслийн гэрээ болох Шинэ гэрээ ч бидэнд ариун байхыг анхааруулдаг.

ХАЛУУН ЗҮРХТЭЙ, АРИУН БУРХАНААР СОНГОГДСОН

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм. (1Петр 1:15–16)

Шинэ гэрээний энэ эшлэлийг Левийн анхааруулгатай зэрэгцүүлж харбал, Бурхан бүхлээрээ ариун учраас, биднийг хийсэн *бүхэндээ* ариун байхыг энд бүр ч нарийн хэлжээ.

Ариун байх гэж юу гэсэн үг вэ? Дараагийн Бичээс илүү нарийн тайлбарлаж байна:

ЭЗЭН Би ариун бөгөөд та нарыг Би Өөрийнх болгох гэж бусад үндэстнээс салгасан тул та нар Надад ариун байгтун. (Леви 20:26)

Бурхан Израильд ариун байгаарай гэсэн. Учир нь тэд Түүнийх байхаар тусгаарлагдсан. Үндэндээ Бурхан тэдэнд: “Би та нарыг Өөрийн болгохоор сонгосон учраас, өөрсдийгөө Над руу тусгаарла. Би хэдийнээ чамайг сонгосон учраас, Намайг сонго” л гэж хэлжээ. Израиль бүх үндэстэн дундаас Бурханых байхаар сонгогджээ. Тэгвэл харь үндэстэн бид яах билээ? Бид хэзээ сонгогдов?

Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм. (Ефес 1:4)

Бурхан биднийг авахаас ч өмнө бид Түүний дотор сонгогдсон байжээ. Бид үндэстнүүд дундаас биш, харин дэлхий бүтээгдэхээс ч өмнө Христийн дотор сонгогджээ. Бурхан газрыг бүтээж байхдаа хэдийнээ биднийг бодож байжээ. Бид нядлагдсан Хурга – Христийн дотор дэлхийн сууриас ч өмнө Бурханаар сонгогджээ. Бид Христийн дотор ялгүй, ариун байх тавилантай байжээ.

Түүний мэлмийд ариун байх гэж юу гэсэн үг вэ? Бид Христийн дотор ариун болгогдсон буюу Түүний төлөө, Түүний таалал, зорилго, алдар руу тусгаарлагджээ. Израилиас бусад үндэстнүүд ариун юмуу тусгаарлагдсан байж болохгүй байсан учраас, бидний хувьд амлалт харийн байв. Харь үндэстнүүд гэрээнд нэвтрэхийн тулд бүх хууль, зүйл заалтыг сахих хэрэгтэй байжээ.

Гэтэл өнөөдөр хөшиг цуу урагдсан. Бидний эсрэг байсан зүйл заалтууд нь Христийн загалмай дээр хадуулж, бид Бурханаас тусгаарлагдахаа больжээ (Колоссай 2:14). Ариун байдал нь Бурхан биднийг зүгээр нэг “сайн” байгаарай гэсэн гуйлт биш юм.

Ариун байдал нь биднийг “Түүнийх” байлгах гэсэн урилга юм. Би ганц бие байхаас зугтаж, хүүхэдтэй болох гэсэндээ Жонтой гэрлээгүй. Би Жонных байх гэж түүнтэй гэрлэсэн. Бид нууц, хүүхдүүд, санхүү, машин, нөхөрлөл, гэр, ороо хуваалцдаг. Гэхдээ миний амьдралд Жоны хүрч чадахгүй, гагцхүү Бурханд хадгалагдсан хэсэг байдаг шиг, Жоны амьдралд ч миний хүрч чадахгүй, гагцхүү Бурханд хадгалагдсан хэсэг бий. Эмэгтэй хүн бүр Ханхүүдээ хамаарах ёстой бөгөөд амьдралд нь гагцхүү Ханхүүд л хамаатай хэсгүүд бий.

Ариун байх нь Түүнд зориулагдан сүнс, сэтгэл, биеэрээ тусгаарлагдсан байх юм. Бид эхлээд Түүний дуудлагад хариулаад, дараа нь хүслээ Түүний Үгд захируулж, Ариун Сүнсээр хөтлүүлснээрээ тусгаарлагдана.

Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг үйлдлийг та нар тунхаглах юм. Та нар урьд нь ард түмэн ч биш байсан бол одоо Бурханы ард түмэн болжээ. Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртжээ. (1Петр 2:9–10)

Бид Түүний ариун үндэстний язгууртан тахилч нар байхаар сонгогдсон. Бид Бурханых учраас, биднийг харанхуй дэлхийгээс авран, Өөрийнхөө жавхланта гэрэлд оруулсанд нь талархан, хайрласандаа Түүнийг дэлхийд магтдаг. Би коллежд байхдаа, хуурай эгч дүүсийнхээ холбоонд элсээд, өөрөөсөө том зүйлд харъяалагдах болсондоо учиргүй баярлан, сургуулийн үйл ажиллагаан дээр холбоогоо магтан дуулдаг байж билээ. Нийгмийн клубын төлөө ингэтлээ баярлаж байхад, биднийг Өөрийнхөө хаанчлалд оруулсан Бурханыгаа магтахгүй байж чадна гэж үү? 1Петр бидний Христ доторх байр суурийг хэлдэг: Бид бол сонгогдсон, язгууртан, ариун тахилч нар.

Хуучин гэрээнд тахилч нар тахил өргөх үүрэгтэй байсан бол, язгууртан тахилч нар хааны өмнө тахил авчрах үүрэгтэй байв. Тахилч бидний тахил юу вэ? Бурханыг үг, үйлдэл, байдлаараа магтах амьдрал юм. Үүнийг илүү нарийн ойлгохын тулд Аароныг харцгаая:

Тэгээд тэд шижир алтаар ариун титмийн пайзыг хийж, түүн дээр тамган сийлээсээр “ЭЗЭНд ариун” гэсэн бичээс сийлэв. Мосед ЭЗЭНий тушаасан ёсоор тэд үүнийг толгойн ороолтны урд талд хөх уяагаар бэхлэв. Ингэснээр уулзалтын майхан асрын бүх ажил дуусжээ. Израилийн хөвгүүд Мосед ЭЗЭНий тушаасан ёсоор хийв. Тэд тийнхүү хийжээ. (Эхлэл 39:30–32)

Аарон тансаг сайхан тахилчийн хувцас өмсчээ. Хувцасных нь хэсэг бүр чухал ач холбогдол, билэгдэлтэй боловч, гол шигтгээ нь “Эзэнд ариун” гэсэн сийлбэр бүхий, шижир алтан титэм байжээ. Аарон үнэндээ ариун байдлаар титэмлэгджээ. Тахилчийн тансаг хувцас, сүр жавхлан нь тэр чигээрээ Аароныг Бурханых гэдгийг нь мэдэгдэж байв. Пайзыг тамга шиг сийлсэн байгааг нь тэмдэглээрэй. Тамга нь дотор, гадар гэсэн сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд юмс дээр ул мөрөө үлдээдэг. Хууль нь хүчин төгөлдөр болмогц, тамга шиг сийлдэг байсан нь тухайн хуулийн ард хэн байгааг нь илтгэдэг байжээ.

Тэгвэл үүнийг амьдрал дээр жишээлэн үзье. Улсын юмуу олон улсын гоо бүсгүйчүүдийн тэмцээний ялагчид титэм, улсынх нь нэр бүхий өргөмжлөл зүүж өгдөг. Гэтэл тэмцээн дундаа орж байтал, Америкийн мисс Япон улсыг төлөөлнө гээд унабал, яах уу? Зөвшөөрөх үү? Мэдээж зөвшөөрөхгүй! Тэр Японыг биш, Америкийг төлөөлөхөөр сонгогдсон – Америкийн соёл, хүмүүсийг төлөөлж, тэдний бахархлыг төрүүлэхээр сонгогдсон. Тэгвэл тахилч нарын хувьд ч ижил. Бид уулзаж, харилцсан хүмүүстээ өөрсдийгөө хэнийх болох, аль хаанчлалыг төлөөлж байгаагаа илэрхийлэх үүрэгтэй. Үүнийг хэрхэн хийхийг Петр цааш нь тайлбарлажээ:

~ Бид уулзаж, харилцсан хүмүүстээ өөрсдийгөө хэнийх болох, аль хаанчлалыг төлөөлж байгаагаа илэрхийлэх үүрэгтэй.

Та нар урьд нь ард түмэн ч биш байсан бол одоо Бурханы ард түмэн болжээ. Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртжээ. Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайгдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя. Харийнхан дунд биеэ зөв авч яв. Ингэснээр тэд та нарыг муу муухайг үйлдэгчид хэмээн гүтгэвч, сайн үйлсийг чинь хараад Түүний харгалзлын өдөр Бурханыг алдаршуулах болно. (1Петр 2:10–12)

Бид өмнө Бурханых биш байсан бол, эдүгээ Бурханых болсон. Бид өмнө Бурханы шүүхийн дор байсан бол, эдүгээ Түүний өршөөлийг хүртсэн. Өөрөөр хэлбэл, бид энэ дэлхийд шүүхийн дор байсан бол, эдүгээ бид энэ дэлхийнх биш, Бурханы хаанчлалынх болсон. Тиймээс бид өмнө энэ дэлхийн иргэд байсан бол, эдүгээ харь хүмүүс болжээ. Тахилч бид энэ дэлхий дээрх Бурханы элчин сайдууд, төлөөлөгч нар юм.

Бид магтаал, амьдралаараа хааны өршөөлд нийцэхүйц тахилыг өргөнө. Ариун байдал нь үнэндээ эзэмшлийн асуудал юм. Эдүгээ бидний

амьдралын эзэн бид биш, Бурхан билээ. Чи “Би хэн нэгний эзэмшил баймааргүй байна!” гэж болох. Чи үүнийгээ мэдсэн байна уу, мэдээгүй

~ Чамайг асар өндөр үнээр худалдаж авсан учраас, Хурганд дуу дуулж байгаа тэнгэрийн ариун хүмүүстэй хамт өргөх магтаал чинь Түүний алдрыг тунхаглах учиртай юм.

байна уу – гэхдээ чи үнэндээ хэзээ ч жинхэнээсээ эрх чөлөөтэй байгаагүй. Чи харанхуйн хаанчлалын ноёрхол дор Бурханы дайсан мэт, уур хилэн хүртэх заяатай хүүхэд мэт амьдарч байсан. Гэтэл хайрын Ханхүү чамайг аварсан. Чамайг асар өндөр үнээр худалдаж авсан учраас, Хурганд дуу дуулж байгаа тэнгэрийн ариун хүмүүстэй хамт өргөх магтаал чинь

Түүний алдрыг тунхаглах учиртай юм.

Тэд шинэ дуу дуулж—Хуйлмал номыг авч, Лацнуудыг нь нээх зохистой нь Та мөн. Учир нь Та нядлуулсан бөгөөд Өөрийн цусаар бүх овог, хэл, ард түмэн болон үндэстнүүдээс Бурханд ариун хүмүүсийг арилжин авч өгсөн билээ. Та тэднийг Бурханы маань төлөөх Хаанчлал ба тахилч нар болгосон. Тэд дэлхий дээр хаанчлах болно гэгцгээж байлаа.

(Илчлэл 5:9–10)

Түүний цус тэнгэрийн төлөө биш, бидний төлөө урссан гэж байгааг тэмдэглээрэй. Сүйт хархүү маань сүйт бүсгүйгээ амиараа өөрийн болгосон.

~ Дураа хүрбэл нийлчихээд, дургүйгээ хүрбэл салчихдаг ойлголт байдаггүй байж.

Гэхдээ энэ сүр жавхлантай хайр дурлалын түүхийн гүнийг ойлгохын тулд бүгдээрээ цаг хугацаагаар аялан, бидний мэдэхгүй ёс заншилтай нэгэн газар очъё. Тэр үед үерхэл, болзоо гэдэг ойлголт байхгүй, гагцхүү сүйт хархүү, сүйт бүсгүй л гэдэг

ойлголт байжээ. Тэр үед дураа хүрбэл нийлчихээд, дургүйгээ хүрбэл салчихдаг ойлголт байдаггүй байж. Гэрлэлтийн эцсийн үйл явц эхлэхээс ч өмнө хос маань бие биедээ үнэнч, итгэмжтэйгээр зориулагддаг байжээ.

Хүү нь гэрлэх насанд хүрмэгцээ ааваасаа эхнэр авч өгөхийг хүснэ. Хүүгийнх нь сэтгэлд хүн байсан ч, ер нь бол аав нь л хүүгээ гэрлэхээс ч өмнө ирээдүйн бэрээ эрж хайдаг заншилтай байж. Тэд хэний охин тохиромжтойг хамтран хэлэлцэж болох ч, эцсийн дүнд аав нь л хүүдээ тохирох гэргийг сонжиж сонгоно.

Санаа нийлбэл, хүү нь охиныхоо гэрт очоод, аавтай нь бас магадгүй ах нартай нь уулзаад, нарийн ширийн, боломжуудын талаар ярилцана. Анхны энэ зөвшилцөлд охин өөрөө оролцохгүй. Охин өөр өрөөнд болж

байгаа үйл явдлыг хажуухнаас сэм тагнуулдах байх. Ярианы зарим хэсэг сонорт нь хүрэхэд охин: “Тэр миний төлөө ийм зүйл хийх нь байна!” хэмээн догдлон шивэгнэх байх.

Гэхдээ хэдий хэмжээний мөнгө авахаа охины аав хэдийн тооцоолсон байна. Охидыг гэр бүлд тохиох санхүүгийн гарлага гэж үздэг байсан учраас, ямагт мөнгөөр хэмждэг байж. Охид хөвгүүд шиг талбай дээр ажиллаж, гэр бүлдээ орлого оруулахгүй. Хэрэв үнэ хөлс дээрээ зөвшилцөхгүй бол, гэрлэлтийн талаарх яриа дуусч, хэлэлцээр төгсөнө. Өнөөдөр энэ бүхэн наймаа шиг сонсогдож болох ч, үнэндээ бүсгүй хүүхдийг хамгаалах хамгаалалт болдог байжээ. Хүссэн үнийг нь хүлээн авах нь аав хүний хувьд охин үрийг нь хайрлан халамжлахын баталгаа болдог байв. Тэр үед аавууд охидоо зүгээр л өгчихдөг биш, харин авран сэргээгдээд, дараа нь олзлуулдаг байж. Олон цагийн асуулт, сайн итгэлийн гуйлт, амлалт, хэлэлцээр өрнөнө.

Сүйт бүсгүйн аав, сүйт хархүү хоёр тохиролцоонд хүрбэл, тэд үүнийгээ сүйт охины үнэ, сүйт хархүүгийн амлалт, тангараг, сүйт бүсгүйн эрх зэргийг тусгасан албан бичиг юмуу гэрлэлтийн гэрээ болгон, цаасан дээр буулгана. Энэ нь сүй тавьсны албан баримт болж, хэрэг явдал сайхан бүтсэний дараа дарс хундагалаж, сүйт бүсгүй болох охиныг оруулж ирнэ.

Охин зөвшөөрөхгүй бол, энэ бүх олон цагийн хэлэлцээр, нарийн ширийн нь зүгээр л гарз болно. Охинд ширээн дээр байгаа гэрээг мэдүүлнэ. Түүний өмнө гэрлэлтийн гэрээг билэгдсэн хундагатай дарс тавина. Охинд хоёр сонголт бий. Охин өмнө нь хундагалаатай буй дарснаас татгалзаад, эргээд яваад өгч болно. Ингэбэл, хэдийгээр аав нь зөвшөөрсөн ч, гэрлэлт болохгүй. Эсвэл охин зөвшөөрч болно. Тэгвэл хундгыг сүйт хархүүд өгч, тэрбээр үүнээс уугаад, дараа нь сүйт бүсгүйдээ өгнө. Охин гэрээний хундгаас уухад, гэрээ тамгалагдана.

Сүйт хархүү сүйт бүсгүйдээ бөгөөд гэрээндээ үнэнч байхаа амласан ямар нэгэн үнэтэй бэлэгийг сүйт бүсгүйдээ гарган барина. Тийнхүү тэр хоёр бие биеэ таньж мэдэхийн тулд хархүү нь нэг хэсэгтээ хадмынхаа байх боловч, хэзээд гэр бүлийнх нь нарийн хараа хяналт дор байна. Өнөөдөр энэ бэлэг нь сүйн бөгж болжээ. Тэр хоёр хэдийгээр гэрлээгүй байгаа ч, хуулийн дагуу сүй тавьж, гэрлэлтээр холбогдоно.

Дараа нь сүйт бүсгүй усан баптисм хийлгэнэ. Энэ нь цэвэрлэгээ, ариутгалын угаал хийх ёслол байв. Энэ нь түүний хуучин амьдралаасаа салж, эр нөхөртэйгээ байх, шинэ амьдралд бэлтгэх цэвэрлэгээ юм. Энэ нь түүний хувьд сүнсний дахин төрөлт маягийн үйл байв. Охин цаашид өөрийнхөө биш, эр нөхрийнхөө болжээ.

Хэсэг хугацааны дараа сүйт хархүү нь гэртээ харина. Тэрбээр хариад хуримдаа бэлтгэн, амьдрах гэрээ барих ажээ. Тэрбээр явахдаа, сүйт

бүсгүйдээ: “Би чамд байр бэлтгэхээр явлаа. Би явлаа ч чамайг авахаар эргэж ирнэ” гэж хэлнэ. Энэ нь Иохан 14 дээр байдаг үгс юм. Тэдэнд салах хэцүү ч, орон байраа бэлтгэхгүй бол, хэзээ ч жинхэнээсээ насан турш хамт байж чадахгүйгээ тэд мэднэ.

~ Тэрбээр явахдаа, сүйт бүсгүйдээ: “Би чамд байр бэлтгэхээр явлаа. Би явлаа ч чамайг авахаар эргэж ирнэ” гэж хэлнэ.

Сүйт бүсгүй сүйт хархүү нь өөрийнх нь төлөө эргэж ирэхийн баталгаа болсон гэрээ, хундага, бүрэн төлсөн мөнгө, бэлэгтэй үлдэнэ. Тэрбээр аавынхаа гэрт биеэ бэлтгэн сууна. Тэрбээр олон нийтийн газар явахдаа, хүнийх болсныг нь илтгэх гивлүүр зүүж явна. Гивлүүртэй эмэгтэйчүүдийг тусгаарлагдсан, ариусгагдсан юмуу өндөр үнээр авагдсан хэмээн тооцно. (Танил санагдахгүй байна уу?) Тэрбээр гэрээгээр өөр хүнтэй холбогджээ. Түүний гоо үзэсгэлэн нь эр нөхөртөө л хадгалагдана. Тэрбээр өөрийгөө хамтын амьдралдаа зэхэн, нөхрөө хүлээнэ. Тэрбээр хуримын хувцсаа зэхэж байхдаа нөхрөө бодон, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр учран золгох өдөр нь ойртсоор байгааг мэднэ. Сүйт хархүү нь ирэх үед тэрбээр далан задгай сууж байлгүй, бэлэн байхыг хүснэ.

Одоо түр зогсоод, эртний энэ хуримын ёсон бидний Христтэй тогтоосон харилцааг тусган харуулдаг болохыг үзье. Учир нь Христ – бидний харилцааг байнга гэрлэлтээр дүрслэн өгүүлдэг:

Энэ нууц нь агуу юм. Гэвч би Христ ба чуулганы тухайд ярьж байна.
(Ефес 5:32)

Есүс Аавынхаа сонгож өгсөн сүйт бүсгүйгээ авахаар тэнгэрийн гэрээ орхисон. Тэрбээр шаардлагыг биелүүлэн, төлөөсийг нь бүрэн төлөөд, түүнийг Өөрийн болгосон. Тэрбээр энэ үнийг төлөхийн төлөө Өөрт байгаа бүхнээ буюу амиа өгсөн. Тэрбээр Сүүлчийн зоог дээр аяганаас уухдаа энэ зөвшилцлийг тамгалаад, дараа нь дагалдагч нартаа дамжуулсан. Тэрбээр Гетсемен цэцэрлэгт үнэ хөлс дээрээ тохироод, загалмай дээр бүрэн төлсөн. Дараа нь Тэрбээр Өөрийнхөө цусыг нүглийн тахил болгон өргөөд, сүйт бүсгүйгээ Үгийн усаар угаасан. Энэ нь оюун ухаан, сүнс, сэтгэлийн шинэчлэлийн үйл явц бөгөөд биднийг харанхуйн хаанчлалаас гэрлийн хаанчлалд шилжүүлдэг.

Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбо, үрчлээсгүй эсвэл алив

ийм юмгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн билээ. (Ефес 5:25–27)

Биднийг Христ л ариун болгодгийг тэмдэглээрэй. Тэр биднийг Өөрийнхөө байлгахаар авран сэргээдэг. Бид өөрсдийгөө аварч, ариун байлгаж чадахгүй. Тийм боловч бид Түүнийг бидэнд зориулан байр бэлтгэж байх үеэр нь өөрсдийгөө бэлтгэж чадна.

Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. (Илчлэл 19:7)

Сүйт бүсгүй нь бэлэн байдлын уур амьсгал, хандлагаа тээх үүрэгтэй. Христийн сүйт бүсгүй бид хүргэгдэн очих хувцсаа бэлтгэх үүрэгтэй: “Тэрээр гялалзсан, цэвэр, нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлс юм.” (Илчлэл 19:8) Нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлдэл юм.

Одоо бүгдээрээ хос руугаа эргэе. Сүйт бүсгүй нь хүлээж буй бүсгүй бол, сүйт хархүү нь аавынхаа гэрт өрөө нэмэн, сүйт бүсгүйнхээ өрөөг хичээнгүйлэн бэлтгэнэ. Энэ нь маш их цаг, бэлтгэл авна. Учир нь өнөөгийнх шиг бэлэн зэлэн барилгын материалын дэлгүүр байхгүй. Сүйт хархүү бүгдийг гараараа бэлтгэнэ. Тэрбээр хичээнгүй ажиллаж байх хугацаандаа ажил нь урагшлах тусам, сүйт бүсгүйтэйгээ учран золгох өдөр нь ойртсоор буйг мэднэ. Аав нь хүүгийнхээ ажлыг анхааралтай ажиглан, урам өгнө. Аав нь мөн хүүгээ ажигласаар, эрийн цээнд хүрэхээр нь гэрлэх болсныг нь хэлжээ. Түүнчлэн сүйт бүсгүйн гэр бүл ч магадгүй сүйт хархүүг хэлсэн ярьсандаа байгаа эсэхийг шалгахаар төлөөлөгч нараа илгээсэн л байх. Тэгээд төлөөлөгч нар нь эргэж ирээд “Бараг л болж байна. Бэлэн байгаарай!” гэсэн мэдээ авчирна.

Эцэстээ аав нь хүүгийнхээ ажлыг нягтлан шалгаад, хүүдээ: “Сүйт бүсгүйгээ авчир!” гэж хэлнэ. Сүйт хархүү бөөн баяр болон найзуудтайгаа хамт сүйт бүсгүйгээ авчрахаар явахдаа, цаг өдрөө яг шөнөөр явж очихоор товлонго. Тэднийг хотод дөхөж очиход, сүйт бүсгүйд амраг хайрт нь айсууг мэдэгдсэн бүрээ дуугарна. Мэдээж тэр дуунаар тэр хотод байгаа бүх сүйт бүсгүйчүүд сэрээд, айх баярлах зэрэгцэнэ. Тэд тосон дэнлүүнийхээ голыг имрэн, дээр нь тос нэмэн асаана. (Бас мэдээж шүдээ угааж, гоёж гоодох байх!) Тэгээд сүйт хархүүгийн найзуудын мэдэгдлийг анхааралтай сонсоно. Найзууд нь сүйт бүсгүйн гэрийн гадна сүйт хархүүд зам засаад, сүйт бүсгүйг: “Сүйт хархүү ирлээ! Угтан аваарай!” хэмээн дуудна (Матай 25:6).

Аав, ах нар нь яг өөрсдийнх нь хүргэн мөн эсэхийг шалгахаар гадаа

гарна. Тэд мэдээж өөр сүйт хархүүд охиноо өгөхийг хүсэхгүй! Мөн гэдгийг нь баталгаажуулсаныхаа дараа охиноо үдэж гаргаж өгөхөөр эргэнэ. Бараг л хулгайлж байгаа юм шиг. Сүйт бүсгүй гэрэлтэй дэнлүүгээ барьсаар, шивэгчдээ дагуулсаар хайрт руугаа гүйн очно. Сүйт хархүү нь түүнийг шүүрч аваад, шууд аавынхаа гэрийг зориод, сүйт бүсгүйнхээ өрөөнд оруулна. Тэгээд тэр хоёр долоо хоног хаалттай хаалганы цаана жаргалаа эдлэнэ.

Сүйт хархүүгийн найзууд хаалганы гадаа суугаад гэрлэлт гүйцэлдэх баярт эгшинг догдлон хүлээнэ. Тэгээд дуу чимээнээр нь бусаддаа баярт мэдээг дуулган, хурим найрандаа бэлтгэнэ. Ямар нэгэн асуудал дэгдэхээс сэргийлэхийн тулд орны даавууг нь цонхоор гаргаад, охин нь онгон байсныг аавд нь батлан харуулна. Онгон хальснаас гарсан цус нь гэрээний эцсийн тамгыг дарна. Долоо хоногийн дараа эмэгтэй гивлүүрээ аваад, сүйт хархүүтэйгээ өрөөнөөсөө гарч ирээд, хурим найр эхлэнэ. Дарс, хоолоор бялхсан, баяр хөөрөөр цалгисан их найр! Ерөөл магтаал, бэлэг сэлт хойно хойноосоо цуварна.

Энэ бол Есүс, Түүний сүйт бүсгүй хоёрын сүр жавхлант, уянгын зураглал ажээ. Тэр үнэхээр бидэнд байр бэлдэхээр явсан. Тэр удахгүй шагналаа аваад ирнэ. Бид Түүний айлчлалд бэлтгэх ёстой.

Та нар тэр өдрийг ч, цагийг ч мэдэхгүй тул соргог бай. (Матай 25:13)

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Тан руу тусгаарлаагүй байгаа хэсгүүдийг маань Сүнсээрээ харуулж өгөөч. Би ариун, бүрэн Таных байхыг хүсч байна. Надад сүйт бүсгүй яах ёстойг зааж өгөөч. Тэгвэл зүрх маань Таныг гэгэлзэн, догдлон хүлээнэ. Дэнлүү маань ямагт бэлэн байж, тосоор дүүрэн байг. Энэ улирлыг тодорхой харах зүрхний минь нүдийг нээгээч. Би зүрхэндээ “Эзэн маань мөд ирэхгүй” гэж хэлдэг муу сүйт бүсгүй шиг биш, харин үнэнч сүйт бүсгүй баймаар байна. Би бусдад гүн сэтгэгдэл төрүүлэх тусгаарлагдсан, ариун амьдралтай баймаар байна. Тэд намайг Таных, Та Минийх гэдгийг мэдэх болтугай. Тантай нүүр нүүрээрээ учран золгож, баяр хөөрөө эдлэх хүртэл намайг Сүнсээрээ халхлаач.

Таны хайрт охиноос.

12 Цэвэр байдлын хүч

Залуу хүн хүчтэй бөгөөд эрх чөлөөтэй байж чадах уу? Паул чадна гэдэгт итгэдэг байжээ:

Хэн ч чамайг залуу гэж дорд бүү үзэг. Харин чи итгэгчдэд үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариунаараа үлгэр дуурайл бол. (Тимот 4:12)

Энэ ишлэл хоорондоо зөрчилдөөд байгаа мэт харагдана. Паул залуу хүнийг итгэгчдийн хувьд үлгэр жишээ амьдрахыг үүрэгдсэн үү? Өнөөдөр ганц бие, залуу хүнийг итгэл, цэвэр байдлын үлгэр жишээ хэмээн тооцох нь ховор. Гэтэл Паул Тимотыг зовхи өөдөө байж, залуу насаа хэний ч сүрдүүлгийн бай бүү болго хэмээжээ. Залуу хүн яриа, амьдрал, хайр, итгэл, цэвэр байдлаараа үлгэр жишээ байх үүрэгтэй байгаа бол, насанд хүрсэн бид бүр ч ариун амьдрах үүрэгтэй бус уу?

Чамд Бурханы нигүүлсэл байна. Нигүүлсэл нь энэ ятгалгыг биелүүлэх Бурханы хүч мөн. Чи наснаасаа үл хамааран, эргэн тойрныхоо хүмүүст үлгэр жишээ болохуй цэвэр амьдралаар амьдарч чадна.

~ Чи наснаасаа үл
хамааран, эргэн тойрныхоо
хүмүүст үлгэр жишээ
болохуй цэвэр амьдралаар
амьдарч чадна.

Эхлээд харахад цэвэр байдал нь ариун байдалтай адилхан мэт боловч, үгүй юм. Ариун байдал нь тусгаарлагдах гэсэн утгатай бол, цэвэр байдал нь ариун хүний биеэ авч явах байдалтай холбоотой. Цэвэр байдал нь ариун байдлын дайвар бүтэгдэхүүн юм. Энэ бүлгээрээ бид шашны хүрээнд зайлсхийдэг боловч, нийгмийн хүрээнд найр тавин хүлээн авдаг сэдвээр ярилцана. Би чамд Бурханы Үгийн цэц

ухаан, анхааруулгаар болоод бас олон жилийн үйлчлэлийнхээ туршлагаар зөвлөх болно. Би чамд ганхашгүй суурийг тавихад чинь туслах учраас, зүрхээ чангалаарай: Бүгдээрээ маш олон Бичээс үзнэ.

Бурхан бидний амьдралын эх ундарга байхыг хүсдэг. Хэрэв чи үнэхээр зоригтой л бол, Бурханы зүсэн, өвчигч Үгийн гэрлээр зүрх, сэдлийг чинь шалгахыг Ариун Сүнсэнд зөвшөөрөөрэй. Энэ нь аймхай хүмүүст зориулагдаагүй.

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салгал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм. Түүний хараанаас нуугдах нэг ч бүтээл үгүй. Харин Түүний мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил болой. Түүнд бид тооцоотой. (Еврей 4:12–13)

Бурханы Үг нь зүгээр нэг цаасан дээрх бичиг биш... харин амьд юм. Итгээд, ойрт. Учир нь Бурханы Үг чиний зүрхэнд бүжиглэж, шөнөөр

чамтай шивнэлдэхийг хүснэ. Энэ нь сэтгэлийг сүнснээс салгах хүчтэй бөгөөд энэ явц дундаа бидний далд бодол, хандлагыг илчлэх чадалтай.

~ Бурханы Үг нь зүгээр нэг цаасан дээрх бичиг биш... харин амьд юм. Итгээд, ойрт. Учир нь Бурханы Үг чиний зүрхэнд бүжиглэж, шөнөөр чамтай шивнэлдэхийг хүснэ.

Бурханаас юу ч нуугдахгүй гэдгийг санаарай. Тэрбээр бүгдийг хардаг бол, бид тэгж чадахгүй. Бид өөрсдийнхөө зүрхэнд хичнээн хууртагддаг билээ. Тийм боловч хэрэв бид үнэнийг асуух юм бол, Бурхан

бидэнтэй Үгээрээ үнэн, худлыг хуваалцана. Би хүний зөвлөгөөг бус, Бурханы цэц ухаан, ухаарлыг хүснэ. Хүний зөвлөгөө нь энэ үеийн соёл, жишгийн нөлөөн дор байна. Энэ нь арван жил тутам хувьсаж байдаг мунхаглал бөгөөд түүний хөлд нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ үрэгддэг. Гэтэл Бурханы Үг мөнхөд тогтох бөгөөд бид энэ жишгээр л шүүгдэнэ.

Чи энэ бүлгээр анхандаа боломжгүй юмуу бүр амьдралгүй гэмээр үнэнтэй нүүрэлдэх болно. Гэхдээ үнэн хэзээд үнэн хэвээрээ л байна. Тэр Өөрийнхөө амлалтыг сахиж чадахгүй гэдэгт итгэх нь худлаа бөгөөд Тэрбээр биднийг унахаас хамгаалсаар сэнтийн өмнө ял буруутгалгүй аваачихдаа л аваачина. Бид үнэнийг мэдэж, үнэн биднийг эрх чөлөөтэй болгоно. Нэгдүгээрт – бүгдээрээ заалттай Бичээсийг үзээд, дараа нь тэр үнэний гэрлээр зарим асуултад хариулна. Ариун амьдрах Бурханы

дуудлага нь ерөөсөө л Түүнийх байх гэсэн утгатай учраас, бид болно, болохгүй гэдэг зүйлээр түрүү барихаас сэргийлэх ёстой.

Харин ариун хүмүүст үл нийцэх аливаа садар самуун, бузар булай, шунал нь (*эдгээрийн санаа төдий зүйл ч*) та нарын дунд бүү дурдагддаг. (Ефес 5:3)

Энэ хүчтэй ишлэл байна уу? Бид бэлгийн ёс бус явдал, цэвэр бус явдал, шуналын *санаа төдий зүйлийг ч* зөвшөөрөх ёсгүй ажээ. Яагаад? Том юм хийчихээгүй, санаа төдийнхөн байхад юу нь буруу гэж? Санааны зорилго нь юу вэ? Санааны цаана илүү том зорилго оршдог нь хэнд ч тодорхой. Энэ төрлийн үйлдэл нь (санаа төдий нь) Бурханы хүмүүст хүлээн зөвшөөрөгдөшгүй ажээ. *Микрософт үгийн толь бичиг* дээр *зүй бус* гэдэг үгийг “бүдүүлэг, цочирдом, зохисгүй, таарашгүй, доромж бүхий” тэгээд “хиймээр зүйл биш!” хэмээн тодорхойлжээ.

Энэ төрлийн зан авир нь бидний эргэн тойрныхонд эргэлзээтэй, эрээвэр ойлголт өгдөг. Жишээлбэл, бүсэлхийгээ ил гаргасан, оодон цамц нь ямар нэгэн *санаа цухуйлгаад* байдаг. Ямар санаа? “Би чамд энэ хүртэл харуулсан болохоор, бүр ч ихийг харуулж чадна шүү. Цаана нь харуулах зүйл ч их бий” гэсэн санаа. (Бид энэ талаар дараа нь дэлгэрэнгүй ярилцана) Бурханы хүмүүс бид Түүний тэмдэгтэй бөгөөд хийсэн, хэлсэн бүхнээрээ Түүнийг л хүндэтгэх ёстой. Энэ нь бидний хэлэх үг ч, үйлдэл ч Бурханы дүр төрхийг тээх ёстой гэсэн үг. Бид зүгээр нэг уучлагдсан биш, харин Түүн рүү ариун юм. Бид нэгэнтээ харанхуй байсан газраа эдүгээ гэрэл болгох ёстой. Ефесийг үргэлжлүүлэн уншъя:

Садар булай, шалиг балай эсвэл самуун балиар яриа нь зохимжгүй.
Харин оронд нь талархалаа өргө. (Ефес 5:4)

Зүй бус энэ үйлдэлд гутамшиг байдал, мунхаг яриа, бүдүүлэг яриа бас орох нь байна. Бохир хошигнол дээр үед ч байсан байх. Учир нь наран дор шинэ юм байхгүй шүү дээ (Номлогчийн үгс 1:9). Гэтэл бид бусдыг ерөөж бас гутаах үгийнхээ хүчийг барагтай ухаарахгүй явах. Дээрх үгсийн утгыг тодорхой болгохын тулд ангилж үзье:

- **Гутамшигт байдал нь** үг, дохио зангаа, зурагаар илэрхийлэгдэж, танилцуулагдсан цэвэр бус, завхарсан яриа юм.
- **Мунхаг яриа нь** тэнгэрийн хууль, Бурханы алдар, хүний мөнхийн аз жаргалыг үл тоох нүгэлтэй, муу ёрын хэл яриа юм.

- **Бүдүүлэг яриа нь** жигшмээр, цэвэр бус, гутамшигтай, балмад, боловсон бус, олиггүй хэл яриа юм.

Ийм маягаар ярихын оронд бид талархлын хэл яриатай байх ёстой. Бид Бурханы бидэнд сунгасан өршөөл, таалалд талархалтай амьдрах ёстой. Ганц энэ шалтгааны улмаас л бид амаа хамхиж явах хэрэгтэй. Бид гутамшигтай, хатуу гомдоллогч нар байж болохгүй. Бид Бурхан шиг үйлдэж, яриагаараа ерөөл, амийг урсгаж, талархалтай зүрхээр Сүнс дотор амьдрах ёстой. Паул цааш нь:

“Садарлагч, бузрыг үйлдэгч, шунахайрагч тухайлбал шүтээн шүтэгч аливаа хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар мэд. Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Учир нь эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. Иймд тэдний хамсаатан бүү бай” (Ефес 5:5–7) гэжээ.

Биднийг эхний удаа хэлэхэд нь ойлгоогүй байж магадгүй гэсэндээ Паул бидэнд “Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг” гэдэг анхааруулга, чиглүүлгээ бүрэн ухааруулахыг хүсчээ. Хоосон үг нь бодитой бус юм. Тэдгээр нь чамайг өөрчлөх хүчгүй, харин мэхлэх хүчтэй. Бурханы хурц бөгөөд амьд Үг биднийг гэмшүүлдгийг санаарай. Хоосон үгс нь хөндий, үхмэл бөгөөд Бурханы Үгээр үнэн, худлыг эрс тэс ангилж чаддаггүй хүмүүсийг мэхлэн, биднийг өөртөө цаггалдахад хүргэдэг. Хоосон үг чимэгтэй ч, аминд хүргэхгүй. Хоосон үгийн жишээнээс дурьбал:

“Зүгээр ээ... бид бүгдээрээ л өсч яваа.”

“Бурхан чиний зүрхийг мэднэ.”

“Хэн ч төгс биш.”

“Бүгд л хийдэг шүү дээ.”

“Чи бусдыг бодбол, харин ч гайгүй байна.”

Эдгээр нь аргалсан үгс бөгөөд үнэн байж болох ч, үнэний амьд үг биш юм. Үнэн биднийг өөрчлөлтөд дуудаж, хуучнаа ардаа орхиж, Бурханы үзэл бодол руу тэмүүлэхийг ятгадаг. Бурханы ухаан нь бидний ухаанаас хол өндөр. Хоосон үг нь бидний зан авирыг өнөөгийн соёлын жишигтэй зэрэгцүүлэн, шалтаг тоочин, бахь байдгаараа үлдэхийг урамшуулдаг. Гэхдээ бид өнөөгийн соёлтой харилцаа тогтоогоогүй, харин Бурхантай харилцаа тогтоосон.

... ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? (Иаков 4:4)

Бид энэ дэлхийн гоц ухаан, мэргэн ухааныг бус, Бурханы Үгийг сонсох ёстой. Христэд итгэгч хүмүүсийг бие биеэ урамшуулаарай гэсэн. Энэ нь бид бие биедээ Бурханы амлалтыг хэлж, урам зориг авчирна гэсэн үг. Хоосон үгсийн тухайд Бурхан ийнхүү зөвлөжээ:

Зүгээр ээ... бид бүгдээрээ л өсч яваа. Бид явц дундаа байгаа юу? Тийм ээ! Гэхдээ бидний эцсийн зорилго – үйл явц биш, харин өөрчлөлт бөгөөд бидэнд “Та нарт сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс болгоно” (Филиппой 1:6) гэсэн амлалт бий.

Бурхан чиний зүрхийг мэднэ. Учир нь зүрхнийхээ бялхалаар ам ярьдаг. Сайн хүн сайн баялгаасаа сайныг гаргадаг, муу хүн муу баялгаасаа муу муухайг л гаргадаг. (Матай 12:34–35)

Хэн ч төгс биш. “Тиймд тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай” (Матай 5:48). Пөөх! “Учир нь зөвт нь долоо бүдрэвч нэг сэхнэ. Буруут харин гай гамшигт нэгмөсөн бүдэрнэ.” (Сургаалт үгс 24:16)

Бүгд л хийдэг шүү дээ. Тиймээс би Эзэний дотор үүнийг хэлж, гэрчилье. Харийнхан оюун санааны хоосролдоо явдаг шиг та нар цаашид тэгж явж болохгүй. Тэд ухаан бодолдоо харанхуй болж, дутуу мэдлэг ба зүрхнийхээ хагуугаас болж Бурханы аминаас хөндийрчээ. (Ефес 4:17–18)

Чи бусдыг бодбол, харин ч гайгүй байна. Учир нь бид өөрсдийгөө магтдаг хүмүүсийн тоонд орохыг, тэдэнтэй өөрсдийгөө харьцуулахыг эс зүрхэлнэ. Тэд өөрсдөө өөрсдийгөө хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг нь ухаангүй аж. Гэвч бид хэмжээгүйгээр сайрхахгүй. Харин та нарт хүрэхийн тулд Бурханы бидэнд ногдуулсан жишиг хэмжээнд л сайрхана. (2Коринт 10:12–13) Ухаантай байж болох байтал хэн тэнэг байхыг хүснэ гэж? Бусдыг харахаа больж, эрх чөлөөний төгс хуулийг хар!

Бид үүнийг нэг мөр болгох хэрэгтэй: Бурхан болоод Түүний Үг үнэн, харин хүний зөвлөгөө худлаа. Эзэний Үгийг хүний үгтэй юмуу Нью

Эйжийн их багшийн ухаантай уусган, хольж хутгаж болохгүй. Бурханы Үг цаг хугацааны шалгуурыг давсаар, хэзээд тогтсоор байна. Энэ нь бидэнд цэц ухаан, удирдамжийн сүр жавхлантай эрдэнэс шиг л ирсэн. Тиймээс үнэний итгэмжтэй гэрч нар байж, бие биеэ зорилго руугаа урамшуулан давшъя.

~ Эзэний Үгийг хүний үгтэй юмуу Нью Эйжийн их багшийн ухаантай уусган, хольж хутгаж болохгүй.

Арваад жилийн өмнө Жон, бид хоёрыг Израилиар аялж явахад Ромчуудын талаар Араб хөтчийн ярьсан түүх одоо ч санаанаас гардаггүй юм. Ромчууд өөрсдийгөө

сайн санаа өвөрлөн, амар тайвныг тогтоохоор ирсэн гээд, Еврейчүүдэд өөрсдийнхөө сүсэг бишрэлийг хүртэл сахихыг зөвшөөрөөд, гагцхүү тэднийг Ромын соёлд нэвтрүүлэхийг л хүсчээ. Ромчууд Еврейчүүдийг яг л Ром хүн шиг биеэ авч явж, амьдарч, үйлдэхийг хүсчээ. Булаан эзлэх тактик тэр цагаас хойш нэг их өөрчлөгдөөгүй мэт санагдах.

Энэ үеийн зөвлөгөө бидэнд: “Чи шашнаа сахиж болно оо. Гэхдээ зүгээр л дэлхийн сайн сайхныг ч бас эдлэх хэрэгтэй! Тайван бай тэгээд уус! Энэ үеийн хүчний эсрэг тэмцэлдээд яана? Чи хүссэн зүйлдээ итгэж болно... зүгээр л бидэн шиг үйлдэхэд л болно!” гэдэг. Гэхдээ мэдээж бидний хувьд энэ санаа бүтэхгүй. Бурхан биднийг уусахыг хүсэхгүй. Иаков номыг харцгаая:

Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. (Иаков 4:4)

Биднийг дэлхийтэй хэлхэлдэх үед зүрх маань хуваагддаг учраас, бид дотроо зөрчилддөг. Давид, эш үзүүлэгч Езекиел хоёр хоёулаа хоёрдмол зүрхтэй байж болохгүйн учрыг ойлгодог байв:

Аяа ЭЗЭН, замаа надад зааж өгөөч. Би Таны үнэнээр явах болно. Таны нэрээс эмээхэд Зүрхийг минь нэгтгээч (*хуваагдаагүй зүрхийг өгөөч*) ! (Дуулал 86:11, тодруулгыг нэмэв).

Тэд тэнд ирэх цагт ой гутам хамаг юм, хамаг жигшүүрийг тэндээс зайлуулахдаа Би тэдэнд ганц зүрхийг өгч (*хуваагдаагүй зүрхийг өгч*), тэдний дотор шинэ сүнснийг тавина. Махбодоос нь чулуун зүрхийг авч, тэдэнд махан зүрхийг Би өгөх нь тэд Миний зарлигууд дор явж, тогтоолуудыг минь сахин түүнийг үйлдэхийн тулд юм. Тэгээд тэд

Миний ард түмэн, Би тэдний Бурхан болно
(Езекиел 11:18–20, тодруулгыг нэмэв).

Чи Бурханд хуваагдаагүй, бүтэн зүрхээр үйлчлэхийг хүсч байгаа учраас л энэ номыг уншиж суугаа гэдэгт би итгэж байна. Энэ нь бие чинь зүрхний чинь удирдамжийг дагана гэсэн үг. Цэвэр амьдрах дуудлага өнөөдрийнх нь шиг амин чухал атлаа дарамттай, хэцүү байсан үе байхгүй байх аа.

Цаг үеийг, нойрноосоо сэрэх цаг хэдийнээ болжээ гэдгийг мэдэн үүнийг хий. Урьд бидний итгэсэн үеэс аврал одоо бидэнд улам ойрхон байна. Шөнө өнгөрч, өдөр ойртов. Тиймээс харанхуйн үйлсийг хажуу тийш тавьж, гэрлийн зэвсгүүдийг агсацгаая. (Ром 13:11–12)

Сүнс дотор маань биднийг зөвт байдал руу сэрээх гэсэн түргэний дуу хадаж байна. Үүнийг яаж хийх вэ? Бид зүрхийг маань энэ дэлхийтэй дөнгөлж байгаа дөнгө бүрийг сүнсний илд, Бурханы Үгээр тасар татна. Бидний хайр зөрчилдөөнгүй байхыг Бурхан хүсдэг. Бурхан биднийг зүрхээ Өөрийнх нь аюулгүй халамжинд байлгахыг хүсдэг бөгөөд бидний сэтгэлийн дайсантай Тэр өөрөө дайтдаг.

Сүнс дотор маань биднийг зөвт байдал руу сэрээх гэсэн түргэний дуу хадаж байна.

Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл. Энэ нь садар самуун, бузар булай, тачаал, муу хүсэл, шунахайрал болох шүтээн шүтэх явдал юм. Эдгээрээс болж Бурханы хилэн [дуулгаваргүй хөвгүүд дээр] ирэх болно. (Колоссай 3:5–6)

Бурхан бэлгийн ёс бус явдал, цэвэр бус байдал, шунал дээр уур хилэнгээ асгахаа дахиад л хэлжээ. Бурхан биднийг Түүний уур хилэнгийн байгаас бүх холбоогоо таслахыг анхааруулжээ. Бид илдээ итгэмжтэй далайхдаа, илдний хүчийг ухаарч, илдний хүчинд захирагдах ёстой. Бурханы Үг биднийг нүглийн хүчээс салгах хүчтэй.

Чи энэ номыг барьж авсан болохоор, зарим асуултад хариу хайж байгаа гэсэн үг. Тэгвэл би чамд шулуухан хариулах гэж хичээх болно. Хариулт маань мэдээж дардан биш, овон товонтой учраас, чи надтай санал зөрж болох ч, би чамд Библи дэрлэсэн зөвлөгөө л өгнө. Энэ бүлгээрээ бид үг, үйлдлийн цэвэр байдлыг авч үзэх бол, удаах бүлгээрээ гадаад төрх, хувцаслалтын цэвэр байдлыг авч үзнэ.

Нэгдүгээр бүлгээрээ би асуулт – хариултын цагийн талаар ярьсныг санаж байна уу? Тэгвэл нөгөө “зөвшөөрөгдөх байдлаар” яриагаа эхлүүлэх үү? Миний хариултыг чи санаж байгаа байх. “Аавынхаа нүдэн дээр хийж чадах юмсаал найз залуутайгаа хий!” Энэ маань энэ сэдвийг дүрэм журмын хайрцгаас гарган, харилцааны талбар дээр тавих оролдлого байлаа. Тэгвэл энэ асуултыг дэлгэрүүлж ярилцъя. Гэрлэлтээс гадуурх сексийн үйлдэл нь аль төвшинд нүгэл болдог вэ?

Анхны тачаадсан үнсэлтээр үү эсвэл хувцасны гаднаас хөхөнд хүрэх үед үү? Эсвэл цамцаа тайлж, дотуур хувцсаа тайчихад нүгэл болох уу? Эсвэл магадгүй бүсэлхийнээс дээшээ зөвшөөрөгдөөд, бүсэлхийнээс доошоо явбал, том асуудалд орох уу? Эсвэл бүсэлхийнээс доош тайчилгүйгээр, хувцасны гаднаас барьж, хүрч болох уу? Эдгээр физик хориог зөрчөөд, нууц юмсыг харж, барьсан ч, яг хурьцал үйлдээгүй л бол, цэвэр хэвээрээ үлдэх үү? Бас амаар сэрэл хөдөлгөх нь хурьцал биш учраас, зүгээрт тооцогдох уу? Сэрлийг нь тэгтэл хөдөлгөчихөөд, дур тавиулахгүй байх нь муухай биш үү? Амаар сэрэх хөдөлгөх явдал нь аман секс рүү хөтлөнө. Тэгээд ч онгон байдлаа алдалгүйгээр, амаар дур тавина гэдэг чинь бараг л гайхамшигт нээлт биш үү?! Ийм зүйл үйлдсэн сүйт хос биеэр албан ёсоор онгон хэвээрээ байж болох ч, үнэхээр цэвэр үү?

Нэгэнт ийм зам дээр гарсан хүн хүсэл, үйлдлээ хөөн улам цаашаа лавшрахын тулд үйлдэл болгоноо шалтаг, маргаанаар зөвтгөнө. Та хоёр сад тавьсан үерийн өөдөөс хүчин мөхөсдөнө. Дур хүслийн хэзээ ч үеэ өнгөрөөшгүй, амттай, халуун урсгал цаг хугацааны эхлэлээс л буцласаар байна.

Тэгэхээр, анхныхаа асуулт руу эргэж оръё. Эдгээр үйлдэл нь яг ямар цэг дээр нүгэл болох вэ? Үнсэхэд үү, хүрэхэд үү, тайчихад уу эсвэл дур тавихад уу? Хамгийн гайхалтай нь эдгээрээс ч өмнө эхлэдэг байх нь. Нүгэл нь физик талбарт эхлэдэггүй, харин хүслийн хэлбэрээр эхлэдэг ажээ. Тиймээс л Есүс эмэгтэй хүн рүү тачаадан

хардаг нь хэдийнээ завхайрсан ялтай гэжээ.

~ Нүгэл нь физик талбарт
эхлэдэггүй, харин хүслийн
хэлбэрээр эхлэдэг ажээ.

Харин тачаалдаа автаж, татагдахдаа хүн бүр уруу татагддаг (тэр чирэгдэн явж, урхидуулдаг) . Тэгээд тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг. Нүгэл нь гүйцэд болохоороо үхлийг гаргадаг аж.
(Иаков 1:14–15)

Хар даа: “Тэр чирэгдэн явж, урхидуулдаг”! Үүнийг хэн хийдэг вэ? Хөвгүүн охиныг чирч авч яваад, урхиддаг уу эсвэл эмэгтэй хүн эр хүнийг

өддөг үү? Үгүй! Хүсэл маань биднийг үнэний гэрлээс угзран, цэц ухаанаас тусгаарлах явцдаа биднээс талархлыг шаардана. Хэрэв дагах юм бол, хүсэл нь нүглээр жирэмслэнэ. Бидний дотор хараахан гэрэлд гарч ирээгүй байгаа ямар нэгэн амьд зүйл оршиж, өсөхийг жирэмслэлт гэнэ. Тэр зүйл тэнд байж, өдөр өнгөрөх тусам хүчирхэгжсээр, дотор маань багтахаа болиод, харанхуй хэвлийгээс гэрэлд гарч ирдэг.

Тэгвэл бүгдээрээ Христэч хүрээнийхэний байнга зугтдаг өөр нэгэн чухал асуултыг зоригтой барьж авъя. Гар хангалга гэж юу вэ? Библид нэр заан хориглоогүй юм чинь гар хангалга зүгээр зүйл үү?

Хэдийгээр Бичээс гар хангалгыг нэр заан дурьдаагүй ч, энэ тухай ярьдаг гэдэгт би итгэдэг. Үүнийг үр жимсээр нь таньж болно. Гар хангалга нь донтуулах чанартай бөгөөд хүслийн нөлөөг гэжээж, хүчжүүлж байдаг нь тодорхой. Энэ нь биеийн тавирал, хэрэгцээгээр эхлэж болох ч, хэзээ ч үүгээр зогсохгүй. Цаг хугацаа өнгөрөх тусам, энэ нь хийсвэр төсөөлөлтэй юмуу порнотой түншлэдэг. Энэ нь урьдын юмуу одоогийн кино, видео, зураг, тэр бүү хэл бэлгийн харилцааны чинь дүр дүрслэл байж болно. Гар хангалгын гол хараа нь “өөрөө” учраас, энэ нь оролцогч нарыг өөрийгөө л хангахад сургана. Гэтэл өөрийгөө хангах нь дотнослын дайсан билээ. Бидэнд газрын мөн чанарт харьяалагдаж байсан зүйлсээ үхүүлж, загалмайн мөн чанарыг даган, өдөр бүр өөрийгөө няцааж амьдраарай хэмээн тушаасан.

Тэд ухаанаа алдаж, зүсэн бүрийн бузар булайг шунахайран үйлдэхийн тулд тачаангуй байдалд өөрсдийгөө тушаажээ. (Ефес 4:19)

Өөрсдийгөө тушаажээ гэдэг нь өөр нэгний хүсэл, мэдэлд өөрийнхөө хүслийг даатгаж, бууж өгөхийг хэлж байна. Бид мэдрэмжинд бууж өгөх бүрийдээ, тачаалын түүдэгт түлээ нэмдэг бөгөөд унтарч байсан гал нь үүнийг дагаад дүрэлзэн шатна. Мэдэрхүй маань бага багаар буурсаар, сүүлээрээ бид Сүнсний юмст ямар ч мэдрэмжгүй болно. Бид Ариун Сүнсээр бус, мэдрэмжийн дур, мэдэрхүйнхээ талбараар л хөдлөнө. Таашаалын үйлдэл болгон тачаалыг бэхжүүлж, энэ зуршлын бат цайз, хэрмийг зузаатгах бөгөөд үүгээр энэ донтолт улам бэхжиж, амь нь уртасна. Би арван есөн жил үйлчлэхдээ, сексийн донтой зөрчилдөж яваа гэрлэсэн, гэрлээгүй хүмүүс, сексийн асуудалтай хосын амьдралд гар хангалга заавал маш том асуудал болсон байхыг харсан билээ.

~ Бид мэдрэмжинд бууж өгөх бүрийдээ, тачаалын түүдэгт түлээ нэмдэг

Зүрх нь л цэвэр байвал, гар хангалга хийж байсан ч, гэмгүй гэхийг би сонссон. Гэхдээ бид зүрхээ мянга цэвэр гэсэн ч, цэвэр бус зүйлд хүргэж байгаа зүйлийг цэвэр гэж хэлж чадахгүй. Түүнчлэн Бурханы зөвлөгөөтэй зөрчилдөж байгаа зүйлийг хууль ёсны ангилалд оруулж чадахгүй. Гар хангалга нь биеэ хянан захирах сүнсний үр жимсийг (Галат 5:23, 2Петр 1:6), цэвэр бодлын үр жимсийг (Филиппой 4:8) зөрчсөн явдал гэдэгт би итгэдэг.

...хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн биеэ хэрхэн хянахаа мэдэж... (1Тесалоник 4:4).

Тэгвэл эсрэгээрээ дур хүслээ барих нь тэвчээр, хүлцэл, биеэ хянан

~ Тэгвэл эсрэгээрээ дур хүслээ барих нь тэвчээр, хүлцэл, биеэ хянан захирах үр жимсийг бүтээдэг. Эдгээр нь эргээд биеийн, мэдрэмжийн, сүнсний хүсэл тэмүүллийг хөгжүүлнэ.

захирах үр жимсийг бүтээдэг. Эдгээр нь эргээд биеийн, мэдрэмжийн, сүнсний хүсэл тэмүүллийг хөгжүүлнэ. Энэ хүсэл тэмүүлэл нь бидний дотор бусадтай хуваалцах сэтгэлийг бүтээнэ. Бид дур хүслээ өөрийн биеэр хангахаас таггалзбал, хүсэл тэмүүлэл, дотнослын охийг хүртэнэ. Учир нь дотносол нь хуваалцдаг зүйл болохоос биш, ганцаараа эдлэдэг зүйл биш.

Өөрийгөө хангах явдал, гар хангалгыг тэжээгээд байвал, эргээд энэ нь аминч чанарыг тэжээнэ. Аминч чанар нь тачаалыг хөгжүүлж, чи хүмүүсийг гагцхүү өөрийнхөө дур хүслийг хангахын төлөө л байгаа юмнууд шиг үзэж эхлэнэ.

Хөвгүүд л гар хангалга үйлддэг гэсэн ойлголт хүмүүсийн дунд бий. Энэ нь ч тэд байнга порнографд өртдөгтэй холбоотой. Гэтэл өнөөдөр охид ч үүнийг хөнжил дотроо үйлддэг. Эмэгтэйчүүд энэ төрлийн сексийн ханалыг үйлдэхгүй бол, өөрийгөө гажиж гэж боддог. Олон сэтгүүл гар хангалгыг дэмжээд зогсохгүй, бүр хэрхэн үйлдэхийг нь ч зааж өгдөг. Энэ бүхэн биднийг юунд хүргэв? Бид маш их гоо үзэсгэлэнгээ алджээ. Хэрэв бид энэ замаараа уруудаад байх юм бол, зарим эмэгтэйчүүд зөвхөн жирэмсэн болох гэж л эрчүүдийг хүсдэг болох байх.

Эцэст хэлэхэд, би гар хангалга нь ямар ч цэвэр зүйлийг бий болгодог

~ Загалмайгаа тээх нь махан биеэ хангах биш, харин няцаах явдал юм.

гэдэгт итгэдэггүй. Энэ нь Бурханы өмнө цэвэр алхах хүслийг дэмжихгүй. Энэ нь хүний үнэ цэнэтэй хүслийг үнэ цэнэгүй арга замаар хангах оролдлого бөгөөд аминч хүслийн зам руу уруудуулна. Загалмайгаа тээх нь махан биеэ хангах биш, харин няцаах явдал юм. Чи

ганц бие бол дур хүслээ Бурхантай тогтоох харилцаандаа юмуу бусдад туслахад зориул. Чи гэрлэсэн бол, эхнэрүүд гэрлэлтийнхээ амьдралд тун ухаалаг хандах үүрэгтэй. Цэвэр байдал нь гэр бүлийн амьдралд ч бий. Бид гэрлэлтийн ор дээрээ цэвэр байлгах үүрэгтэй.

Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр нь ч бүү бузартаг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ. (Еврей 13:4)

Энд гэрлэлтийн ор дэрэн дотор юу ч хийж болно гэж хэлээгүй байна. Энд гэрлэлтийг хүндэтгэж, завхайрал, бэлгийн ёс бус явдлаас сахин хамгаалах ёстой гэжээ. Үүнд порно, бусдын талаарх бэлгийн төсөөлөл ч багтана. Нэгэн сайхан эмэгтэй нөхөртэйгээ гэрлээгүй байхдаа бэлгийн харилцаанд орж байгаа мэтээр төсөөлөн бодохгүй л бол, нөхөртэйгээ ямар ч таашаал эдлэдэггүй гэдгээ надад хүлээсэн юм. Тэд гэрлэхээсээ өмнө унтсан бөгөөд бараг хорин жилийн дараа ч тэрбээр онгод авах гэж нүглийн ор руугаа эргэсээр байх. Бид хоёр хамтдаа залбирсан бөгөөд тэрбээр нүглээ хүчингүй болгож, Бурханаас гэрлэлтийн орыг нь цэвэр бөгөөд дур хүсэлтэй болгож өгөхийг гуйсан юм.

Өөр нэг том асуудал нь аман секс юм. Мэдээж гэрлэлтээс гадуур энэ нь нүгэл боловч, гэрлэсэн хүмүүсийн хувьд яах уу? Аман секс зүгээр зүйл үү? Олон хүн надтай санал нийлэхгүй л байх. Гэхдээ би л хувьдаа эмэгтэй хүний хоолой ам эр хүний үрийн шингэнээр дүүрэх гэж бүтээгдээгүй гэдэгт итгэдэг. Хурьцлаар хоёр нь нэг болж, тэр нэгдлээрээ амийг бүтээдэг. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хоёрын харилцаанд л байдаг, онцгой зүйл. Гэтэл аман секс нь тийм биш. Тухайлбал ижил хүйстнүүдийн дунд аман секс байдаг ч, жинхэнэ хурьцал байдаггүй. Адам эхнэрээ таньсан. Тэрбээр эхнэрийнхээ хэвэлд нэвтрээд, үрээ суулгасан.

Тэгвэл ижил хүйсийн харилцааны тухайд, Бурхан эрэгтэй хүнийг эрэгтэй байлгахаар, эмэгтэй хүнийг эмэгтэй байлгахаар буюу өөрөөр хэлбэл гетеросекс байлгахаар бүтээсэн гэдэгт би итгэдэг. Бурхан гомосексүүд гэдэг хоёрдагч угсааны хүмүүсийг бүтээхээр шийдээгүй. Тийм юм байхгүй. Зүгээр л ижил хүйсдээ тэмүүлсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс л бий. Тэд шинэ үйлдрийн юмуу угсааны хүмүүс биш. Тэдэнд сонголт байхгүй гэдэг үзлийг хүлээн зөвшөөрөх нь худлаа юм. Бурхан ижил хүйсийн авирын тал дээр маш хатуу байр суурьтай байдгаа айлдсан:

Хэрэв эр хүн эмэгтэйтэй унтдагтай адилаар эр хүйстэнтэй унтсан байх аваас тэд хоёулаа жигшүүрт зүйл үйлдсэн бөгөөд тэд гарцаагүй алуулаг. Тэд өөрсдийн цусыг өөрсдөө хариуцна. (Леви 20:13)

Арай л хатуудсан Бичээс мэт боловч, завхайрсан хүмүүс ч ижил хүйстнүүдийн нэгэн адил Бурханы хуулиар цаазлуулах ялтай байсныг бүү мартаарай. Амин чанар нь цэвэр байдал юм.

Ижил хүйсийн явдал, завхайрал нь Бурханы өмнө ганц эрэгтэй, ганц эмэгтэй хоёр нэг болох Эхлэлийн төлөвлөгөөг зөрчиж байгаа юм.

Ижил хүйсийн явдал, завхайрал нь Бурханы өмнө ганц эрэгтэй, ганц эмэгтэй хоёр нэг болох Эхлэлийн төлөвлөгөөг зөрчиж байгаа юм. Хуучин гэрээнд ижил хүйсийн явдлын талаар хэд хэдэн удаа өгүүлэхдээ, хэзээ ч амьдралын бас нэгэн төрлийн сонголт гэж

хэлээгүй. Гэтэл Паул сүүлчийн өдрүүдэд энэ сэтгэлгээ өөрчлөгдөх талаар өгүүлжээ:

Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхиж. Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж, эрчүүд эрчүүдтэйгээ ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна. (Ром 1:26–27)

Хэвийн бус хүсэл, жигшүүртэй үйлдэл нь Бурханы үнэнийг худлаар сольсон хүмүүний соёлын үр дагавар билээ. Бурхан ямарваа зүйлийг хэвийн бус, шившигтэй, жигшүүртэй гэсэн л бол энэ нь Түүний төлөвлөгөө биш болохыг илтгэнэ. Энэ тал дээр Бурхан эргэлзээгүй, бид эргэлзэж байна. Бурхан садар самуун, порно, завхайрал, ижил хүйсийн явдал, гаж хүслийн тачаалд хүлэгдсэн хүмүүсийг чөлөөлөхийг л хүсдэг. Би ижил хүйсийн хүслээс чөлөөлөгдөх амархан гэж хэлээгүй ч, чөлөөлөгдөх бүрэн боломжтой.

Порногийн дүр дүрс нь мөн л цэвэр байдлыг хүчирхийлсэн явдал юм. Порно дүр дүрс нь хөнгөн хүндээсээ үл хамааран чамайг бусдын ичгүүрийг хуваалцахад хүргэдэг. Чи үүнд нь оролцож, энэ нь чамайг ямар ч бусад дүр

Чи бусдын нүглийг харах ёсгүй хүн.

дүрсээс илүү олзлоно. Чи киноны өөр үйл явдлыг санах гэж зүдэрч болох ч, бэлгийн сэдэлтэй зураглалыг маш сайн тогтоож авна. Тэдгээр нь чиний оюун санаанд файл болон

хадгалагдаж, чамайг өөрийг нь нээхийг даллан дуудна. Энэ нь бүлэглэсэн нүгэл учраас аюултай. Ноагийн хоёр хүү нүцгэн аавыгаа харахгүй гэж нүдээ буруулан явсаар, хучсаныг санаж байна уу? Энэ зүгээр нэг утгагүй үйлдэл биш шүү. Чи бусдын нүглийг харах ёсгүй хүн.

Би нүднийхээ өмнө Үл бүтэх ямар ч юмыг байлгахгүй. Би урвагчдын ажлыг үзэн яддаг. Тэр нь надад наалдахгүй. (Дуулал 101:3)

Та нар эцгүүдийнхээ замнал ёсоор бузарлагдаж, ой гутам юмсыг нь дуурайн садар самууныг үйлдэх үү? (Езекиел 20:30)

Порно нь чиний ухамсрыг зэрэмдэглэж, чиний гэрлэлтийн орыг олзлохоор дайн дэгдээдэг. Порнод гар бие оролцсон бол, гэмшиж, тэдгээр дүр дүрсийг арчиж зайлуулахыг Бурханаас гуйж, Түүний оршихуйд байж, Үгийг уншиж, Бурханыг магтах цаг гаргаарай.

Бид ичгүүр болохоор дуудагдаагүй, харин цэвэр байдалд дуудагдсан. Бид ямар ч үнээр хамаагүй ичгүүрээс зайлахыг хүсдэг учраас, ичгүүрээс дөлөн эсэргүүцэхийн оронд найр тавин хүлээн авдаг болжээ. Ганц бие, гэрлэсэн, хөгшин залуу – эмэгтэй хүн бүрийн амьдралд цэвэр байдлын хүч ноёрхоосой гэж би хүснэ. Паулын халуун сэтгэл, захирамжийг зүрх сэтгэлдээ хоногшуулаарай:

Бурханы хардалтаар би та нарыг хардаж байна. Учир нь би та нарыг Христийн өмнө ариун онгон охин мэт аваачих гэж ганц нөхөртэй сүй тавиулсан. Могой, залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ дор [цэвэр] эгэл байдлаас чинь та нарын санаа бодлыг төөрүүлчих вий гэхээс би харин айж байна. (2Коринт 11:2–3)

Нүгэл биднийг Христэд цэврээр бүрэн зориулагдахаас маань хорихоор могойн дүрээр ирдэг мэт. Бид хэний үгийг сонсохоо сонгох ёстой: Аврагчийнхаа үгийг сонсох уу эсвэл амийг маань авахыг хүссэн могойг сонсох уу? Номлогчийн, зөвлөхийн, багшийн үг биш, Бурханы Үг л туйлын эрх мэдэлтэй. Бурханаас асуух юм бол, Тэрбээр Сүнсний илдийг аваад, амьдралд чинь байгаа бүх худлыг тас цавчина.

Өнөөгийн энэ их гадаад өөрчлөлтийн дунд ч бид үндсэн асуудал руугаа эргэх ёстой. Цэвэр бодол нь цэвэр үйлдэл, төрх, яриаг бүтээнэ. Хичнээн зөрчилдөж байсан ч, дотоодын дайндаа ялалт байгуулж чадахгүй бол, дарамт дор орохдоо бид гадаадын дайндаа ч ялагдана. Би чамд Бурханы бүрэн зөвлөгөөний дагуу л зөвлөх гэж хичээлээ. Зарим сургаал нь дэндүү хатуу байж болох учраас, хичээлээ нэмэлт Бичээсээр дуусгамаар байна. Хүмүүний зөвлөгөө, буултыг Бурханы цэц ухаанаас дээр гэж хэлэх явдал чамаас хол байг.

... тэдгээрийг янхны эрхтнүүд болгох уу? Огт үгүй. Янхантай нийлсэн нь түүнтэй нэг бие болно гэдгийг та нар мэдэхгүй юу? Учир нь “Хоёр нь нэг махбод болно” гэсэн юм. Харин Эзэнтэй нийлсэн нь Түүнтэй нэг сүнс болой. Садар самуунаас зугт. Хүний үйлддэг нүгэл бүр биеийнх нь гадна байдаг. Харин садарлагч нь өөрийнхөө биед нүгэл үйлддэг. Та нарын бие бол Бурханаас та нарт буй, дотор чинь байдаг Ариун Сүнсний сүм бөгөөд та нар ч өөрсдөө өөрсдийнх бус гэдгээ мэддэггүй юм уу? Та нарыг үнэтэйгээр худалдан авсан тул биеэрээ Бурханыг алдаршуул. (1Коринт 6:15–20)

Харин махбодын үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар тачаал, садарлал, шүтээн шүтлэг, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, харгалдаан, хагарал, тэрс үзэл, агаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй. (Галат 5:19–21)

Бурханы хүсэл нь та нарын ариусал бөгөөд тэр нь юу гэвэл, та нар садар самууныг цээрлэж, хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн биеэ хэрхэн хянахаа мэдэж, Бурханыг мэддэггүй харийнхан мэт тачаангуй хүсэлд эс байх нь юм. (1Тесалоник 4:3–5)

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Би Таныг бүх амьдралаараа мэдмээр байна. Та бол үнэн, гэрэл, хайр, цэвэр байдал, ариун байдлын охь. Би Таных. Би Таны Үгэнд эмээн захирагдаж байна. Би Таны Үгийг өдөр бүр амьдралдаа хүндэтгэж, дээдлэж, Үгэнд тань захирагдана. Би Таны Үгийг амьдралынхаа тал бүр дээр урьж байна. Их Эмч минь Та, миний амьдралын үнэ цэнэтэй юмсыг өвчнөөс салгаж эмчлээч. Намайг бүрэн Өөрийнхөө болгож, Таны таалал, зорилго руу тусгаарлахын тулд ерөнхий мэс засалчийнхаа ур чадвараар зүрхэнд минь байгаа бохир болгоныг, бэлгийн амьдралд минь байгаа эмгэг болгоныг зайлуулаач. Би Таны Үгийн үнэнийг хүлээн авч, энэ дэлхийн жишгээс буруулж байна. Есүсийн нэрээр. Амень.

Таны хайрт охиноос.

13 *Аминд халтай хувцаслалт*

Бид санаатай бөгөөд санаандгүй байдлаар бусдад үргэлж нөлөөлдөг. Бид бусдад гурван сувгаар нөлөөлдөг: *үгээрээ* (үг, дууны өнгөөрөө), *үйлдлээрээ* (авир үйлдэл, үйлсээрээ), *дүр төрхөөрөө* (биеэ авч явж байгаа, өөрийгөө танилцуулж байгаа байдлаараа). Бид өнгөрсөн бүлгээрээ хэл яриа, үйлдлийн талаар ярьсан. Тэгвэл хүний биеэ авч явж байгаа байдал дутахгүй нөлөө үзүүлдэг ажээ. Хүмүүс сонссон зүйлээсээ гэхээсээ илүү харсан зүйлээсээ их нөлөө авдаг учраас, энэ нь тун чухал сэдэв мөн. Энэ нь эмэгтэйчүүдээс илүү эрчүүдийн хувьд үнэн. Яагаад гэвэл эрчүүд нь хараа төвтэй байдаг.

Үүнийг ойлгох юм бол, бид энэ хүчийг өөртөө давуутайгаар, үр ашигтайгаар ашиглаж чадна. Бид толгой эргүүлсэн мессеж өгч, хэлэх гэсэн санаагаа зөрчилдүүлж болохгүй. “Анхны сэтгэгдлийг төрүүлэх хоёр дахь боломж байхгүй” гэдэг хуучны хэлц үгийг чи мэдэх байх. Энэ үг хуучны үг байж болох ч, үнэн гэдэг нь яриангүй. Манай соёлд имиж гэдэг зүйл амин чухал болжээ. Харааны имиж нь маш ил тод, эрс тэс болж, өөрийгөө илэрхийлэх байдал гэдэг ойлголт өнөөгийнх шиг хүчээ авч байсан түүх байхгүй байх аа. Жишээлбэл, үсний өнгө л гэхэд ногооноос авахуулаад, үзмэн ягаан болжээ. Уруулын будаг нь ягаан, улаан, улаан хүрэн гэсэн уламжлалт өнгийг орхин, хар өнгөтэй болох жишээтэй. Шүүгээнд маань загвар загварын хувцас байх. Өөрийгөө илэрхийлэх ийм олон төрлийн сонголт хэзээ ч байгаагүй ч, энэ бүхнээрээ бид чухам юуг хэлнэ вэ? Өөрийгөө илэрхийлэх энэ их эрх чөлөө нь үнэндээ аль хэр үр нөлөөтэй байна вэ?

Жишээлбэл, залуучууд чиний ухааныг үнэлээсэй гэж хүсч байгаа бол, задгай хувцаслалт, хүйснийхээ нүхээрээ нүдийг нь бүү хужирла. Зорилго чинь бүтэлгүйтнэ.

Самууруулсан, ойлгомжгүй дохио чинь буруу орчуулгад хүргэнэ. Залуус чиний ил биеийг л харахаас биш, далд байгаа, мундаг АйКюг (IQ) чинь олж харахгүй.

Чиний хувцаслалт, өөрийгөө танилцуулж байгаа байдал чинь бусдад тодорхой мессеж дамжуулаад зогсохгүй, хэлэх гэсэн зүйлээс чинь ч илүүг ойлгуулж мэдэх. Энэ нь чиний өөрийнхөө талаар бодож явдаг, итгэж явдаг эсвэл хүчээ авдаг гэж бодож явдаг зүйлээс чинь өөрийг хэлж болох. Тэгээд мэдээж хэнийх болохыг чинь ч илэрхийлнэ.

*Жингээлбэл, залуучууд
чиний ухааныг үнэлээсэй
гэж хүсч байгаа бол, задгай
хувцаслалт, хүйснийхээ
нүхээрээ нүдийг нь бүү хужирла.*

Энэ талаар хэсэг бодно уу. Хөвгүүд маань хувцаслах хэв маягаараа сургууль дээрээ бусдаасаа онцгойрдог бүлэг хүүхдүүдийн талаар ярьдаг. Дэлгүүр орохдоо би хөвгүүдээсээ: “Энэ цамц ямар байна?” гэж асуухаар, тэд: “Үгүй ээ, наадах чинь скэйтерүүдийн брэнд” гэж хариулдаг. Би тэрийг нь яаж мэдэх билээ? Хүүхдүүдийн дунд өөрийн гэсэн систем оршдог учраас, скэйтээр гулгадаггүй бол, тэдэн шиг хувцаслаж болдоггүй ажээ. Өөр бас *цагаан захтнууд, хөх захтнууд* гэсэн нэрс байна. Нэг нь албан тушаалтнууд бол, нөгөө нь ажилчин ангийнхан. Эдгээр нэр томъёо нь өөрийн гэсэн дохио тэмдэг, үзэл санаа бүхий хувцаслалтыг тодорхойлж байна.

Тэгвэл чи юуг дамжуулж байна? Ямар мессеж илгээж байна? Тэдгээр нь чамайг хэн болохыг зөв тусгаж байна уу эсвэл чи зүгээр л дүр эсгэж байна уу? Эдгээр нь тун чухал асуулт бөгөөд чи үүнд шударгаар хариулах хэрэгтэй. Чиний хувцаслалт, төрх чамайг яг хэн болохыг илэрхийлж чадаж байж болох. Чи “Би мэргэжилтэн бөгөөд үүнийхээ дагуу хувцаслаж чадаж байгаа” гэж хэлж болох. Эсвэл чи оюутан учраас, “бэлтгэл ангийн” гэдгээ мэдэрч, үүнийгээ илэрхийлэх маягаар хувцаслаж байж болох. Тэгвэл жаахан лавшруулж үзье.

Чи хувцаслах хэв маягаараа бусдад хэрхэн нөлөөлж байна? Чи эрчүүдэд бурханлаг үлгэр жишээ, хүсэлтэй байхад нь тус болж байна уу? Хүмүүс чамайг л харж байна уу эсвэл хувцсыг чинь л харж байна уу? Хүмүүс чам руу харахдаа, юу хардаг бол?

Чи Бичээсийг цээжээр эшлэн, яаж харагдах нь хэнд ч падлийгүй, Бурхан зүрхийг хардаг, хүнийг төрхөөр нь шүүж болохгүй хэмээн маргаж болох. Бурхан бидний зүрхийг хардаг нь юутай сайхан. Гэхдээ бид газар дээр амьдарч байна. Тиймээс Бурхан л дотрыг хардаг болохоос хүмүүс гаднахыг л харна.

мөхөс нэгэнтэй адил хүний гаднах төрхийг хардаггүй. ЭЗЭН зүрхийг нь хардаг. (1Самуел 16:7)

Энэ эшлэл нэгэн баримтыг хэлжээ: Бид харснаараа хөдлөдөг. Бидний савалгаа бусдад нөлөөлдөг учраас, бид хянуур байх ёстой. Ихэмсэг байдал нь уурших найдвар учраас, үзэмждээ найдах нь мунхаг хэмээн бидэнд анхааруулсан буюу.

Бүгдээрээ 1–ээр бүлэгт тавьсан асуултыг дахин сөхье: Ил задгай хувцаслах зүгээр үү? Нэг удаадаа биеэ хэр зэрэг ил гаргаж болох вэ? Хоёулаа энэ асуудлыг жаахан малтаж үзье. Бид эр хүний сэтгэлийг яаж татсан – яг л тэр аргаараа тогтоож барина. Жишээлбэл ил задгай, өдсөн шинжтэй хувцас нь ер нь бол сексийг амладаг. Хувцаслалт нь зүгээр нэг өөрийгөө илэрхийлэх, хувийн бөгөөд мэргэжлийн үнэ цэнээ илэрхийлэх арга биш юм. Хувцаслалт нь эдгээрээс том зүйл. Цөмөөрөө жишгийн хөндлөвчийг жаахан дээшээ өргөө. Бурханы хүүхдүүд бид амьдралынхаа бүхий л талаараа Аавыгаа хүндэтгэх учиртай гэдгээ ойлгох хэрэгтэй.

Ингэж хэлэхээр, намайг зулайнаасаа шагай татсан, майхан шиг хэлхэгэр өмсгөлийг суртчилдаг, шашинтан байна гээд, номоо чулуудчих бий! Би тийм хүн биш. Бид дэлхийн дүр төрхөөр хувилахгүйгээр гоё хувцаслаж, дур булаам байж болно гэдэгт би итгэдэг. Гэхдээ ингэхийн тулд маш торгон ухаантай байх хэрэгтэй. Учир нь хуульчлалын байна уу, эрх чөлөөний байна уу – аливаа асуудлыг туйлшруулах амархан байдаг. Би чамайг өмсөж байгаа хувцсандаа арай жаахан хариуцлагатай хандахыг уриалж байна. Яагаад гэвэл өнөөдөр зааг хязгаар улам л бүдгэрч, заримдаа Христэд итгэдэг хүмүүс соёлын хэм хэмжээнээс өндөр хүмүүс биш, харин хуулбарлан дууриагч болсон мэт харагддаг.

Хуульчлалын байна уу, эрх чөлөөний байна уу – аливаа асуудлыг туйлшруулах амархан байдаг. Би чамайг өмсөж байгаа хувцсандаа арай жаахан хариуцлагатай хандахыг уриалж байна.

Би энэ номыг бичиж байхдаа зурагтаар нэгэн ярилцлага үзсэн юм. Сэдэв нь: тэрслүү охидтой цөхөрсөн ээжүүдийн яриа байв. Охид нь олны дунд явахдаа, зохистой хувцасладаггүй ажээ. Тэд олны хараанд байх дуртай аж. Нэг нь дээгүүрээ усны хувцасны хөхөвч зүүгээд, өөдсийн чинээ, нимгэн саронаар (жижиг нимгэн даавуу) бөгсөн биеэр ороожээ. Бас нэг биеэрхүү охин нь улаан шаргал хиймэл үс зүүгээд, бариу цээживч, бөгсөө цухуйлгасан богино өмд өмсжээ. Тэд ердөө л арван дөрөв, тавтай бөгөөд хэн хэн нь секс хийж, хар тамхи, архи хэрэглэдгээ гайхуулж байв.

Тэр жаахан охид гэнэн, цэвэрхэн дүр төрхөө ор мөргүй алдаж, яг л

эвдэрсэн, хөгшин янхан шиг харагдана. Ээжүүд нь охиноо алдчихсан аятай л гашуудан уйлж байв. Алагхан охин нь нүдэн дээр нь л хогийн янхан болон хувирчээ. Ээжүүд нь охидоо ямар хөөрхөн байсныг санагалзан дурсаад, тэр охидын гэр бүл дээрээ авчирсан зовлон, шаналлын талаар асгаруулан ярьж бас нэг л өдөр хаа нэг газраас үхсэн олдох вий гэдгээс айж байгаагаа хэлэв. Гэтэл энэ хооронд охид нь хөхрөлдөж, ээжийгээ болоод танхимаас тэдэнд үг хэлсэн хүн болгоныг харааж байв. Тэдний хэл ам нь аймшигтай бохир учраас, бараг хэлсэн үг бүрийг нь цензурдэж байлаа. Би тэр мэхлэгдсэн охидын төлөө бас голоо урагдтал цөхөрсөн ээжүүдийнх нь төлөө уйлав.

Тэр ээжүүд охидоо сэхээрүүлэх гэмээн аргаа барсандаа л нэр нүүрээ баран, үндэсний телевизээр гарсан байх. Яагаад тэр ээжүүд тийм хүчгүй байна вэ? Яагаад ийм байдалд хүрэв? Бас тэр охидын аавууд нь хаана байна?

Тэр жаахан охидод ямар ч бүсгүй хүний шинж байсангүй. “Тачаангуй” гэж нэрлэхийн ч аргагүй, зүгээр л “хогийн” гэмээр. Өмнөөс нь нүүр улаймаар. Тэд өөрсдийгөө хэн нэг алдартай дуучин шиг л гоё хүүхнүүд гэж сэтгэж байсан ч, үнэндээ жигшмээр харагдаж байв. Бүр нүд хальтирмаар. Тэдэнд дусал ч цэц ухаан, нэр төр үлдээгүй учраас, ямар ч ичгүүр сонжуур, гоо үзэсгэлэн байсангүй. Тэд уйлж байгаа ээжүүдээсээ биеэ тас өмөөрөн, нулимж байв.

Тэд өөрсдийгөө их л хүчирхэг хувцасласан гэж бодож байсан байх. Тэд тачаал төрүүлэх чадвараа хүчирхэг байдалтай андуурчээ. Тэд гудмаар

явахдаа, эрчүүд өөрсдийг нь хүссэндээ дуу алдаж байна гэж бодно. Жаахан ухаантай байсан бол, эрчүүд тэднийг хүсэх биш, харин бэлгийн дур хүслээ л тайлахыг хүсч байгааг ойлгоно доо. Гэтэл тэр жаахан охид боол болсноо хүч чадалтай эндүүрчээ.

Тэд тачаал төрүүлэх чадвараа хүчирхэг байдалтай андуурчээ.

Эрчүүд тэднээс амиа хуваалцаач гэж хүсэхгүй. Эрчүүд тэднийг зүгээр л хүчирхийлээд хаяна. Гэвч тэнэг охид үүнийг ойлгохгүй.

Үнэндээ тэр охидын хувцаслалт нь тэдний гүнд байгаа зөрчлийг илэрхийлж байгаа юм. Эрт дээр үед улс үндэстнүүд өөр хоорондоо дайтахдаа, ялсан тал нь ялагдсан улсаа юу ч үгүй самран, тонон дээрэмдэж, солиорцгоодог байжээ. Тэр солиорол нь жинхэнэ дайнаасаа ч аймшигтай, харгис үйл явдал болдог байв. Булаан эзлэгч нар айлуудыг шатаан, эмэгтэйчүүдийг хүчиндэн, айл гэрийн аюулгүй байдал, нэр төрийг гутаан доромжилно. Энэ нь ялагдал хүлээсэн дайсныг юу ч үгүй доромжилж байгаа үйл явдал байв. Эмэгтэйчүүд энэ улайрсан, аймшигт эрчүүдээс айж зугтахсаас биш, баярлаж угтсан тохиолдол түүхэнд тэмдэглэгдээгүй.

Гэтэл толгой нь эргэсэн тэр хоёр охин энэ байдлыг хүчин, хүчирхийлэл гэж ч үзсэнгүй. Энэ бүх садар явдлын цаана нэр төр гэж юм байдгийг ч ойлгосонгүй. Тэд гудманд гараад, эрчүүдийг шагнал мэт угтан авахдаа, тэдгээр сексийн ангуучдыг гоо сайхнаараа олзоллоо л гэж бодно. Тэд бүсгүй хүний гоо үзэсгэлэн, нандин чанарыг эрчүүдийн дур хүслийг тайлдаг, таван долларын хөлсний янханаар л төсөөлжээ.

— *Охидын хувцаслалт нь тэдний гүнд байгаа зөрчлийг илэрхийлж байгаа юм.*

Олон бүсгүйчүүдийн даган дууриах гээд байдаг, өөрт нь хүч өгнө гэж амладаг өдөөлтийн имижийг харцгаая. Тэдгээр нь мэс заслын аргаар нялх хөхөө түмбийлгэсэн өсвөр насны охидоос эхлэнэ. Тэдгээр имиж нь онгоцны буудал, жижиглэнгийн дэлгүүр, хүнсний дэлгүүрийн тавиур дээрх сэтгүүлийн нүүрэн дээрээс цоо ширтэх нь ой гутмаар. Тэд дэлэн хөхөө товойлгон, эрүүгээ өргөөд “Би хүчирхэг! Миний цэц ухааныг сонс” гэнэ. Космо, Аллор, Ин стайл тэргүүтэй эмэгтэйчүүдийн сэтгүүл болгон чамд нарийнхан гуя, алмайрмаар сексийн нууцыг тайлахаа амлана. Тэд чамд яаж тэргүүний янхан болохыг заана.

Кассанд бичүүлэхийн тулд хүссэн хүсээгүй тэр сэтгүүлийн тавиурын хажуугаар гаргал, есөн настай хүү маань над руу ойртоод: “Ээж ээ, тэр эмэгтэй над руу яг намайг идэх гэж байгаа юм шиг харж байна!” гэж хэлж билээ. Тэр хүүхний олзлогч харц хүүд маань айдас төрүүлжээ. Миний бодлоор эрчүүд хэдийгээр мэдрэмжээ миний гэнэн хонгор хүү шиг ухаардаггүй боловч бас яг ингэж сүрддэг байх.

Улайрсан, түрэмгий, өдөөгч төрхөөрөө эрчүүдийн нүд рүү эгцлэн ширтэх дүр нь нэн тэргүүнд эр хүний амин мөн чанарт занал хийлэх маягаар сэрлийг нь хөндөнө. Эрэгтэй хүнд байлдан дагуулал амтагдан, уриалан дуудагчийнхаа тулаанд бэлтгэн, тестостероных нь төвшин нэмэгдэнэ. Тэгээд эрэгтэй хүн эмэгтэй хүнийг дарж авснаараа, хүчээ ээлбэн сэргээнэ. Сэтгүүлийн нүүрнээс авахуулаад хөгжмийн клип дотроос “Намайг хүсч байна уу? Чамд харахын заяа байхаас хазахын заяа байхуй” хэмээн басах сексийн түрэмгийлэгч эмэгтэйчүүд эрчүүдэд амар заяа үзүүлдэггүй гэлтэй. Эдгээр имижийг тархиндаа хэвлэж авсан эрчүүд хэвлэл, зурагт доторх эмэгтэйчүүдийг өөрийн болгож чадахгүй учраас, янхан барааддаг байна.

Эрчүүд сэтгүүлийн хавтас, порно хэвлэлд итгээд байх юм бол, эмэгтэйчүүд бүгдээрээ наанаа үгүй гэдэг ч, цаанаа сексийг хүсдэг гэдэгт итгэх болно. Тэд бидний үгүй гэдэг үгийг зүгээр л сексийн байлдан дагуулах тоглоомын нэгээхэн хэсэг л гэж эндүүрнэ. Өнөөдөр кинонд ч секс, хүч хоёрын холбоо нь секс, хайрын талаарх хуучны ойлголтоос

тэс ондоо болжээ. Бас секс, үхэл хоёр ч түншлэх болсон байна. Чи “Энэ хоёр хүн бие биеэ алах гээд байгаа юмуу хүсээд байгаа юм уу?” гэдгийг ерөөсөө ойлгохгүй.

Сэрж үз! Энэ бүх худалд бүү итгэ! Чамд амлаад байсан хүч нь хаана байна? Чи ялахгүй, эзлэгдэж байна. Чи нүцгэлэгдэж, хүчиндүүлж байна.

Чиний нэр төр хаана байна? Хүч тэнхээ чинь хаана байна? Хүндэтгэл чинь хаана байна? Чамаас дайжжээ.

~ Сэрж үз! Энэ бүх худалд бүү итгэ! Чамд амлаад байсан хүч нь хаана байна?

Надад ийм дүр төрх тэнэг санагддаг. Тэд гаднаа хачин гоё харагдаж болох ч, дотроо хэр үзэсгэлэнтэй нь эргэлзээтэй. Жинхэнэ

гоо үзэсгэлэн хамгаалж, хадгалах хүслийг төрүүлдэг. Бидний өмнүүр жагсах эдгээр дүр төрх нь нүцгэлэх зоригтой хүмүүсийг л хамгийн түрүүнд баясгана. Эдгээр өдөөгчдийн атганд орсон хүн амьдралын шуурганд ямар ч өршөөл, хамгаалалт, тайтгарал үзэхгүй. Магадгүй, чи намайг хөгшин учраас агаархсандаа ингэж ярьж байна гэх байх. Гэхдээ үгүй юм. Эдгээр дүр төрх нь анх дур булаам, хүчтэй мэдрэмж төрүүлдгийг би мэднэ. Би ч залуу байсан, би ч үүнд татагдаж явсан. Гэхдээ энэ бүхэн намайг хов хоослоод, үнэхээр намайг хайрлаж, хамгаалах хүн байна уу хэмээн орь дуу тавихад хүргэсэн юм. Би дайчин, өрсөлдөгч байхаас залхаж, зүгээр л хайрлуулж, хамгаалуулахыг хүсч билээ.

Эмэгтэй хүн хүүхэд юмуу залуу байхдаа, аавтайгаа эрүүл саруул харилцаа тогтоож чадаагүй бол, энэ нь эрчүүдэд хандах хандлагад нь нөлөөлдгийг би өмнө хэлсэн. (Над шиг Ханхүүтэйгээ учраагүй тохиолдолд) Аавууд нь охидоо биширч, үнэт эрдэнэ шиг л үзэх ёстой. Би таван настайдаа нүдээ авахуулахдаа, эмэгтэй хүний хамаг мөн чанар, гоо үзэсгэлэнгээ хамт алдсан юм. Намайг сургуульд “ганц нүдэт”, “Дува сохор” гэж дууддаг байсан нь надад хайр татсан, хөөрхөн охин гэсэн мэдрэмж төрүүлдэггүй байв. Намайг нүдээ авахуулснаас хойш аав маань ч надаас хөндийрсөн болохоор, би өөрөө л өөрийнхөө төлөө тэмцэхийг сурсан юм. Аав миний гүргэр занд эгдүүцсэндээ надтай огт харилцахгүй. Тэр намайг “бар”, жижигхэн хусуур” гэж дуудна. Ийм дүр төрхтэй охин даашинз, эмэгтэй төрх зохино гэж үү? Тиймээс би өөрийгөө хамгаалахын тулд хэзээ ч маягтай, эгдүүтэй охин болохгүй байхаар шийдэв.

Гэтэл нэгэн Хагас сайн өдөр ангийнхантай кино үзэж байхдаа, би өөрийнхөө баатар – эмэгтэйг олж харсан юм. Тэрбээр ягаан даашинзгүй, ямар ч маяг зангүй. Түүний амьдрал тэр чигээрээ адал явдал. Тэрбээр Жэймс Бондын охидын нэг байв. Хөвгүүдтэй мөр зэрэгцэн гүйдэг, зэвсэг агссан, өмдтэй тэр охид яг сэтгэлд минь хүрэв. Тэд эрчүүдээс юугаараа ч

дутахгүй, тэднийг хэн ч түлхэж чадахгүй. Тэд эрчүүдээр хамгаалуулахгүй, өөрийгөө хамгаалчихна.

Би ийм эмэгтэйг өмнө сэтгүүлээс харж байлаа. Түүнийг манай найз аавынхаа шүүгээнээс олсон юм. Тэр сэтгүүлийг нь Плэйбой гэдэг байв. Би эрчүүд нууцаар ийм эмэгтэйг хүсдэг учраас л гэртээ авчирчээ гэж ойлгосон юм. Аав, ээж нарт би нэгэн анхааруулга өгье. Та нар гэртээ ямар нэгэн юм нууж чадна гэж бодож байгаа бол, эндүүрч байна. Та нар нууж чадахгүй. Ийм төрлийн материал нь дуу хоолойтой учраас, хүүхдүүдийг чинь олтол нь өөр рүүгээ даллаж байдаг юм.

*Хөвгүүдтэй мөр зэрэгцэн
гүйдэг, зэвсэг агссан, өмдтэй
тэр охид яг сэтгэлд минь хүрэв.*

Бүгдээрээ дахиад миний түүх рүү эргэе: Би кино үзэхдээ арван гуравтай байсан бөгөөд аав маань биднийг орхиод явчихсан байсан учраас, эрчүүд эцэстээ хаяад явдаг юм байна гэсэн ойлголттой болоод байлаа. Хар нялх байхад минь тогтсон энэ бодлоос болж би тун аюултай алдаа хийхэд хүрсэн юм. Гэтэл намайг ахлах сургуульд байхад гарсан *Чарлигийн сахиулсан тэнгэрүүд* гэдэг алдартай кино миний сонголтыг улам л зөвтгөн бэхжүүлж билээ.

Нэгэн удаа манай ахлах сургуулийн өдөрлөгөөр бидний хэсэг охид “Калифорнийн охид” гэдэг дуугаар үзүүлбэр бэлтгэсэн юм. Хоёроос олон хүний өмнө гарахаасаа ухаан алдталаа айдаг хүүхэд би, яаж яваад ч энэ үзүүлбэрт орчихсон юм, бүү мэд. Ямар ч байсан би “Умардын охид үнсэлтгээрээ найз хөвгүүдээ шөнө дулаалцуулдаг” гэдэг мөрийг хэлэх ёстой байв. Тэгээд яаж муурч унахгүйгээр үгээ хэлэх билээ хэмээн зовниж байлаа. Гэтэл үзүүлбэрийнхээ өмнөх орой хувцсаа өмсөж үзэхэд минь бүх зүйл өөрчлөгдөв: хар бариу өмд, бариу цамц, ээжийн өндөр өсгийтэй, өвдгөөр татсан, арьсан гутал. Би өөрийгөө толинд хараад ангайв. Яг л Бондын охин! Маргааш нь ганцаархнаа бор үстэй би шар толгойтой найз охидтойгоо хувцсаа өмсөхөөр хувцасны өрөөнд оров. Нэг охин мөрөвтэй өмд, нөгөө нь зуны хөөрхөн хувцас, гурав дахь нь жийнсэн өмд, цамц өмсчээ. Тэгээд мэдээж би. Би ээлжээ хүлээн корридорд зогсож байхдаа сандарч байсан боловч, намайг зааланд явж ороход, хөвгүүд орилолдон, бүх зүйл өөрчлөгдсөн юм. Сексийн хүчтэй, хагуу эмэгтэй байх нь мэдээж догь байв! Би тэр дүрд улам орсоор байсан ч, олохоосоо алдах нь их байлаа.

Цөмөөрөө Жэймс Бондын охид руу дахин эргэе. Миний санаж байгаагаар, Бондын кино болгонд нэг бүсгүй амиа алддаг байв. Тэгээд Бонд амьд үлдсэнтэй нь нэг оронд ордог боловч, түүнтэйгээ дахиж хэзээ ч уулзахгүй. Дараагийн анги дээрээ Бонд шинэ адал явдал эхлүүлэв ч,

хуучин бүсгүй нь хамт байхгүй. Бонд нэг эмэгтэйтэй унтаа л бол, орхиод өөр бүсгүйтэй хөөцөлдөж эхлэнэ. Магадгүй тэд буулт хийснээсээ болж хүчээ алддаг, жинхэнэ “хүлээсний охид” байсан болтой. (“Бонд” гэдэг нь бас “хүлээс” гэсэн утгатай үг)

~ *Бондын охид их бага хэмжээгээр – ялангуяа хяналтаа алдахаараа айдаг. (Тиймээс ч буутай явдаг байх)*

Энэ хэцүү гэдгийг би мэднэ. Сексийн тал дээрээ хүчирхэг эмэгтэй эхэндээ зоригтой харагдаж болох ч, үнэндээ тийм биш юм. Бондын охид их бага хэмжээгээр – ялангуяа хяналтаа алдахаараа айдаг. (Тиймээс ч буутай явдаг байх) Тэдний олонх нь жаахан байхдаа, төрсөн аавынхаа

хайр хамгаалалтыг үзээгүй учраас, эрчүүдэд итгэхээ больсон байх. Зарим нь хайрлан, хамгаалагдсан ч, хүрээлэн буй соёлынхоо нөлөөгөөр Бурханд биш, харин эрчүүдэд таалагдахын тулд гоо сайхандаа найдахыг сурсан байх. Тийм боловч ийм эмэгтэйчүүд эцэстээ гадаанаас дотогшоо өнгийсөөр хоцордог. Дур булаам гэдэг нь эрх чөлөөтэй гэсэн үг биш юм.

Гэтэл Бичвэр юу гэж хэлдэг вэ? “Энэ зарц бүсгүйг хүүтэй нь зайлуул. Зарц бүсгүйн хүү эрх чөлөөт эмэгтэйн хүүтэй хамт өв залгамжлахгүй” гэдэг. Тиймээс ах дүү нар аа, бид зарц бүсгүйнх биш, харин эрх чөлөөт эмэгтэйн хүүхдүүд билээ. (Галат 4:30–31)

Манай соёл эрх чөлөөт эмэгтэйчүүдэд биш, аминч зарц охидод илүү боломж олгодог гэлтэй. Би ч бас бусад охидын л нэгэн адил Хагас сайны өдөрлөгөөрөө *Салхиар туугдагсад* гэдэг олон ангит кино үзэж билээ. Хэдийгээр эцэстээ хамаг юмаа алдсан нь цочирдмоор боловч, намайг Скарлет шиг байхыг хүссэн гэвэл чи гайхахгүй биз. Би уйланхай Мелани шиг байхыг хэзээ ч хүссэнгүй. Надад энэ хоёрын нэгтэй нь адилхан байх сонголт ирсэн бол, би унжгар байдлыг сонгохгүй. Мэдээж тэр кино биднийг: нэг бол хар залуугаараа үхдэг, сайхан сэтгэлтэй, сул дорой, аймхай, гомдомхой, бүлтгэнэсэн бүсгүй байх эвсэл байгаа бүхнээ алдсан ч гэсэн, хүссэн бүхнийхээ араас аймшиггүй явдаг, хүчирхэг, догшин эмэгтэй байх гэсэн хоёрхон л сонголт байгаа гэдэгт итгүүлэхийг хүсчээ.

~ *Гэтэл өөр сонголт байх бөгөөд тэдгээрийг мэдэх цаг нь ирээд байна.*

Гэтэл өөр сонголт байх бөгөөд тэдгээрийг мэдэх цаг нь ирээд байна. Эмэгтэйчүүдэд өөрийгөө гоёх илүү өндөр сонголт бий. Түүнд хувцаслалт (миний урт гутал шиг), өөрийгөө хамгаалах буу

шийдэм хэрэггүй. Тэр эмэгтэй сексийн түрэмгийлэгчийн дүр төрхөөс

хавьгүй эр зоригтой. Эрчүүд түүн рүү довтолдоггүй. Харин түүнд зохистой байхыг хүснэ. Тэр эмэгтэй амийг авдаг бус, харин өгдөг. Тэр хэзээд цэц ухаанаар, зохистой хувцасладаг. Тэрбээр эрчүүд дээр төвлөрдөггүй, эрчүүдийг оволзуулдаггүй, харин тэднийг зөөлөн, болгоомжтой, ухаалаг байхад урамшуулдаг.

Ийм хүнийг сэтгүүлийн нүүрэн дээр тавиад байдаггүй учраас, амьдрал дээр ийм хүн байдаг эсэх нь тодорхойгүй. Тэрбээр сайхан сэтгэлтэй, ховорхон хүн бөгөөд хүнсний дэлгүүрт гялалздаг, нийтлэг дүр зурагаас тэс өөр байдаг. Түүний хувцсыг үзэх юм бол, маш тансаг цаг үе рүү аялсан мэт санагдана. Түүний тансаг хувцас нь өмссөн хүн болгоныг нас, галбираас нь үл хамааран – гоо сайхан харагдуулна. Би “*Жэйн Остины*” киноны бас орчин үеийн Үнсгэлжингийн түүх болох “*Амар сайхандаа*” эсвэл “*Бен Гур*” киноны хувцсанд дуртай. Тэдгээр нь өнөөгийн юнисекс (эрэгтэй хүн ч, эмэгтэй хүн ч өмсөж болдог) хувцаснаас тэс өөр бөгөөд эмэгтэй хүний гоо чанарыг тодруулдаг. Өнөөгийн хуримын хувцас магадгүй үүнд дөхөж очих байх.

Би дээр үеийн кино үзэхдээ “Өнөөдөр яагаад ингэж хувцасладаггүй юм бэ?” гэж санаа алдмаар болдог. Чамд ч бас өөрийн гэсэн дуртай хэв загвар байдаг байх. Бараг гар хүрч зүрхлэмгүй, тансаг хувцас! Тэдгээр хувцсанд ямар нэгэн санаа илэрхийлсэн юм юу ч байхгүй, дээрээсээ доошоо хүртлээ зүгээр л тансаг! Дур булаам боловч, маш хүндэтгэлтэй. Тэнгэрт буй ариун хүмүүсийн хувцсыг гэрэл, алдраар цацарсан, туяаран гийсэн хэмээн дүрслэдэг. Тэр хувцас газрын чанараас ангид, тэр чигээрээ тансаг аж!

Бүгдээрээ гадаад байдлаараа цэвэр байх тал дээр Бурханы Үг юу хэмээн зөвлөснийг сонсьё. Бид Түүнийх учраас, ганц бие байна уу, гэрлэсэн байна уу, бэлбэсэн байна уу, салсан байна уу – бүгдээрээ Түүнд таалагдах маягаар хувцаслах хэрэгтэй. Бурхан биднийг амлалтын айдасгүй, үзэсгэлэнтэй охид гэсэн. Бид чөлөөтэй хэвээрээ байхын тулд Сүнсээр амьдрахыг сонгоно. Учир нь энэ нь Бурханы Үгийн чиглүүлгийн цаад сэдэл юм. Цөмөөрөө хувцасны талаар өгүүлсэн Шинэ гэрээний Бичээсийг цуглуулъя. Эхнийх нь Тимотод заасан Паулын заавар:

Үүнчлэн эмэгтэйчүүд даруу, намбалаг байдлаар зохистой хувцаслан, өөрсдийгөө сүлжсэн үс, алт, сувдаар, эсвэл үнэтэй хувцсаар биш, Бурханаас эмээгч эмэгтэйн зохист сайн үйлсээр чимэгтүн.
(1Тимот 2:9–10)

Миний бодлоор энд хэдэн санаа байна. Хамгийн нэгдүгээрт – эмэгтэй хүний хувцас *даруу* байх ёстой. Энэ нь өөртөө гадны анхаарал татсан, бардам биш байх ёстой гэсэн үг. Хоёрдугаарт – *зохистой* байх ёстой. Энэ

нь цэвэр, ёс суртахуунтай, ухаалаг гэсэн үг. Бид үүний эсрэг хувцаслахыг буюу *зохисгүй* хувцаслах талаар хэдийнээ үзсэн. Би чамтай шударгаар ярьмаар байна – заримдаа би чуулганд байгаа залуу охид, бүсгүйчүүдийн хувцаслалтыг гайхдаг. Би ч өөрөө аврагдсаныхаа дараа шүүгээ дүүрэн зохисгүй хувцастай байснаа мэднэ. Гэхдээ би энэ талаар яриагүй байна. Чуулганд өссөн охид гайхмаар, гайхмаар хүндэтгэлгүй хувцаслах. Залуу хөвгүүдийн ээж нар “Хувцаслалт нь хөвгүүдэд хичнээн нөлөөлж байгааг

Бид хувцсаараа бусдыг хүндэтгэдэг гэдгээ мэдүүштэй.

охидод хэлж өгөөч!” хэмээн гуйх нь олонтаа. Дээрх эшлэлд эмэгтэйчүүдийн хувцсыг бас намбалаг хэмээн дүрслэжээ. Үүнийг хүндэтгэлтэй, зүй ёсны гэж хэлж болох. Хурим дээр зочид нь бэлтгэлийн

хувцастай очбол сүйт хархүү, бүсгүй хоёрыг үл хүндэтгэсэн хэрэг болохтой адил, бид хувцсаараа бусдыг хүндэтгэдэг гэдгээ мэдүүштэй.

Паул дараа нь гадаад гоёл, сайн үйлс хоёрыг сөргүүлэн харьцуулжээ. Паул бол тэнгэрт очиж үзээд, газрын зүйлс тэнгэрийн зүйлсийн хаа ч хүрэхгүйг мэддэг болсон, үнэхээрийн өндөр сэтгэлгээтэй хүн байв. Тэрбээр эмэгтэйчүүдэд газрын эрдэнэст цаг заваа зориулахгүй байхыг зөвлөжээ. Зохистой, сайн үйлсээр тэнгэрт өөртөө эрдэнэс хураа.

Нэгдүгээр Петр дээр бас итгэдэг эмэгтэйчүүдэд хэрхэн хувцаслахыг зааж өгчээ:

Гоёл чинь үс сүлжилт, алтан эдлэл зүүх, эсвэл хувцаслалт гэх мэт гадна талынх бүү байг. Харин зүрхэнд нуугдсан хүнийг дөлгөөн ба даруу сүнсний мөхөшгүй чанараар гоё. Энэ нь Бурханы өмнө асар үнэтэй болой. Учир нь ийнхүү урьд цагт Бурханд найдвараа тавьсан ариун эмэгтэйчүүд нөхрүүддээ захирагдан өөрсдийгөө гоёдог байв.

(1Петр 3:3–5)

Петр дотоод гоо үзэсгэлэнгээ дартлаа гаднаа бүү гоёорой гэжээ. Тэгээд ариун эмэгтэйн гоо үзэсгэлэнгийн нууцлал нь эелдэг зөөлөн, даруу төлөв сүнснийг хөгжүүлэн бий болгох явдал гэжээ. Энэ гоёлын хамгийн гол чанар нь Бурханд найдах юм. Паул эмэгтэйчүүдийг сайн үйлсээрээ гоё гэсэн бол, Петр үл харагдах эрдэнэс дээр төвлөрөхийг заажээ. Бид сүнсээ эртний ариун эмэгтэй шиг хөгжүүлэх юм бол, нигүүлсэл, магтаалын хувцсыг өмсөх болно. Эдгээр нь хэзээ ч хуучрахгүй, харин цаг хугацаа өнгөрөх тусам улам туяарна.

Ёр муугийн алив хэлбэрийг цээрлэ. (1Тесалоник 5:22)

Бидний хувцас хэзээ ч өдсөн *шинжтэй байх* ёсгүй. Тэгэхээр Бондын охидын хувцас бидэнд зохихгүй нь байна. Уг нь энэ нь тайлбарлалтгүй, тодорхой зүйл боловч, би ойлгомжтой байлгах үүднээс тайлбарлаж хэлье л дээ. Гэдэс, хүйсээ эсвэл гуя хасаа ил гаргах нь цуглаанд, залуусын бүлэгт юмуу амралтанд тун зохисгүй. Түүнчлэн хэт бариу цамц, өмд, даашинз ч бүгдийг хэлээд өгнө. Ийм хувцас өмсөөд явах газар ч ховор. Энэ хувцас нь хамаг анхаарлыг хөх, хүйс, хөл, бөгсөнд татдаг учраас, зохисгүй юм. Бас бусдыг буюу нэн ялангуяа гормондоо жолоодуулдаг, хараа төвтэй эрчүүдийг эвгүй байдалд оруулдаг учраас, хүндэтгэлтэй гэж хэлж болохгүй. Тэгээд мэдээж Бурханы нэрээр нэрлэгддэг хүмүүст бүр ч зохисгүй. Би чамайг хувцасны шүүгээгээ онгойлгоод, Ариун Сүнснээс загварын зөвлөгөө авахыг ятгаж байна. Чи хувцаслаж байхдаа өөрөөсөө: “Энэ зохистой байна уу? Энэ хүндэтгэлтэй байна уу? Миний очих гэж байгаа газарт энэ хувцаслалт зохих уу? Энэ хувцаслалт намайг хүндэтгэж байна уу? Энэ хувцаслалт эрчүүдэд хэрхэн нөлөөлөх бол? Энэ хувцсаар би тэднийг цэвэр байдлыг мөшигхөд нь туслаж байна уу?” гэж асуугаарай.

Дайсан чамайг тайчиж, нүдний зугаа болгож, биеийг чинь арилжихыг хүсдэг ч, тэнгэрийн Аав тань чамайг мөнхийн гоо үзэсгэлэн, хүч, нэр төр, хүндэтгэлээр хувцаслахыг хүсдэг.

~ Дайсан чамайг тайчиж,
нүдний зугаа болгож, биеийг
чинь арилжихыг хүсдэг ч,
тэнгэрийн Аав тань чамайг
мөнхийн гоо үзэсгэлэн,
хүч, нэр төр, хүндэтгэлээр
хувцаслахыг хүсдэг.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,
Намайг Хүүгээрээ хувцаслаач. Би нэр төр, хүч, хүндэтгэлээр
хувцасламаар байна. Надад энэ дэлхийн татлагаар биш, харин
тэнгэрийн зорилгоор хувцаслах цэц ухаан хайрлаач. Ил гарсан
ичгүүр, нүцгэн байдлыг минь хучаач. Би амлалтын эрх чөлөөт охин
байхыг хүснэ. Би сексийн түрэмгийлэл, уруу татлагын дүр төрхийн
бугуйлыг тасар татаж, хүчингүй болгож байна. Бүсгүй хүний
нууцлалын нандин байдал, гоо үзэсгэлэнг минь сэргээгээч. Би нүцгэн,
шившигтэй байхыг хүсэхгүй байна. Би гэрэл дор эрх чөлөөтэй бүждэг
эмэгтэй баймаар байна.*

Таны хайрт охиноос.

14 *Харуусалгүй амьдрах юмсан*

Харуусалгүй амьдрахын тулд чи ирээдүйгээ харж, зорилготой амьдрах ёстой. Чи ямар ч мөрөөдөл, зорих газаргүйгээр хүссэн газраа оччихно гэж байхгүй. Бид хүсээгүй унаагаараа хүсээгүй газраа хүрэх нь даанч их. Бид бохир ор дэр дотроо “*Би яаж яваад ийм байдалд хурчихэв ээ?*” хэмээн гашуунаар харуусан хэвтдэг. Харуусал бол аймшигтай газар бөгөөд тийшээ хүрэх зам ч биднээс хамаг амьдрал, хүчийг маань сордог. Тиймээс л Библи биднийг энэ аймшгаас сэргийлэх үүднээс маш олон зөвлөгөө хэлдэг бөгөөд энэ цэц ухааныг бид тус бүлгийнхээ сүүлээр сурна.

Чи ямар ч мөрөөдөл, зорих газаргүйгээр хүссэн газраа оччихно гэж байхгүй.

Харуусал нь далд зовиурыг авчрах ер бусын хүчин чадалтай зүйл. Харуусал зүрхийг чинь цөхрөлийн төмөр утсаар хэгэн, хоосролын ёроолгүй гүнд живүүлдэг. Хүүхэд байхдаа бид харуусал, үр дагавар гэдгийг мэддэггүй байж. Хүүхэд нас бол хөнгөхөн үе. Зүгээр л “*Би үүнийг хийх юм бол... түүнийг алдана*” гэдэг л ойлголттой. Хүүхдэд зөв, ухаалаг, шийдвэр гаргахад нь туслахын тулд бүхний учир шалтгааныг тодорхой тайлбарлаж өгөх шаардлагатай. Бүх зүйлийг тодорхой ойлгуулсны дараа хүүхэд хийх сонголтынхоо арыг дааж чадна гэж үзсэн тохиолдолдоо л муу сонголт хийнэ. Харамсалтай нь бид дандаа л дааж чадна гэж эндүүрдэг.

Намайг тавтай байхад, том хүнтэй хөтлөлцөлгүйгээр зам хөдлөн гарч болохгүй гэж сургасан байлаа. Ээж маань надад энэ зааврыг ягштал баримтлах нь яагаад чухал болохыг тодорхой тайлбарлаж өгсөн ч, би хөтлүүлэхээсээ ичдэг байв. Манайх маш их хөл хөдөлгөөнтэй гудманд аж төрдөг байсан учраас, машин намайг дорхноо гамбир болгож чадах байлаа. Бусад жаалууд хоёр тийшээ харж байгаад л гүйчихдэг байхад, би

заавал том хүнээр хөтлүүлж гарна.

Нэг өдөр би замын нөгөө талд амьдардаг Женниферийн гэрт очиж тоглохыг маш их хүссэн болохоор, ээж намайг хөтлөсөөр тэднийд хүргэж өгөв. Би хаалга тогшихдоо, дотроос аальгүй хөхрөлдөөн сонсоод, намайг ээжээрээ хүргүүллээ гэж шоолж байгааг нь шууд мэдэв. Би ээждээ баяртай гэж даллачихаад, хэдэн цаг шавайгаа ханатал тоглолоо. Тэгээд гэртээ харих болоход, Женниферийн ээж нь том охиноороо намайг хүргүүлэх гэсэн боловч, би эрс татгалзав! Би тэр эгчид өөрөө зам гарах хэмжээнд хүрсэн том хүн гэдгээ мэдүүлээд, ээж намайг өөрөө хүрээд ирж болно гэсэн хэмээн худлаа яриу. Би зам руу цээжээ түрэн, зоригтой алхласан боловч, дотроо айж байлаа. Би үүнийг үл тоосоор, хоёр тийшээгээ харж байгаад, замаар амжилттай гүйж гарав. Тэгэхдээ шууд гэрийнхээ урдуур зам гарч болохгүй гэдгээ сайн мэдэж байсан болохоор, зам гарсан хойноо замын хажуугийн моддын ардуур нуугдсаар, үүдэн дээрээ бушуухан хүрч ирэв. Тэгээд яг ээжийгээ харилцуураа тавьж байхад нь орж ирээд:

“Ээж ээ, би ирчихлээ!” гэж хэлчихээд, өрөө рүүгээ сүнгэнэв.

Гэтэл ээж намайг зогсоогоод: “Хөөе Лиза, нааш ир ээ! Ээж нь юм асууя. Чамайг хэн хүргэж өгсөн?” гэлээ.

Дотор пал хийгээд л явчихлаа. Би зам гатласан хэсэг маань цонхоор харагдаж байгаа эсэхийг нягтлан, хойшоо нэг харснаа: “Синди!” гэв.

– “Нээрэн үү?” хэмээн ээж ч лавшруулан байцаалаа.

Би дахиж худлаа хэлмээргүй байсандаа, толгой дохив.

Ээж: “Би хатагтай Хофман руу утасдаад, асуух уу?” гэлээ.

Би ч: “Болохгүй!” гэсэн шиг толгойгоо хүчтэй сэгсрэв.

Тэгтэл ээж маань хатагтай Хофман намайг гэр рүүгээ ганцаараа яваад өгсөн гэж хэлснийг надад мэдэгдэв. Би баригджээ. Би дуулгаваргүй аашлаад зогсохгүй, дээрээс нь худлаа ярьсан. Тэгээд аавыг иртэл өрөөндөө хоригдов.

Өрөөнд хоригдоно гэдэг нь орон дээрээ хэвтэж, тоглоомоороо тоглож болохгүй гэсэн үг. Би суух тусам, хонго өвтгөдөг модон сандал дээр сууж байх ёстой байлаа. Бас аавыг ирэхээс айж байв. Машин дуугарах болгонд дотор минь пал пал хийнэ. Аав удахгүй ирээд, намайг болгож өгнө. Ийнхүү сууж байхдаа, элдвийг төсөөлнө. Магадгүй онжгон дээрээ алгадуулах байх. Эсвэл намайг замаар ганцаараа гарах насанд хүрсэн хэмээн өмөөрөх байх. Тийнхүү элдвийг бодоод л, хүлээгээд л сууна.

Тэгж байтал аав ирэв. Ер нь аавыг ирэхэд, би өөдөөс нь угтаж гардаг болохоор, би гарч ирэхгүй байгаа нь хоёр шалтгаантай байна: нэг бол би гэртээ байхгүй эсвэл хэрэг тарьсан. Тэгээд аав, ээж хоёр нам дуугаар дүнгэнэлдэх нь сонсогдоно. Тэд миний гэмт хэргийн талаар ярьж байгааг

би мэдэж байлаа. Дотор хачин болж, яг л өвдөх гэж байгаа юм шиг санагдав. Тэгээд корридорoor хөлийн чимээ гарна. Хаалга онгойход... цаана нь аавын маань ноцтой царай... .

– “Лиза, гараад ир. Чамтай ярина аа.”

Би нулимсаа шудраад, аавынхаа араас яг л нядлуулах гэж байгаа хурга шиг дагалаа. Шүүх хурал том өрөөнд болов. Би ногоон сандал дээрээ шомбойж, аав, ээж хоёр цагаан буйдан дээр өөдөөс харан сууна. Тэд надад лекц уншсан ч, “*Намайг зодох болов уу?*” гэсэн бодол маань чихэнд дүнгэнээд, аав, ээжийн яриа сонсогдохгүй байв.

Тэгтэл аавын “Чи зам гарч болохгүй гэсээр байтал, үгэнд оролгүй, худлаа ярьсан уу?” гэсэн үг намайг буцааж сэрээв.

Би ч: “Тийн!” гэж хариулаад, шүүгч нар намайг өршөөх болов уу хэмээн горьдсондоо, асгарчихлаа. Харамсалтай нь шийдвэр хэдийн гарчээ.

– “Чи намайг яахыг мэдэж байгаа, тийм үү?” гэж аав асуув.

Би: “Тийн” гэж хариулахдаа, өнгөрчээ гэдгийг мэдлээ.

Аав: “Нааш ир” хэмээн толгойгоороо дохив.

Би энэ уудам өрөөг туулсаар, аав дээрээ очно гэсэн үг. Өрөөний талд очоод, хаалгаар гарч зугтах санаа төрсөн ч, дахиад цаашаа нэг гишгэхдээ, буцах гарцгүй болсноо ойлгов. Би явсхийсээр аав дээрээ очоод, өвдгөн дээгүүр нь тонгойгоод... бай бай хийлгүүлэв.

Аав намайг өвөр дээрээ суулгаж, харин ээж надад ямар их итгэдгээ хэллээ. Ээж надад дахиж итгэхийг хүсч байгаа бөгөөд бас итгэсээр байна гэв. Хэвлийд зангирсан айдас арилж, би аав, ээжийн цэвэрлэгдэж, хайрлагдсан охин болжээ. Би дахиж энэ хэргийн талаар сонсохгүй. Дараагийн удаа би зам хөндлөн гарахдаа айдас ч, ичгүүр ч мэдэрсэнгүй.

Би буруу хэргийнхээ төлөө шийтгүүлснээ ухаарав. Амьдрал ийм амар байдаг бол, сайхан аа.

~ Би буруу хэргийнхээ
төлөө шийтгүүлснээ
ухаарав. Амьдрал ийм амар
байдаг бол, сайхан аа.

Гэтэл харуусал үүнээс гүн явж, үр дагавраас ч урт удаан хоногшдог. Харуусал орой руу ортлоо амьдралд маань цуурайтсаар л байдаг. Залуу хүүхдүүдийн хувьд харуусал богино настай бөгөөд нэгээхэн эгшинд төрөөд л, мартагддаг: “*Би ингэж хэлэх, хийх хэрэггүй байж...* .” Гэтэл насанд хүрсэн хүмүүсийн хувьд аав, ээж нь мөрдөн байцааж, авраад байхгүй учраас, харуусал нь тэс өөр авиртай байдаг. Хүн залуу байхдаа нууц ажиллагаа явуулах тал дээрээ мэргэшиж, хийсэн хэргээ нуун дарагдуулахдаа гаршдаг. Тэгээд “*Мэдэхгүй зүйл хэнийг ч өвтгөхгүй*” гэж бодно. Бидний нууцыг хэн ч олж мэдэхгүй гэдэгт бид мунхаглан итгэжээ.

Гэтэл тэнд харууслын үр унаж амжаад, залуу насны маань хөрсөнд соёлон ургасаар байдгийг бид ухаардаггүй. Тэгээд бидний өнгөрсөн амьдралыг сүүдэрлэх нас биед хүрсэн ургамал болтлоо боловсроод, хамгийн эгзэгтэй үед ил гарч ирнэ.

Харууслын зовиуртай атгыг хүмүүс сайн мэднэ. Энэ нь бидний бугуйнаас атгаад, эргэн тойрны хүмүүст алдааг минь зарлах хүртлээ тавихгүй: “Чи нөгөө яаснаа санаж байна уу?” Тэгээд бидний өөрөөсөө олон жил хөнжил дороо нууж, сүүдэрт дарж байсан зүйлийг яг өчигдөр болсон юм шиг гэрэлд барин, хүн бүхэнд харуулна. Тэр үед бүлээн зүрх минь “Үүнийг хийгээгүй байсан бол!” хэмээн халаглана.

Харуусал нь мөн бидний алдааг мөшгидөг. Өчигдөр нууцаар хэлсэн

юмуу хийсэн зүйл өнөөдөр гэнэт гэрэлд гардаг. Бодлогогүй үг, тоомжиргүй үйлс нь эргээд бодох тусам, улам л хатууран, хүчирхэгжиж, хүндэрнэ. Өнөөдөр эргээд харахад, өчигдрийнхөөс хавьгүй хатуу

~ Бид үг, үйлдлээ жинлэлгүй амьдарсан хойноо харуусдаг.

сонсогдож, харгис санагдана. Бид: “*Би тэгье гэж бодоогүй. Та нар ойлгохгүй байна. Би тэр үед өөр байсан*” хэмээн биеэ өмөөрөх гэж оролддог. Бид үг, үйлдлээ жинлэлгүй амьдарсан хойноо харуусдаг.

Би харуусал гэж юу байдгийг мэддэг хүнийхээ хувьд үүнийг чамд хэзээ ч хүсэхгүй. Би өчигдөр мунхаг зөвлөгөө дагасан учраас, өнөөдөр шаналж үзсэн. Би одоо чамд зааж байгаа зүйлдээ итгэдэггүй байлаа. Би залуу байхдаа үр дагавар гэж юм байдгийг мэддэггүй байсан бөгөөд харанхуйн дор үйлдэж байгаа зүйлс хожим надад тэгтэл нөлөөлөх юм чинээ санаагүй юм. Найзын чинь хувьд, би чамайг миний явсан тэр замаар яваасай гэж хүсэхгүй. Үе үеийн хүмүүс үнэнийг ярьж, удаах үеийнхэндээ анхааруулах маягаар алдаагаа засах завшаантай гэдэгт би итгэдэг. Ирээдүйн ээжүүд болох охид сургамж сургаалаа удаах үедээ дамжуулах боломжтой бөгөөд хариуд нь охид нь илүү өндөрт гарч, тодорхой харж, ээжийнхээ сэргийлж чадаагүй нүхийг тойрч чадах юм. Энэ нь бид бусдад сургамж болгохын тулд өнгөрсний алдаагаа өнөөдөр ил гаргах хэрэгтэй гэсэн үг.

Энэ бол сексийн тал дээр харууслыг үзсэн эмэгтэйчүүдийн хувьд бусдыгаа тэр замаар явуулахгүйн тулд харанхуй замыг нь гэрэлтүүлж өгөөрэй гэсэн урилга юм. Энэ нь тэр бүтэхгүй замаар явах санаатай хүмүүст хандсан анхааруулга юм: “*Үүгээр битгий яваарай! Үүгээр явсан хүн өндөр төлөөс төлөхөөс гадна цаг хугацаа өнгөрөх тусам, хүү нь улам өссөөр байна!*” Энэ нь гэрэл, ерөөл, дуулгавартай байдлын замыг сонгосон хүмүүсийг улам бүр хамгаалж, шийдвэрийг нь бэхжүүлнэ. Нууц гэж байдаггүйг зарим чинь мэдэж байгаа.

Илчлэгдэхгүй байхаар халхлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. (Лук 8:17)

Огт үгүй гэдэг үгийг харж байна уу? Бид иймэрхүү эшлэлийг уншихаараа, өөрсдийгөө илүү ухаантай гэж сэтгэдэг юмуу эсвэл эдгээр үг нь бидэнд хамаагүй гэж боддог юмуу – утгыг нь ойшоодоггүй. Бид Библи уншихдаа, Бурхан биднийг шившиг болгохгүй байх гэсэндээ алгасчихдаг.

Тийм боловч биднийг нууцаар шившиг үйлдэх үед Бурхан биднийг шившиг болгодоггүй, бид өөрөө өөрсдийгөө шившиг болгодог. Яг л нууцаар үр суулгасан атлаа ургамал нь гараад ирэхээр Бурханд уурлахтай л адил юм. Магадгүй бид өөрсдийгөө зарим зүйлийг тас нууж чаддаг бөгөөд энэ эшлэл нь бидний нөхцөлд хэрэгжихгүй гэж боддог болтой. Гэхдээ Бичээс *огт үгүй* гэсэн л бол, үүнээс хэн ч мултрахгүй л гэсэн үг. Нууцлагдсан, дарагдсан болгон нь малтлагаар гэрэлд ил гарах л болно.

~ Биднийг нууцаар шившиг үйлдэх үед Бурхан биднийг шившиг болгодоггүй, бид өөрөө өөрсдийгөө шившиг болгодог.

Тиймээс л бид зан авираа үнэхээр анхаарах ёстой юм. Ефес ном үүнийг “*хянамгай бай*” гэсэн.

Харин бүх зүйл гэрлээр илчлэгдэхдээ харагддаг. Учир нь харагддаг аливаа зүйл нь гэрэл юм. Тиймд “Нойрсогч оо, сэр. Үхэгсдээс бос. Христ чиний дээр гэрэлтэх болно” гэдэг. Тиймээс та нар мэргэн бусчууд шиг биш, мэргэн хүмүүсийн ёсоор, хэрхэн алхаж буйгаа *хянаж бай*. (Ефес 5:13–15, тодруулгыг нэмэв)

Хянамгай байх гэдэг нь бидний амьдрал тэр чигээрээ нэг л цул зүйл бөгөөд өнгөрсний маань үйл явдал ирээдүйд ил гарах цаг ирнэ гэдгийг хэзээ ч марталгүй амьдрах гэсэн үг юм. Хянамгай байх гэдэг нь хараа хяналттай байх (тойрох юмуу бүслүүрдэх, ямар нэг зүйлийг нарийн ажиглан шинжих) гэсэн үг. Ийнхүү бид шийдвэр, үйлдэл, үзэл бодол болгоноо өнцөг бүрээс жинлэх хэрэгтэй. Бид ямар нэгэн шийдвэрт бүрэн зориулагдахаасаа өмнө үүнийгээ бүслүүрдэн тойрч, өрөө болгоныг нь шалгаж, өнцөг бүрээсээ яг л бидний хүссэн, таалсан хэмжээнд байгаа гэдгийг баталгаажуулах хэрэгтэй. Гэтэл ихэнх маань ингэдэггүй.

Би Колорадо руу нүүхдээ том өрөөндөө буйдан авсан юм. Тэгээд нэг буйдан маш их таалагдав. *Төгс буйдан!* Тэр буйдан тавилгын дэлгүүрийн хананы өмнө гоёл чимэглэлийн дунд ёстой л дурайж байв. Гэтэл манайд тэр буйдан хананы өмнө биш, өрөөний голд тавигдана. Тэгээд тэр буйданг

татаад, арыг нь харахдаа манай гэрт огт таарахгүй болохыг нь ойлгов. Би тэр буйданг урдаас нь л хараад, гэртээ авчраад, дээр нь суухдаа, буйдандаа дурлаж, мундаг сонголт хийсэндээ өөртөө баяр хүргэж болно. Гэхдээ гал тогооныхоо өрөө рүү орчихоод буцаж гарахдаа, буйдангийнхаа арыг хараад тэр бүх баяр төгсөх байв.

Ихэнх хүмүүс юмсын нүүрэн талыг л хардаг. Бид тухайн зүйлийн үзэмж, өгч байгаа мэдрэмжинд нь дурлахдаа, бусдад: *“Ийм сайхан эдийг би эдлэхгүй бол, хэн эдлэх билээ... Би авлаа!”* гэдэг. Тэгээд бүр сүүлд нь л арыг нь шалгаад, ичгүүрт орно.

Би залуу байхдаа, хүссэн бүхнээ зоригтой хийх хэрэгтэй гэж боддог байлаа. “Тэгээд ч би чинь насанд хүрсэн, санал өгөх эрхтэй, жолоо барих эрхтэй, мэргэжлээ сонгох эрхтэй коллежийн охин... намайг адал явдлаар дүүрэн амьдрал уриалан дуудаж байна!” Гэтэл хорин жилийн дараа хоёр том хүү маань надаас “Ээж ээ, та аавтай гэрлэхдээ онгон байсан, тийм ээ?” гэж чин сэтгэлээсээ асуухад, тийм аймшигтай шившиг мэдрэх юм чинээ санаагүй билээ. Тэдний энхрий хонгор дуу хоолой намайг яллаагүй, харин чин зүрхнээсээ итгэж явдаг ээжийнхээ чанарт баталгаа хайсан боловч, би үүнийг нь няцаах болоод байв.

Коллежд дур хүсэлдээ шатаж явахдаа би надад ийм асуулт ирнэ гэж зүүдлээ ч үгүй билээ. Хэрэв би тэр үед ухаантай байгаад, ирээдүйгээ бодсон бол, тэр сексийн тэмцээнд оролцох бардам зангаа татах байсан юм. Гэхдээ хөвгүүдийгээ асуух үед би бардамнахтай манатай л болов. Би яахаа мэдсэнгүй. Би гэрлэсэн өдрөө онгон байсан гэж худлаа ярьж болно эсвэл та нарт хамаагүй гэх мэтээр асуултаас зайлж болно. Эсвэл Христэд итгэдэг хүмүүсийн сонгодог хариултыг хэлж болох байв: “Ээж нь тэр үед Христэд итгэдэггүй байсан учраас, үүнээс өөрийг мэддэггүй байсан юм аа.” Эсвэл би үнэнийг үнэнээр нь хэлж болох байв. Би гүн амьсгаа аваад: “Үгүй ээ, ээж нь байгаагүй. Үүндээ ч насаараа харуусч явна. Гэхдээ та хоёр надаас өөрөөр амьдарна гэж итгэж байна” гэж хариулсан юм.

Үнэнээс өөр зүйл нь хүүхдүүдийн маань цэвэр амьдрах чадвар, хүчийг устгах байв. Үнэн эрх чөлөөг, харин ичгүүр худлыг үржүүлдэг. Чи нарийн шириийнийг нь ярилгүйгээр үнэнийг илчлэх боломжтой.

~ Үнэнээс өөр зүйл нь хүүхдүүдийн маань цэвэр амьдрах чадвар, хүчийг устгах байв.

Яг одоо чи: *“Би уучлагдсан, шинэ бүтээл. Хуучин нь өнгөрч, миний хувьд бүх зүйл шинэ болсон”* гэж маргаж болох. Мэдээж энэ бол Бурханы Үгийн үнэн. Би уучлагдсан гэдэгтээ итгэдэг. Нүглээ илчлэхэд,

бүх нүгэл угаагдсан гэдэгт ч итгэдэг. Би өөрийгөө шинэ болж, Христийн яндашгүй нигүүлслийг хүртсэн гэдэгтээ ч итгэдэг. Гэхдээ урьд өмнө

хийсэн сонголтын маань бүх дайвар бүтээгдэхүүн хар аяндаа устчихгүй. Би шүүгдээгүй бас ялгүй болсон боловч, хийсэн юмсын маань үр дагавар үлддэг. Хүүхдүүд маань ваар хагалсан бол, би хүүхдүүдээ уучилна. Гэхдээ тэглээ гээд ваар бүтэн болохгүй.

Маргаанаа лавшруулахгүйн тулд бүгдээрээ дараах нөхцлийг төсөөлөн бодож үзье. Хэрэв би тэгж явж байгаад жирэмсэн болчихсон бол, яана? Магадгүй ухаарах байсан байх. Тэгээд жирэмсэн байхдаа, итгэсэн бол, яах уу? Би Христийн хайр, өршөөлийг хүртсэн ч, хүүхэд маань алга болохгүй. Хүүхэд бий болсон нь миний нүглийн өршөөлийг няцаахгүй, миний нүглийн өршөөл ч хүүхдийг няцаахгүй. Миний хийсэн сонголтын дайвар бүтээгдэхүүний үр жимс ургахдаа л ургана. Хэдийгээр тэр хүүхэд гэрлэлтээс гадуур олдсон ч, би тэр хүүхдийг баяртайгаар хүлээн авна.

Тэгтэл одоо амьдралын жинхэнэ жишээ хэлье. Би гэрлэснийхээ дараа нэгэн гоо сайхны бүтээгдэхүүний суртчилгааны төлөөлөгчөөр ажилладаг байлаа. Тэр компани Далласт гурван төлөөлөгчийн газартай, Хьюстонд гурван төлөөлөгчийн газартай байв. Бидэн дунд Христэд итгэдэг хэд хэдэн хүн байсан учраас, бид хамтдаа аялж, хоолон дээрээ нөхөрлөх тун дуртай байв.

Гэтэл бидний дунд ажилладаг нэгэн царайлаг, ганц бие, итгэгч бүсгүй байнга өвчин тусч, өвдөж хавдаж явдаг байв. Тиймээс би түүнийг үүнээсээ болоод ажлаасаа халагдчих вий гэж зовнидог байлаа.

Нэг удаа суртчилгааны үеэр би түүнээс өөрийнх нь төлөө залбирч болох эсэхийг асуув. Би түүнийг ингэсээр байгаад бүр цөхрөх вий хэмээн айж, ядаж л залбирлаараа тус болохыг хүссэн юм. Түүнд бүх юм байв: чуулган, компанийн машин, сайн цалин, тэтгэмж, зугаатай аялал. Тийм боловч тэрбээр аз жаргалтай байсангүй. Түүнээс учрыг нь асуутал, тэр надад сэтгэлээ нээсэн юм.

– “Чи гэр бүлтэй болохоороо над шиг ганц бие хүнийг ойлгохгүй. Дандаа ганцаараа байна гэж юу болохыг чи мэдэхгүй.”

Би түүнийг гомдол гаргахаа больж, байгаа зүйлдээ талархан, цуглаандаа гар бие оролцохыг урамшуулав.

– “Бүтэхгүй юм билээ. Би оролдож үзсэн. Би маш их аялдаг. Тиймээс хариад, амралтын өдрөөрөө биеэ тэнхрүүлээд л таардаг.”

Ер нь намайг юу ч зөвлөсөн, тэр бүсгүй яаж ийж байгаад л няцааж байв. Цаг орой болсон боловч, би түүний төлөө залбирч ч амжаагүй байлаа. Сүүлдээ би өөрөө тэр бүсгүйг дагаад итгэл найдвараа алдаж эхлэв.

Тиймээс би: “Юу ч гэсэн... хоёулаа эхлээд залбирья” гэж хэллээ.

Бид хоёр гараа барин залбирч эхлэсэн боловч, би түүний залбирлыг сонссонгүй. Би тэр хооронд тэс өөр зүйл үзэв. Ариун Сүнс надад маш

муухай дүр зураг харуулав. Би залбирлынхаа үеэр энэ талаар хэлсэн бол, нөгөө бүсгүй хэлэх үггүй болох байлаа.

Тиймээс би боломж нь таарахаар хэлнэ гэдгээ Бурханд амлалаа. Үзэгдэл бүдгэрсээр, нөгөө бүсгүйн залбирал чихэнд тодрон орж ирэв. Тэрбээр Бурханд хандан: “Намайг уучлаач, намайг уучлаач!” хэмээн үглэн уйлж байлаа.

Би түүнд: “Тэр уучилсан!” гэж хэлэв.

Гэтэл тэрбээр: “Үгүй, уучлаагүй. Би уучлал гуйдаг ч, Тэр уучилдаггүй” хэмээн эсэргүүцлээ.

Би нүдээ нээгээд, бүсгүйн гарыг атгаад, нүд рүү нь харлаа.

– “Бурхан яагаад чамайг уучлаагүй гэж бодоод байгааг чинь би мэднэ.”

– “Чи мэдэхгүй. Тэр намайг уучлаагүйг би мэднэ.”

Би гүнзгий амьсгаа аваад: “Бурхан чамайг бэлгийн замын халдварт өвчнөөс эдгээгээгүй учраас, чи Түүнийг чамайг уучлаагүй гэж бодож байна” гэлээ.

Тэр цочсоноо: “Чи яаж мэдсэн юм?” гэж асуув.

– “Би мэдээгүй. Бурхан надад харуулсан. Тэр чамд маш их хайртайгаа хэлсэн. Эдгээгүй гэдэг чинь уучлагдаагүй гэсэн үг биш.”

Тэгээд бүсгүй надад эмгэнэлт түүхээ дэлгэхэд бүх зүйл тодорхой болж эхлэв. Тэрбээр бүх насаараа Христэд итгэгч байсан боловч, болохгүй гэдгийг нь мэдсээр байж, нэгэн үдэшлэгт оччихжээ. Тэгээд хөндий хүйтэн уур амьсгалд нүүр хагарах гэсэндээ ууж эхлэсэн юмсанж. Гэтэл нэгэн аятайхан залуу түүний энэ сандарсан байдлыг анзаараад, танилцан, яриа дэлгэж, хөөрхөн байна хэмээн магтжээ. Нэг мэдэхнээ, тэр хоёр хоёулханаа үлдэж... тэгээд дараа нь юу болсон нь тодорхой. Бүсгүй үнэхээр биеэ барьж дийлээгүй ажээ. Хоёулханаа байгаа, халамцуу эр, эм хоёр хагас нүцгэн үедээ биеэ хянан захирах боломжгүй байдгийг тэрбээр мэдээгүй аж. Бүсгүй хориглосон боловч, залуу сонсоогүй бөгөөд түүнийг зогсоох ч хүн байсангүй. Тэр орой бүсгүй охин биеэ алдаж, бэлгийн замын халдварт өвчин авчээ. Тэр явдлаас хойш олон жил өнгөрсөн ч, ял, шившиг нь арилсангүй.

– “Би анх унтаад л халдвар авсан! Гэтэл манай найзууд хаа хамаагүй явалдаж л байдаг – яадаг ч үгүй. Одоо ихэнх нь гэрлэсэн” хэмээн бүсгүй асгаруулан өгүүлэв.

– “Бурхан чамайг яллах гэсэндээ надад харуулаагүй. Бурхан чиний уйлааныг сонсож, зовлонг харж, уучилсан гэдгээ мэдүүлэх гэж л харуулсан. Үгүй бол, юу гэж намайг чам руу явуулж, энэ бүхнийг илчлэх билээ?” хэмээн би ч итгэлтэй хэллээ.

Тэр орой бүсгүй Бурханд уурласан уураа орхиж, уучлагдсан юм.

Тэрбээр харуусал дор дэндүү удаан амьдарсандаа, Бурханыг буруутгажээ. Өмнө нь тэр явдлыг дурсах бүрийдээ, Бурхан түүнийг хийсэн нүглээс нь болж яллаж байна гэж боддог байсан юмсанж. Харин тэр орой бүсгүй ялаас чөлөөлөгдөж, сүнс, сэтгэл, биеэр эдгэрэв.

Энэ бол олон жилийн өмнө болсон явдал. Би түүнтэй уулзалгүй хориод жил өнгөрчээ. Би түүнийг биеэр эдгэрсэн үгүйг мэдэхгүй. Гэхдээ зүрхнийх нь эдгэрэл тэр орой эхлэснийг мэднэ. Бурхан түүний биеийг эдгээж чадна гэдэгт би итгэдэг үү гэж үү? Тийм ээ, Бурханд боломжгүй зүйл үгүй. Гэхдээ Бурхан хамгаас түрүүнд шархтай зүрхэнд анхаардаг юм.

Тэгвэл одоо өөр нэгэн ганцаардсан бүсгүйн түүхийг үзье. Тэрбээр салхитай эргийн зах дээр сууна. Түүний бараан үс салхины аясаар байн байн нүүр рүү нь орж, тэрбээр нулимстай нүдийг нь шавхуурдах үсээ чихнийхээ хойгуур байн байн оруулна. Бүсгүй сонголтынхоо үр дагаврыг хорин хоёрхон насандаа амсчээ. Тэрбээр Бурхан өршөөнгүй гэдгийг мэдэх боловч, нөгөөтэйгүүр үйлдсэн нүгэл нь дэндүү том хэмээн айна. Өнөөдөр тэрбээр далайн гүнд нуучихсан гэж бодож явсан тэр зүйлийнхээ төлөө хариулах ёстой ажээ.

Бүсгүй орой болсныг мэдээд, сүүлийн удаа цөхөрсөн залбирлаа хэлээд, босов. Машин руугаа явахдаа, зоригтой бөгөөд шударга байхаа өөртөө амлав. Өнөөдөр тэрбээр хайртай хүнтэйгээ уулзана. Тэр залуу түүнтэй гэрлэх хүсэлтэй. Гэхдээ үүнээс өмнө тэрбээр залуудаа үнэнээ хэлэх ёстой. Залуу нь биеэ ирээдүйн эхнэртээ хадгалсан хүн учраас, үнэнийг мэдээд яаж гонсойхыг нь төсөөлж ядна. Тэр залуу түүнээс хавьгүй дээр бүсгүйтэй учрах хувьтай хүн. Тиймээс өнөө орой бүсгүй залуудаа хамаг үнэнээ хэлнэ.

Бүсгүй ганц өрөө хөндий хоосон байрандаа ирээд, усанд ороод, оройн уулзалтдаа бэлтгэв. Өмнөх орой нь залуутайгаа болзоогоо тохирохдоо, ямар нэг газар очилгүй, зүгээр л гадуур салхилъя гэжээ. Бүсгүй залуудаа үнэнээ хэлэхдээ, хүмүүсийн нүд, чихнээс хол байхыг хүсчээ.

Залуугийнх нь байр хэдэн байшингийн цаана байрших бөгөөд бүсгүй залуутайгаа зугаалахаасаа өмнө хэсэг ганцаараа алхахыг хүсэв. Тэрбээр салхины өөдөөс гунигт үнэнээ чангаар давтаад, хэлэх бүрийдээ чичирч байлаа. Нэг л мэдэхнээ залуугийнхаа байрны үүдэнд ирчихсэн байв.

Хаалгыг нь алгуурхан тогшиход, хамгийн сүүлийн удаа ирж байгаа ч байж мэднэ хэмээн бодогдоно. Дотроос ороорой гэсэн дуу гараад, түүний өмнө өдий наслахдаа учирсан хамгийн найз нь зогсож байв. Залуу нь бүсгүйгээ тавгүй байгааг мэдрээд, тэврэх гэсэн боловч, бүсгүй нь гараараа хаагаад зайгаа авлаа. Тэврүүлчихбэл, үнэнээ хэлж чадахгүй байх.

Бүсгүй: “Өрөөний чинь залуу хаачаав?” хэмээн сандрангуй асуулаа.

– “Хөвгүүдтэй хамт гарсан... чи зүгээр үү?”

– “Зүгээр биш ээ, ярьсны дараа дээрдэх байх.”

– “За, тэгвэл би гутлаа өмсөөд, хоёулаа гарах уу? Гэхдээ эхлээд би чамд нэг Бичээс уншиж өгмөөр байна. Чамд зориулсан үг юм шиг.”

Бүсгүй нь даруухнаар толгой дохисон боловч, залуугаа Библиэ эргүүлж байхад нь чичирч байлаа. Бурхан түүнд юу л хэлэв гэж дээ? Өнөөдөр өдөржин Бурхан руу хашхирахдаа, өөрийнхөө бодлоос өөр ямар ч хариу сонсоогүй шүү дээ. Дандаа л ялласан дуу хоолой. Тийм байхад Бурхан одоо түүнд юу л хэлэв гэж?

– “Энэ! Жаахан сонин санагдаж магадгүй шүү. Чамайг гомдохгүй гэж найдаж байна.”

– “За хэл, хэл!”

– “Чи энэ эшлэлийг мэднэ л дээ: “Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!” (2Коринт 5:17) Энэ жаахан хачин гэдгийг би мэдэж байна л даа. Гэхдээ Бурхан хуучин зүйлсийг шинэ болгож, чамайг... онгон бүсгүй шиг болгосон гэж хэлж байгаа юм шиг санагдсан.”

Бүсгүйн ээрээд, мэлмэрээд л явчихав: “Гэхдээ би онгон биш шүү дээ. Чамд үүнийг л хэлэх гэсэн юм.”

Залуу нь түүний өмнө зогсоод, чичирч байгаа мөрөн дээр нь гараа тавиад: “Гэхдээ Бурхан чамайг онгон гэсэн бол, чи Түүнтэй маргах хэн билээ?” гэж хэлэв.

Бүсгүй нь итгэж ядан толгой сэгсрээд, асгарав. Залуу нь бүсгүйгээ цээжиндээ наагаад, шуурга намжиж, бүсгүй нь өөрийгөө дахин цэвэр болсон гэж мэдрэх хүртэл нь хүлээв.

– “Хоёулаа гарах уу?”

– “Баярлалаа!”

Манай хоёр тэр шөнө олон цаг зугаалан, тэднийг салгахаар заналхийлж байсан тэр шившигтэй нууц дээр нар жаргахыг хамтдаа харав. Бурханы өршөөл мөнхөд оршино. Энэ явдал бараг хориод жилийн өмнө болсон бөгөөд тэр цагаас хойш Жон, бид хоёр хамт байна.

Тиймээс л би чамайг өнгөрснийхөө хий үзэгдэлтэй над шиг бүү зөрчилдөөсэй гэж хүснэ. Зарим чинь минийх шиг л замыг туулсан байх.

Шуургатай тулж, үнэн рүү эргэх цаг болжээ. Гэмшин нүглээсээ эргэж, зүрхээ үйрүүлээд, үйрмэгийг нь Ханхүүдээ барих цаг иржээ. Тэрбээр гадуурхагдсан, гологдмол эмэгтэйчүүдэд өршөөнгүй, зөөлөн ханддаг.

Би чамд охиндоо бичсэн нэгэн ээжийн

~ Гэмшин нүглээсээ эргэж, зүрхээ үйрүүлээд, үйрмэгийг нь Ханхүүдээ барих цаг иржээ.

захидлаас толилуулмаар байна. Учир нь би чамайг сексийн цэвэр байдлын гоо үзэсгэлэнг харуусалгүй хараасай гэж хүсч байна.

Биеэ Бурханы цэвэр нандин охин мэт хадгалах хүслийг чинь энэ үнэн бадраах болтугай. . . . Ээж нь аавтай нь ойртохдоо, дэндүү жаргалтай байдаг маань ичгүүрийг мэддэггүй учраас л тэр юм. Яагаад гэвэл ээж нь охин байхдаа чиглүүлэг авч, цэвэр байхын үнэ цэнийг ойлгосон юм. Энэ бол үнэт эрдэнэ гэдгийг ээж нь мэддэг байлаа. Бурхан надад сүйн хугацаандаа өөрийнхөө биеийг цэвэр хадгалахад туслаж бас миний цэвэр байдлыг хүндэтгэдэг эр хүнийг заяасан билээ. Аав, ээж хоёр нь анх ойртох үед унтлагын өрөөний ханан дээр өлгөөтэй хуримын даашинз маань бидний цэвэр байдлын билэгдэл болсон юм. Тэр цэвэр байдал өнөөдөр ч амьдарсаар байна. Эрх чөлөөтэй эдлэх хувьтай энэ блэгийнхээ төлөө Бурхандаа талархъя.

Энэ ээжийн үг ямар ч харуусалгүй, дан баяр хөөр ажээ. Би чамд үүнийг л хүсч байна. Чи нүгэл үйлдсэн бол, энэ сүүдрийг амьдралаасаа зайлуулахын тулд зүрхнийхээ хатуурлыг бурханлаг гашуудлаар дэвтээж, гэмшлийн хүчээр аврал руу хөтлүүлээрэй.

Бурханы дагуух гашуудал нь авралд хүргэдэг гэмшлийг бий болгодог.
Харин ертөнцийн гашуудал үхлийг бий болгодог. (2Коринт 7:10)

Дэлхийн гашуудал гэж юу вэ? Энэ нь нэр төр, мөнгө, эзэмшил, харилцаа зэрэг дэлхийн юмсын хойноос гашуудах явдал юм. Дэлхийн гашуудал нь тухайн зүйл нь бусдад болоод Бурханд хичнээн их зовлон тарьсныг ухааралгүйгээр, тэр зүйлийнхээ араас харуусдаг. Дэлхийн гашуудал зүрхний сэдлийн үндсийг хөндөлгүйгээр, зүгээр л шашны хүчин зүтгэлээр дамжуулан өөрийнхөө хүчээр өөрчлөлт авчрахыг хүсдэг. Дэлхийн гашуудлаар гашуудсан хамгийн яруу тод жишээ бол Иудас юм.

Бурханы гашуудал үр дагаврын зовнилоос давж, Бурхантай тогтоох харилцаан дээр төвлөрдөг. Бурханы гашуудал нь хөшгийг яран, юмсын бодит төрхийг харуулдаг. Үүний хамгийн шилдэг жишээ нь Дуулал 51:1 дээрх Давидын үг ажээ.

Бурхан, хайр энэрлийнхээ учир Намайг нигүүлсээч. Арвин их өршөөлийнхөө учир Гэмт үйлдлийг минь арилгаач.

Давид Бурхан руу хараагаа өргөөд, Түүний хөсөрдүүлэшгүй хайранд найдан, нүглийн өршөөлийг гуйжээ. Тэгээд үйлдсэн нүглээ гэмшсэн байна.

Таны, зөвхөн Таны эсрэг би нүгэл үйлдэж, Таны мэлмийд ёрын муут хийлээ. Тийм болохоор Та айлдвараараа зөвтөж, Та шүүгдэхдээ эзмгүй болой. (Дуулал 51:4)

Давид нүглээ хаацайлж, бусдыг буруутгаагүй. Тэр нүглээ ил тод хүлээн зөвшөөрсөн. Бид нүглээ ил тод хүлээн зөвшөөрөхдөө, ил тод цэвэрлэгддэг. Бид гүн нигүүлслээр дутахдаа (Ийм өршөөл хэрэггүй хүн байдаг гэж үү?), өөрсдийгөө даруусгадаг бөгөөд тийнхүү Бурхан биднийг нөхцөл байдал дундаас маань өргөх болно.

Балуунаар гэмийг минь цэвэршүүлээч. Би цэвэр болно. Намайг угаагаач, Би цаснаас цагаан болно. (Дуулал 51:7)

Давид одоо хүүгээсээ холдоод, цэвэрлэгээний төлөө гуйж байна. Тэрбээр өөрөө өөрийгөө цэвэрлэж чадахгүйгээ хүлээн зөвшөөрөөд, нүглийг нь ерөнхийд нь зайлуулаад орхих биш, харин бүх толбо, үлдэгдэл, хэлтэрхийтэй нь хамж зайлуулаач хэмээн Эзэнээс гуйжээ.

Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, Миний дотор зөв сүнсийг шинэчлэн авчраач. (Дуулал 51:10)

Нүгэл нь цэвэрлэгдсэний дараа Давид цэвэр зүрх, шинэчлэгдсэн сүнсийг гуйж эхлэжээ. Нүгэл нь Бурханд үйлчлэх шийдэмгий зүрхийг мохоон сулруулдгийг Давид ойлгодог байж. Тэгээд цааш нь:

Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч, Хүсэл зоригийнхоо сүнсээр намайг тэтгээч. Би тэрслэгчдэд Таны замуудыг заах бөгөөд Нүгэлтнүүд Тан уруу буцах болно. (Дуулал 51:12–13)

Сүүлийн энэ эшлэл нь миний хамгийн хайртай эшлэл. Энд харуусал, гунигт автсан газарт баяр баясгалан бадрахыг амладаг. Энд хамгийн муухай зүйлээс хамгийн сайхан зүйлийг бүтээх шинэ эхлэлийг амладаг. Энд бусад нүгэлтнүүдэд Бурханы итгэмжтэй хайр, өршөөлийг заах боломжийг хэлж, тэднийг дахин сэргээхийг амладаг. Тэнгэрийн Бурхан Аав маань харууслын харанхуй газар бүрийг итгэмжтэй байдал, үнэний гэрэлт бамбараа болгох болтугай.

болгох болтугай. Тэр чиний авралд ялалт байгуулах болтугай. Хариуд нь чи амьдралд чинь махан бие болж ирсэн Үгийг нүгэлтнүүдэд зааж, өвчтэй хэсэг бүрийг гоо үзэсгэлэн, эрх чөлөөний үлгэр жишээ болгох болтугай.

Дуулал 51:

1. Бид Бурхан дээр эрийнхээ сайнд биш, Түүний өршөөл дээр тулгуурлан очдог.
2. Бид Бурханы эсрэг нүгэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрнө.
3. Бид Түүний шүүхийг шударга болохыг хүлээн зөвшөөрнө.
4. Бид Түүний цэвэрлэгээг гуйж, үүнийг нь үг дуугүй хүлээн авна.
5. Бид Түүнээс бохирдол бүрийг цэвэрлэж, сүнсийг минь цэвэрлэхийг гуйна.
6. Бид Түүний авралын баяр хөөрийг гуйна.
7. Бид алдаагаа бусдад сургамж болгон зааж, даруугаар амьдарна.

Хэдийгээр Бурханы охид та бүхний амьдралын зам өөр, өөр боловч, шийдэл нь нэг л ижил юм шүү. Миний алдааг чамд сануулга болгож, миний сэргэлтийг чамд найдвар болгож, миний эрх чөлөөг чиний чөлөөлөлт болгож байгаа Аавынхаа өршөөлийг биширье. Бүгдээрээ Давидтай хамт залбирцгаая:

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ,

Бурхан, хайр энэрлийнхээ учир Намайг нигүүлсээч. Арвин их өршөөлийнхөө учир Гэмт үйлдлийг минь арилгаач.

Хилэнцээс минь намайг олонтаа угааж, Нүглээс минь намайг цэвэрлээч. Би гэмт үйлдэлээ мэднэ. Нүгэл минь үргэлж миний өмнө. Таны, зөвхөн Таны эсрэг би нүгэл үйлдэж, Таны мэлмийд ёрын мууг хийлээ. Тийм болохоор Та айлдвараараа зөвтөж, Та шүүгдэхдээ зэмгүй болой. Харагтун, хилэнц дунд би төрж, Нүгэл дотор эх минь намайг олж тээсэн. Харагтун, сэтгэлийн гүнд үнэн байхыг Та хүсдэг бөгөөд Дотоод чанадад минь Та Мэргэн ухааныг мэдүүлнэ. Балуунаар гэмийг минь цэвэршүүлээч. Би цэвэр болно. Намайг угаагаач, Би цаснаас цагаан болно. Надад баяр хөөр, баясгаланг сонсгооч. Та яйруулсан ясаа баясгаач. Гэм нүглээс минь нүүрээ буруулж, Хилэнц бүхнийг минь арилгаач. Оршихуйгаасаа намайг бүү холдуулаач. Ариун Сүнсээ надаас бүү аваач. Би тэрслэгчдэд Таны замүүдыг заах бөгөөд Нүгэлтнүүд Тан уруу буцах болно. Бурхан, авралын минь Бурхан, Намайг цус урсгалтаас авраач. Хэл минь Таны зөвт байдлыг дуулна. ЭЗЭН, уруулыг минь нээгээч. Ам минь Таны магтаалыг тунхаглана. Учир нь Та тахилд баярлахгүй. Тийм бишсэн бол би түүнийг өргөхсөн. Та шатаалт тахилыг таалахгүй. Бурханы авах тахил нь эмтэрсэн сүнс юм. Эмтэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй. (Дуулал 51:1–17)



15 *Бид буулт хийхдээ ялагддагийн учир*

Эмэгтэй хүний бэлгийн дур булаам чанар нь түүний нууцлаг чанартай нягт холбоотой. Эмэгтэйчүүд маш амархан болсон өнөөгийнх шиг үед энэ асуудал бүр ч ач холбогдолтой.¹

–Лиза Шеффрен, Эмэгтэйчүүдийн сэтгүүлээс

Орчин үеийн сэтгүүлээс олдох энэ үг бас л нэгийг бодогдуулмаар. Бүх хуучин зүйлс шинэ болж, Бурхан ч эмэгтэйчүүдийг бидний санаснаас илүү өмгөөлдөг ажээ. Нийгэм хүртэл санаж сэрээд, хормойн явдал нь тэдэнд хүссэн зүйлийг нь өгөхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн, гонсгор эмэгтэйчүүдийн ууртай дуу хоолойг өргөж байна. Эмэгтэй хүмүүс буулт хийхдээ, эрчүүдээс ч ихийг алддаг.

Нийгэм бидэнд, хандлагаа бууруулж байж л хүсээд байгаа нарийн нандин зүйлээ олж авна гэж заадаг. Гэхдээ энэ худлаа юм. Учир нь бидэнд өндөр дуудлага бий. Бид жишгээ бууруулж байж хүссэнээ олж авахгүй. Цаашид ялагдах хүсэлгүй, хөгшин залуу – үе үеийн эмэгтэйчүүд нэр хүнд, хүндэтгэл, чадал тэгээд мэдээж хүчийг олж авна.

~ Цаашид ялагдах хүсэлгүй, хөгшин залуу – үе үеийн эмэгтэйчүүд нэр хүнд, хүндэтгэл, чадал тэгээд мэдээж хүчийг олж авна.

Даниелле Криттендений “Ээжийн минь захиж хэлээгүй үг” гэдэг ухаарал хайрлам номоос эш татмаар байна:

Үнэхээр, эмэгтэйчүүд биднийг бие даалгана, эрх чөлөөтэй болгоно гэсэн зүйл бүрийн амлалт дундаас сексийн эрх чөлөөнд хүргэнэ гэсэн амлалт шиг худлаа амлалт байсангүй. Мэдээж өнөөдөр энэ талаар л хамгаас түрэмгий заадаг. Охин хүүхдийн хамаг л сексийн бахархал нь түүний хувьд хамгийн чухал хүн болох хөвгүүн нь өөрийнхөө биеийг хангачихаад, одоо чи хэрэггүй гэдгийг ойлгуулахтай нь хамт замхардаг юм. Хичнээн феминист дүр эсгэлээ гээд, хичнээн тийм өөдгүй хүнээр дутахгүй гэдгээ батлалаа гээд, энэ бүхэн нь залуугаа яваад өгсний дараа торойж үлдэхдээ сексийн тал дээрээ хүчирхэг биш, хог шавхруу шиг болгосон доромжлол, зовиураас хамгаалахгүй.²

Хүмүүс хар залуугаараа ийнхүү ашиглагдаж, хаягдаж, гологдож байна гэхээр аймшигтай. Гэтэл бид өөрийгөө бүрэн зориулж, нүцгэлж, илчилчихээд хаягдах биш, харин ч улам хайрлуулах учиртай юм. Бид хамгийн нандин газраа нээж өгчихөөд, дараа нь хаягдах учиргүй. Сексийн нэгдэл нь хоёр хүн нэг болон гагнагдах үйл явдлын баярт оргил байх учиртай. Энэ нь салахын өмнөх сүүлчийн үйлдэл байх ёсгүй. “Би хүссэнээ авсан болохоор, одоо явлаа. Баярласан шүү” гэдэг үгийг сонсох юутай аймшигтай.

Бидний умай нь амийн үрийг нандигнан байж, хайраар суулгадаг газар болохоос биш, харанхуйд хайр найргүй цацдаг зүйлийн хогийн сав биш. Бидний хэвэл нь цэцэглэхийн тулд арчилж тордох ёстой газар юм. Бурхан Израилийн шинээр гэрлэсэн эрчүүдийг эхний жилдээ гэртээ үлдэж, эхнэрээ жаргаа гэдэг байжээ (Дэд хууль 24:5). Тэрбээр аз жаргалын цэцэрлэгтээ аюулгүй суулгагдан, соёолон ургаж, амьдрал төрүүлэх учиртай байж.

Эмэгтэйчүүд бид эрчүүдийн бэлгийн дур хүслийг тайлахын төлөө л бүтээгдээгүй. Эмэгтэйчүүд бид өөрсдийнхөө бэлгийн дур хүслийг тайлахын төлөө л бүтээгдээгүй. Эмэгтэйчүүд дотносол, хайр дурлал, дур хүслээр цангадаг. Бид өөрийгөө мэдүүлж бас мэдэхийг хүсдэг. Итгэлцэл

байхгүй газар дотносол байхгүй. Гэрээ байхгүй газар мөнхийн итгэлцэл байхгүй. Маргааш дэргэд байх үгүй нь мэдэгдэхгүй хүнд яаж итгэх вэ? Тэр өнөөдөр сексийн дур хүслээ хойш тавиад, чамайг хүлээх хүсэлгүй байж, юу гэж маргааш чамайг хүлээж суух

*Эмэгтэйчүүд
дотносол, хайр дурлал,
дур хүслээр цангадаг.*

билээ? Эрчүүд төрөлхийн байлдан дагуулагч чанартай: Тэд нэг зүйлийг эзлэсэн бол, бах тав нь ханаад, дараагийн байлдан дагуулалдаа ордог.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцаанд өөр нэгэн онцгой эргүүлэг бий. Бэлгийн харилцаагаар эхлэсэн эрэгтэй, эмэгтэй хоёр хүний харилцаа

цаашаа гүнзгийрэх бараг боломжгүй. Кинон дээр болоод л байдаг л даа. Гэхдээ амьдрал дээр, эрэгтэй хүн тийм хурдан мэдээд авчихсан зүйлээ лавшруулж судлах сонирхолгүй болдог. Дарсыг нь хоослочихоод, шилийг нь сонирхдог хүн ховор.

Эрчүүд аялал, нууц явуулгад дуртай бөгөөд өөрийг нь илүү том зүйлд чадвартай гэдгийг нь мэдээд, тийш нь уриалан дуудаж байдаг эмэгтэй хүнд дуртай. Эрчүүд өөрт нь итгэдэг хүнд итгэхийг хүснэ. Эрчүүд тийм эмэгтэйд зүрхээ, хүүхдүүдээ, мөнгөө даатгадаг. Сайн эрчүүд битүүхэндээ хэн нэг бүсгүйн гялалзсан хуяг дуулгатай ханхүү, баатар байхыг хүсдэг. Чи ханхүүгээ хүлээж байгаа бол, тэр ч бас гүнжээ хайж явааг бүү мартаарай.

Одоо бүгдээрээ эмэгтэй хүн буулт хийснээрээ юугаа алддагийг үзье:

Алдагдал: хүндэтгэл, онгон бие, хүч, буцаашгүй нандин чанар, нууцлал, ариун чанар, итгэл, сайн нэр, хяналт, бэлгийн эрүүл мэнд, цэвэр байдал, нөхөн үржих чадвар, эрх чөлөө тэгээд харилцааныхаа ирээдүйг.

Биологийн талаасаа эрэгтэй хүн биш, эмэгтэй хүн л жирэмслэдэг. Эрэгтэй хүн цусаа урсгалгүйгээр хүүхдээ хаяад явж чаддаг бол, эмэгтэй хүн чадахгүй. Эмэгтэй хүн л аавгүй хүүхдээ тээсээр төрүүлнэ эсвэл дотроо өсч байхад нь ална. Эмэгтэй хүн л хүүхдээ тээсээр, нэг өдөр яагаад аав нь түүнийг хаяад явсныг тайлбарлах үүрэгтэй болно. Эдгээр нь маш зовиуртай сонголт.

Олон БЗХӨ (Бэлгийн замын халдварт өвчин) нь илрэхээсээ өмнө эмэгтэй хүний нөхөн үржлийн системийг эвддэг. Тиймээс үргүй болсон эмэгтэйчүүд хүүхэд төрүүлж чадахгүй. Үүнээс гадна ДОХ-ын нян амь насыг нь богиносгоно. Эрчүүд сексийн нэг харилцаанаас нөгөө рүү маш хурдан шилжиж чаддаг ба санаатай бөгөөд санаандгүйгээр үрийн шингэнээс гадна өөр олон зүйл дамжуулж чадна.

Нэгэн залуу миний таньдаг нэг охиныг бас түүний хамгийн сайн найзын дүүг нь зэрэг, зэрэг жирэмсэн болгочихжээ. Тэд хэдхэн өдрийн зайтай амаржиж билээ. Тэднийг хүүхдээ төрүүлэх гэж тарчилж байхад, нөгөө залуу хаана байв? Гарыг нь атгаж байв уу? Үгүй ээ, тэрбээр хотоос яваад өгсөн гэдэг.

Тэгвэл эмэгтэй хүн гэрлэлтээс гадуурх сексээс ямар ашиг авдаг вэ?

Ашиг: хэсэгхэн зуурын бэлгийн таашаал.

Эрэгтэй хүний ашиг, алдагдал юу вэ?

Алдагдал: онгон байдлаа алдах, бэлгийн эрүүл мэндээ алдах.

Ашиг: хэсэгхэн зуурын бэлгийн таашаал, зорьсондоо хүрсэн мэдрэмж, өөр хүн рүү шилжих эрх чөлөө.

Энэ олон ангит кино өдөр бүр зурагтаар гардаг. Нэг удаа зурагт үзэж таартал, 15-хан настай, царай алдсан нэгэн охины нүүрэн доогуур

“Хүүхдийнхээ эцгийг эрсэн нь” гэсэн утгатай бичиг урсаж байв. Хүүхдийнх нь эцгийг тодруулах зорилготой нэвтрүүлэг болтой. Тэр шууд нэвтрүүлгээр хөвгүүн нь буруугүй гэдгээ хамаг хүчээрээ батлах бөгөөд тэрбээр нэвтрүүлгийн төгсгөлд нэг бол нэр цэвэр үлдэнэ эсвэл нэр нүүргүй болно. Тэгтэл хөтлөгч яг л хүндтэй шагнал гардуулах гэж байгаа мэт нэгэн дугтуй гаргаж ирэв. “Шинжилгээний хариу нь... (бөмбөрдөөрэй!)... энэ залуу хүүхдийн аав биш!” Залуу суудлаасаа дэвхрэн босоод: “Би гэртээ эрх чөлөөтэй харих нь! Би чөлөөтэй! Би хэлсэн биз дээ... би чамд хэлсэн... наадах чинь миний хүүхэд биш гэж хэлсэн!” хэмээн хашхиран дээшээ, доошоо өндөлзөв. Тэрбээр танхимд сууж байсан найзуудтайгаа тэврэлдээд, дараа нь тайзны ард ч баяраа тэмдэглэж байгаа нь хөтлөгч, охин хоёрын арын том дэлгэцэн дээр гарч байлаа.

Гэтэл тэр жаахан охины царайн дээрх аймшиг намайг өвтгөв. Тэрбээр хамаг итгэл найдвараа алджээ. Түүний айдсыг мэдэрсэн хөтлөгч ч охин руу бөхийгөөд: “Түүнийг март! Бид чамд туслана” гэж хэлэв. Охин даруухнаар толгой дохих зуур арынх нь дэлгэцэн дээр эрх чөлөөтэй болсондоо галзууран дэвхцэх залуугийн дүрс гарсаар л байлаа.

Би энэ үйл явдлыг үзээд асгартал уйлж билээ. Тэр охины амьдрал хэзээ ч урьдынх шигээ байхгүй. Тэрбээр хүүхдээ аавтай болгох гэсэндээ л хэрэг явдлаа үндэсний телевиз дээр авчирсан боловч, аав нь биш болохыг мэджээ. Тэгэхээр “Яагаад тэр охин тухайн үед унтсан бүх залуугаа авчирсангүй вэ?” гэдэг асуулт тавигдана. Магадгүй нөгөө хөвгүүнийг л хүүхдийнхээ аав байгаасай гэж хүссэндээ тэр юм болов уу? Охин хэдэн сая танихгүй хүний өмнө нэр нүүргүй шившиг болон хоцорчээ. Үзэгчдийн санал

~ Эрчүүдтэй харьцуулахад,
эмэгтэй хүмүүс хормойн
хэрэг явдалдаа хавьгүй
өндөр төлөөс төлдөг юм.

бодол хуваагдаад байлаа. Зарим нь алмайрч, зарим нь толгой сэгсэрч, зарим нь шоолж байв. Харин би тэр охиныг тас тэвэрмээр байлаа.

Би түүнийг тэвэрч чадахгүй ч, чамд анхааруулж чадна. Эрчүүдтэй харьцуулахад, эмэгтэй хүмүүс хормойн хэрэг явдалдаа хавьгүй өндөр төлөөс төлдөг юм. Энэ нь Еденд үйлдсэн нүглээс болж бидэн дээр буусан зөрчлийн нэгээхэн хэсэг гэдэгт би итгэдэг.

Энэ бол хайрын хууль зөрчигдөх үед эмэгтэй хүн л зовдгийн бас нэгэн жишээ. Энэ хууль нь чиний баяр хөөр, таашаалыг хулгайлахын тулд биш, харин хамгаалахын тулд тавигдсан юм шүү. Тэр охин нөгөө хөвгүүний гарт ч, бусад хөвгүүдийн өвөрт ч хэсэгхэн зуурын таашаал эдлэсэн гэдэг нь эргэлзээгүй ч, тэр оргилуун таашаал нь зурагтаар гарсан өдрөө мэдэрсэн шившигийнх нь дэргэд юу ч биш байсан байх.

Нэгдлийн оргил нь байх ёстой зүйлээр харилцаагаа эхлүүлчихбэл, тэр цэгээс эхлэн бүх зүйл хар эрчээрээ уруудна. Харилцааны хамгийн өндөр төвшин нь (сексийн) түрүүлчихээрээ, бусад хэсэг нь барьцалдах цементгүй болдог. Эрэгтэй хүн өөртэй нь унтчих эмэгтэйг ядах юмгүй олно. Бараг үнэ хөлс ч шаардагдахгүй байх.

Би оюутан байхдаа, эрчүүдийн порно сэтгүүлээс уншиж байсан нэгэн комиксыг чамд ярьж өгмөөр байна. Эрэгтэй, эмэгтэй хоёр орондоо ороод, секс хийх гэж байв. Эмэгтэй нь гараараа эрэгтэйгээ зогсоогоод, урьдаар түүний нэгэн асуултад хариулахыг хүсэв: “Чи өглөө болоход намайг хүндэтгэсэн хэвээрээ байх уу?” Дараагийн зураг дээр нь эрэгтэй нь гайхсан царай гаргаад: “Өглөө хүндэтгэх ий? Би чамайг ерөөсөө хүндэтгэдэггүй шд!” хэмээн хариулж байв.

Хэрэв чи хүндэтгэлийг хүсч байгаа бол, үүнийг хормойн явдлаас олохгүй. Эрчүүд хэнтэй ч унтаагүй эмэгтэйг л эхнэрээ болгохыг хүсдгээс биш, хэдийнээ мэддэг хүнээ болгохыг хүсэхгүй. Эрчүүд галзуу охидтой унтах, сээтэгнэх, тэр бүү хэл болзох дуртай ч, тэднийг гэрлэж, үр хүүхдийнхээ ээж болгох хүмүүсийн жагсаалтад багтаадаггүй.

Хормойн явдал нь эмэгтэйчүүдэд эрчүүд шиг л эрх дураараа явах эрхийг олгодог. Тийм үү? Үнэндээ бид яаж ч авирласан – хэзээ ч эрэгтэй хүн болохгүй. Тиймээс яагаад эрэгтэй хүн шиг үйлдэх ёстой гэж? Эмэгтэй хүн эмэгтэй хүний нууцлалаа хүлээж авахдаа л хамгийн хүчирхэг байдаг.

Мэдээж манай соёл эмэгтэй хүн байх гэдэг ойлголтыг эмзэг, дорой, уйланхай дүр төрхөөр төсөөлдөг. Эрэгтэй хүнийг эмэгтэй хүний чанараар хувцаслал, хачин жигтэй юм болно. Тийм боловч эмэгтэй хүнд бүсгүй хүний чанар нь л яг зохино. Эмэгтэй хүн эмэгтэй хүнийхээ үүргийг хүчтэй биелүүлбэл, эрэгтэйчүүд үүргээ шинэ төвшин, шинэ жишгээр биелүүлэхийн төлөө тэмүүлнэ. Эрэгтэйчүүд өөрийг нь тэгшитгэсэн хань ижлийнхээ хүндэтгэл, таалал, анхаарлыг хүсдэг. Эрэгтэй хүний хувьд ганцаараа байх нь сайн биш. Тэрбээр хүчин зүтгэл, амьдралаа хуваалцах хүнгүй бол, зорилгогүй болно. Эрэгтэйчүүд шалдан эмэгтэйг эзлэж, хүчирхийлэх санаатай байдаг бол, хувцастай эмэгтэйг хамгаалахыг хүсдэг.

Дотнослыг эргүүлж олохыг хүсч байвал, үнэнтэй эвлэрэх ёстой. Нэр төр, хүндэтгэлээ эргүүлж авахыг хүсч байвал, хувцсаа өмсөх хэрэгтэй. Сексийн эрх чөлөө гэдэг зүйл эмэгтэйчүүдийн дүр төрхийг өргөмжлөх биш, гутаадаг. Эмэгтэй хүний чанарыг тээгээгүй, хоосон өдөөлт байж болно оо. Гэхдээ эмэгтэй хүний чанар нь эмэгтэй хүний нууцлалын хамаг гоо үзэсгэлэнг тээдэг юм.

~ Сексийн эрх чөлөө гэдэг зүйл эмэгтэйчүүдийн дүр төрхийг өргөмжлөх биш, гутаадаг.

Олон зууны турш Евагийн охид Адамын хөвгүүд рүү: “*Миний төлөө золиос бүхий хайраа зориулаач. Намайг аварч, хамгаалаач. Миний гүн хэрэгцээ, аюулгүй байдлыг хангаач*” хэмээн орь дуу тавьсаар ирсэн. Хариуд нь Адамын хөвгүүд эмэгтэй нь түүний гаргаж хэлж чадахгүй санаашралыг нь хангах байх хэмээн найдахдаа, биелүүлж чадахгүй амлалтаа өгдөг. Гэвч хэн, хэн нь бүтэлгүйтнэ. Учир нь бидний доторх энэ гүн хэрэгцээг Бурхан л ганцаараа хангадаг юм.

Бид цөхөрсөндөө өөрийгөө худалдаж, Адамын хөвгүүдээр өөрсдийгөө ерөөлгөж, үнэ цэнээ батлуулах гэсэндээ, тэдэнтэй барилдан, дайтдаг. Гэтэл энэ тэмцэл биднийг улам л гонсойлгодог. Үүний үр дүнд бид хүчиндүүлж, шархадсан амьтан гав ганцаараа шороотой хутгалдан хоцрох нь олонтаа. Энэ бүхэн нь хоёр талыг хоёуланг нь ялагдалд хүргэдэг, эцэж цуцмаар, утгагүй үйл явц билээ. Үүнд Адамын хөвгүүд буруугүй. Тэд бидний хүсээд байгаа ерөөлийг өгч чадахгүй бөгөөд бид тэдэнд сэтгэлийг маань захирах эрх хүчийг олгосноороо, тэднийг айлгаж орхидог. Тиймээс хүсээд байгаа ерөөл маань Бурханаас л ирдгийг мэд. Бурханаас шинэ нэр ав. Учир нь бид сүүдэрт хорогдогч Евагийн охид биш, харин гэрэл, амлалтын охид буюу Түүний сүйт бүсгүйчүүд болсон билээ.

Жон Эдрэж “*Зэрлэг зурхтэн*” (Томас Нельсон Паблишн, 2001) хэмээх онцсайн номдоо эрчүүд “алтан үст бүсгүйгээс” ханамжийг хайхдаа, ямар бүтэлгүйтэлд хүрдгийг хуваалцдаг. Тэгвэл эмэгтэйчүүд бид ч дутахгүй буруутай бус уу? Бид Адамыг горьдон харсаар байвал, улам л гонсойсоор байна. Адам Евагаас өмнө бүтээгдсэн бөгөөд одоо ч тэргүүлдэг. Адам нэгдүгээрт учраас, эмэгтэй хүн хэзээ ч танин мэдэж чадахгүй давуу тал түүнд бий. Ева Адамыг зүгээр нэг нөхрөө гэж хараагүй. Адам Евагийн хувьд ах шиг нь бас аав шиг нь байсан. Учир нь Ева эр хүнээс төрсөн цорын ганц эмэгтэй хүн шүү дээ. Тэрбээр Адамын сонголтонд ч гонсойсон, өөрийнхөө сонголтонд ч гонсойсон. Бид эрчүүдийг биднээс том зүйлээс хүч чадлаа аваасай гэж хүсдэг.

Адам бидний гинжийг таслаж чадахгүй. Адамыг л хараад байвал, чи зөрчилдөж, гонсойно. Харин Бурханыг харах юм бол, чи цаашид

Евагийн шившигтэй, шалдан охин биш, харин аврагдан сэргээгдэж, хувцаслагдсан амлалтын охин... ханхүүгээ дуулан, бүжин хүлээж буй алдарт сүйт бүсгүй байна. Чи хуулийг хүслээр, хүлээсийг эрх чөлөөгөөр, дүрмийг харилцаагаар сольсон учраас, халуун хүсэл тэмүүлэлтэй байна. Чи бол язгууртан бүсгүй. Зарим эмэгтэйчүүд өршөөлийн баяр хөөрийн үерийг үзэхээсээ өмнө гашуун

~ Адам бидний
гинжийг таслаж чадахгүй.
Адамыг л хараад байвал,
чи зөрчилдөж, гонсойно.

БИД БУУЛТ ХИЙХДЭЭ ЯЛАГДДАГИЙН УЧИР

харууслыг үздэг. Энэ бол эмэгтэйчүүдийг анхныхаа хүч чадал, нэр төр, хүндэтгэлийн байр суурь руу нь дуудсан шуурхай дуудлага юм. Бид толгойгоо өөд өргөн, бусад эгч дүүс, охиддоо эрх чөлөөг тунхаглаж чадна. Тийм ээ, бид тэднийг “Яв... дахиж нүгэл бүү хийгээрэй!” хэмээн чөлөөлнө.



ДүГНЭЛТ: *Хайрын хүү*

Би гэрлээд хориод жил болж байгаа ч, сүйт бүсгүй байснаа тодорхой санаж байна. Би завгүй бэлтгэл, санхүүгийн дарамт, хуримын төлөвлөгөөний талаар яриагүй байна. Эдгээр нь хэзээ ч сүйт бүсгүйн ачаа байгаагүй ээ. Сүйт бүсгүй чинь шүүрэгдэх учиртай шүү дээ. Би догдлон хүлээлгэсээр ирээд, нийтээрээ донслон тэмдэглэдэг хайрын баяр хөөрийн талаар ярьж байна. Би урьдын амьдралаасаа тусгаарлагдаж, мөрөөдлийнхөө аян замд гарах өдрийг хуруу даран тоолж байсан сан. Амьдрал маань миний төсөөлсөн шиг байх болов уу? Бид бүгдээрээ Түүний сүйт бүсгүй учраас, сүйт бүсгүй хэрхэн сэтгэх ёстойг мэдэх хэрэгтэй.

- Сүйт бүсгүй сүйт хархүүтээсээ бас олны нүд, чихнээс дайжин, үзэсгэлэнтэй, нууцлаг газар руу зугтахыг хүснэ. Тэрхүү нам гүм газар сүйт бүсгүй маань үгээр илэрхийлэшгүй хайрлуулахыг хүснэ.
- Сүйт бүсгүй сүйт хархүүгийн хүрэлтийг тэсэн ядан хүснэ. Сүйт хархүү нь түүний гүнд буй мэдрэмж, дур хүслийг сэрээсэн бөгөөд тэдгээрийг нь гагцхүү хүрэлтээрээ л хангаж чадна. Сүйт бүсгүй үлэмж ихээр хайрлуулж, хүлээн авагдахыг хүснэ.
- Сүйт бүсгүй гагцхүү сүйт хархүүтэйгээ л хуваалцах дуутай – тэдний хайрыг амьдруулж, ганцхан “тэднийх” байх эгшиг дуутай.
- Сүйт бүсгүй сүйт хархүүгийнхээ зөөлөн шивнээнд дуртай. Тэр шивнээ ганцхан түүнд зориулагдсан болохыг тэрбээр мэднэ.

УЙЛУУЛАХ УЧИРГҮЙ ҮНСЭЛТ

- Сүйт бүсгүй тансаг хувцаслаад, цаг нь болохоор зөөлөн тайчуулахыг хүснэ.
- Сүйт бүсгүй сүйт хархүүгийнхээ өмнө ичэлгүйгээр, нүцгэн зогсохыг хүснэ. Тэрбээр бүх биеэрээ сүйт хархүүдээ хамгийн үзэсгэлэнтэй, хүслэнтэй, галбиртай, хэмжээтэй байхыг хүснэ.
- Сүйт бүсгүй сүйт хархүүдээ бүх талаараа таалагдахыг хүснэ.
- Сүйт бүсгүй үйлдэл бүхэндээ цэвэр бөгөөд дур хүсэлтэй байхыг хүснэ.
- Сүйт бүсгүй түүний зөвхөн хэл яриаг бус бас зүрхийг нь илэрхийлж чадахгүй гүнийг нь сонсоосой гэж хүснэ.
- Сүйт бүсгүй хамгийн эмзэг үедээ аюулгүй байхыг хүснэ.
- Сүйт бүсгүй өөрийгөө айдасгүй илэрхийлэхийг хүснэ.
- Сүйт бүсгүй гэнэтийн бэлгэнд дуртай.
- Сүйт бүсгүй сүйт хархүүтэйгээ нууцаа хуваалцдаг.
- Сүйт бүсгүй хайртай хүнээ араасаа гүйлгэж, хайртай хүнийхээ араас гүйх дуртай.
- Сүйт бүсгүй хэн нэгэнд хамаатай байх дуртай.
- Сүйт бүсгүй тордуулж, хамгаалуулж, чиглүүлэгдэж, тэр бүү хэл зөөлөн засуулахыг хүсэх боловч, шүүмжлүүлэхийг хүсэхгүй. Түүнийг шүүмжлэх юм бол, тэрбээр цэцэглэхээ больж, хайртай хүнийхээ хүрэлтээс дайжина.
- Сүйт бүсгүй анхны хайрдаа л хайртай учраас өөр хайрыг сонирхохгүй.

Энэ дүрслэл чиний зүрхийг эмтлэж байгаа бол, эмтлэг. Яагаад гэвэл Бурхан чиний хатаж дагтаршсан зүрхийг хагалаад, “Би чамайг хайрлая” гэж байгаа нь тэр. Эмэгтэй хүн болгоны дотор байдаг энэ гүн санаашралыг

газрын хөвгүүд хангаж чадахгүй. Адамын хөвгүүд зарим үед зарим зүйлийг хангаж чадах ч, зарим нь ханаагүй хэвээрээ хоцорно. Газрын хайр чамайг гомдоож, орхиж болох ч, үнэндээ чи өөр хүнийх юм. Тэр тэнгэрийн Ханхүү чамайг хэзээ ч гомдоож, шархлуулахгүй. Тэр чиний гүний хүслийг урласан бөгөөд үргэлж чиний мөрөөдөл байсан шиг, чи ч бас Түүний мөрөөдөл байсан юм.

Сүйт залуу сүйт бүсгүйдээ баярладаг шиг Бурхан чинь чамд баярлана.
(Исаиа 62:5)

Хуримын бэлтгэл нь байдаг л нэг, уйтгартай цаг байх ёсгүй. Энэ нь сүйт бүсгүйн ертөнцөөс хайртынхаа ертөнц рүү шилжих, догдолмоор цаг хугацаа юм. Чи Бурханы дуу хоолойг сонсож, Түүний оршихуйд мэхийн ёслох тэнгэрийн язгууртан охиныхоо хувьд баяр хөөрөөр доргисон эртний ёслолд нэгдэнэ.

Бурхан сүйт бүсгүйгээ хэрхэн нягтлан хайдаг болохыг чамд ойлгуулах гэж би их л чармайлаа. Бурхан чамайг Хүүдээ зориулж авахын тулд хичнээн хол, хичнээн өндөр явдгийг чи харах болтугай. Бурханы итгэмжтэй хайрыг мэдэхээс нааш чи жинхэнээсээ Түүнийх байж чадахгүй. Тэр биднийг шүүрээд авч явахын тулд зүрхийг маань олзлох ёстой. Учир нь эрдэнэс байгаа газар зүрх маань тогтоно.

Би ЭЗЭНий дотор ихэд бахдан Сэтгэл минь миний Бурханд баярлана.
Сүйт залуу цэцгийн хэлхээгээр чимж, Сүйт бүсгүй үнэт чулуугаар гоёдог шиг Тэр намайг авралын хувцсаар хувцаслаж, Зөвт байдлын нөмрөгөөр бүтээв. (Исаиа 61:10)

Түүний авралаар нүцгэнээ нуу. Түүний зөвтгөлөөр өөрийгөө хуч. Түүний таалсан гоёлоор өөрийгөө чим. Түүнд тэврүүлэн, Түүний өмнө бүжиглэ.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Намайг сэрээгээч. Би Таных. Таны хайрыг харуулж, хүрэлтийг мэдрүүлээч. Би Танаас зуурч, Танаар ширтүүлмээр байна. Намайг зүрхэндээ тамгалаач. Надаас чанга атгаад, хэзээ ч битгий тавиач. Би Танд хайртай, миний сүр жавхлантай, сайхан Ханхүү минь. Намайг авралаараа гоёоч. Эзэн Есүс ээ, хурдан ирээч.

Таны хайрт охиноос.



Тэмдэглэл

9-ээр бүлэг

1. *Matthew Henry's Commentary on the Whole Bible: New Modern Edition, Electronic Database* (Hendrickson Publishers, Inc., 1991)
2. Ibid

14-ээр бүлэг

1. Лиза Шиффрен, *Эмэгтэйчүүдийн сэтгүүл* 1997, 97
2. Даниелле Криттенден, “*Ээжийн минь захиж хэлээгүй үг*” (Нью-Йорк: Точстон, 1999), 31.



Зохиолчийн тухайд

Лиза Бивэр нь *Out of Control and Loving It; The True Measure of a Woman; Be Angry, But Don't Blow It!; You Are Not What You Weigh* зэрэг бестселлер номуудын зохиолчоос гадна нэртэй илтгэгч, зурагт, радиогийн байнгын зочин бөгөөд Колорагод нөхөр Жон, дөрвөн хүүгийнхээ хамт аж төрдөг.



Талархал

Миний төгс Ханхүү бөгөөд Аврагч – Есүстээ баярлалаа. Та миний нүцгэнийг нэр төрөөр, ичгүүрийг хүндэтгэлээр хувцасласан. Өчүүхэн миний үг, үйлдэл Танд талархсан сэтгэл, Танд татагдах хүслийг минь хэзээ ч бүрэн илэрхийлж чадахгүй. Таны үнэт Үг амьдралд маань үргэлж бодитой оршиж, хүмүүс Таны үзэсгэлэнг харах болтугай.

Хань Жондоо баярлалаа. Хорин жилийн өмнө чи миний ичгүүрийг давж, гоо үзэсгэлэнг минь хараад, намайг хар дарсан зүүднээс хулгайлж, хамгийн сайхан зүүдний босгоор давуулсан... баярлалаа, чамдаа.

Аддисон, Аустин, Алек, Арден дөрвөн хүүдээ, номлол, номоор дамжуулан ээжийгээ бусадтай хуваалцсанд баярлалаа. Та дөрвийн тарьсан үрийг Бурхан үржүүлж, нэг бүрийн чинь зүрхэнд мөрөөдлийг өгөх болтугай. Та дөрөв дөрвүүлээ ээжийнхээ зүрхний баяр баясгалан мөн билээ.

Намайг анхааралтай сонсож, урамшуулж бас ажлыг маань өндөр чадвараар хянан тохиолдуулсан Кристен Лукастаа баярлалаа.

Хүчин чадлыг минь улам гүнзгийлэн малгаж байдаг Виктор Оливертоо баярлалаа.

Шинэ санаа хайрладаг Белинда Басстаа баярлалаа.

Хэцүү үе инээдээрээ хөнгөлж өгдөг Памела Клементдээ баярлалаа.

“Том санаа” шаардаж байдаг Майк Хиятдаа баярлалаа.

Нэр дурьдагдаагүй боловч, хоригдлуудыг чөлөөлөх энэ төсөлд хамаг л бэлэг, авьяас чадвараа шавхсан бүх хүнд баярлалаа.

АДАМАНТ

Олон санаат ертөнцөд үнэнийг олох



Эрт цагт адамант чанар буюу бат бэх чанарыг агуулсан алмаз чулууны гайхамшгийг хүмүүн олж мэдсэн юм. Харин орчин үед ялагдашгүй, хөдлөшгүй, усташгүй аливаа зүйлийг алмаз чулуутай зүйрлэж адамант гэдэг үгээр илэрхийлдэг болов. Хэрэв хайр ба үнэний талаар өгүүлэх ёстой бол үнэндээ тэр цаг аль хэдийнээ иржээ. Бурхан бол Хайр. Бурхан бол Үнэн. Хайр ба Үнэн хоёулаа цаглашгүй, бүх цаг үеийн, ямар ч олон ургальч үзлийг сэтлэн та бидний энэ цаг үед ирсэн юм. Тиймээс та бид үнэнийг өгүүлж бас үнэнээр амьдрах ёстой.

Шилдэг борлуулалттай номын зохиолч Лиза Бивэр та биднийг Бичээсийн дагуу хөтлөн Бурханы Ууланд аваачих болно. Тэнд та бид хэзээ ч хөдлөшгүй Бурханы үнэн ба хайрын бат холбоосоор адамант буюу хөдлөшгүй, шийдэмгий, тууштай хүмүүс болж өөрчлөгддөг. Гүн итгэл үнэмшил, гал халуун сэтгэлээр хэрхэн адамант байх тухай ойлголтыг Лиза та бидэнд хуваалцах болно. Бурханы дотор амьдрахад Бурханы хүсэл төлөвлөгөө бидэнд ил болж Христийн дотор та бид адамант дүр төрхөд яагаад хувирч өөрчлөгдөх ёстойг энэ номд өгүүлнэ.

CloudLibrary.org



зочлоорой!

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

*Эргэлзээ, харьцуулалтын энэ эрин цагт өөрийгөө
болон зорилгоо олж мэдэх*



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтлож байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг. Та хүнээс эрэн хайгаад байдаг тодорхой, дотно харилцаагаа Бүтээгчтэйгээ тогтообол, өөрийгөө хэн болохыг жинхэнээсээ мэдэж, бусадтай өрсөлдөн барьцахаа болино. Лизагийн Библийн ул суурьтай, эш үзүүлэлтэй, хошин мэдрэмж, халуун сэтгэлтэй үгсээр та:

- Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга.
- Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт.
- Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь.
- Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур.
- Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

CloudLibrary.org



зочлоорой!

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд мөнхийн зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

СЭЛЭМТЭЙ ОХИД

ЗАГАЛМАЙГАА ЖИНХЭНЭ БААТАР ШИГ ҮҮРЬЕ



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна. Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Жон, Лиза Бивэрийн энэхүү болоод бусад цогц сургалтын материал нь Мессенжер Интернэйшнэлийн үнэ төлбөргүй видео суваг дээр болон доорх цахим хуудас дээр бий:



CloudLibrary.org

Эмэгтэй хүн

буулт хийхдээ ялагддаг

Эмэгтэй хүн эрэгтэй хүний бэлгийн гарц байхаар бүтээгдээгүй. Ялагдах хүсэлгүй үе үеийн эмэгтэйчүүд нэр төр, хүндэтгэл, хүч чадал тэгээд эрх хүчээ сэргээх цаг иржээ.

- Хэцүү асуултад Бурханы өгөх хатуу боловч, хүчирхэг хариултыг олж мэд.
- Цагаас нь эрт сэрээсэн зүйлээ буцааж нойрсуул.
- Бурханы яндашгүй өршөөлийг хүлээн ав.
- Эрх чөлөө, хүч, цэвэр байдал дор алх.



Халуун, хурц, найдвартай, хүчирхэг, хөгжилтэй. Энэ бол **Лиза Бивэр**. Нью-Йорк Таймсын бестселлер зохиолч, 200 гаруй улсад дамжуудаг "The Messenger" телевизийн хөтөлбөрийн хамтран хөтөлгөч.

Лиза Бивэр Бурханы Үгийг хувийнхаа туршлагаар сүлжин илэн далангүй, шулуун шударга номлохдоо, эмэгтэйчүүдийн амьдралыг эрх чөлөө, өөрчлөлтөөр хүчирхэгжүүлдэг. Тэрбээр нийгмийн шударга бус явдалд санаа тавин, өөрчлөлтийн дүү хоолой болохоос гадна биднийг хүрээлэн буй хүнд хэцүү асуудалд хариулт болохын төлөө бусдыг уриалан дуудагч болдог юм.



Бусад материалыг дараах цахим хуудаснаас:
CloudLibrary.org

Cloud Library



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэ ном нь танд зориулсан зохиолчийн
бэлэг бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

